



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

Нэрт археологич, академич Доржхандын Доржийн
мэндэлсний 80 жилийн ойд зориулав

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ-2015

- 2016 оны 2 дугаар сарын 4,5-ны өдөр
- ШУА-ийн хүрээлэнгүүдийн Нэгдсэн I байрны 410 тоот хурлын танхим

Зохион байгуулагч: Шинжлэх Ухааны Академийн Түүх, археологийн хүрээлэн

Оролцогч байгууллага: МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим
Монголын Үндэсний Музей
Улаанбаатарын Их сургууль
ШУТИС-ийн БУХС
Нүүдлийн Соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
Соёлын өвийн төв
Эрүүгийн цагдаагийн газрын ЗБГХТХ

Улаанбаатар
2016

Нэрт археологич, академич Доржхандын Доржийн
мэндэлсний 80 жилийн ойд зориулав.

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ - 2015 ОН

Ерөнхий редактор: С.Чулуун

Эрхлэн нийтлүүлсэн: Ч.Амартүвшин
Хэвлэлд бэлтгэсэн: Б.Бадма-Оюу, Б.Батдалай,
Д.Бөхчулуун, М.Алтаншагай

Хэвлэлийн дизайнер: Л.Ишцэрэн
Цаасны хэмжээ: 176x250
Хэвлэлийн хуудас: 15,0 хх



ДОРЖХАНДЫН ДОРЖ
(1936-1991)

ГАРЧИГ

Өмнөх үг	9
<i>Д.Цэвээндорж, Б.Цогтбаатар.</i> Монголын нэрт археологич, академич Д.Дорж	10
<i>Ц.Болорбат, Б.Гүнчинсүрэн, Н.Звинс, Г.Ангарагдөлгөөн.</i> Монгол-Америкийн хамтарсан “Төлбөр-16 палеолитын дурсгалын малтлага: Монгол нутаг дахь дээд палеолитын эхлэл” төслийн 2015 оны хээрийн судалгааны ажлын зарим үр дүн	22
<i>Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Д.Одсүрэн, Е.П.Рыбин, Н.Звинс</i> <i>А.М.Хаценович, Г.Ангарагдөлгөөн</i> “Умард Монголын чулуун зэвсгийн үе” төслийн 2015 оны хээрийн судалгааны үр дүнгээс	26
<i>Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар, М.Изүхо, Д.Одсүрэн</i> “Монголын палеолитын судалгаа” төслийн 2015 оны шинжилгээний ажлын үр дүнгээс	30
<i>Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз</i> “Говь - тал хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн 2015 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн	35
<i>Я.Цэрэндагва, Ж.Шнейдер, А.Розен, Ж.Фаркухар,</i> <i>С.Далантай, П.Хадел, С.Гиллиланд, Р.Төрбат, Г.Олзбаяр</i> “Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэн судлах Монгол-Америкийн хамтарсан экспедицийн 2015 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүнгээс	41
<i>Я.Цэрэндагва, Р.Кортум, Б.Жаргалсайхан</i> “Хотон нуурын хөндийн хадны зургийн судалгаа” экспедицийн 2015 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн	47
<i>Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга, У.Бросседер</i> Монгол-Германы хамтарсан “Баркор” төслийн 2015 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн	53
<i>Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга, Г.Лхүндэв, Ж.Магай, К.Салисис</i> Монгол-Монакогийн хамтарсан “Хойд Тамир-Хүнүй” төслийн 2015 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн	58
<i>З.Батсайхан, Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Ч.Баяндэлгэр,</i> <i>Брайс Лаури, Вильям Тэйлор</i> Монгол-Америкийн хамтарсан “Баянхонгор” төслийн хээрийн судалгааны ажлын үр дүн	65

<i>Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Жеан Лүк Хюл</i> Монгол-Америкийн хамтарсан “Баруун Монгол” төслийн археологийн судалгааны ажлын үр дүн	69
<i>Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Лукас Бартон, Кристофер Морган</i> Монгол-Америкийн хамтарсан “Увс нуурын сав дахь нэн эртний хүмүүсийн ахуй орчин” төслийн хээрийн судалгааны ажлын үр дүн	73
<i>Жулиа Кларк, Г.Бүрэнтөгс, Т.Түвшинжаргал</i> Монгол-Америкийн хамтарсан “Умард Монгол” төслийн археологийн судалгааны зарим үр дүн	76
<i>Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Браян Миллер, Мартен Фурхольт, Леннарт Брандштетер</i> Монгол-Германы хамтарсан “Хэрлэн” төслийн хээрийн судалгааны товч үр дүн	80
<i>Д.Түмэн</i> “Дорнод Монгол” төслийн 2015 оны хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн	83
<i>Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Ч.Баяндэлгэр</i> Ховд аймгийн Мянгад сумын “Урд Улаан Үнээт” ууланд хийсэн хадны оршуулгын малтлага судалгаа	86
<i>Ж.Баярсайхан, Ц.Одбаатар, Т.Түвшинжаргал, Г.Бүрэнтөгс, Ч.Баяндэлгэр</i> Монголын Үндэсний музейн 2015 онд хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгаа	89
<i>Ц.Амгалантөгс, Миямото Казуо, Н.Батболд, Л.Дэлгэрмаа, Э.Амарболд</i> Монгол-Японы хамтарсан “Эртний Монгол хүн” төслийн хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн	92
<i>Ц.Төрбат, Н.Эрдэнэ-Очир, Д.Батсүх, Г.Энхбаяр</i> “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн ба монголчуудын угсаа гарлын цогц судалгаа” төслийн хүрээнд Эрдэнэ уул ба Хөх нуурт малтлага хийсэн тухай	95
<i>Г.Эрэгзэн, Ч.Амартүвшин, Ч.Ерөөл-Эрдэнэ, Б.Батдалай</i> “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон монголчуудын угсаа гарлын цогц судалгаа” төслийн хүрээнд Хөвсгөл, Өмнөговь аймагт ажилласан хээрийн судалгааны үр дүнгээс	97
<i>Ч.Ерөөл-Эрдэнэ, Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Б.Батдалай</i> Архангай, Говь-Алтай, Завхан аймгийн нутагт хийсэн хээрийн судалгааны зарим үр дүнгээс	102



<i>С.Өлзийбаяр, Б.Батсүрэн, Б.Очир, Г.Одмагнай</i> “Онон-2015” хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс	106
<i>С.Өлзийбаяр, Б.Батсүрэн, Б.Очир, Г.Одмагнай</i> “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон угсаа монголчуудын гарлын цогц судалгаа” төслийн хүрээнд Хэнтий аймагт ажилласан хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс	110
<i>Г.Энхбат, Г.Анхсанаа, Б.Алтансүх</i> Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, цахим удирдлагын систем	113
<i>Б.Наранбаатар, О.Энхбаяр, Д.Баярбат</i> Соёлын биет өвийн эсрэг гэмт хэрэг ба түүний талаар цаашид авах арга хэмжээний тухай	117
<i>Л.Эрдэнэболд, Р.Төгссайхан</i> Төв аймгийн Алтанбулаг суманд хийсэн малтлага судалгааны ажлын товч үр дүн	120
<i>Л.Эрдэнэболд, Ц.Бямба-Очир, Н.Н.Крадин, А.Л.Ивлиев, С.А.Васютин, Е.В.Ковычев, А.В.Харинский</i> Тэрэлжийн дөрвөлжин балгасанд явуулсан 2015 оны археологийн малтлага судалгаа	123
<i>Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд, Сон Ый-жон, У Сэй-ён, Ким Сан-мин, Хуанбо Чансо</i> “Гуа дов”-ын дурсгалт газарт хийсэн Монгол-Солонгосын хамтарсан археологийн судалгааны үр дүнгээс	127
<i>Ч.Амартүвшин, Г.Галдан, Б.Батдалай, У.Ханичёрч, Ж.Врайт</i> Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2015 оны товч үр дүн	132
<i>Б.Жаргалан, У.Гарднер, Д.Бөхчулуун</i> Монгол-Америкийн хамтарсан “Тарвагатайн хөндийн археологийн судалгаа” төслийн 2015 оны археологийн судалгааны товч үр дүн	136
<i>Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, Ч.Ванчигдаш</i> Нийслэлийн СХД-ийн Зүүнсалаан дахь хүннүгийн жирийн иргэдийн булш оршуулгын дурсгалыг авран хамгаалах малтлага судалгааны ажлын товч тайлан	140
<i>Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, Ч.Ванчигдаш</i> Төв аймгийн Заамар сум, Баянголын хөндийд хийгдсэн малтлага судалгаа	143

- Т.Идэрхангай, Э.Мижиддорж, С.Оргилбаяр,
Д.Эрдэнэбаатар, Б.Галбадрах* Улаанбаатарын Их сургуулийн
Археологийн тэнхимийн 2015 оны зун Эгийн голын Усан Цахилгаан
Станцын талбайд явуулсан авран хамгаалах судалгаа 146
- Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн, Г.Галдан, П.Алдармөнх,
М.Нямхүү, Т.Сасада, И.Үсүки, М.Сагава*
Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын үйлдвэрлэлийн
түүх” төслийн 2015 оны хээрийн судалгааны үр дүнгээс 150
- Д.Батсүх, Б.Эрдэнэ, Г.Энхбаяр, Ц.Төрбат, С.Дюшен, Д.Николаева*
Монгол-Францын хамтарсан “Тамир” төслийн 2015 оны хээрийн
судалгааны ажлын үр дүнгээс 155
- Н.Эрдэнэ-Очир, Г.Одмагнай*
Ноён уулын хүннүгийн дурсгалын дагуул булшны малтлага судалгаа 158
- Ц.Одбаатар, С.Энхболд, Г.Бүрэнтөгс*
Айрагийн гозгорт явуулсан археологийн малтлага судалгааны
урьдчилсан үр дүн 162
- Н.Батболд, Б.Өмирбек, Л.Эрдэнэбат, Бён Ён Хуан, Вүз Мен Хуан*
Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж, хамгаалах”
төслийн 2015 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн 165
- А.Очир, Б.Анхбаяр, Х.Цэрэнбямба*
Монгол, БНХАУ-ын хамтарсан археологийн хээрийн шинжилгээний
ажлын 2015 оны товч үр дүн 168
- Ц.Төрбат, Н.Баярхүү, С.Лепец, В.Бернард*
“Монгол Алтайн түрүү ба түүхэн үеийн оршин суугчдын цогц
судалгаа” төслийн хээрийн шинжилгээний товч үр дүн 172
- У.Эрдэнэбат, Т.Батбаяр, К.Франкен*
Монгол-Германы хамтарсан “Орхон” хээрийн шинжилгээний
ангийн үр дүнгээс 177
- Б.Цогтбаатар, Н.Эрдэнэ-Очир, Г.Лхүндэв, Б.Батдалай, Ц.Буянхишиг,
Г.Ангарагдөлгөөн, Э.Амарболд, Т.Осава, Ш.Сайто*
Монгол-Японы хамтарсан “Дорнод Монголын эртний Түрэгийн
үеийн түүх, археологийн судалгаа” төслийн 2015 оны малтлага
судалгааны үр дүнгээс 180
- Ц.Баттулга, М.Эрдэнэ, Р.Мөнхтулга,
Ахмэт Ташагыл, Алпаслан Ашык, Адил Йылмаз*
2015 онд Монгол-Туркийн хамтарсан “Мотар-2” төслийн гүйцэтгэсэн
хээрийн судалгааны урьдчилсан үр дүн 187



<i>Д.Цэвээндорж, А.Энхтөр, Т.Эрдэнэцогт, З. Самашев, Н. Базылхан, А. Онгар, Г. Киясбек, М.Ахметов</i> Булган аймгийн Баян-Агт сумын нутагт орших Шивээт Улааны дурсгалт газарт хийсэн хайгуул судалгааны урьдчилсан үр дүн	190
<i>А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Г.Батболд, Т.Эрдэнэцогт, Семих Гүнэр</i> Монгол-Туркийн хамтарсан “Тоньюкук” төслийн археологийн малтлага судалгааны тухай	194
<i>Б.Цогтбаатар, Л.Ишцэрэн, Г.Батболд Б.Эрдэнэ, Н.Ширайши, Т.Миякэ, Т.Сасада</i> Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн	197
<i>Л.Мөнхбаяр, Т.Хантөгс</i> Хубилайн цэргийн хот “Хөгшин тээлийн балгас”-ын малтлага судалгаа-2015	202
<i>С.Чулуун, Э.Уртнасан, Ч.Энхтуул</i> “XVII зууны Монголын хотууд” төсөл: Сарьдагийн хийдийн судалгаа-2015	204
<i>З.Батсайхан</i> МУИС-ийн Антропологи-археологийн тэнхимээс зохион байгуулсан археологийн авран хамгаалах судалгааны зарим үр дүн	208
<i>Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, С.Болормаа, Ц.Бямба-Очир, Р.Төгссайхан, С.Бат-Эрдэнэ</i> ШУТИС-ийн БУХС-ийн Археологи-Этнографийн судалгааны багийн Эгийн голын хөндийд хийсэн 2015 оны археологийн авран хамгаалах судалгаа	212
<i>Ч.Амартүвшин, Б.Батдалай</i> ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгээс 2015 онд явуулсан археологийн авран хамгаалах судалгааны ажлын товч үр дүн	216
Илтгэлийн зохиогчдын танилцуулга	221

ӨМНӨХ ҮГ

Тус хүрээлэнгээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Монголын археологи” эрдэм шинжилгээний бага хурлыг нэрт археологич, академич Доржхандын Доржийн мэндэлсний 80 жилийн ойд зориулахын зэрэгцээ хурлын цар хүрээг өргөжүүлж, мэргэжлийн судлаачид хоорондоо мэдээлэл солилцож, харилцан туршлага судлах зорилгоор археологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллага, судлаачдыг оролцуулан 2016 оны 2-р сарын 4-5-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Энэ удаагийн хээрийн судалгааны үр дүнг хэлэлцэх эрдэм шинжилгээний хуралд тус хүрээлэнгээс гадна Монгол улсын их сургуулийн Антропологи-археологийн тэнхим, Монголын Үндэсний Музей, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Улаанбаатарын Их сургууль, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Соёлын өвийн төв, Эрүүгийн Цагдаагийн газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс гэсэн 7 байгууллагын 70 орчим судлаачид, гадаадын 50 гаруй эрдэмтдийн оролцсон 50 илтгэлийг хэлэлцүүлэв.

Хурлыг нээж тус хүрээлэнгийн захирал, доктор, профессор С.Чулуун, БСШУЯамны Шинжлэх ухааны бодлого, зохицуулалтын газрын дарга, доктор Ж.Даваасамбуу, ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Т.Дорж нар үг хэлэв. Мөн нэрт археологич, академич Д.Доржийн үр хүүхдүүд түүний эрдэм шинжилгээний гар бичмэл, зарим бүтээлийг тус хүрээлэнд хүлээлгэн өгөв.

Эрдэм шинжилгээний хурлын хүрээнд 2015 онд археологийн салбарын судлаач, эрдэмтэд Монгол улсын хэмжээнд гадаадын 9 улстай хамтарсан 29 төслийг 15 аймгийн 33 сумын нутагт чулуун зэвсгийн бууц суурин, хүрэл зэвсгийн булш оршуулгын дурсгал, буган хөшөө, бууц суурин, хүннүгийн үеийн хот суурин, язгууртны болон жирийн булш, бууц суурин, сяньби, жужан, түрэг, уйгурын үеийн булш оршуулга, болон хот суурин, XIII-XIV зууны булш оршуулга, хот суурины судалгаа гэсэн олон чиглэлийн илтгэлүүд хэлэлцүүлэгдэв. Эдгээрээс гадаадтай хамтарсан төсөл тус хүрээлэн 22, Монголын Үндэсний Музей 5, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн 2 төслийг хэрэгжүүлжээ.

Мөн энэ жил 11 аймгийн 16 суманд “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон монголчуудын угсаа гарлын цогц судалгаа”, “Эртний Дотоод Азийн түүхэн орон зай дахь монгол аймгууд”, “XVII зууны хотууд” зэрэг төслийн хүрээнд үндэсний хээрийн шинжилгээний ангийг зохион байгуулж Монголын түүхийн зангилаа асуудлыг шийдэхэд зохих хувь нэмрээ оруулсан байна.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс археологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагууд 55 тооны ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай болон шинээр тавигдаж буй автозамын трассын дагууд хайгуулын ажлыг 8 аймгийн 20 сумын нутагт гүйцэтгэж 2600 орчим дурсгал шинээр илрүүлэн олсноос гадна Усан цахилгаан станц баригдах талбай, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд буй 270 дурсгалд авран хамгаалах малтан судалгааг гүйцэтгэжээ.

Эрдэм шинжилгээний хурлын төгсгөлд Монголын археологичдын холбооноос “Монгол Алтайн түрүү ба түүхэн үеийн оршин суугчдын цогц судалгаа” төслийн хээрийн шинжилгээний товч үр дүн илтгэлээр тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.Баярхүү, Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн 2015 оны зун Эгийн голын Усан цахилгаан станцын талбайд явуулсан авран хамгаалах судалгаа илтгэлээр Улаанбаатарын Их сургуулийн багш Т.Идэрхангай нарыг тус тус шалгаруулан үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулав.

МОНГОЛЫН НЭРТ АРХЕОЛОГИЧ, АКАДЕМИЧ Д. ДОРЖ

Монголын археологийн шинжлэх ухааны тулгын чулууг тавилцсан ахмад эрдэмтдийн нэг бол академич Доржхандын Дорж билээ. Тэрээр 1936 онд одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг Чоно голд төрсөн хэмээн өөрийн намтартаа өгүүлсэн бол зарим бүтээлүүдэд түүнийг Онгон сумын нутаг Молцог элс хэмээх газарт малчин ард Мажигийн гэр бүлд төрсөн гэж бичсэн нь бий. Түүнийг хоёр настай байхад Д.Доржхандын гэрт үрчлүүлсэн бөгөөд “эх Доржханд, ах Цэнд нарын асрамжинд хүмүүжсэн” байна.

Тэрээр 1945-1955 онд Улаанбаатар хотын 10 жилийн 5 дугаар дунд сургуульд суралцан төгсөж, 1955 онд ЗСБНХУ-ын/хуучин нэрээр/ Ленинград хотын Улсын Их Сургуулийн Түүхийн факультетид элсэн суралцаж, 1960 онд археологич мэргэжил эзэмшин төгссөн байна. Д.Дорж нь оюутан ахуй цагаасаа Монгол оронд амьдарч байсан эртний хүмүүсийн аж ахуй, түүхийн дурсгалын нэгэн төрөл хадны сүг зургийн дурсгалыг судлах ажлыг нэрт эрдэмтэн А.П.Окладниковын удирдлагаар хийж “Монголын хадны зураг” сэдвээр дипломын ажил бичсэн нь эрдэм шинжилгээний ажлынх нь эхлэл болсон юм.

Д.Дорж бол тухайн үед ЗСБНХУ-д археологич мэргэжлээр суралцан төгссөн цөөн хэдэн хүний нэг бөгөөд 1960 оны 7 дугаар сараас ШУА-ийн Түүхийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар орж, Монголын эртний түүх, тэр дундаа хадны зураг, чулуун зэвсгийн үеийн түүхийн судалгааны чиглэлээр голлон судалгаа хийж эхэлжээ.

Тэрээр Монголын эртний түүхийн харьцангуй бага судлагдсан үе болох хүй нэгдлийн түүхийн судалгааг голлон явуулах болсон нь энэ чиглэлийн судалгааны эхлэлийг тавилцсан Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, Ц.Доржсүрэн нарын эрдэмтэд өөр өөрийн судалгааны чиглэлд илүү анхаарах болсон тул Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн бүрэлдэхүүнд “Чулуун зэвсгийн дурсгал судлах анги” тогтмол ажиллуулах болжээ.

Мөн дээрх чиглэлээр судалгаа хийх нь өөрийнх нь хүсэл тэмүүлэл голлох нөлөө үзүүлсэн бөгөөд хожим намтартаа тэрээр “...ард түмнийхээ эртний иргэншлийн түүхийг археологийн шинэ шинэ ховор олдвороор баяжуулан судлах сайхан завшаан олдсонд туйлаас баярлаж явдаг...” хэмээсэн нь тэрээр өөрийн ажил мэргэжил, судалгааны ажилдаа туйлаас дур сонирхолтой байсны илрэл юм. Тиймээс ЗСБНХУ-д мэргэжил эзэмшсэн залуухан археологич тухайн үед бараг судлагдаагүй цагаан толбо хэвээр байсан нэн эрт үеийн түүхийн зангилаа асуудлаар судалгаа хийж эхэлсэн байна.

Д.Дорж 1960-1969 онуудад МЗТСХЭ-ийн “Чулуун зэвсэг судлах анги”-д эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллахдаа Дорнод Монголын нутаг дэвсгэрээс шинэ чулуун зэвсгийн олон арван дурсгалт газрыг илрүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан юм. Энэхүү судалгааныхаа үр дүнд тулгуурлан “Дорнод Монголын шинэ чулуун зэвсгийн үе” сэдвээр 1970 оны 2 дугаар сард ЗСБНХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарт дэд эрдэмтний зэрэг хамгаалсан бөгөөд 1971 онд “Неолит Восточной Монголии” хэмээх нэгэн сэдэвт бүтээлээ Улаанбаатар хотод хэвлүүлжээ. Уг бүтээлд Дорнод Монголын бүс нутаг, тухайлбал, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Хэнтий аймгийн нутгаас тухайн үед илрүүлэн олсон шинэ чулуун зэвсгийн бууц, суурингуудыг судалгааг нэгтгэн дүгнэж, Тамсагбулаг, Овоот зэрэг газарт малтан судалсан неолитын үеийн хэд хэдэн булш, орон сууцыг анх удаа илрүүлэн малтан шинжилсэн судалгааны шинэхэн үр дүнг нийтэлсэн нь Монгол төдийгүй Төв ба Умард Азийн шинэ чулуун зэвсгийн судлалд анхаарал

татсан үйл явдал болсон билээ. Тэрээр энэхүү нэгэн сэдэвт бүтээл болон бусад эрдэм шинжилгээний өгүүлэлдээ Монголын эртний оршин суугчид байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг бэлнээр нь авч хэрэглэж байсан аж ахуйн хэлбэрээс үйлдвэрлэх аж ахуй буюу газар тариалан, мал аж ахуйн үндэс суурийг тавьсан хийгээд неолитын үеийн хүний эдийн боловсрол, оюуны соёлын асуудлыг өргөн цар хүрээтэй авч үзсэн юм.

1969-1990 онуудад МЗТСХЭ-ийн “Палеолитын шинжилгээний анги”-ийн Монголын талын удирдагчаар ажиллаж, Зөвлөлтийн эрдэмтдийн хамт Монгол орны ихэнхи нутаг дэвсгэрийг хамарсан чулуун зэвсгийн хайгуул судалгаа хийж, хэд хэдэн дурсгалыг малтан шинжилжээ.

Түүний оролцсон энэхүү судалгааны үр дүнд Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Ховд, Говь-Алтай, Дундговь, Дорнод болон бусад аймгуудын нутгаас хүй нэгдлийн үеийн хүний амьдарч байсан дархны газар, олон мянган чулуун зэвсэг олж судалсны дотор Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул орчмоос олдсон гилбэр зэвсэг бүхий дурсгал, Дорноговь аймгийн нутаг Ёроол говь, Ховд аймгийн Алтай сумын Барлагийн гол, Баянхонгор аймгийн Цагаан агуй, Нарийн гол, Уран хайрхан орчмоос олдсон чулуун зэвсгийн олдворууд нь эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой байв. Эдгээр олдворууд зөвхөн Монгол нутагт хүн амьдарч эхэлсэн түүхийн он цагийг тухайн үед 500 гаруй мянган жилээр тогтоох боломж олгосон төдийгүй нэн эртний хүний үүсэл, хөгжил, нүүдэл, суурьшлын шинэ бүс нутгийг илрүүлэн олсонд оршино. Түүнчлэн Монголын палеолитын үеийн эртний хүний зэвсэг багаж үйлдэж байсан үндсэн арга, мөн үеийн соёлын ерөнхий төрх нь хөрш зэргэлдээ орны болон “сонгодог гилбэр зэвсэгтэн” оршин амьдарч байсан хэмээн тухайн үед үзэж байсан Африк, баруун Европын мөн үеийн соёлтой нэгэн адил хэмжээнд байсан тухай бодит баримтанд тулгуурлан анх удаа нотолсон юм.

Тухайн үед чулуун зэвсгийн үеийн судлалаар нарийн мэргэшсэн цорын ганц судлаач байсны хувьд чулуун зэвсгийн аль нэг үеэр дагнан ажиллахаас илүү харилцан холбоотой бүх үеийг хамарсан өргөн хүрээтэй судалгаа хийж Монголын нэн эртний түүхийн цагаан толбо болж байсан асуудлыг шинжлэн судлах хариуцлагатай үүргийг нэр төртэй биелүүлсэн юм.

Түүний эрдэм шинжилгээний ажлын бас нэгэн голлох чиглэл нь хадны зургийн судалгаа байсан бөгөөд Монголын хадны зургийн дүр дүрслэл, утга санаа, онцлог, холбогдох он цаг зэрэг олон асуудлуудыг хөндсөн хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсний зэрэгцээ 1975 онд “Петроглифы Монголии” бүтээлээ Э.А.Новгородоватай хамтран хэвлүүлсэн юм. Энэхүү бүтээлдээ тухайн үед өөрөө бие дааж болон бусад судлаачдын олж илрүүлсэн 30 гаруй дурсгалт газрын олон тооны хадны зургийг анх удаа нэгтгэн дүрслэлийн онцлог, түүхэн он цагийн хамаарлыг тодорхойлсон билээ.

Д.Дорж Монголын палеолитын үеийн судалгааны гол үр дүн, санал дүгнэлтээ “Монголын палеолит” (УБ., 1978, Д.Цэвээндоржийн хамт), “Палеолит и неолит Монгольского Алтая” (1990., А.П. Деревянко нарын хамт) зэрэг нэгэн сэдэвт болон хамтын бүтээлүүд болон олон өгүүлэл, товхимолуудад нийтлүүлсэн байна.

Дорноговь аймгийн Хэрээ уул, Хэрлэн голын 9 дэх буудал, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад, Баян-Өлгий аймгийн Цагаан нуур, Хар-Ус, Сагсай зэрэг газруудаас палеолитоос неолитод шилжих үе буюу мезолитын үеийн дурсгалуудыг илрүүлэн олж хөрш зэргэлдээ болон бусад бүс нутгийн дурсгалуудтай харьцуулан судалж Төв Азиас Умард Америкт хүн анх нүүдэллэн очсон хэмээх таамаглалыг чулуун зэвсгийн биет баримтаар баталгаажуулж өгсөн



юм. Түүнчлэн БНМАУ-ын түүхийн I, II боть бүтээлийн үндсэн зохиогч ба “Монголын археологи”, “Монголын чулуун зэвсгийн үе”, “Төв Азийн иргэншлийн түүх” зэрэг хэд хэдэн томоохон хамтын бүтээлд зохиогчоор оролцсон бөгөөд түүний бүтээлүүд нь ЗСБНХУ, АНУ, Англи зэрэг орны мэргэжлийн цувралуудад нийтлэгдэж, Монголын судлал төдийгүй Төв, Умард Азийн нэн эртний түүхийн судалгаанд бодит хувь нэмэр оруулсан юм. Тэрээр ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн “Археологийн судлал”, “Этнографийн судлал” зэрэг эрдэм шинжилгээний цувралууд, ШУА-ийн “Түмэн бодис” сэтгүүлийн редактораар ажиллаж байсны зэрэгцээ тухайн үед Монголын археологийн талаар гарсан олон тооны ганц сэдэвт зохиол, хамтын бүтээлүүдийг эрхлэн гаргажээ.

Д. Дорж нэрт эрдэмтэн төдийгүй авъяаслаг сурган хүмүүжүүлэгч байсан юм. Тэрээр 1960-аад оны дунд үеэс эхлэн 20 гаруй жилийн турш манай улсын их дээд сургуулиудад багшилж, эрдэм шинжилгээний залуу ажилтнуудыг эрдэм судлалын ажилд дагалдуулан сургаж байлаа.

Мөн тэрбээр Монголын шинжлэх ухааны салбарын шилдэг удирдагч, сайн зохион байгуулагч байв. Тухайлбал 1960-1991 онуудад ШУА-ийн Түүхийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар тасралтгүй ажиллахдаа 30 шахам удаагийн хээрийн шинжилгээний ангид оролцогч, удирдагчаар, 1977-1989 онд Түүхийн хүрээлэнгийн Археологи-Этнографийн секторийн эрхлэгч, 1981-1989 онд Эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1990-1991 онд Хүрээлэнгийн захирлаар тус тус ажиллаж байв.

Д.Доржийн 30 гаруй жилийн судалгаа шинжилгээний үр дүнд Монголын чулуун зэвсгийн үеийн судалгааны үндэс суурь бүрэлдэн, цаашдын чиг хандлага баттай төлөвшин тогтсон байна. Тэрээр гадаад хэл, түүний дотроос орос хэлийг онцгой сайн эзэмшсэн бөгөөд зохиол бүтээлээ гол төлөв оросоор бичдэг, тухайн үеийн шинжлэх ухааны нэгэн том төв ЗХУ-д хүлээн зөвшөөрөгдсөн нэрт эрдэмтэн байв.

Д.Дорж 1990 онд өөрийн 30 жилийн эрдэм судлалын ажлын үр дүндээ тулгуурлан ЗХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Түүх, Хэл шинжлэл, Философийн нэгдсэн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлд “Монголын чулуун зэвсгийн үе” сэдвээр түүхийн шинжлэх ухааны докторын зэргийг амжилттай хамгаалжээ. Түүний эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үнэлж 1991 онд БНМАУ-ын ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгосон юм.

Нэрт эрдэмтэн, академич Д.Доржийн бүтээл туурвил, эрдэм номын гэгээн мөр нь цагийн уртад улам тодрон гэрэлтэж, үе үеийн түүхч, археологичдын оюуны сан хөмрөгт үнэт өв болон үлдэх болно.

*Доктор, профессор Д.Цэвээндорж,
Доктор, дэд профессор Б.Цогтбаатар*

АКАДЕМИЧ. Д.ДОРЖИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ЦЭС

Нэгэн сэдэвт зохиол:

1. Неолит Восточной Монголии. Улаанбаатар. 1971.
2. Петроглифы Монголии. Улаанбаатар. 1975. /Э.А. Новгородовагийн хамт/.
3. Монголын палеолит. Улаанбаатар. 1978 /Д. Цэвээндоржийн хамт/.
4. Каменный век Монголии: палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск. 1990. /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин, Е.В. Девяткин, Е.М. Малаева нарын хамт/.

Товхимол:

1. Археологические исследования в Монголии в 1983 году // Изв. СО АН СССР. Сер. история, филология и философия. – 1984. – Вып. 3, №14. – С. /А.П. Деревянко, В.П. Алексеев, В.Е. Ларичев нарын хамт/.
2. Археологические исследования в Монголии: общ. сведения. – Новосибирск, 1984. – 16 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин нарын хамт/.
3. Археологические исследования в Монголии: краткие итоги полевых и камеральных работ. – Новосибирск, 1984. – 21 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). / А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин нарын хамт/.
4. Археологические исследования в Монголии: памятники каменного века местонахождений Их Цахюр и Манхан. – Новосибирск, 1984. – 53 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). / А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин нарын хамт/.
5. Археологические исследования в Монголии: памятники каменного века местонахождений Алтан-Цугц и Баян-гол Манхан. – Новосибирск, 1984. – 40 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). / А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин нарын хамт/.
6. Археологические исследования в Монголии: памятники каменного века долины реки Сагсай. – Новосибирск, 1984. – 59 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). / А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин нарын хамт/.
7. Археологические исследования в Монголии: памятники каменного века местонахождений Хойт-Цэнкэр-гол. – Новосибирск, 1984. – 60 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). / А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин нарын хамт/.
8. Археологические исследования в Монголии: памятники каменного века местонахождений Олон-нор. – Новосибирск, 1984. – 63 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР.



Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.

9. Археологические исследования в Монголии: отдельные местонахождений каменного века. – Новосибирск, 1984. – 58 с. – (Препр. / АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
10. Археологические исследования в Монголии: древние памятники района Олон-нора. – Новосибирск, 1984. – 58 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
11. Археологические исследования в Монголии в 1984 г.: общ. сведения. – Новосибирск, 1985. – 23 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
12. Археологические исследования в Монголии: Цаган-нур и Кобдо 14 - Новосибирск, 1985. – 45 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
13. Археологические исследования в Монголии: памятники левобережья р. Кобдо. Ачитнурская впадина. - Новосибирск, 1985. – 50 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
14. Археологические исследования в Монголии: памятники левобережья р. Кобдо. Кобдо 1, 2, 5. - Новосибирск, 1985. – 50 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
15. Археологические исследования в Монголии: памятники левобережья р. Кобдо. Кобдо 8-13 и 15. - Новосибирск, 1985. – 44 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
16. Археологические исследования в Монголии: памятники правобережья р. Кобдо. Баян-Ульги 6 – памятники устьевого зоны р. Баян-гол. - Новосибирск, 1985. – 53 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). //А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
17. Археологические исследования в Монголии: памятники правобережья р. Кобдо. Баян-Ульги 1-5 и Баян-гол 1, 2 – памятники устьевого зоны р. Баян-гол. - Новосибирск, 1985. – 29 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
18. Археологические исследования в Монголии: памятники правобережья р. Кобдо. Салхит, Алтан-Цугц сомон (зимний), Ак-Арал и Баян-Нур сомон (летний). - Новосибирск, 1985. – 62 с. – (Препр. / АН СССР. Сиб. отделение. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.

19. Археологические исследования в Монголии: памятники правобережья р. Кобдо. Памятники района зимнего Баян-нур сомона. - Новосибирск, 1985. – 59 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филологии и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
20. Археологические исследования в Монголии: местонахождение в 27 км к северо-западу от Баян-Нур сомона (зимнего). - Новосибирск, 1985. – 40 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
21. Археологические исследования в Монголии: памятники правобережья реки Кобдо Улан-Хус. - Новосибирск, 1985. – 47 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
22. Археологические исследования в Монголии: памятники юга Монгол Алтая. - Новосибирск, 1985. – 34 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
23. Археологические исследования в Монголии: памятники долины рек Булган и Уэнч окрестностей сомона. Танхил, а также зоны разведочного маршрута Баян-Булак-Булзийт. - Новосибирск, 1985. – 60 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
24. Археологические исследования в Монголии: памятники долины р. Уэнч. - Новосибирск, 1985. – 42 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
25. Археологические исследования в Монголии: Барлагин-гол 1 и 2. - Новосибирск, 1985. – 62 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
26. Археологические исследования в Монголии: Барлагин-гол 3 и 4. - Новосибирск, 1985. – 52 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
27. Археологические исследования в Монголии в 1985 г. // Изв. СО АН СССР. Сер. история, филология и философия. – 1986. – Вып. 3, №14. – С.54-62. /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, Д. Цэвээндорж нарын хамт/.
28. Археологические исследования в Монголии: общ. сведения. – Новосибирск, 1986. – 21 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
29. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, левобережье Туйн гола, местонахождения 1-8, 10-13,



20. - Новосибирск, 1986. – 43 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
30. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, левобережье Туйн гол, пункты 14-24, 27, 29-35. - Новосибирск, 1986. – 74 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
31. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, правый берег р. Туйн гол, (пункты 1-9). - Новосибирск, 1986. – 43 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
32. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, правый берег р. Туйн гол, пункты 14-19. - Новосибирск, 1986. – 32 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
33. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, Аргалант 1. - Новосибирск, 1986. – 64 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
34. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, Аргалант 2, 3 - Новосибирск, 1986. – 42 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
35. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, Аргалант 4 и 5. - Новосибирск, 1986. – 40 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
36. Археологические исследования в Монголии: Гоби-Алтайский аймак, Хатан-Хайрхан уул 1-11. - Новосибирск, 1986. – 40 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
37. Археологические исследования в Монголии: Гоби-Алтайский аймак, Хатан-Хайрхан уул 12-16. - Новосибирск, 1986. – 48 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
38. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, Баян-лэг 1-4, Баян-Ундэр, Богд-Сомон 1-3, 5-7, 9; Адгийн- ус 1-3. - Новосибирск, 1986. – 41 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.

39. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, Баян-Гоби 1-8, Шинэ-Жинст (Мэргэн) Шинэ-Жинст 1-6, Баян-Ундэр, - Новосибирск, 1986. – 67 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
40. Археологические исследования в Монголии: Гоби-Алтайский аймак, Бога-Голын эх 1, 2, 4-6, Южно-Гобийски аймак: Булган Сомон-9, Гурван-Тэс1-4, 6, Средне-Гобийский аймак: местонахождения, открытые у дороги Далан-Дзадгад-Мандал-Гоби. - Новосибирск, 1986. – 49 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
41. Археологические исследования в Монголии: Гоби-Алтайский аймак, Тайшир 1-2, Цаган-Хайрхан,. - Новосибирск, 1986. – 29 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории/А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
42. Археологические исследования в Монголии: Баян-Улгийский аймак, местность Шивэр-уул, побережье озера Толбо, пади Бух и Хату. - Новосибирск, 1986. – 35 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
43. Археологические исследования в Монголии: район сомонов Муст и Цэцэг Кобдосского аймака. - Новосибирск, 1986. – 21 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т.Петрин нарын хамт/.
44. Археологические исследования в Монголии: Кобдосский аймак, Манхан 1-7. - Новосибирск, 1986. – 50 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/..
45. Археологические исследования в Монголии: Кобдосский аймак, Манхан 8-14. - Новосибирск, 1986. – 38 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
46. Археологические исследования в Монголии: памятники каменного века Убснурского аймак. Тэс-Сомон, Давст-Сомон, Гурван-Загал, Сагил-Сомон. - Новосибирск, 1986. – 15 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). //А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
47. Монголын чулуун зэвсгийн судалгаа. Улаанбаатар. 1986 /А.П. Деревянко, В.П. Алексеев, В.Е. Ларычев нарын хамт/.
48. Археологические исследования в Монголии: Убур-хангайский и Баян-Хонгорский аймаки, Долина р. Онги-гол 1-4. Котловина озер: пункты Гучин- Ус 1-2, Жинст 1, Туйн гол 2-4, Богдо 6. - Новосибирск, 1987. – 49 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.



49. Археологические исследования в Монголии: Убур-Хангайский аймак, пункты Арц-Богдо 1-3. - Новосибирск, 1987. – 27 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
50. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, Северное побережье котловины озер. Пункты Орок-нор1, 3, 4; Туйн-гол 2, 3. - Новосибирск, 1987. – 47 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
51. Археологические исследования в Монголии: долина р. Байдарик гол, пункты 1-12. - Новосибирск, 1987. – 70 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
52. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, дункт Нарийн гол-17А.. - Новосибирск, 1987. – 72 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
53. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, поселение Орок-нор 2. - Новосибирск, 1987. – 48 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/..
54. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, дункт Нарийн гол-17Б. - Новосибирск, 1987. – 49 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
55. Археологические исследования в Монголии: общие сведения. - Новосибирск, 1987. – 14 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
56. Археологические исследования в Монголии: местонахождение Хубсугульского, Булганского, Завханского и Убснурского аймаков. Баян-Хонгорский аймак, дункт Нарийн гол-17А.. - Новосибирск, 1987. – 36 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
57. Археологические исследования в Монголии: Баян-Хонгорский аймак, долина р. Баядарик-гол. - Новосибирск, 1987. – 67 с. – (Препр. / АН СССР. Сиб. отдние. Ин-т истории, филология и философии; АН МНР. Ин-т истории). /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.
58. Археологические исследования в Монголии в 1986 г. // Изв.: СО АН СССР. Сер. история филология, философия. - Новосибирск, 1987. – Вып. 3, №16. - С. 50-53. /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.

59. Археологические исследования в Монголии в 1986 г. // Изв.: СО АН СССР. Сер. история филология, философия. - Новосибирск, - 1989. – Вып. 2, - С. 26-34. /А.П. Деревянко, Р.С. Васильевский, В.Е. Ларычев, В.Т. Петрин нарын хамт/.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ, ИЛТГЭЛ:

А. Монгол хэлээр

1. Монголын хүрлийн үеийн хадны зураг //Археологийн судлал. Эртний судлал, угсаатны зүйн бүтээл. Том. II, fasc. 2. Улаанбаатар. 1963.
2. Монгол орны хад чулуун дээрх зураг сүгийн зүйл // Түүхийн судлал. Монголын түүх, эртний судлал, угсаатны зүйн зарим асуудал. Том.II, fasc. 8. Улаанбаатар. 1962.
3. Дорноговь аймгаас олдсон нэгэн хадны зургийн тухай //ШУАМ. № 1. Улаанбаатар. 1963. тал. 44-49.
4. Тэвшийн хадны зургууд // Археологийн судлал. Монголын хүрлийн үе. Том. IV, fasc. 1. Улаанбаатар. 1965.
5. Хадны нэгэн зургийн тухай дахин өгүүлэх нь // Түүхийн судлал. Том. VIII, fasc. 3. Улаанбаатар. 1969.
6. Дорнод Монголын неолитын үеийн булш, сууц // ШУАМ. №3, Улаанбаатар. 1963.
7. Төв Азийн иргэншилд нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг // ЮНЭСКО-ийн захиалгаар бичиж явуулсан өгүүлэл. /Н.Сэр-Оджавын хамт/.
8. БНМАУ-ын нэн эртний түүхийн зарим асуудал // ШУАМ, №4, Улаанбаатар. 1975. тал. 16-23.
9. Монголын доод палеолилын тухай асуудалд // ШУАМ, №3, Улаанбаатар. 1977.
10. МАХН-ын XVIII их хурал, Монголын археологи // Археологийн судлал. Том. X, fasc. 1. Улаанбаатар. 1982.
11. Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедиц: үр дүн, зорилт // ШУАМ, Улаанбаатар. 1984.
12. Монголын чулуун зэвсгийн судалгаа // ШУАМ, № 3. Улаанбаатар. 1985 / А.П.Деревянкогийн хамт/.
13. Доод палеолитын үеийн Монгол орон // ШУАМ. №2, Улаанбаатар. 1991.
14. Дунд ба дээд палеолитын үеийн Монгол орон // ШУАМ, №3. Улаанбаатар. 1991.

Б. Гадаад хэлээр

1. К истории изучения наскальных изображений Монголии // Монгольский археологический сборник. Издательство Академии Наук СССР. Москва. 1962. С.45-53
2. Новое в изучении неолита Восточной Монголии // Түүхийн судлал. Том. VII, Улаанбаатар. 1970. С.155-170. /А.П. Деревянкогийн хамт/.
3. Периодизации наскальных изображений Монголии // Олон улсын Монголч эрдэмтдийн II их хурлын материал. I боть. Улаанбаатар. 1972.
4. Новые материалы по неолиту Восточной Монголии // Археологийн судлал. Том. V, fasc. 3. Улаанбаатар. 1972. /А.П. Окладников, В.Е. Ларичев нарын хамт/.



5. Тамсаг-булакская культура и ее место в древнейшей истории Центральной Азии // “Роль кочевых народов в цивилизации Центральной Азии” Улаанбаатар. 1974. тал. 127-131.
6. Гобийский всадник // Бронзовый и железный век Сибири. Новосибирск. 1974. С.174-176.
7. Мезолитическое поселение на р. Халхин-гол // Монголын судлал. Улаанбаатар. 1975
8. Труды Монгольских историков. Улаанбаатар. 1975 /Ц.Ишдоржийн хамт/.
9. Памятники каменного века на Юге МНР (по работам 1971-1972 гг) // Археологийн судлал. Том. VII, fasc. 1. Улаанбаатар. 1976 /А.П.Окладниковын хамт/.
10. Нижний палеолит Монголии и его место древнекаменном веке Центральной Азии // “Олон улсын Монголч эрдэмтдийн III их хурал” III боть. Улаанбаатар. 1979.
11. Мезолит Монголии и этническая общность Центральной и Северной Азии // Олон улсын Монголч эрдэмтдийн IV их хурал. II боть. Улаанбаатар. 1986.
12. Улан-Хус верхнепалеолитическая мастерская долины р. Кобдо (Монгольский Алтай) // Археологии и этнография и антропология Монголии. Новосибирск. 1987. /Р.С.Васильевский, В.Е.Ларичев нарын хамт /.
13. Из истории исследования палеолита Монголии // Түүхийн судлал. Том. XXIV, fasc.8, Улаанбаатар. 1990. тал. 65-87.
14. Каменные век Монголии. Докторын зэрэг хамгаалсан бүтээлийн хураангуй. Новосибирск., 1990.
15. Lower Paleolithic Cultures: Dani A.H., Masson V.M. (Eds.) // History of Civilization of Central Asia, Volume 1: The Dawn of Civilization, Earliest Times to 700 BC. UNESCO Publishing, Paris. / V.A. Ranov, Lü Zun-E нарын хамт/.
16. Neolithic tribes in northern parts of Central Asia: Dani A.H., Masson V.M. (Eds.) // History of Civilization of Central Asia, Volume 1: The Dawn of Civilization, Earliest Times to 700 BC. UNESCO Publishing, Paris. / A.P. Derevyanko нарын хамт/.

Археологийн хээрийн судалгааны тайлан:

1. 1968 онд Дорнод аймагт ажилласан Монгол-Зөвлөлтийн археологийн хамтарсан шинжилгээний ангийн урьдчилсан тайлан. ШУА-ийн ТАХГБСХ.
2. Отчет палеолитического отряда ССМИКЭ за 1967-1969 /А.П. Окладников, В.Е. Ларичев нарын хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.
3. 1970 онд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Дундговь аймагт ажилласан чулуун зэвсгийн ангийн урьдчилсан тайлан. ШУА-ийн ТАХГБСХ.
4. Совместный отчет Монгольского-Советской Историко-Культурной экспедиции (1969-1975) /А.П. Окладников, В.В. Волков, С.Г. Кляшторный, Н.Л. Жуковская, Д. Цэвээндорж, Н. Сэр-Оджав нарын хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.
5. Отчет палеолитического отряда ССМИКЭ за 1971-1973 и 1978 /А.П. Окладниковын хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.
6. МЗТСХЭ-ийн чулуун зэвсэг судлалын ангийн 1980 оны тайлан

- /Д.Цэвээндоржийн хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.
7. 1982 оны МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн тайлан /Д. Цэвээндорж, Р.С.Васильевский нарын хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.
 8. Отчет палеолитического отряда ССМИКЭ за 1983-1984 г /А.П. Деревянко нарын хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.
 9. Баянхонгор, Өвөрхангай аймгийн нутагт ажилласан судалгааны тайлан /Д.Баяр нарын хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.
 10. Отчет палеолитического отряда за 1985 г /А.П. Деревянко нарын хамт/. ШУА-ийн ТАХГБСХ.

Редакторласан зохиол, бүтээл:

1. Наваан Д. Дорнод Монголын хүрлийн үе. Улаанбаатар. 1975.
2. Пэрлээ Х. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. Улаанбаатар. 1975
3. Сэр-Оджав Н. Монголын эртний түүх. Улаанбаатар. 1977.
4. Наваан Д. Эртний Монголын түүхийн дурсгалууд. Улаанбаатар. 1980.
5. Археологийн судлал. Х боть. Улаанбаатар. 1980
6. БНМАУ-ын нийгмийн шинжлэх ухаан /орчуулга/ Улаанбаатар. 1981
7. Цэвээндорж Д. Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал. Улаанбаатар. 1983
8. Сэр-Оджав Н. Баянлигийн хадны зураг. Улаанбаатар. 1986.
9. Баяр Д. Дорнод Монголын хүн чулуу. Улаанбаатар. 1985.

**МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “ТӨЛБӨР-16 ПАЛЕОЛИТЫН
ДУРСГАЛЫН МАЛТЛАГА: МОНГОЛ НУТАГ ДАХЬ
ДЭЭД ПАЛЕОЛИТЫН ЭХЛЭЛ” ТӨСЛИЙН
2015 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ
АЖЛЫН ЗАРИМ ҮР ДҮН**

Ц.Болорбат, Б.Гүнчинсүрэн, Н.Звинс, Г.Ангарагдөлгөөн

Монгол-Америкийн хамтарсан “Төлбөр-16 палеолитын дурсгалын малтлага: Монгол нутаг дахь дээд палеолитын эхлэл” төслийн хүрээнд 2012 оноос эхлэн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг, Их Төлбөрийн голын хөндийд орших олон соёлт давхарга бүхий 16-р дурсгалт газарт малтлага судалгааны ажил гүйцэтгэж байгаа бөгөөд тус бүс нутгийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн аргын онцлог, холбогдох он цагийг баттай тогтоох; тухайн үеийн уур амьсгал, байгаль орчин, ургамал, амьтны аймгийн өөрчлөлт хувьсал зэрэг асуудлыг сэргээн тогтоох зорилготой юм. Энэхүү төслийн хүрээнд бид 2015 онд өмнөх жилүүдэд малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн Төлбөр-15; Төлбөр-16; Төлбөр-21 палеолитын дурсгалт газраас хөрсний дээж авч лабораторийн нарийвчилсан судалгаанд өгөх, мөн Төлбөр-16 палеолитын дурсгалт газрын ойр орчимд хайгуул судалгаа болон сорьц малтлага хийхээр төлөвлөсөн.

Монгол-Америкийн хамтарсан төслийн хээрийн судалгаа 2015 оны 08-р сарын 05-наас 08-р сарын 20-ныг хүртэлх үргэлжилж, дээр дурдсан палеолитын дурсгалт газруудын малтлагын талбайгаас хуучин шороог гарган авч хөрсний 1-р давхаргаас эхлэн 5 см давтамж бүхий чулуун зэвсэг агуулагдаж буй доод давхаргыг хүртэл хөрсний дээж авав. Хөрсний дээжийг Их Британийн Кембрижийн Их сургуулийн мэргэжилтэн тусгай багажаар, зохих аргазүйн дагуу зориулалтын саванд авсан бөгөөд 2016 онд лабораторийн шинжилгээнд илгээхээр бэлтгэж байна.



Зураг 1. Төлбөр-16 палеолитын дурсгалт газраас хөрсний дээж авсан байдал



Зураг 2. Төлбөр-21 палеолитын дурсгалт газраас хөрсний дээж авсан байдал

Бид Төлбөр-16 палеолитын дурсгалт газрын хойно холгүй орших Шар хад хэмээх уулын баруун бэлд баруун талаараа гүн жалгатай, урд талаараа гүехэн жалга дагасан бага зэрэг налуу, намхан дэвсэгийн жалга дагасан ирмэг дагуулан хоорондоо 2 м зайтай, 2х1 мхэмжээ бүхий хоёр жижиг талбайд 2 м орчим гүнд хүртэл сорьц малтлагыг гүйцэтгэсэн. Цаг хугацаа давчуутул малтлагыг хүрэээр гүйцэтгэсэн бөгөөд зарим том хэмжээтэй олдворуудын илэрсэн гүнийг хэмжилт хийн тэмдэглэж, тус давхаргын шороог шигшүүрийн тусламжтайгаар шалгаж байв. Энэхүү хоёр сорьц малтлагаар нийтдээ 440 ш чулуун зэвсгийн олдвор олсноос 395 ш олдворыг шигшүүрийн тусламжтайгаар илрүүлсэн. Энэ удаагийн

сорьц малтлагын талбай жижиг, давчуу байсан тул хөрсний давхаргын үе, заагийг тодорхойлох боломжгүй байсан бөгөөд олдвор хэдий хэрийн гүнд хүртэл агуулагдаж буйг тогтоов.



Зураг 3. Хөрсний дээж хийсэн тусгай сав



Зураг 4. Хөрсний дээжтэй уут

1-р талбайгаас нийт 195 ш чулуун зэвсгийн олдвор олдсон бөгөөд 166 ш эдлэл нь шигшүүрээс илэрчээ. Харин малтлагын талбайгаас олдсон 29 ш олдворыг ангилан ялгавал: Онгитой зэвсэг 1 ш, шүдлэг-хүнхэр зэвсэг 1 ш, ялтас 1 ш, залтас 20 ш, хагархай-хэлтэрхий 6 ш тус тус байна. Сонирхол татахуйц олдворуудыг доор тодорхойлов.

Холтослуур зэвсэг 1 ш. Цуулдсан ялтасны үзүүр хэсэгт байрлах томоохон хүнхэр хэсгийг жижгээр холтчин ирлэсэн нь холтослуур зэвсгийн хэв шинжийг агуулна (зураг 5-5).

Шүдлэг-хүнхэр зэвсэг 1 ш. Навчин хэлбэртэй цуулдасны тууш ирмэгт байх хүнхэрийг шаталсан ирээр ирлээд, цааш үргэлжлүүлэн хоёр талаас сэлгүүлэн холтчих замаар шүдлэг ир гаргажээ. Нэг хурц үзүүрийг ирлэсэн байдал ажиглагдахгүй байна (зураг 5-3).


2-р талбайгаас нийт 274 ш чулуун зэвсгийн олдвор илэрсэн бөгөөд 229 ш эдлэл нь шигшүүрээс илэрчээ. Харин малтлагын талбайгаас 45 ш олдвор олдсоныг ангилан ялгавал: Бэлдэц 1 ш, үлдэц 2 ш, хутга 1 ш, хосолмол зэвсэг 1 ш, цавчих зориулалттай зэвсэг 1 ш, залтас 11 ш, ялтас 4 ш, цуулалтын оромтой хагархай 4 ш тус тус байна. Энэ сорьц малтлагаар цөөн тоотой илэрсэн анхдагч цуулалтыг илэрхийлэх олдворыг доор тодорхойлон толилуулж байна.

Бэлдэц 1 ш. Хөндлөн огтлол нь гурвалжин хэлбэртэй бэлдэцийн тэгш цохилтын талбайг хоёр цохилтоор бэлтгэжээ. Цуулалтын гадаргууг бэлтгэж засаагүй байх ба суурь хэсгийг гурван талаас олон тооны жижиг цуулалтуудаар шовхлон зассан байна.

Үлдэц 2 ш. Эхний эдлэл нь цохилтын нэг талбайтай, цуулалтын нэг гадаргуутай, зэрэгцээ цуулалтын зарчимт үлдэцийн төрөлд багтана. Цохилтын талбайг огцом налуу байдалтай бэлтгээд хоёр талаас хөндлөн цуулалтаар зассан байна. Ар талын гадаргууг суурийн зүүн хажуугаас нэг сөргүүлсэн цохилтоор зассан бол үлдсэн хэсэг нь чулууны өнгөн бүрхүүлээ хэвээр хадгалж үлджээ. Цуулалтын гадаргуу нь гүдгэр бөгөөд ялтас цуулаж авах оролдлого хийсэн ором байна. Үлдэцийн зүүн хажууг олон тооны жижиг цуулалтуудаар зассан байх ба зарим хэсэгт чулууны өнгөн бүрхүүл хэвээр үлджээ (зураг 5-1). Хоёр дахь үлдэцийн байгалийн хэлбэрийг ашиглан ялимгүй налуу цохилтын талбайн хагасыг хоёр цуулалтаар зассан бол үлдсэн хэсэг нь чулууны өнгөн бүрхүүлтэйгээ байна. Түүний



гурвалжин хэлбэртэй цуулалтын гадаргууг бага зэрэг засах оролдлого хийснээс гадна нэг залтас салган авсан ором үлджээ. Суурь хэсгийг жижиг цуулалтуудаар хурцлан зассан байна. Энэ үлдэц нь цуулалтын эхэн шатанд хамаарна.



Зураг 5. 1-үлдэц, 2-хосолмол зэвсэг, 3-шүдлэг хүнхэр ирт зэвсэг, 4-хутга, 5-холтослуур, 6-цавчих зориулалттай зэвсэг.

Хутга 1 ш. Залтасаар бэлтгэсэн байх ба баруун ирмэгт долгиотой, налуу ир гаргаад дараа нь ирмэгийг дагуулан жижгээр холтчиж зассан нь хутга маягтай болжээ (зураг 5-4).

Цавчих зориулалттай зэвсэг 1 ш. Энэ нь баргил том хэмжээтэй, дугуй хэлбэртэй эдлэл юм. Уг зэвсгийг хоёр талаас олон тооны цуулалтаар зассан байх бөгөөд дээд ирмэгийг хоёр талаас сэлгүүлэн ирлэх замаар солбисон ир гарган цавчих хэлбэрийн зэвсэг болгожээ. Энэхүү эдлэлийг ашиглаж байсан ул мөр мэдэгдэхгүй байна (зураг 5-6).

Хосолмол зэвсэг 1 ш. Гурвалжиндуу хэлбэртэй залтасны хөндлөн ирмэгийг холтчих замаар ирлэсэн нь хянгар хэлбэртэй болсон бол баруун хажууд буй хүнхэр хэсгийг эсрэг талаас жижгээр холтчин ирлэсэн нь холтослуур зэвсэгтэй төстэй болсон байна (зураг 5-2).

Энэхүү хоёр сорьц малтлагаар илэрсэн олдворууд нь Их Төлбөрийн голын дээд палеолитын дурсгалуудаас илэрч олдсон эдлэлүүдтэй цуулалтын арга, хэв шинжийн хувьд ерөнхийдөө ижил төстэй байна. Тухайлбал, Шар хадны 2-р талбайгаас илэрсэн цохилтын нэг талбайтай, цуулалтын нэг гадаргуутай, зэрэгцээ цуулалтын зарчимт үлдэц нь Төлбөр-15 палеолитын дурсгалт газрын 5-р давхаргаас илэрсэн мөн хэлбэрийн үлдэцтэй тун төстэй ажээ¹. Мөн чулуун зэвсгийн олдворуудаас гадна адууны шүд, бод малын ясны том хэсгүүд олдож байгаа нь тухайн давхаргын он цагийг бодитой тогтоох, Их Төлбөрийн голын хөндийгөөр ямар амьтад идээшин нутагшиж, тэр үеийн хүмүүс ямар төрлийн амьтныг хоол хүнсэндээ голлон хэрэглэж байсныг тогтоох боломжийг олгоход чухал ач холбогдолтойг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол-Америкийн хамтсарсан “Төлбөр-16 палеолитын дурсгалын малтлага: Монгол нутаг дахь дээд палеолитын эхлэл” төслийн хүрээнд илрүүлж, сорьц малтлага хийсэн Шар хадны хэмээх энэхүү дурсгалт газар хийсэн сорьц малтлагыг цаашид өргөтгөн үргэлжлүүлэх зорилго тавьж байна.

¹ Б.Гүнчинсүрэн, С.А.Гладышев, Ц.Болорбат, А.А.Цыбанков, Д.Одсүрэн, Т.Т.Чаргынов. Археологическое изучение многослойного палеолитического памятника Толбор-15 в 2008 году. Археологийн судлал. XXV. УБ., 2008.5-26-р тал.

“УМАРД МОНГОЛЫН ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕ” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Б.Гунчинсүрэн, Ц.Болорбат, Д.Одсүрэн, Е.П.Рыбин,
Н.Звинс, А.М.Хаценович, Г.Ангарагдөлгөөн

Монгол орны Умард хэсэг буюу тодруулбал, Сэлэнгэ мөрний дунд урсгалаар зүүн гар талаас нь цутгах Их Төлбөрийн голын хөндий чулуун зэвсгийн дурсгалаар нэн баялаг гэдэг нь Монгол-Оросын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн жил дараалсан судалгааны үр дүнд тодорхой болсон юм.

“Умард Монголын чулуун зэвсгийн үе” төслийн хүрээнд 2015 онд Их Төлбөрийн голын зүүн гар талд, үргэлжилсэн уулсын зүүн тал руу хандсан Уургын ам хэмээх хавчиг амны адагт орших Төлбөр-21 хэмээн тэмдэглэгдсэн дурсгалт газарт өмнөх жилүүдийн малтлага судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэв.

Хуучин чулуун зэвсгийн соёлт давхарга бүхий энэхүү суурин далайн түвшнээс дээш 1089 м өндөрт өргөгдсөн бөгөөд уулын бэлийн харьцангуй өргөгдсөн дэвсгэ газарт, ар талаараа нөмөртэй, зүүн болон зүүн урагшаа харууц сайтай газарт байрлажээ.

Уг дурсгалт газарт анх 2011 онд хоорондоо 30 м зайтай хоёр сорьц малтлага хийсэн¹ бөгөөд үндсэн түүхий эдийн бөөгнөрөл 150-200 см гүнд буюу түүнээс дээш байрлахыг тогтоожээ. Мөн C14 шинжилгээний үр дүнд тулгуурлан 45.000~39.000 жилийн тэртээд холбогдоно хэмээн үзсэн байна.

Эдгээр сорьц малтлагын мэдээнд тулгуурлан, тэдгээрийн дунд 4 х 1 м хэмжээтэй талбай сонгон 2014 онд малтлага хийсэн. Малтлагын явцад 2.5 м гүн хүртэл хөрсний 6 үе буйг тодорхойлсон бөгөөд эхний 3 соёлт давхаргыг дээд палеолитын өөр өөр цаг үед холбогдуулж, доод соёлт давхаргуудыг илүү эрт үед буюу дунд палеолитын үед холбогдох боломжтой хэмээн үзсэн байна².

Энэ онд 2014 оны малтлагын талбайг зүүн тал руу нь сунган 8 м² талбайд судалгааг гүйцэтгэсэн байна.

Тухайн дурсгалт газрын 3, 4-р давхаргаас харьцангуй олон олдвор илэрч байв. Ялангуяа 4-р давхаргаас хэмжээгээр том үлдэцүүд гарсныг тэмдэглэх хэрэгтэй. Харин 5, 6-р давхаргаас цөөн олдвор олджээ. 2014-2015 оны малтлагаар 3-р давхарга (археологийн 4-р үе) болон 4-р давхаргын (археологийн 5-6-р үе) хурдасаас ясны үлдэгдэл олдож байв.

6-р үеэс нийт 8 ш чулуун зэвсгийн олдвор илэрсэн байна. Эдгээрийн дотор нэг зэвсгийн чанартай эдлэл байгаа нь иртэй залтас юм. Бусад нь ямар нэг хоёрдогч боловсруулалт хийгдээгүй ажээ.

5-р үе нь нийт 45 ш чулуун зэвсгийн олдвор агуулж байна. Иртэй цуулдасуудын дотор хэв шинжийн хувьд ялтсанцарууд зонхилно. Нэг залтас байгаа нь конвергент хэлбэрийн захтай, холточсон цохилтын талбайтай байгаа нь леваллуагийн хэлбэртэй төстэй.

Зэвсгийн цуглуулгад ирлэсэн залтас (2 ш), ялтас ашиглан бэлтгэсэн цоолтуур(зураг 2. 4), ирлэсэн ялтас(зур 2. 10) хамаарна.

¹ А.В.Табарев, Б.Гунчинсүрэн, Дж.К.Гиллам, С.А.Гладышев, Т.Доганджич, Н.Звинс, Ц.Болорбат, Д.Одсүрэн. Комплекс памятников каменного века в долине р. Их-Тулбэрийн-Гол, Северная Монголия (разв едочные работы с использованием ГИС-технологий в 2011 г.) // *Studia Archaeologica. Tom. XXXII, fasc. 2. УБ., 2012. стр. 26–43.*

² Е.П.Рыбин, Б.Гунчинсүрэн, Ц.Болорбат, А.М.Хаценович, Д.Одсүрэн. Рекогносцировочные исследования палеолитического памятника Толбор-21 в Северной Монголии // *Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий: Материалы Итоговой сессии Института археологии и этнографии СО РАН 2014 года. Новосибирск. стр. 79-82.*

4-р үеэс 691 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлжээ. Олдворын дунд үлдэц 3.3%-ийг эзлэх бол зэвсэг 6.6%-ийг, цуулдас 90.1 %-ийг тус тус эзэлж байна. Төрөл зүйлийн хувьд үлдэц хэлбэрийн эдлэл (14 ш), бэлдэц (6 ш), цохилтын нэг талбайтай, ялтас цуулж авахад зориулагдсан хавтгай үлдэц (зураг 2. 18), нэг болон хоёр цохилтын талбайтай, ялтас цуулж авахад зориулагдсан призм хэлбэрийн үлдэц (6 ш) (зураг 2. 9, 17; 3. 4), цацарган цуулалт бүхий үлдэц хэмээн ангилагдана.

Цуулдасны үйлдвэрлэлд хайрс, хагархай-хэлтэрхий хамгийн олон бөгөөд 69.7%-ийг эзэлнэ. Ялтсанцар мөн олон байх ба (томоохон хоёр талт болон хавирган ялтас, мөн ялтсанцар, бичил ялтас (зураг 3. 3, 8) бүх цуулдасны 27.4%-ийг эзлэх ажээ. Харин техникийн цуулдас (цуулалтын гадаргууг засах явцад гарсан цуулдас, захын цуулдас, цохилтын талбайг засах явцад гарсан цуулдас гэх мэт) 2.9%-ийг эзэлж байна.

Зэвсгийн төрлийн олдворын тал хувийг ялтас ашиглан бэлтгэжээ. Үүнд гүдгэр хянгар(4 ш)(зураг 2. 7, 15), төгсгөл хусуур (зураг 2. 11), шүдлэг-хүнхэр зэвсэг (2 ш) (зураг 3. 6), шүдлэг зэвсэг, иртэй ялтас (10 ш)(зураг 2. 12, 19), иртэй ялтсанцар, иртэй залтас (4 ш)(зураг 3. 5), ялтасаар бэлтгэсэн тэгш хэмт үзүүр мäs, цоолтуур (2 ш), хатгуур (2 ш)байна.

Чулуун зэвсгээс гадна амьтны ясны дөрвөн хэсэг олджээ. Мөн тэмээн хяруулын өндөгний хальсаар хийсэн зүүлт (зураг 2. 6) олдсон байна. Эндээс засч янзлаагүй тэмээн хяруулын өндөгний хальсны хагархай 4 ш илэрсэн нь дээрхтэй холбоотой бололтой.

3-р үеэс 864 ш чулуун зэвсгийн олдвор илэрчээ. Үлдэцийн төрлийн эдлэл 2.5%-ийг, зэвсгийн цуглууга 2.7%-ийг, цуулдас 94%-ийг тус тус эзэлж байна.

Үлдэц хэлбэрийн эдлэл 13 байгаагаас цуулалтын эхэн болон дунд шатанд холбогдох үлдэцүүд зонхилно. Бэлдэц болон цуулалтын оромтой эдлэл 7 ш илэрчээ. Үлдэцүүд цохилтын хоёр талбайтай, цуулалтын нэг гадаргуутай, ялтас цуулахад зориулагдсан, ялтас цуулж авахад зориулагдсан тайрдсан(зураг 3. 10), цохилтын нэг талбайтай, ялтас цуулж авахад зориулагдсан призм хэлбэрийн (2 ш)(зураг 2. 14; 3. 9), үлдэцийн хагархай хэмээн ангилагдана.


Цуулдасны үйлдвэрлэлд залтас хамгийн олон буюу 71.5 % (иргүй цуулдас болон хайрс, хагархай-хэлтэрхий) байгаа бол ялтсанцар 27.3%(зур 2. 2, 3; зур 3. 1, 2), техникийн цуулдас 1.2%-ийг эзэлж байна.

Зэвсгийн цуглуулгад 14 ш эдлэл холбогдоно. Эдгээрийг голдуу ялтас ашиглан бэлтгэжээ (10 ш). Зэвсгийн дотор хусуур (2 ш)(зураг 2. 8), хүнхэр иртэй зэвсэг, хайрган зэвсэг (харуул), иртэй ялтас (6 ш), иртэй бичил ялтас (зураг 2. 5), иртэй залтас (2 ш), цүүц хэлбэрийн зэвсэг (зур 2. 1)тус тус байна.

2 болон 1-р үеэс цөөн тоотой олдвор илэрсэн нь цөм дээд палеолитын төгсгөл үед буюу голоцены эрт үед холбогдоно.

4 болон 3-р үеэс илэрсэн олдворууд хэв шинж болон үйлдвэрлэлийн аргын хувьд хоорондоо адилаар байна. Цуулдасуудын дунд ялтас, зэвсгийн цуулдсан бэлдэц оролцуулаад 4-р үед 31%-ийг эзэлж байгаа бол 3-р үед 29.5%-ийг эзэлж байна. Төлбөр-4 палеолитын дурсгалт газрын 6-5-р үед ялтсанцар 27.4%, Төлбөр-16 палеолитын дурсгалт газрын 7-р үед 50.9 хүртэлх хувийг эзэлж байна³

³ А.П.Деревянко, Е.П.Рыбин, С.А.Гладышев Б.Гунчинсүрэн, А.А.Цыбанков, Д.Олсен. Развитие технологических традиций изготовления орудий в каменных индустриях раннего этапа верхнего палеолита Северной Монголии (по материалам стоянок Толбор-4 и -15) // Археология, этнография и антропология Евразии. – 2013. – № 4 (56). – С. 21–37; / N.Zwyns, S.A.Gladyshev, B.Gunchinsuren, T.Bolorbat, D.Flas, A.Tabarev, T.Dogandzic, J.C.Gillam, A.Khatsenovich, Sh.McPherron, D.Odsuren, C.Paine, K.E.Purevjal, J.Stewart. The open-air site of Tolbor 16 (Northern Mongolia): preliminary results and perspectives // Quaternary International. – 2014. – Vol. 347. – P. 53–65.



Зураг 1. 2015 оны малтлагын зүүн ханын зүсэлт ба илэрсэн олдворууд

Ялтасууд нь үе хооронд ялгаатай бөгөөд тухайлбал, 4-р үеийн ялтасууд илүү том, бас өргөн бол 3-р үеийн ялтасууд нарийхан байна. Эдгээр үеийн ялтас болон ялтсанцар/бичил ялтасууд нь бараг ижил хувьтай ажээ. Жишээлбэл, 4-р үед нийтдээ 36.4%-ийг эзлэх бол 3-р үед 40.6%-ийг эзэлж байна. Энэ нь Төлбөрийн голын археологийн бичил бүс нутгийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой нэг үзүүлэлт юм.

Тухайлбал, Төлбөр-4 суурингийн 6-5-р үеүд дээд палеолитын эхэн үед хамаарах ба жижиг ялтас бүх ялтсан цуулдасны 22.1%-ийг бүрдүүлж байгаа бол Төлбөр-15 суурингийн 7-5-р үеийн ялтсан цуулдасны дотор жижиг ялтас болон бичил ялтас 31.3%-ийг эзэлдэг.

3-р үеийг цуглуулгад ар талын гадаргуудаа хоёр тууш цуулалт бүхий эдлэл 16% , нэг чиглэлд цуулалт бүхий эдлэл 72.1% байгаа бол 4-р соёлт үеийн цуглуулгад ар талын гадаргуудаа хоёр тууш тууш цуулалт бүхий 16%, нэг чиглэлд цуулалт бүхий 57.7%-ийг эзэлж байна. 4-р үед ар талын гадаргууд хийсэн хоёр тууш цуулалт хумигдаж байх ба хавирган цуулалтанд зориулагдсан, мөн хөндлөн болон сэлгэсэн (ташуу) цуулалт зонхилох болжээ.

4 болон 3-р үеийн үлдэцүүдийн 14.2%, 14.3% нь хоёр талтай болон холточсон цохилтын талбайтай ажээ. Тэгш цохилтын талбай бүхий 3-р үед 59%, 4-р үед 50%-ийг эзэлж байна. Мөн цэгэн/шугаман цохилтын талбай (3-р үед 13.6%, 4-р үед 19%) дийлэнх хувийг эзэлнэ.


Олдворууд нь түүхий эдийн хэв шинжийн хувьд сонирхолтой байдлаар хуваагдана. Бүхэлдээ 12 төрлийн хувирмал, тунамал чулуулгийг түүхий эд болгон ашиглажээ.

Эдгээрт дээд палеолитын эхэн үед холбогдох томоохон, хоёр тууш цуулалт бүхий үзүүр мэсэн ялтас, нэг чиглэлд цуулалт бүхий үлдэц-сийлүүр байхгүй бөгөөд нэг чиглэлд цуулалт бүхий жижиг ялтас, ялтасны эзлэх хувь өндөр байна. Төлбөр-15 палеолитын дурсгалт газрын 7-6-р үеийн он цаг ойролцоогоор 33-30 мянган жилийн тэртээд холбогдож ба тухайн цуглуулга болон Төлбөр-4 палеолитын дурсгалт газрын 6 болон 5-р үе, Төлбөр-16 палеолитын дурсгалт газрын 7б давхарга нь дээрх он цагтай ойртоно. Төлбөр-21 палеолитын дурсгалт газрын 4 болон 3-р соёлт үеийн олдворуудад дээд палеолитын эрт үеийн уламжлал тодорхой харагдана.



Зураг 2. Төлбөр-21 дурсгалын 2015 оны малтлагаар илэрсэн чулуун зэвсгийн олдворууд

Зураг 3. Төлбөр-21 дурсгалын 2015 оны малтлагаар илэрсэн чулуун зэвсгийн олдворууд



“МОНГОЛЫН ПАЛЕОЛИТЫН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС

Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар, М.Изүхо, Д.Одсүрэн


ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн нь Япон улсын Токио Метрополитан Их Сургуультай хамтран “Монголын палеолитын судалгаа” эрдэм шинжилгээний төслийг 2013 эхлэн оноос хэрэгжүүлж байгаа билээ.

Уг төслийн хүрээнд Монгол орны умард хэсэг, тодруулбал, Хүдэр, Уялга, Цөх голын хөндийд чулуун зэвсгийн дурсгал илрүүлэх хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ эрт үеийн байгаль цаг уур, хүрээлэн буй орчин, түүний дотор эртний хүмүүстэй хөршлөн амьдарч, өдөр тутмын ахуй амьдралынх нь нэг хэсэг болсон амьтдын судалгаанд гол анхаарлаа хандуулж байна.

Савагт хирсний ясны судалгаа. 2015 онд хамтарсан төслийн судлаачид эртний амьтны ясны судалгаа, чулуун зэвсгийн бууц суурины хайгуул судалгаа гэсэн үндсэн хоёр чиглэлд ажиллав.

Эртний амьтны ясны судалгааны хүрээнд Хэнтий аймгийн ОНС музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа савагт хирсний ясыг цэвэрлэх, хэмжилт хийх, гэрэл зурган баримтжуулалт үйлдэх болон ясыг бэхжүүлэх зорилгоор хоёр удаа ажиллав.

Чулуун зэвсгийн судалгаанд тухайн үеийн хүрээлэн буй орчин, ялангуяа эртний хүмүүсийн ахуй амьдралын салшгүй хэсэг байсан амьтдын тухай судалгаа томоохон байр суурийг эзэлдэг билээ. Плейстоцены үеийн уур амьсгалд дасан зохицсон өвсөн тэжээлт амьтдын ясны хэсгүүд манай улсын нутаг дэвсгэрээс илэрч олдсон мэдээ байх боловч судалгаа шинжилгээний эргэлтэнд орсон нь энэ хир үгүй юм.



Зураг 1. Хэнтий аймгийн Орон Нутаг Судлах музейн сан хөмрөгт хадгалагдаж буй савагт хирсний ясны тэмдэглэгээ

Барилгын ажлын явцад 2012 оны 6 сард Хэнтий аймгийн Өндөрхаан хотоос том амьтны яс санамсаргүй байдлаар илэрсэн нь эртний өвсөн тэжээлтэн болох савагт хирсний яс болох нь тогтоогдсон бөгөөд одоо тус аймгийн ОНС музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Энэ нь Монгол орны нутаг дэвсгэрээс энэ төрлийн амьтны ясны үлдэгдэл харьцангуй бүтнээр олдсон анхны тохиолдол тул шинжлэх ухаан болон танин мэдэхүйн чухал ач холбогдолтой билээ. Тиймээс “Монголын палеолитын судалгаа” төслийн хүрээнд энэхүү ясыг судлах, хадгалж хамгаалах, олон нийтэд танилцуулах үүднээс Хэнтий аймгийн ОНС музейтэй хамтран ажиллаж байна.

Судалгааны явцад уг яснаас дээж авч АНУ-ын Калифорни мужийн Ирвиний Их Сургуулийн лабораторид он цаг тогтоох шинжилгээ хийлгэсэн бөгөөд BP 42050-39450; BP 41970-39350 жилийн өмнөх үед холбогдоно гэсэн он цагийн хамаарал гарсан. Энэ нь уг амьтан хуучин чулуун зэвсгийн дээд үеийн эхэнд амьдарч байсныг баталж байгаа бөгөөд чулуун зэвсгийн үеийн хүрээлэн буй орчин, түүний дотор тухайн үеийн амьтдын судалгааг шинэ баримт хэрэглэгдэхүүнээр баяжуулж байна.



Зураг 2. Савагт хирсний ясыг бэхжүүлсний дараа үзмэрт бэлтгэж дэглэсэн байдал

Ясыг бүтцээр нь ангилж үзэхэд толгой, хүзүү болон сээрний зарим үе, зарим хавирга, урт мөчдийн ясны хэсгүүд, сүүлний үе яснуудаас бусад нь байгааг тогтоосон.

Мөн савагт хирсний ясыг үзмэрт дэглэж байршуулах үүднээс хажуу талаар нь хэвтүүлсэн байрлалаар анатомийн бүтцийн дагуу өрж дэглэх ажлыг гүйцэтгэв.

2016 онд уг яснаас DNA-ийн дээж авч судалгаанд явуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэ нь тухайн амьтны хүйс, нас зэргийг тодруулах зорилготой юм.

Чулуун зэвсгийн хайгуул судалгаа. Хамтарсан төслийн судлаачид 2015 онд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг Цөх, Хүдэр голын сав нутагт өмнөх жилүүдийн хайгуул судалгааг үргэлжлүүлэн хийв.


Хайгуул судалгааг Цөх голын сав дагууд эхлэн гүйцэтгэсэн бөгөөд энэ голоор



Монгол улс, ОХУ-ын хил зааглагддаг. Сансрын зургийн мэдээнд тулгуурлын Цөх голын зүүн эрэг дагуух өргөргийн дагуу сунаж тогтсон өндөр уулсын хойд зүгт хандсан нарийн амуудыг шалгасан болно. Эдгээр амууд хэдийгээр өндөр уулын ар бие рүү алсаас намссан, зарим хэсэгтээ нөмөр дулаан хунхтай бөгөөд газарзүйн ийм хэв шинж нь Умард Монголын чулуун зэвсгийн дурсгалт газруудын байршлын нэг онцлог билээ. Гэвч энэ хавьд чулуун зэвсэг үйлдвэрлэх түүхий эд, хатуулаг сайтай чулуулаг байхгүй. Хайгуулын ажлын явцад эртний хүний ул мөр, чулуун зэвсгийн үлдэгдэл илрээгүй тул цаашид хайгуул судалгааг Хүдэр голын зүүн талаар үргэлжилсэн уулсын ам, бэлээр гүйцэтгэв.

Рашааны ам 2. Хамтарсан төслийн хүрээнд хайгуул судалгаа хийж буй тухайн газар орон нь Монгол орны газар тариалангийн бүс нутаг юм. 2014 оны хайгуул судалгааны үр дүнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төвөөс баруун хойд зүгт, Хүдэр голын зүүн гар талд орших Рашааны амны адагт, тариан талбайгаас цуулалтын арга барилаараа дээд палеолитын хэв шинжийг илтгэх цөөн тооны олдворууд илрүүлсэн. Энэхүү дурсгалт газар үргэлжилсэн уулсын зүүн тийш харсан амны адагт, уулын хормойн налууд орших бөгөөд нутгийн олон Рашааны ам хэмээн нэрлэх тул бид тухайн дурсгалыг баримтжуулахдаа энэхүү нэрийг баримтласан болно. Тухайн үед Рашааны амны ихэнх хэсэг тариалалттай байсан тул нарийвчилсан самналт хийж шалгах боломжгүй байв. Тиймээс энэ онд Рашааны амны өнжсөн талбайнуудад хайгуул судалгааг гүйцэтгэлээ. Хайгуулын үр дүнд Рашааны амны адгаас хөрсөн дээр олдворууд агуулсан шинэ дурсгалт газар илрүүлэн Рашааны ам-2 хэмээн нэрлэж баримтжуулсан. Энд уулын зүүн хойд бэлийн налууг дагасан тариан талбайгаас гол төлөв өөхөн чулуу, цөөн тохиолдолд хайрга ашиглан хийсэн олдворууд 100 x 80 м хэмжээтэй талбайд сийрэг байдлаар тархсаныг тогтоосон

Эндээс 21 ш чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цуглуулсан бөгөөд төрөл зүйлийн хувьд бэлдэц (2 ш), үлдэц, үлдэц хэлбэрийн эдлэл, цуулалтын оромтой түүхий эд (2 ш), хянгар, залтас (6 ш), ялтас (3 ш), цуулалт бүхий хагархай (5 ш) хэмээн ангилагдана



Зураг 3. Рашааны ам-2. Үлдэц

Цуулалтын оромтой түүхий эд. Энэ дурсгалт газраас түүвэрлэн цуглуулсан чулуун зэвсгийн олдворуудыг хийсэн түүхий эд нь өөхөн (кварцийн төрлийн) чулуу юм. Энд тодорхой дэс дараалалгүй боловч цуулалтын оромтой түүхий эд хоёр олдсон нь том хэмжээтэй.

Хоёрдогч боловсруулалт хийгдсэн зэвсгийн төрлийн олдвор нэг илэрсэн нь хянгар юм. Түүнийг залтас ашиглан хийсэн бөгөөд нэг шулуун ирмэгийг хөндлөн холтчин ирлэсэн байна.

Цуулдасны үйлдвэрлэлд залтас, ялтас, хагархай хэлтэрхий хамаарна. Залтасуудын ихэнх дундаж хэмжээтэй бөгөөд гадаргуудаа өмнөх цуулалтын оромтой хоёрдогч, гадаргуугийн ихэнх хэсэг чулууны өнгөн бүрхүүлээ хадгалсан анхдагч цуулдас хэмээн ангилагдана. Залтасуудын дунд хайрган чулуунаас цуулсан хэд хэдэн эдлэл байна. Ялтасуудын нэг нь хоёр талтай бөгөөд үзүүр нь хугарчээ. Нөгөөх нь гадаргуугийн ихэнх хэсэгтээ чулууны өнгөн бүрхүүлээ хадгалсан хагас анхдагч цуулдасны төрөлд хамаарна. Сүүлийн эдлэл нь ялтасны дээд хэсгийн хугархай юм. Цохилтын талбайн үлдэгдэл нь холточсон оромтой бөгөөд бөмбөгөр хэлбэртэй тул леваллуагийн цуулдастай төстэй харагдана. Гэвч эдлэлийн нэг хажуу чулууны өнгөн бүрхүүлээрээ байгаа тул шууд леваллуагийн арга барилаар бэлтгэгдсэн гэхэд хэцүү. Хагархай хэлтэрхийнүүд гадаргуудаа замбараагүй хагачиж цуулсан оромтой бөгөөд ихэнх нь дундаж хэмжээтэй өөхөн чулуу юм.



Зураг 4. Рашааны ам-2. Бэлдэц



Зураг 5. Рашааны ам-2. Үлдэц хэлбэрийн эдлэл

Рашааны ам-2 дурсгалт газарт хүрзэн шалгалт хийх явцад хөрсөн доороос ямар нэг олдвор, эд өлгийн зүйл илрээгүй тул ил суурин хэмээн үзэж байна. Тиймээс чулуун зэвсгийн олдворуудын цуулалтын арга барилд үндэслэн холбогдох он цагийн асуудлыг хэлэлцэх боломжтой юм. Анхдагч цуулалтын илэрхийлэх үлдэц болон үлдэц хэлбэрийн эдлэлүүд төв рүү чиглэсэн цуулалтын арга барилыг гол болгосон бөгөөд мустьен үйлдвэрлэлийн хэв шинж ажиглагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Монгол орны нутаг дэвсгэрээс Нууруудын хөндийд орших Байдрагийн гол, Нарийн гол, Орог нуур, Аргалант, Говь-Алтайн нурууны Цагаан агуй, Олон нуур, Хойт Цэнхэр, Барлагийн гол, Манхан зэрэг олон дурсгалаас мустьен үйлдвэрлэлийн хэв шинжийг илэрхийлэх эдлэлүүд олдсон билээ.

Рашааны ам-2 дурсгалт газраас илрүүлсэн чулуун зэвсгийн олдворуудын тоо



цөөн, төрөл зүйл хязгаарлагдмал байгаа тул нарийвчилсан харьцуулалт хийхэд хүндрэлтэй байгаа хэдий ч Умард Монголын бүс нутгаас мустьен үйлдвэрлэлийн хэв шинжийг илэрхийлэх чулуун зэвсгийн олдворууд илрүүлсэн нь судалгааны хувьд чухал ач холбогдолтой билээ.

Хайгуул судалгааны явцад эртний хүний ул мөр бүхий дараагийн газрыг Рашааны амнаас урагш 4 км зайд, өргөргийн дагуу чиглэсэн нарийн хөндийн адагт, уулын ар бэлийг дагасан тариан талбайгаас илрүүлсэн.

Эндээс цөөн тооны залтас, цуулдас, цуулалт бүхий хагархай хэлтэрхийн хамт саарал өнгийн цахиурлаг занараас цуулсан зууван хэлбэрийн богиновтор цуулдасаар хийсэн хянгар олдсон. Түүний хоёр хажуугийн урт ирмэгийг үзүүр хэсэгтээ нийлэх хүртэл нүүрэн талаас босоодуу холтчин ирлэсэн байна. Уг эдлэлийг конвергент хянгарын төрөл хамаатуулан үзэж буй бөгөөд түүнтэй адил олдворууд Сэлэнгэ мөрний дунд урсгал орчмын соёлт давхарга бүхий дурсгалууд, тухайлбал Их Төлбөрийн голын хөндийн дурсгалуудын хуучин чулуун зэвсгийн эхэн болон дунд үед холбогдох давхаргаас илэрч олддог билээ. Тиймээс бид энэхүү олдворт газрын он цагийг мөн энэ хүрээлэлд хамаарна хэмээн үзэж байна.

“ГОВЬ - ТАЛ ХЭЭРИЙН БҮСИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, АНУ-ын Аризонагийн Их Сургуультай хамтран Монгол орны говь, хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн дурсгалыг судлах, тухайн үеийн аж ахуй, түүнээс үүдэлтэй ахуй амьдралын хэлбэр зэрэг энэ хир бүрхэг хэвээр буй зарим асуудлыг тодруулах зорилготой “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” эрдэм шинжилгээний төслийг хэрэгжүүлж байна.

Тус төслийн судлаачид 2015 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын шинэ чулуун зэвсгийн сууринд малтлага судалгаа хийв.

Зараа уул тэр хавьдаа ноёлог өндөр бөгөөд хад асга ихтэй учир эртний түүхийн дурсгалууд олонтой билээ. Энд чулуун зэвсгийн дурсгалт газар, “Улаан зуух” хэлбэрийн булш, хэлбэрт булш, дөрвөлжин хашлагатай намхан дараастай булшнууд, хиргисүүр, хүннү булш, Монголын үеийн булш оршуулга, он цаг тодорхойгүй чулуун байгууламжууд олон бий.

Одоогоор Зараа уул орчмоос их, бага талбайд чулуун зэвсгийн олдворууд тархсан 13 дурсгалт газар илрүүлээд байна. Эдгээрийн хамгийн баялаг олдвортой нь Ил Энгэрийн өвөлжөө орчмын дурсгалт газрууд юм.

Зараа уулын дунд хэсэгт, өвөр биед нь орших нэгэн өвөлжөөг нутгийн олон Ил Энгэр хэмээн нэрийдэх ба өвөлжөөний баруун талын намхавтар толгодын өвөр бэлээр чулуун зэвсгийн олдворууд тархсан дурсгалт газар буйг Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн хүрээнд 2013 онд илрүүлсэн.

Судалгааны үр дүнд энд хоорондоо төдийлөн холгүй орших 7 дурсгалт газар байгааг тогтоон “Зараа уул” 1-7 хэмээн тэмдэглэж баримтжуулав (зураг 1).

Чулуун зэвсгийн олдворууд намхавтар толгойн өвөр бэлийн налуу гадаргуугаар харьцангуй нягтшилтай тархсан бол толгойн орой, шилээр сийрэг байгаа нь ажиглагдсан.

Чулуун зэвсгийн олдворууд харьцангуй нягтшилтай тархсан, мөн жижиг толгойн өвөр бэлд хөрсний хурдас хуримтлагдах боломжтой хэмээн үзсэн тул 2-р дурсгалт газарт 1 x 2 м хэмжээтэй сорилын малтлагыг хоёр хэсэг газарт хийв. Мөн тухайн дурсгалт газар болон 1, 5 дугаар дурсгалт газрын хөрсөн дээрх олдворуудыг сонголтын зарчмаар түүвэрлэсэн нь чулуун зэвсгийн олдворын төрөл зүйлийн ангиллыг тодорхойлох, үйлдвэрлэлийн арга барилыг тодорхойлоход чиглэгдэж байгаа юм.

Сорилынмалтлагаас олдворуудыг зааглах хөрсний давхаргын тодорхой ялгарал мэдэгдээгүй нь 40 см орчим гүнээс өнгөн хөрс хүртэл ургасан ургамлын (дэрс) үндэсний нөлөө байж болох юм. Гэвч хөрсний бүтцэд тулгуурлан давхаргын зааг ялгааг тодорхойлов.

Малтлагын явцад чулуун зэвсгийн олдворууд, амьтны ясны жижиг хэсгүүдийн хамт 55 см гүнд хүртэл хөрсний үе, давхаргуудад хадгалагдсан нь тогтоогдсон байна. Давхаргуудаас чулуун зэвсэг цуулалтын үйл ажиллагааны дүнд бий болсон хагархай хэлтэрхий, жижиг залтас, хайрс олон тоотой илэрсэн бөгөөд анхдагч цуулалтыг илэрхийлэх олдворууд (зураг 3, 1, 2), хоёрдогч боловсруулалт хийгдсэн зэвсгийн төрөл зүйлийн олдворууд (зураг 3, 3-6, 11) цөөн тоотой гарсан байна.

Хөрсний давхаргаас илэрсэн чулуун зэвсгийн олдворуудын ихэнхийг жижиг залтас, хагархай хэлтэрхий эзэлж байгаа бол анхдагч цуулалтад хамаарах



олдвор, хоёрдогч боловсруулалт хийсэн зэвсгийн шинж төрхтэй олдвор бага хувийг эзэлнэ.

Түүвэр цуглуулгын хувьд анхдагч цуулалт болон зэвсгийн төрөл зүйл харьцангуй баялаг юм. Чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалт нь гол төлөв бичил ялтас цуулан авахад чиглэгдсэн бөгөөд үүнийг гүйцэтгэхдээ шаантган, тайрдсан, призм хэлбэрийн цуулалтын арга барил бүхий үлдэцүүдийг ашиглажээ. Мөн цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэцүүдээс богино хэмтэй, өргөн ялтас цуулан авсан ором мэдэгдэнэ.

Зэвсгийн төрөл зүйлд хусуур олон байна. Зэвсгийн төрөл зүйлд буй сонирхолтой олдвор бол ооль юм. Тэдгээрийг мод болон том амьтны ясаар хийсэн ишинд суулгаж зэвсэг болгон ашиглах ба үндсэн зориулалт нь мод боловсруулах хэмээн үзэж байна. Гүйцэд боловсруулсан зарим эдлэлийн ир элэгдсэн, гадаргуугийн зарим хэсэгт зүлгэгдэж мөлийсөн шинж тэмдэг илэрсэн нь тэдгээрийг ашиглаж байсны баримт юм. Зараа ууланд хийсэн судалгааны явцад 16 ш ооль олсон (зураг 3, 7-9, 10, 15). Ихэнх олдвор хөрсөн дээрээс олдсон бол бүрэн дуусгаагүй нэг ооль 2 дугаар малтлагын 3 дугаар давхаргаас буюу 51 см гүнээс, бүрэн зассан жижгэвтэр хэмжээтэйг өрмөн шалгалтын явцад гадаргаас 29-42 см гүнээс илрүүлсэн. Үүнээс харахад эдгээр зэвсгүүдийг неолитын эхэн үеийг дуустал ашиглаж байсан хэмээн үзэж болохоор байна.

Бидэнд байгаа материалаас үзвэл говь, тал хээрийн бүсийн шинэ чулуун зэвсгийн дурсгалуудаас иймэрхүү ооль хэлбэрийн зэвсэг мэр сэр олддог боловч нэг дурсгалт газраас олноор илэрсэн нь үгүй юм. Тиймээс Зараа уулын эртний оршин суугчдын ахуй амьдралд энэ төрлийн зэвсэг чухал үүрэгтэй байсан бололтой. Цаашдын судалгаанд бусад дурсгалт газруудаас олдсон ийм төрлийн зэвсгүүдийн түүхий эдийг харьцуулан үзсэнээр сонирхолтой үр дүнд хүрч болох юм.

Зэвсгийн бусад төрөл хутга (зураг 3, 14), хүнхэр ирт зэвсэг, цоолтуур, хатгуур, сийлүүр, сүх, үрүүл, зуулга, хоёр талт зэвсгийн хагархай, ирлэсэн цуулдас, самбар чулуу болон самбар чулууны хагархай, торны хүндрүүлэгч зэрэг байна.

Чулуун сүхийг хийсэн арга барил нь хоорондоо ялгаатай. Нэг эдлэлийг хоёр талаас нь хөндлөн болон тууш цуучиж зассан байх ба ишинд суулгах хэсгийг бэлтгэсэн бол нөгөөх нь голын усанд элэгдсэн урт мөлгөр чулууны нэг талын богино ирмэгийг холтчин хагалж ирлэсэн байна. Хоёр дахь хэлбэрийн эдлэлтэй хийсэн арга барилын хувьд адилсах сүх Баянзагийн Шавар уснаас олджээ. Мөн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Хар хадны дөрвөлжингөөс түүврээр илэрсэн ийм сүхийг судлаачид шинэ чулуун зэвсгийн үед холбогдуулан үзсэн нь бий.

Сорилын малтлагуудаас гарсан ясны дөрвөн хугархай, гурван ваарны хагархайг АНУ-ын Жеоржиагийн Их Сургуулийн Изотопын судалгааны төвд шинжлүүлсэн (хүснэгт 1). 1 дүгээр малтлагыг жижиг толгойн хормой хэсэг буюу харьцангуй их хурдас тогтож, салхинд бага үлээгдсэн хэсэгт хийсэн тул он цагийн хувьд неолитын сүүл болон төмрийн түрүү үед холбогдож байна. Бичил залтас болон бифас хэлбэрийн зэвсгүүд ваарны хагархайд хийсэн лабораторийн шинжилгээний он цагтай яв цав таарч байгаа бол төмрийн үе хэмээн гарсан ясны коллаген чулуун зэвсгийн олдворуудтай он цагийн хувьд нийцэх боломж тун бага байна. Т1-9г:1 дугаартай дээжийн лабораторийн судалгааны үр дүн тухайн дурсгалыг неолитын төгсгөл үед хамруулан үзэх боломжтойг харуулж байна.

Тухайн бүс нутагт малтан судалсан Улаан зуух хэлбэрийн булшны антропологийн хэрэглэгдэхүүнд хийсэн лабораторийн шинжилгээний дүн НТӨ 1423-1385 оны үед холбогдохыг судлаачид тодорхойлсон бөгөөд энэ нь бидний

1 дүгээр малтлагын Т1-9g:1 дугаартай дээжийн лабораторийн судалгааны үр дүнтэй ерөнхийдөө дүйж байгаа нь уг дурсгалт газрыг неолитын сүүл, Улаан зуух хэлбэрийн дурсгалын эхэн үед хамруулан үзэх боломжийг олгож байна. Энэхүү таамгийг тухайн дурсгалт газрын ойр орших Улаан зуух хэлбэрийн булшнуудын судалгааны үр дүнгээр баталгаажуулах шаардлагатай.

Хүснэгт 1. Лабораторийн судалгааны үр дүн

Лабораторийн дугаар (UGAMS#)	Дээжийн дугаар	Материал	$\delta^{13}\text{C}, \text{‰}$	C14 насжилт (BP)	$\pm$	pMC	$\pm$
22328	T1-9g:1	Шавар	-24.8	3230	25	66.84	0.21
22329	T1-9j:1*	Коллаген	-21.6	2580	25	72.55	0.22
22330	T1-9m:1	Коллаген	-21.8	1850	20	79.44	0.23
22331	T2-3b:38	Коллаген	-18.8	6990	30	41.87	0.14
22332	T2-3e:65a	Коллаген	-17.9	6620	30	43.86	0.14
22333	T2-3g:1	Шавар	-25.5	6580	30	44.05	0.17
22334	T2-3m:1a	Шавар	-18.3	5910	30	47.89	0.16
22335	J1.1TP-96	Шавар	-23.1	1590	25	82.00	0.25

2 дахь малтлагын Т2-3m:1a хэмээн дугаарласан дээж бусдыгаа бодвол харьцангуй сүүл үеийнх бөгөөд мэрэгч амьтны нүх мэдэгдсэн, цөөн тооны олдвортой 3 дугаар үеэс илэрсэн юм. 2 дугаар үеэс хөндлөн бүсэлсэн зэрэгцээ төвгөр шугамын дээд, доод талаар босоо зэрэгцээ зурааслан хээлсэн ваар (зураг 3, 12) болон олон хонхор хээтэй ваарны хагархай (зураг 3, 13) олдсон. Зэрэгцээ олон хонхор бүхий хээтэй ваарны хагархай Шавартайн булагаас олдсон ваарны хагархайтай яг адилхан. Шавартайн булагаас илэрсэн ийм хээтэй вааранд хийсэн он цаг тогтоох лабораторийн шинжилгээний дүн НТӨ 3271-3013 онд холбогдохыг заасан байна. Ваарны хээ чимэг олон мянган жил хэлбэрээ алдахгүй байж болох хэдий ч он цагийн судалгаанаас үзвэл, хоёрдугаар үеийг неолитын эхэн үеэс сүүл хүртэл буюу НТӨ 5000-3000 оны хооронд авч үзэж болохоор байна. Харин 3 дугаар үе нь дангаараа неолитын эхэн үед хамаарах бололтой.

Малтлагаас илэрсэн ясны төрлийн олдворуудын хадгалалт муу бөгөөд бүгд



жижиг хагархайнууд юм. АНУ-д эдгээр ясны дээжүүдийг илгээн лабораторийн шинжилгээ хийлгэж байгаа бөгөөд 1 дүгээр малтлагаас гарсан ясыг урьдчилсан байдлаар үхрийнх хэмээн таамаглаж байна. Гэвч лабораторийн шинжилгээний дүн харьцангуй сүүл үед холбогдохыг зааж байгааг хэлэх хэрэгтэй.


2 дугаар малтлагаас ясны жижиг хэсгүүд олон илэрсэн ч тэдгээрийг ямар амьтны болохыг бүрэн тодорхойлох боломжгүй байна. Одоогоор молтогчин, адуу эсвэл хулан, ямаа болон жижиг, дунд, том биетэй хөхтөн амьтны ясны хэлтэрхий байгааг тогтоосон.

1 дүгээр малтлагын 3 дугаар давхаргаас тал саран хэлбэрийн самбар чулуу, 2 дугаар малтлагаас самбар чулууны булангийн хагархай, хөрсөн дээрээс мөн самбар чулууны хагархай хэд хэд илэрсэн нь эндэхийн эртний оршин суугчдын ахуй амьдралд үр тариа, ургамлын гаралтай хүнс чухал үүрэгтэй байсныг илтгэнэ.

Шахалтын аргаар бэлтгэсэн хоёр талт зэвсгүүд 1 дүгээр малтлагаас хэд хэд илэрсэн бол 2 дугаар малтлагаас цөөн гарсан. Малтлагуудын радиокарбоны он цагаас үзвэл, шахалтын аргаар бэлтгэсэн бифас хэлбэрийн зэвсгүүд, ялангуяа хоёр талаас нь жигд холтчин нимгэлж бэлтгэсэн зэв неолитын эхэн үеийн төгсгөлд, эсвэл неолитын сүүл үед үйлдвэрлэлд нэвтэрсэн бололтой. Одоогийн байдлаар Зараа уулын түүвэр олдворуудын цуглуулгад ийм хэв шинжийн зэв зөвхөн нэг байгаа нь энэ хэсэг газарт неолитын сүүл үе хүртэл их түгээгүй байсан нь харагдаж байна. Бидэнд байгаа хэрэглэгдэхүүнээс үзвэл, хоёр талаас нь шахалтын аргаар засч нимгэлэн бэлтгэсэн зэвүүдийг неолитын сүүл үеэс хийж, хэрэглэж эхэлсэн бололтой. Шавартайн булагаас ингэж хоёр талаас нь боловсруулсан зэв олон олддог бөгөөд тэндэхийн ваарны дээжийн лабораторийн судалгааны үр дүн НТӨ 3271-3013 онд хамаарахыг дээр дурдсан билээ. Нөгөөтэйгүүр, Чихэн агуйн мезолитын үед холбогдох 3, 2 дугаар давхаргаас хэд хэдэн ялтсан зэв гарсан бөгөөд Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн эхэн үед холбогдох давхаргаас тэгш хэмтэй ялтасаар хийсэн зэв хоёр олдсон. Одоо бидэнд буй хэрэглэгдэхүүнээс үзэхэд, мезолит болон неолитын эхэн үед ялтсан зэв, неолитын эхэн үеийн төгсгөл, эсвэл сүүл үеэс хоёр талаас нь бэлтгэсэн нарийн хийцтэй зэв үйлдвэрлэлд нэвтэрсэн хэмээн таамаглаж байна.

1 дүгээр малтлагаас илэрсэн шавар ваарны хагархайд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзвэл, Зараа уулын Ил Энгэрийн өвөлжөө орчмын чулуун зэвсгийн дурсгалыг үлдээсэн эртний оршин суугчид тухайн бүс нутгийн Улаан зуухын дурсгалыг үлдээгчдээс өмнөхөн, эсвэл нэг цаг үед амьдарч байсан хэмээн үзэж болох юм.


Энэ оны хээрийн судалгааны үр дүнд тухайн дурсгалт газар неолитын эхэн үеэс төгсгөл үе хүртэл хүмүүс суурьшин амьдарч байсныг лабораторийн судалгааны үр дүнгээр баталгаажуулсан бөгөөд соёлт давхаргатай суурин гэдгийг тогтоолоо. Цаашдын судалгааны явцад тухайн дурсгалт газар болон бусад чулуун байгууламжит дурсгалуудын хооронд холбоо хамаарал бий эсэх, энэхүү суурин нь уур амьсгалаас үүдэлтэй улирлын чанартай эсэх зэрэг асуултуудын хариуг хайх юм.



Зураг 1. Зараа уулын Ил Энгэрийн чулуун зэвсгийн дурсгалт газруудын бүдүүвч



Зураг 2. Зараа уулын Ил Энгэрийн чулуун зэвсгийн 2 дугаар дурсгалт газар (хойд талаас)



Зураг-3. 1, 2 - үлдэц; 11-хутга (2 дугаар сорьц малтлагын 2-р давхарга); 3-цоолтуур; 4-бифасны хугархай; 5-зуулга; 6-хатгуур (1 дүгээр сорьц малтлагын 3-р давхарга); 7, 8, 9- ооль (2 дугаар дурсгалт газрын түүвэр цуглуулга); 10, 15-ооль (6 дугаар дурсгалт газрын түүвэр цуглуулга); 12, 13 - ваарны хагархай (2 дугаар сорьц малтлагын 2-р давхарга)

ИХ НАРТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛЫГ БҮРТГЭН СУДЛАХ МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН ЭКСПЕДИЦИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮНГЭЭС

*Я.Цэрэндагва, Ж.Шнейдер, А.Розен, Ж.Фаркухар,
С.Далантай, П.Хадел, С.Гиллиланд, Р.Төрбат, Г.Олзбаяр*

Удиртгал

Их Нартын Байгалийн Нөөц газрын (ИНБНГ) археологийн дурсгалыг бүртгэн судлах ажил 2010 оноос эхэлсэн. Энэ хугацаанд тухайн Байгалийн нөөц газраас олон зуун археологийн дурсгалыг илрүүлэн олж бүртгэл мэдээллийн сан болон судалгааны эргэлтэд оруулжээ.

Энэ жилийн хээрийн шинжилгээний ажил зургаадахь удаагийнх болж байгаа бөгөөд олон тооны судлаачид, сайн дурын археологичид оролцон ажилласнаараа онцлог юм. 2015 оны хээрийн судалгааны ажил хоёр үе шаттай явагдсан.

Хээрийн шинжилгээ судалгааг 6-р сарын 1-14, 06-р сарын 24-07 сарын 04-ны хооронд хоёр ээлжээр 20 хоногийн хугацаагаар хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, дэд профессор Я.Цэрэндагва, эрдэм шинжилгээний ажилтан С.Далантай, УБИС-ийн багш Р.Төрбат, МУИС-ийн магистрант Г.Олзбаяр, ИНБНГ-ын соёлын өвийн хамгаалагч Ц.Чойбалсан, АНУ-ын Калифорни мужийн Үндэсний Паркын археологич дотор, Ж. Шнейдер, Техасын Их сургуулийн проф. А.Розен, археологич Ж.Фаркухар, П.Хадел, С.Гиллиланд нар болон бусад 19 сайн дурын судлаач нар оролцон ажилласан байна.

Археологийн судалгаа, шинжилгээ

Хээрийн шинжилгээний ажил хайгуул болон малтлага гэсэн үндсэн хоёр чиглэлээр ажиллаа. Эхний ээлжийн баг хайгуулын ажлыг түлхүү хийж гүйцэтгэсэн бол хоёрдахь ээлжийн баг малтлагын ажилд гол анхаарлаа хандуулсан юм. Хайгуул судалгааны ажилд урьд өмнөх жилүүдэд хэрэглэж байсан шугаман хайгуулын аргыг хэрэглэв. Энэхүү аргаар 5 хэсэг газарт хайгуул хийж олон тооны түүвэр олдворыг илрүүлэн, сонголтын зарчмаар зарим олдворыг түүвэрлэсэн юм. Мөн энгийн самналт, ганцаарчилсан хайгуулын хайгуулын аргыг хэрэглэв. Илэрч олдсон булш, чулуун байгууламжуудын хэмжилтийг археологийн бүртгэлийн стандартын дагуу хийж гүйцэтгэлээ.

Хайгуулаар илэрч олдсон дурсгалууд

Хайгуул судалгааны дүнд Бургастайн аманд чулуун зэвсгийн суурин - 1, хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед холбогдох булш - 1, тахилын байгууламж – 3; Хуурай аманд чулуун зэвсгийн суурин - 1, ваарны хагархай бүхий эртний бууцны үлдэгдэл - 1, Монголын үед холбогдох булш - 1, Шинэ-Усны аманд чулуун зэвсгийн суурин - 2, Их бор хэмээх газарт чулуун зэвсгийн суурин - 1, дөрвөлжин булш - 5, Хүйтний өвөлжөөнд чулуун зэвсгийн суурин – 1, дөрвөлжин булш - 4 олж илрүүлэн баримтжууллаа. Мөн ганцаарчилсан хайгуулыг хоёр удаа хийж хиргисүүр - 4, дөрвөлжин булш – 8, дугуй дараастай булш – 3, хөшөө чулуут чулуун байгууламж – 2, чулуун байгууламж – 1, хөшөө чулуу – 4, түрэгийн тахилын хашлага бүхий цогцолбор дурсгал -1 тус тус илрүүлэн бүртгэн баримтжууллаа.

Нарийвчилсан шугаман хайгуулыг нийт 5 талбайд хийснээс бүх газарт тодорхой хэмжээгээр дурсгал илэрч бидний бүртгэлийн санг баяжуулсан. Их Нартын Байгалийн Нөөц газарт неолитын үеийн чулуун зэвсгийн дурсгал газрын



хөрсөн дээр маш арвин тархсан ил суурингууд их байгаа нь байгаль, газарзүйн өвөрмөц тогтоцтой холбоотой. Дээрх суурингуудаас чулуун зэвсгийн зэрэгцээгээр вааран савны хагархай, төмөр эдлэлийн хэсгүүд илэрч олдож байна.

Малтлага судалгаа

Судалгааны анги ажиллах хугацаандаа сорилын малтлага - 2, том малтлага -1-ийг хийж гүйцэтгэв.

1-р сорилын малтлага: Хуурай амны урд дэнжид байрлах боржин хаднуудын хойш харсан аманд дугуй хүрээ бүхий ил галын ором мэдэгдэнэ. Тус газарт 200 х 180 см хэмжээтэй малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэлээ. 20 см гүнд байгалийн хөрс мэдэгдэх учир малтлагын ажлыг дуусгалаа.

2-р сорилын малтлага: Бургасны амны адагт сайрын эрэглэсэн хэсэгт (101-р дурсгалт газрын ойролцоо) хөрсний давхарга зүйг тодруулах зорилгоор бага хэмжээний сорилын цэвэрлэгээ хийж гүйцэтгэв. Цэвэрлэгээний дүнд хөрсний гурван давхаргатай болох нь тодорхой мэдэгдсэн бөгөөд ямарваа нэгэн археологийн дурсгал илрэн олдоогүй тул малтлагыг өргөжүүлэн үргэлжлүүлэлгүй зогсоов.

Чулуун зэвсгийн суурингын малтлага судалгаа: Бургасны амны эх Бургасны энгэрт байрлах 28-р суурин (IKH-28)-дөргөрөгийн дагуу сунасан дөрвөлжин хэлбэртэй хоёр чулуун байгууламжийг эхний ээлжийн хайгуулын явцад буюу 6-р сарын 3-ны өдөр олж илрүүлэн бүртгэн баримтжуулсан. Тус байгууламжийг хүний гараар бүтсэн байгууламж мөн эсэхийг шалгах зорилгоор зүүн урд талын буланг дайруулан 5х5 м хэмжээтэй тэг татан малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Малтлагыг 10 см гүнтэйгээр үечлэн явуулсан. Хэмжилтийн тулгуур цэг (0)-ийг зүүн урд буланд авсан.

Малтлагын 1-р үе 1А, 1В өргийн заагаас хүрэн өнгөтэй, гадна талдаа ташуу хайрага, ёроол хэсгээрээ олон тооны дусал, амсар хэсгээрээ сөөлжир чагтан хээг тодорхой зайтай сийлсэн, бөөрөн хэсэгт нь нүхэлсэн нягтрал сайтай шавар ваарны амсар болон хагархай илэрсэн. 1-р өргийг малтаж дууссаны дараагаар дараагийн өргүүдийг бүтэн талбайгаар нь 10 см гүнд малтлагыг үргэлжлүүлсэн. Шороог шигшиж гарсан олдворуудыг тухайн төвшинд нь хэмжилт хийж олдворын уутанд хийж авах арга зүй зарчмаар малтлагыг явуулж байв. Дээр дурдсан ваарны хагархай 7 өргөөс 18 см гүнээс дахин гарсан. Энэ мэтчилэн 10 см гүнээр үечлэн малтахад хамгийн гүн хөрсөн давхаргатай хэсэг нь 25-р өрөг хамгийн гүн хөрсөн давхаргатай (120 см) байв. (зураг 4-7)

Өмнөх чулуун байгууламжийн зүүн хана 7, 8, 9, 10 өргүүдэд, урд хана 11, 12, 17, 22-р өргүүдэд, баруун талын ханын хэсэг 23 өрөгт тус тус мэдэгдэнэ. Ханын өндөр 35-40 см, өргөн 50 см орчим юм. 2, 4, 5-р өргүүдэд малталт хийгээгүй. Зарим өргүүдийг малтан судлахад байгалийн эх хөрс 15-20 см гүнд мэдэгдэх учир бид ярилцан малтах шаардлагагүй хэмээн үзсэн.

Дээрх чулуун байгууламж нь хүний гараар бүтсэн байгууламж гэдэг нь тодорхой. Харин ямар зорилгоор барьсан бэ? гэдэг нь малтлагын ажил бүрэн дуусаагүй учир тодорхойлоход бэрхшээлтэй байна.

Малтлагын явцад бид 25 өргөөс 466 ш олвор хэрэглэгдэхүүн гарсан. Тэдгээрийг төрөл зүйлээр нь ангилан ялгавал: анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэл нэг байгаа нь тайрдсан үлдэц юм. Зэвсгийн төрөл зүйлийг дөрвөн эдлэл илэрхийлнэ. Үүнд зуулга ир 2 ш, хусуур 1 ш, шөвөг 1 ш тус тус бий. Бусад чулуун зэвсгийн хувьд үйлдвэрлэлийн хаягдал болох хэлтэрхий, ялтас, ялтасны хугархай, хагархай давамгайлна.

Малтлагаас ваар савны хагархай 9 ш илэрч олдов. Энэ нь нарийн ширхэгтэй

хүрэн шавраар хийсэн шатаалтгүй ваарны хагархайнууд юм. Цуулдасны үйлдвэрлэлийг илэрхийлэх эдлэл нэлээд их тоотой байна. Үүнд цуулдас 2 ш, ялтас 293ш, залтас 37, хэлтэрхийнүүд 129 ширхэг байна.

Анхдагч цуулалт

Тайрдсан үлдэц: Шаргал өнгөтэй цахиур чулууг түүхий эд болгон үйлджээ. Хөндлөн болон ташуу цуулалтын аргаар бэлтгэсэн, ар тал руугаа бага зэрэг налсан цохилтын талбайтай. Эх биеийг тойруулан зөв цуулалтад хутган ялтас цуулсан ажээ. Үзүүр хэсгээс тайралт хийсэн оромтой. Хэмжээ нь 1, 5х 1 х 0,7 см.

Зэвсгийн төрөл зүйл

Зуулга ир (2 ш): Эхний зэвсгийг хүрэн өнгөтэй цахиур чулуунаас цуулсан урт хутган ялтасыг ашиглан үйлджээ. Ялтасны хоёр захын хажууг хөндлөн цуулалтын аргаар холтчин боловсруулж ирийг бэлтгэжээ. 4,2 х 0,4 х 0,2 см хэмжээтэй. Дараагийн зэвсгийг цагаан өнгөтэй цахиур чулуун ялтас ашиглан үйлдвэрлэжээ. Ялтасны хоёр хажуу захыг хөндлөн холтчиж гол хэсгийг төвийлгөн бэлтгэсэн байна. Хэмжээ нь 2,1 х 0,6 х 0,2 см.

Хусуур: Саарал хас чулуугаар бэлтгэсэн. Нэг хажуугийн буланг холтчин нарийн гаргасан. Ар тал нь цохилтын төвгөр төдий мөлгөр. Хэмжээ нь 1,7 х 1,4 х 0,3 см.

Шөвөг: Тунгалаг манан залтас ашиглан хийсэн. Залтасны өргөн талыг хоёр зах руу холчин нарийн шовх үзүүрийг гаргажээ. 1,2 х 1 х 0,3 см хэмжээтэй.

Цуулдасны үйлдвэрлэл

Цуулдасны үйлдвэрлэлийг илэрхийлэх эдлэл нэлээд их тоотой байна. Үүнд цуулдас 2 ш, ялтас 293 ш байгаагаас бүтэн 13 ш, үзүүр хэсгийн хугархай 80 ш, дээд хэсгийн хугархай 78 ш, дунд хэсгийн хугархай 122 ш залтас 37 ш, хэлтэрхийнүүд 129 ширхэг байна.

Ваар сав.

Ахуйн хэрэглээний ваар савны үлдэгдлүүд нь нарийн ширхэгтэй хүрэн шавраар хийсэн шатаалтгүй, түүхий шавраар хийсэн ваарны хагархайнууд юм. Зарим нь гадаргуудаа хөндлөн болон ташуу хэлбэртэй хумсаар дарсан мэт зураасан хээтэй. Хажуу бөөрөн дээрээ нүхтэй.

Товч дүгнэлт

Манай судалгааны багийн хамт олон Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, судлах, хамгаалах зорилтоо амжилттай биелүүлэн судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Тус газрын байгаль, экологийн өвөрмөц тогтоц нь монголчууд бидний өвөг дээдсийн хэдэн үе улиран нутаглахад нөлөөлсөн гэлтэй. Тиймээс үе үеийн археологийн дурсгалаар баялаг болох нь сүүлийн 6 жил явуулсан судалгаагааны ажлын явцад тодорхой харагдана. 2015 оны хайгуул судалгааны ажлын үр дүнг дараах байдлаар товч дүгнэж байна. Үүнд:

Бид тусгай хамгаалалттай бүс нутгийн археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах үүднээс хамгаалалтанд байх газрын төв хэсгийн таван газрыг сонгон авч нарийвчилсан шугаман хайгуулын ажил хийлээ. Эдгээр газруудад бүгдэд нь чулуун зэвсгийн суурин, хоёр газар цөөн тооны дөрвөлжин булш, монгол булш, хүрэл зэвсгийн үед холбогдох булш, хиргисүүр, хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн бууцны үлдэгдэл бололтой ваарны хагархайн тархалт бүхий газар, түрэгийн тахилын цогцолбор байгууламж, хөшөө чулуут чулуун байгууламж, хөшөө чулуу



зэрэг олон арван дурсгалыг илрүүлэн баримтжуулалт хийсэн.


Шугаман хайгуул хийсэн таван газрын чулуун зэвсгийн суурингуудын хоёр нь палеолитын үед холбогдох олдвор хэрэглэгдэхүүнтэй. Энэ нь палеолитын үеэс эртний хүний улбааг хөндөн ярих болцоог дахин олгож байна.

Мөн тус бүс нутагт неолитын үеийн овог аймгуудын амьдрал эрчимтэй өрнөж байсныг шигүү тархсан чулуун зэвсгүүдээс харж болно.

Тус бүс нутаг дахь хүй нэгдлийн үеийн хүмүүсийн аж ахуйн хөгжлийн онцлогыг харуулах үр тариа цайруулах самбар чулуу дахин шинээр хэд хэд олдсон нь цаашдаа тус бүс нутагт газар тариалангийн аж ахуй эрчимтэй хөгжиж ирсэн үү? эсвэл түүвэрлэх аж ахуйн хөгжил оргил цэгтээ хүртэл хөгжсөн үү? гэдгийг тодруулж өгөх чухал олдвор юм.

Талархал

Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг судлах ажлыг бүх талаар дэмжин тусалсан ШУА-ийн дэд ерөнхийлөгч Т.Галбаатар, Денверийн Зоологийн сангийн ажилтан Р.Рыдынг, Денверийн Зоологийн сангийн Монголын хөтөлбөрийн захирал Ж.Ганчимэг, Монголын ховор амьтныг хамгаалах эвслийн гүйцэтгэх захирал Т.Сэлэнгэ, ИНБНГ-ын Хамгаалалтын захиргааны дарга С.Амгаланбаатар, байгаль хамгаалагч Ц.Чойбалсан, ИНБНГ-ийн Хамгаалалтын захиргаа, Судалгааны төвийн нийт судлаачид, байгаль хамгаалагчид, жолооч нар, хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлэхэд таатай байна.



Зураг 1. Хайгуул судалгааны явцад илэрч олдсон сумны зэв, үлдэцүүд



Зураг 2. Хайгуул судалгааны явцад илэрч олдсон
а) гилбэр, б) хутга, в) сүх, г) төмөр зэв



Зураг 3. 1-р сорьц малтлагын явц



Зураг 4. Хадны зургийн дурсгалт газар



Зураг 5. Малтлага



Зураг 6. Малтлагын талбайн хамгийн
гүн хэсэг болох 25-р өрөг



Зураг 7. Чулуун өрлөгийн нурсан байдал



Зураг 8. Малтлагын явцад илэрсэн чулуун өрлөг



Зураг 9. Малтлагын нөхөн сэргээлт

**“ХОТОН НУУРЫН ХӨНДИЙН ХАДНЫ ЗУРГИЙН СУДАЛГАА”
ЭКСПЕДИЦИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН**

Я.Цэрэндагва, Р.Кортум, Б.Жаргалсайхан

Удиртгал

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт Хотон нуурын хойд хөвөөнд орших Далан Түргэний хос толгой, Арцат уулын хадны зургийн судалгааны ажлыг Монгол-Америкийн хамтарсан судалгааны анги 2004 оноос явуулж ирсэн эхэлсэн түүхтэй¹. Улмаар 2007, 2011, 2012, 2014 онуудад хамтарсан судалгааны анги ажиллаж дурсгалын байршил зүйг тогтоох, бүртгэн баримтжуулах, хадны зургийн хуулга хийх, геологийн тогтоцыг судлах, хадны зураг бүхий уулын эргэн тойрны археологийн бусад төрлийн дурсгалыг бүртгэх, малтах зэрэг ажлыг шат дараалалтай хийсээр иржээ².

2010 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал доктор Д.Цэвээндорж, археологич Я.Цэрэндагва, ШУА-ийн Баян-Өлгий аймаг дахь Нийгэм эдийн засгийн судалгааны төвийн ажилтан Б.Өмирбек нарын зэрэг судлаачид Далан Түргэний хос толгойн хадны зургийн дурсгалыг судалж, холбогдох хуулбарыг хийж гүйцэтгэсэн байна.

2015 оны хээрийн шинжилгээ

Хээрийн шинжилгээг 2015 оны 7-р сарын 5-11-ний хооронд 7 хоногийн хугацаатай АНУ-ын Мэйн Их сургууль, ШУТИС-ийн хамтарсан мөстлөгийн судалгааны экспедицтэй хавсран гүйцэтгэв.

Мөстлөгийн судалгааны экспедицийн судалгааны ажлын гол зорилго нь Монгол Алтайн нурууны мөстлөгийн он цаг, хамарч байсан хүрээ, хил хязгаарыг тогтоох явдал юм байна. Тус экспедицийн Монгол Алтайн нуруу тэр дундаа Даян нуур, Хотон, Хурган нуурын орчим дахь судалгаа 2014 онд анх эхэлсэн бөгөөд мөстлөгийн үлдэгдэл болох морены боржин бул үхэр хаднуудаас олон тооны дээж авч он цагийг амжилттай тогтоосон байна. Тэдний судалгааны үр дүнд Хотон нуурын энэ бүс нутагт 18 000 жилийн өмнө мөстлөг нэгэнт дууссан байсан болох нь тодорхой болсон ажээ. Энэ нь бүс нутагт мөстлөгийн өмнө болон мөстлөгийн дараах тухайн бүс нутгийн эртний хүмүүсийн амьдралын хэмнэлийг багцаалахад үнэлж баршгүй ач холбогдолтой он цаг тогтоолт юм.

Энэ жил тус экспедицийн бүрэлдэхүүнд АНУ-ын Колумбын Их сургуулийн профессор Т.Лиу (Tanzhuo Liu) оролцон ажилласан бөгөөд тэрээр хадны гадаргуу дээр тогтсон бор өнгийн гялтгаас (говийн гандаас) /англиар “varnish”, оросоор “пустинный загар”/ дээж авч он цаг тогтоох судалгааг лабораторийн нөхцөлд хийх зорилготой байв.

¹ R.Kortum, Z.Batsaikhan, K.Edelkhan, J.Cambrell. An another new petroglyph complex in the Altai mountains, Bayan-Ulgii aimag, Mongolia: Biluut 1, 2 and 3 // International newsletter on rock art. №41. 2005. pp. 7-14

² R.Kortum, J. Franklin, M. Whitelaw, J. Nave, Ya.Tserendagva. Archaeological Explorations of Biluut 1, 2, and 3: An Extensive Petroglyph and Burial Complex in the Altai Mountains of Mongolia // 73RD Annual Meeting of the Society for American Archaeology, March 26-30, 2008, Vancouver, BC, Canada; Я.Цэрэндагва, Р.Кортум. Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедицийн Баян-Өлгий аймгийн Толбо, Цэнгэл сумын нутагт хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан. ТАХ-БМТ. УБ., 2006; Я.Цэрэндагва, Р.Кортум. Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедицийн Баян-Өлгий аймгийн Толбо, Цэнгэл сумын нутаг Билүүтэд хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан. ТАХ-БМТ. УБ., 2008; Я.Цэрэндагва, Р.Кортум, Б.Жаргалсайхан. 2014 онд Хотон нуурын Далан Түргэний хос толгойд хийсэн хадны зургийн судалгаа // Монголын археологи-2014. УБ., 2015. Тал 46-51.



Манай судалгааны ангийн америк судлаач, доктор Р.Кортум өмнө нь энэ экспедицийн судлаачидтай АНУ-д байхдаа хэд хэдэн удаа уулзаж судалгааны арга барил, зорилго чиглэлээ ярилцаж байсан бөгөөд энэ удаад хадны зургийн дурсгал дээр тогтсон өнгө гялтгаас (говийн гандаас) дээж авч болох боломжийн талаар газар дээр нь дурсгалаа үзэж, манай талтай (Монголын) хамтарсан зөвшилд хүрвэл өнгө болоод хэв шинжийн хувьд харилцан адилгүй хэд хэдэн газраас дээж авахаар тогтсон бөгөөд он цаг тогтоох энэ төрлийн дээж авах нь энэ жилийн судалгааны ажлын гол зорилт байлаа.

Хадны зургийн дурсгалтай газар дээр нь танилцсан профессор Т.Лиугийн дүгнэлтээр хадны зургийн дээр он цаг тогтоох дээж авч болохуйц хангалттай өнгөр гялтга тогтсон болох нь батлагдсан юм. Судалгааны багийн гишүүд ямар байдлаар дээж авах, хадны зургийн дурсгалд хэрхэн нөлөөлөх, хэрэв хадны зургийн дурсгалд хэтэрхий хор хөнөөлтэй бол дээж авах боломжгүй зэргийг сайтар ярилцаж газар дээр нь дээж авах туршилт зэргийг хийж үзсний үндсэн дээр энэхүү судалгааны аргыг хэрэглэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Дээжийг гар өрмөөр хадны зурагт тогтсон цэг хэлбэрийн өнгөр гялтга дээр 0,4-0,5 мм хэмжээтэй голдоо нүхтэй, алмазан хушуутай өрөм ашиглан өрөмдөж 0,5 мм хиртэй гүн ухаж дээжээ авдаг ажээ. Дараа нь гарсан нүхийг хадны зураггүй ижил төрлийн өнгөтэй хаднаас мөн өрөмдөн авч бөглөдөг юм байна. Т.Лиу бол энэ төрлийн судалгаа хийдэг нэртэй эрдэмтэн бөгөөд 20 орчим жил судалгаа хийж байгаа ажээ.

Авсан дээжээ лабораторийн нарийн шинжилгээнд оруулж уг өнгөр гялтгад үлдэж хоцорсон органик үлдэгдлийг шинжлэх замаар он цагийг тогтоодог. Энэ аргыг анх Аризонийн Их сургуулийн профессор Р.Дорн 20 гаруй жилийн өмнөөс судалгаанд хэрэглэх саналыг гаргаж, судалгаа хийгдэж эхэлжээ. Хадны өнгөр гялтга нь бичгийн цаастай адил зузаантай байдаг бөгөөд микроскопын тусламжтайгаар түүний үеийг тогтоон, найрлага дахь органик үлдэгдлийг шинжлэх замаар он цаг тогтоох үйл ажиллагаа хийгддэг нарийн явц бүхий он цаг тогтоох арга юм. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр нь Varnish Micro Lamination (VML) буюу монголчилбол өнгөр гялтагын бичил үе гэсэн утгатай.

Далан Түргэний хос толгой, Арцат уул, Хүйтэн голын цутгал орчим зэрэг нийт хадны зургийн 4 цогцолбор газраас сонголтын зарчмаар дээж авахаар тогтов. Хэдий хадны зургийн тодорхой хэсэгт нүх гарах замаар анхдагч шинжид нь өөрчлөлт орох боловч хадны зургийн дурсгалын он цаг тогтоолтыг шууд тогтоох арга учир дээж авахуулах нь зүйтэй хэмээн үзсэн юм. Дээрх авах дээжээс хэрэв он цаг тодорхой гарвал эргээд Монголын хадны зургийн төдийгүй Төв, Дундад Ази, Сибирь, Уулын Алтайн хадны зургийн судалгаанд чанарын үндсэн эргэлт гаргах ч ач холбогдолтой юм.

Судалгааны ажлын хүрээнд 4 хадны зургийн дурсгалт газрын долоон хадны зургаас дээж авсан юм. Хадны зургийг сонгохдоо дүрслэлийн онцлог, өнгөр гялтга тогтсон байдал зэргийг харгалзан үзсэн болно.

Дээж авсан хадны зургийн дурсгалууд

1) Урт Хүйтэн голын цутгалд буй хадны зургын дурсгалаас хамгийн эртний өнгөр гялтаас тогтсон гэж үзсэн хоёр хадны зургаас дээж авав.

1-р хадны зураг. Урт Хүйтэн голын цутгалын баруун дэнжид байгаа бор саарал өнгийн боржин цул хадны зүүн үзүүрт зурагдсан хоёр аргаль, түүний дээд талд янгир, морь, хадны төв хэсэгт том гахай, түүнийг араас нь ноцож буй чоно гэсэн амьтдын дүрслэлтэй (зураг 1, 3).

Хадны зураг бүхий хад нь энэ дэнж дээр буй мөстлөгөөс үүдэлтэй морены цул

боржин хаднаас өнгө, бүтцийн хувьд эрс өөр байгаа онцлогтой аж.

Хоёр аргаль, янгир, гахай, дээд талын нарийн хавтгайд дүрсэлсэн янгир зэргээс нийт 8 дээж авав.

2-р хадны зураг. Хотон нуур уруу түрж орсон тохойн хойд дээрх голоороо хоёр хуваагдсан том үхэр боржин хадны баруун дор буй хавтгай хадан дээрх олон тооны зургуудаас хоёр хүн, нэг аргалийн дүрслэл дээрээс дээж авлаа. Дээжний голч - 0,5 мм. Гүн - 0,5 мм. Хадны зургийг бага гэмтээх үүднээс хүний дүрсний хөлний үзүүр, гарын дээд хэсэг, аргалийн хондлой гэх мэт газруудаас дээжлэв.

Төрөл	Үлдэц	Кварцитан зэвсэг	Цоолтуур	Иртэй залтас	Сийлүүр	Хянгар	Хусуур	Хагархай	Залтас	Ялтас	Сегментэн цуултас
Тоо	4	1	1	2	1	2	1	1	12	2	2

2) Далан Түргэний хос толгойн баруун толгойн хоёр хэсэг газраас дээж авсан болно.

3-р хадны зураг. Толгойн урд бэл, Хотон нуурын эрэгт байх том хавтгай хаданд буй олон тооны хадны зургаас сонголтын зарчмаар морь, буга хоёрын дүрсэн дээрх өнгөр гялтгаас дээж авав. Мөн л морины хондлойн дээд тал, янгирын эврийн үе зэргээс дээж авав.

4-р хадны зураг. Толгойн зүүн хажуугийн хамар дээр байх олон зургаас өвөрмөц нэгэн дүрснээс (зарим судлаачид бөөгийн дүрс хэмээн үздэг) ганц дээж авав. Мөн л 0,5 мм-ийн голчтой өрмөөр 0,4 мм өрөмдөж дээжлэв.

3) Далан Түргэний хос толгойн зүүн толгойн хадны зургийн дурсгалаас хоёр газрын зургийг сонгон дээж авсан болно.

5-р хадны зураг. Энэ хаднаа загварчилсан буга, морьтон, янгир, үхэр, буга, аргаль, морь, нохой, үл танигдах амьтдын дүрслэл, элдэв дүрс зэрэг нийт 60 орчим дүрслэлтэй. Тэдгээрийн нэг болох загварчилсан бугын дүрслэлээс нэг дээж авав.

6-р хадны зураг. Хоёр толгойн голын хөндийн зүүн тал, зүүн толгойн бэлд байх олон тооны том морьтны дүрслэл бүхий хадны зургийн нэг том мориноос дээж авсан.

4) Арцат уул.

7-р хадны зураг. Арцат уулын урд хамар дээрх зургаас гурван аргаль, нэг хүний дүрс бүхий зургийн зүүн талын аргалийн дүрснээс дээж авсан болно.

Хадны зургийн дээж авах шинжилгээний зэрэгцээгээр чулуун зэвсгийн гүймэг хайгуулыг Хүйтэн голын цутгалын орчимд хийхэд 29 тооны чулуун зэвсгийн дурсгал илрүүлэн олж байршлыг GPS багажаар тодорхойлон, бичвэр үйлдэн түүвэрлэн цуглуулав. Дээрх чулуун зэвсгүүд нь төрөл зүйлийн хувьд дараахь байдлаар ангилагдаж байна.

Товч дүгнэлт

Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедицийн 2015 оны хээрийн судалгаанаас дараах үр дүнд хүрлээ.

- Монголд анх удаа хадны зургийн он цагийг шууд тогтоох аргыг амжилттай



туршиж, тодорхой тооны хадны зургаас он цаг тогтоох дээж авлаа. Энэ судалгаа Монголын төдийгүй Төв Ази, бусад бүс нутгийн хадны зургийн он цаг тогтоох судалгааны тулмагдсан олон асуудлыг шийдвэрлэхэд зохих хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.


- Хотон нуурын эрэг дагуух бүс нутагт палеолитын үеийн дээд шатны өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий чулуун зэвсгийн үйлдвэрлэл эрхэлдэг эртний хүмүүс (*Homo sapiens*) нутаглаж байсныг тодруулах чухал ач холбогдол бүхий чулуун зэвсгийн бууц илрүүлэн олов.




1-р зураг. Дээж авсан нэг дэх хадны зураг
(Урт Хүйтэн голын цутгал)




2-р зураг. Проф. Т.Лиу дээж авч байгаа нь



3-р зураг. Дээж авсан хадны зураг



4-р зураг. Дээж авсан хоёр дахь хадны зураг
(Урт Хүйтэн голын цутгал)




5-р зураг. Хүний дүрсний хөлийн үзүүрээс дээж авсан байдал (Урт Хүйтэн голын цутгал)



6-р зураг. Аргаль, хүний гарын үзүүр зэргээс дээж авсан байдал (Урт Хүйтэн голын цутгал)



7-р зураг. Дээж авсан гурав дахь хадны зургийн өнгө гялтгын байдлыг шалгаж байгаа нь (ДТХТ-I)




8-р зураг. Дээж авсан бугын дүрслэл (ДТХТ-I)




9-р зураг. Гуравдахь хадны зургийн дээж авсан адууны дүрслэл (ДТХТ-I)



10-р зураг. Дээж авсан тав дахь хадны зургийн хэсэг (ДТХТ-II)



11-р зураг. Дээж авсан бугын дүрслэл (ДТХТ-II)



12-р зураг. Дээж авсан зургаадахь хадны зургийн хэсэг (ДТХТ-II)



13-р зураг. Дээж авсан морины дүрслэл
(ДТХТ-II)



14-р зураг. Дээж авсан аргалийн дүрслэл
(Арцат уул)



15-р зураг. Урт Хүйтэн голын цутгалын орчмоос
олдсон палеолитын үлдэц



16-р зураг. Урт Хүйтэн голын цутгалын орчмоос
олдсон палеолитын хянгар зэвсэг



17-р зураг. Урт Хүйтэн голын цутгалын орчмоос
олдсон палеолитын ялтас



18-р зураг. Урт Хүйтэн голын цутгалын орчмоос
олдсон палеолитын хусуур зэвсэг

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН “БАРКОР” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга, У.Бросседер

Монгол-Германы хамтарсан “Баркор” төслийн хээрийн шинжилгээний анги 2015 оны 08-р сарын 19-нөөс 09-р сарын 25-ныг хүртэл нийт 37 хоног Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутаг, Майхан толгойн дурсгалт газарт малтлага судалгаа хийснээс гадна орчмын бусад дурсгалын агаарын зургийг авч гүймэг хайгуул судалгаа хийв. Мөн Орхон голын өмнөд эрэгт нь орших Ар булан хэмээх газарт Хүннүгийн үед холбогдох 10 булштай оршуулгын газарт хэмжилт хийсний зэрэгцээ агаарын зураг авч баримтжуулсан байна (Зураг 10). Агаарын зургаас Майхан толгойн дурсгалт газрын орчим, Орхон голын савд хожим газар хагалж тариа тарьж байсан (Зураг 11) болохыг тогтоож улмаар хайгуул судалгаагаар тээрмийн чулуу, түвд бичээс сийлсэн чулуу зэргийг илрүүлсэн юм. Тэдгээрээс гадна Майхан толгойн хойд талд орших хаднаа тамга тэмдэг, цөөн тооны үг сийлсэн монгол бичээс байсныг олж баримтжууллаа (Зураг 8, 9).

Малтан судалсан хоёр булшнаас оршуулга илэрсэн бөгөөд тахил өргөсөн малын яс, дараасан дундаас чулуун эдлэлийн хугархай зэрэг гарсан бол тахилын байгууламжаас богийн дал, хавирганы яс зэрэг эрт цагт тахил тайлгын зан үйлийн ул мөр илэрсэн. Мөн Майхан толгойн оршуулгын газрын баруун талаар цувуулж зоосон чулуун зураг илрүүлэн хэмжиж баримтжуулав. Үүнийг тахилын байгууламж эсвэл оршуулгын газрын хязгаарыг тодорхойлсон хүрээ хэмээн урьдчилсан байдлаар үзэж байгаа юм.

Малтлага судалгаа

Майхан толгойд малтан судалсан дурсгал нь дөрвөн хөшөөт (5-р булш) болон дугуй хэлбэрийн намхан чулуун дараастай булш (21-р булш), зүүн урд буландaa хөшөө чулуу бүхий дөрвөлжин хашлагат тахилын байгууламж (87-р дурсгал) байв.

5-р булш нь гадаад зохион байгуулалтын хувьд дөрвөн хөшөөт (Сагсай хэлбэрийн) булшны төрөлд хамаарах мэт боловч нас барагчийн толгойг чанх хойд зүгт хандуулан зүүн хажуугаар нь тавьсан байхаас гадна дараасны зүүн хойд булангаас бодын, зүүн урд булангаас богийн чөмөгний яс, модны нүүрс гарсан зэрэг оршуулга, тахилгын зан үйлийн өвөрмөц шинжүүд илэрсэн (Зураг 1, 2).


21-р булш нь хэмжээгээр харьцангуй том буюу 21 метр голчтой, том чулуугаар дугуй хүрээ хийж голын зайг том чулуугаар дүүргээд дээрээс нь жижиг чулуугаар чигжиж гадаргууг тэгшилсэн байв. Зохион байгуулалтын хувьд дараасны голд том чулуугаар хашлага мэт хүрээ үйлдсэн ч хашлага дотор бус түүний зүүн талд хавчиг, гүехэн нүх ухаж нас барагчийг оршуулсан нь хожим тоногдохоос сэргийлж нууцалсан шийдэл бололтой. Нас барагчийн толгойг хойд зүгт хандуулан баруун хажуугаар нь хэвтүүлж оршуулжээ. Хөл бүсэлхийг дамнуулан үлэмж том чулуугаар дарснаас гадна цээжин хэсэг, толгойн дээр том чулуу тавьж ирмэгүүдийг жижиг чулуугаар завсар зай гаргалгүй нягт дарсан тул гадны нөлөө ороогүй, огт хөндөгдөөгүйгээс гадна хүний яс сайн хадгалагдсан байв. Мөн хүрээ чулууны гадна талаас нэг чулуун эдлэлийн хугархай олдсон (Зураг 3-5).

87-р дурсгал нь Майхан толгойн дурсгалт газрын зүүн өмнөд захад байрлах том хавтгай чулууг хавиргалан зоосон дөрвөлжин хэлбэрийн хашлага бүхий зүүн буландaa хөшөө чулуутай байгууламж юм. Хөшөө чулуу нь унаж хугарчээ. Судалгааны явцад хашлаганы дотор талаас ямар нэг эд өлгийн зүйл илрээгүй ба нүхний толбо гэхээр зүйл ялгарч мэдэгдсэнгүй. Харин хашлаганы гадна, зүүн



талаас богийн хавирга, дал, богтос чөмөгний яс илэрснээс үзвэл хонины хаагаар тахилга өргөснийг илтгэнэ (Зураг 6, 7). Энэ төрлийн тахилын байгууламжийг урьд өмнө Түрэгийн үед холбогдуулан үздэг байсан бол сүүлийн үеийн лабораторийн судалгаагаар он цаг нь хүрэл зэвсгийн үед холбогдох болсон.

Малтан судалсан дурсгалуудын холбогдох он цагийг радио-карбоны шинжилгээгээр тодорхойлох, гурван хэмжээст зураглалыг боловсруулж байгаа болно.



Зураг 1. 5-р булшны дараасыг цэвэрлэсний дараах байдал




Зураг 2. 5-р булшны оршуулга




Зураг 3. 21-р булшны дараасыг цэвэрлэсний дараах байдал



Зураг 4. 21-р булшны оршуулга



Зураг 5. 21-р булшны дараасын гадна талаас олдсон чулуун эдлэлийн хугархай



Зураг 6. 87-р дурсгалын
өнгөн хөрсийг цэвэрлэсний дараа



Зураг 7. 87-р дурсгалаас илэрсэн бог малын яс



Зураг 8. Тамга, монгол бичээс бүхий
ханан хад (урдаас)



Зураг 9. Тамга, монгол бичээсийн хуулбар



Зураг 10. Ар булангийн хүннүгийн оршуулгын газар



Зураг 11. Майхан толгойн баруун талаарх тариан талбай

МОНГОЛ-МОНАКОГИЙН ХАМТАРСАН “ХОЙД ТАМИР-ХҮНҮЙ” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга, Г.Лхүндэв,
Ж.Магай, К.Салисис

Монгол-Монакогийн хамтарсан “Хойд Тамир-Хүнүй” төслийн хээрийн шинжилгээний анги 2015 оны 06-р сарын 08-наас 08-р сарын 03-ныг хүртэл нийт 57 хоног Архангай аймгийн Хайрхан, Эрдэнэмандал сумдын нутаг Гол модны Хүннүгийн оршуулгын дурсгалт газар, Их Тамир, Батцэнгэл сумдын нутаг Хойд Тамирын голын хөндийд ажиллав.

Энэ жилийн хээрийн судалгаа нь малтлага болон топографийн судалгаа гэсэн үндсэн хоёр чиглэлийн дагуу хийгдсэн. Малтлага судалгааг Гол мод, Хөрөөгийн үзүүрт хийсэн бол топографийн судалгааг Хөрөөгийн үзүүр орчимд хийж гүйцэтгэсэн болно.

Монгол-Монакогийн хамтарсан “Хойд Тамир-Хүнүй” археологийн судалгааны төслийн хүрээнд, Монако улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгээр Архангай аймгийн Их Тамир сумын Буган багийн нутаг, Баянцагааны хөндийд “Археологийн судалгааны төв”-ийг байгуулав.

Судалгааны төвийн албан ёсны нээлт 2015 оны 7-р сарын 14-ны өдөр болсон ба төвийг Монголын ууган археологичдын нэг Цогданзангийн Доржсүрэнгийн нэрэмжит болгожээ. Энэхүү судалгааны төв нь Түүх, Археологийн хүрээлэнгийн харъяанд үйл ажиллагаа явуулах юм.

1. Гол модон дахь малтлага судалгаа

Гол модны дурсгалт газрын зүүн өмнөд хэсэгт буюу Наагийн ар хэмээх газарт орших 61-р булшны дагуул 14 булшийг малтан шинжилсэн.

Гол модны дурсгалт газарт хоорондоо тодорхой зайтай гурван дэд бүлэгт хуваагдсан нийт 490 гаруй булш бий бөгөөд 1956-57 онд Ц.Доржсүрэн, 2000-2010 онд Монгол-Францын хамтарсан экспедиц ажилласан ч оршуулгын газрын зөвхөн хойд хэсэгт малтлага судалгаа хийсэн юм. Иймээс энэ жилийн судалгааны онцлог нь өмнө малтан судалсан дурсгалуудаас 700 орчим метр зайд буюу оршуулгын газрын өмнөд бүлгийн булшнаас сонгон малтсан явдал юм. Энэ нь Хүннүгийн язгууртны оршуулгын газрын микро топографийн судалгаа хийгээд тухайн дурсгалт газрын он цагийн асуудлыг нарийвчлан судлах, цаашлаад оршуулгын газрыг бүрдүүлж буй бүлэг булш хоорондын ялгаа, угсаа гарал зэрэг асуудлыг тодруулахад зохих хувь нэмэр болох нь дамжиггүй юм.

Энэхүү 61-р булш нь Гол модонд дараасны хэмжээгээрээ хамгийн том булш бөгөөд дараас нь 71.7 м урт (үүнээс үүдэвч нь 31 м), өргөн нь 37.7-39 м. Зүүн талдаа хойноос урагшаа цуварсан 14 дагуул булштай ба эдгээр нь том булшны зүүн талд 16-22 м зайд байрлана (Зураг 1, 2). Дагуул булшнуудын дараасны голч 200-535 см ба булшны нүхний гүн урдаас хойшлох тусам 148-212 см болж нэмэгдэж байв. Нийт 14 булшны 10-наас буюу 2,6-14-р булшнаас оршуулга, цөөн тооны олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдсон. Уг дурсгалт газрын хөрс элсэрхэг, чийглэг тул хүн, малын яс, олдвор хэрэглэгдэхүүний хадгалалт маш муу байдаг. Энэ жилийн зарим онцлог олдворыг дурдвал, бүтэн төмөр амгай, зуузай, төмөр зэв, чулуун товч, чулуун сондор, бүсний хүрэл, чулуун шигтгээтэй чимэглэлийн үлдэгдэл зэрэг болно (Зураг 3.1-4). Түүнээс гадна 13, 14-р булшнаас олдсон ваарны хагархайнууд нэг ваарных болох нь тогтоогдсон (Зураг 3.5). Малтан судалсан булшнуудын он цагийг лабораторийн судалгаагаар тогтоох, хүний

яснаас дээж авч генетикийн судалгаа хийхээр төлөвлөж байгаа болно.

2. Хойд Тамир дахь малтлага судалгаа

Энэ жил Авдар хадны өвөр дэх чулуун зэвсгийн дээд үе болон хүрэл, түрүү төмрийн үед холбогдох бууц сууринд үргэлжлүүлэн малтлага судалгаа хийснээс гадна Хөрөөгийн үзүүрт орших том дугуй хүрээтэй хиргисүүрүүдийн (KTS-169, 171) хойд талд байрлах тэгш өнцөгт хэлбэрийн намхан чулуун дараастай, гадуураа хөшөө чулуу бүхий 2 тахилын байгууламж малтан шинжилсэн болно.

Чулуун зэвсгийн суурин. Энэ жилийн Авдар хадны малтлагын талбайд A5, B6, C6, C7 өргүүдийн A5c, B6a, B6b, B6c, B6d, C6a, C6d, C7a, C7b, C7c, C7d хэсгүүд хамаарагдсан бөгөөд эдгээр нь 3 м² талбайг эзэлнэ. A5, B6, C6, C7 өргөөс нийт 279 ш олдвор илэрсэн. Тэдгээр нь чулуун зэвсгийн олдвор (178 ш), амьтны ясны үлдэгдэл хэсгүүд (101 ш) болно. Соёлт давхаргын зузаан 4-28 см.

Чулуун зэвсгийн олдворуудыг анхдагч цуулалттай холбоотой эдлэл 3.4 %, багаж зэвсгийн төрөлд хамаарах эдлэл 9.0 %, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэл 82 %, жижиг хэмжээтэй түүхий эд 5.6 %-ийг тус тус эзэлж байна. Багаж зэвсгийн төрөлд үзүүр мэс, иртэй ялтас олон байгаа бол бусад төрлийн зэвсгүүд тус бүр нэг байна. Чулуун зэвсгийн зүйлсийг орон нутгийн хайрга, занар болон цахиурын төрлийн хатуулаг сайтай чулуугаар хийжээ.

Бууц суурин. Чулуун зэвсгийн суурингийн баруун хойд талд орших бууц сууринд 19 өрөгт (K 3-5, J 3-5, C 7, B 7, A' 7, B' 3, 4, 6, C' 3, 4, 7, D' 3, 4, 7, E' 3, 5, 6, F' 5, 6) буюу 76 м² талбайд малтлага судалгаа хийв (Зураг 4).

Малтан судалсан талбай бүрийн гүн харилцан адилгүй ба 5-42 см байв. Малтлагаас чулуун зэвсгийн зүйлс, вааран савны хээтэй, хээгүй хагархай, төмөр зэв, төмрийн хүдэр, хаягдал, ясны үлдэгдэл, модны нүүрс зэрэг хэдэн зуун олдвор хэрэглэгдэхүүн илэрсэн болно (Зураг 5). Эдгээр олдворууд нь түүхийн олон үед холбогдох боломжтой бөгөөд зарим олдвороос дээж авч лабораторийн нарийвчилсан он цаг тогтоолгохоор илгээгээд байна.

Тахилын байгууламж. Хөрөөгийн үзүүрт орших том дугуй хүрээтэй хиргисүүрүүдийн (KTS-169, 170) хойд талд байрлах тэгш өнцөгт хэлбэрийн намхан чулуун дараастай, гадуураа хөшөө чулуу бүхий 2 тахилын байгууламж малтан шинжилсэн (Зураг 6, 7).

Эхний тахилын байгууламж нь 169-р хиргисүүрийн хойд талд 9 м зайд оршино. Уг байгууламж нь зүүн хойшоо 50° чиглэлд байгуулагдсан ба дараас нь 10.8 м урт, баруун талын өргөн 3.8 м, зүүн талын өргөн 4.1 м. Баруун талдаа унасан 6 хөшөө чулуутай, зүүн талдаа унасан 4 хөшөө чулуутай ба тэдгээр нь 5.6-6.6 м зайд цуварч байрлана. Уг байгууламжийн зүүн талд 530 см зайд 2 босоо хөшөө чулуу, дугуй хэлбэрийн овгор шороон байгууламж бий (Зураг 6).


Тахилын байгууламжийн суурийг хавтгай том чулуудыг 2-3 давхарлан өрж тавиад гол хэсгийг жижиг чулуугаар дүүргэсэн байна. Байгууламжийн хойд болон зүүн хананаас дотогш 60 см зайд 22 см голч бүхий галын ором илэрсэн ба гүн нь 30 см. Эндээс бог малын (?) шатсан ясны үлдэгдэл гарсан. Харин тус байгууламжийн зүүн талд орших хоёр босоо хөшөө чулуутай байгууламжаас тахилын зан үйлийн ул мөр илрээгүй болно.

Хоёр дахь тахилын байгууламж нь 171-р хиргисүүрийн хүрээний хойд талд 540 см зайд байрлана. Байгууламжийн чулуун дараас өмнөх байгууламжийн адил ба 7.7 м урт, баруун талын өргөн 4.2 м, зүүн талын өргөн 5.1 м. Дөрвөлжин байгууламжийг тойроод нийт 15 хөшөө чулуутай (баруун талдаа 5, хойд талдаа 5, зүүн талдаа 5). Уг байгууламжийн зүүн талд 520 см зайд 1 босоо хавтгай том хөшөө чулуутай, дугуй хэлбэрийн 540 см голч бүхий овгор чулуун дараастай нэг



байгууламж бий (Зураг 7). Уг байгууламжийн чулуун дараасан доороос бог малын ясны үлдэгдэл илэрснээс өөр зүйл гараагүй. Харин хоёр дахь байгууламжийн хойд хашлаганаас дотогш 20 см, зүүн талын хашлаганаас дотогш 60 см зайд 20 см голчтой галын ором илэрсэн. Уг галын ором нь 51 см гүн бөгөөд эндээс мөн л шатсан ясны үлдэгдэл гарсан.


Топографийн хэмжилт судалгаа. Хойд Тамирын хөндийн булш, хиргисүүр хамгийн их шигүү тархсан газар бол Хөрөөгийн үзүүр юм. Тиймээс бид уг дурсгалт газрын дурсгалуудыг шат дараалалтай бүртгэн баримтжуулж байгаагийн нэг нь топографийн хэмжилт судалгаа юм. Энэ жилийн топографийн хэмжилт судалгаагаар 370 гаруй булш, хиргисүүр, чулуун байгууламжийн дэвсгэр зургийг хийж гүйцэтгэсэн болно.




Зураг 1. Гол модны 61-р булшны дэвсгэр зураг ба ерөнхий хэмжээ



Зураг 2. Гол модны 61-р булшны дагуул булшнууд (урдаас)



Зураг 3. Гол модны 61-р булшны дагуул булшнуудаас гарсан зарим олдвор
1. Төмөр амгай, зуузай, 13-р булш, 2. Хээ бүхий мөнгөөн хөөмөл ялтас, чулуун товч, оюу шигтгээ, 14-р булш, 3. Бүсний хүрэл чимэглэлийн хэсэг, 14-р булш, 4. Чулуун сондор, 14-р булш, 5. Шавар ваар, 13, 14-р булш




Зураг 4. Авдар хадны суурингийн малтлагын талбайн дэвсгэр зураг
(Бор өнгөөр 2014, улбар шар өнгөөр 2015 оны малтлагын талбайнуудыг тэмдэглэв)



Зураг 5. Авдар хадны суурингаас олдсон олдворын дээж
1. Төмрийн баасны үлдэгдэл, 2. Төмөр зэв, 3. Хээтэй ваарны хагархай,
4. Засаж янзалсан ваарны хагархай



Зураг 6. Хөрөөгийн үзүүрт орших 169А-р тахилын байгууламж



Зураг 7. Хөрөөгийн үзүүрт орших 171-р тахилын байгууламж

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “БАЯНХОНГОР” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

*З.Батсайхан, Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал,
Ч.Баяндэлгэр, Брайс Лаури, Вильям Тэйлор*

Монголын Үндэсний Музей, МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхим болон АНУ-ын Чикагогийн их сургуулийн Антропологийн тэнхимтэй хамтарсан уг судалгааны анги 2015 оны 8 дугаар сарын 1-нээс 9 дүгээр сарын 15-н хүртэл Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Өлзийт сумдад археологийн хайгуул, малтлага судалгаа хийлээ. Судалгааны ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас МУИС-ийн багш, доктор, профессор З.Батсайхан, МҮМ-н Эрдэм шинжилгээний төвийн дарга, археологич Ж.Баярсайхан, ЭША археологич Т.Түвшинжаргал, Ч.Баяндэлгэр нар, АНУ-ын Чикагогийн их сургуулийн докторант Брайс Лаури, Пурдье их сургуулийн остеологич, антропологич, доктор Жереми Бийч болон МУИС-ийн оюутнууд хамтран ажиллав.

Судалгааны баг Эрдэнэцогт сумын Хужирын гол, Түйн голын сав дагуу нийт 18 км хавтгай дөрвөлжин талбай, Өлзийт сумын нутаг Булган уул, Тэмээн хүзүүний гол орчимд 16.5 км хавтгай дөрвөлжин талбайд тус тус археологийн нарийвчилсан хайгуул судалгаа хийв. Үүний үр дүнд 390 орчим археологийн дурсгал, ваар савны хагархай үлдэгдэл бүхий 12 газар, чулуун зэвсгийн ул мөр бүхий 95 дурсгалт газрыг бүртгэн баримтжуулав.



Зураг 1. Дугуй цэгээр тэмдэглэсэн газрын орчимд хайгуул, малтлага судалгаа хийсэн

Мөн Эрдэнэцогт сумын нутаг Бор шорооны аманд гурван буган хөшөө шинээр илрүүлэн олж сэргээн босгож, 2 дөрвөлжин булш, буган хөшөө, хиригсүүрийн тахилгын байгууламж гурвыг малтан судаллаа. Шатар чулууны дурсгалт газрын дэвсгэр зураг, буган хөшөөдийн гар зургийг хийж гүйцэтгэв. Мөн буган хөшөө, хиригсүүрийн тахилгын байгууламж 5, дугуй хэлбэрийн дараас чулуутай байгууламж 1-ийг тус бүр малтав.

Өлзийт сумын нутаг Их суваргын хөндийд 1 шоргоолжин булш, Мааньт уулын энгэрт 1 дугуй булш, Тэмээн хүзүүний голын баруун бие Хар сайрын аманд Хүрлийн үед холбогдох 1 хиргисүүр, дугуй хэлбэрийн чулуун дараастай булш 5, дөрвөлжин хэлбэрийн чулуун дараастай булш 1-ийг тус тус малтсан. Эдгээр булшны малтлагаас хос оршуулга, түрүүлгэ нь харуулж тавьсан оршуулга, хөлийг зөрүүлэн тавьсан оршуулга гэх мэт сонирхолтой зан үйлийг илрүүлэн судалж байна.



Бор шорооны амны дурсгалт газрын судалгаа

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Сэнжит багийн нутаг Хужирын голын баруун биед баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон багавтар жалгыг Бор шороо хэмээн нутгийн малчид нэрлэнэ. Бор шорооны амны тэгш өндөрлөг дэнж дээр хиригсүүр, дөрвөлжин булш, буган хөшөө, Түрэгийн үеийн хашлага чулуу зэрэг олон үеийн түүхэн дурсгалууд бий. Бид уг дурсгалт газрыг хайгуул судалгааны үр дүнд илрүүлэн олсон бөгөөд энд хоёр дөрвөлжин хэлбэрийн булш, буган хөшөөний 1, хиригсүүрийн 2 тахилгын байгууламж малтан судалж, гурван буган хөшөөг сэргээн босгов.

Буган хөшөөд: Бид Бор шорооны амны дурсгалт газраас анхны суурин дээрээ унасан 1, дөрвөлжин булшны дараас болгон ашигласан 1, дөрвөлжин чулуун хашлаганы голд унасан байдалтай 1 буюу нийт 3 буган хөшөөг илрүүлэн бүрэн баримтжуулалт хийж, сэргээн босголоо.

Дөрвөлжин булш №1 (BSA SG-1) Уг дөрвөлжин булшийг малтан судлах болсон шалтгаан нь уг дурсгалын төв хэсгийн дараас дундаас нэлээд том буган хөшөөний хэсэг цухуйж байсан бөгөөд энэ нь буган хөшөө ашиглан бүтээсэн нэгэн дурсгал болох нь илэрхий байв. 6х5.5 м хэмжээтэй. Уг дурсгал нь Дорнод Монгол, Манжуурын тал, Өвөр Байгальд өргөн тархсан дөрвөлжин булшны сонгодог хэлбэр, гадаад зохион байгуулалтаас өвөрмөц, том хавтгай хавтан чулуу ашиглаагүй, газрын хөрснөөс цухуйсан дөрвөлжин хэлбэрийн намхан чулуун өрлөг хүрээтэй, голдоо өнгөн хөрсөн дээр цөөн тооны чулуун дараастай.

Уг дурсгалыг малтах явцад талбайн энд тэндээс шоо хээтэй болон шулуун сараачмал хээтэй болон хээгүй ваарны хагархайнууд, адууны шүдний хагархай хэсгүүд гарсанаас гадна өнгөн хөрснөөс доош 35 см гүнд дөрвөлжин чулуун хүрээний дотор талд зүүн хойд булангаас шоо хээтэй ваарны амсар хэсгийн хоёр том хагархай хэсэг гарсан нь уг ваарны амсар хэсгийг нөхөн сэргээж судлаж болохуйц чухал олдвор байв. Буган хөшөөний дороос булшны нүх илэрсэн боловч хүний яс огт гараагүйгээс харахад магадгүй уг дурсгалыг анх бүтээсний дараахан тонож сүйтгэсэн байж болох юм. Хэдий тийм боловч эл дурсгалын бүтэц зохион байгуулалт, илэрсэн олдворууд нь тухайн дурсгалын холбогдох он цаг, зан үйл зэргийг тодруулан судлахад чухал ач холбогдолтой юм.

Дөрвөлжин булш №2 (BSA SG-2): Энэхүү дурсгал нь бидний өмнө малтан судалсан 1-р дөрвөлжин булшны зэрэгцээ хойд талд байрлах бөгөөд гагцхүү хэмжээгээр нэлээд том уртрагийн дагуу 6.4м, өргөрөгийн дагуу 7.4 м урт. Уг дурсгалын хөрсөн дээр ил харагдаж байсан чулуун Дурсгалын төв хэсэгт дараас чулуу хомс байгаагаас ажиглахад эрт үед тоногдсон бололтой (Зураг 2).

Малтлагын явцад эндээс ваар савын цөөн хагархай хэсгүүдээс гадна 80-100 см гүн болоход нүхний зүүн хэсэгт олон тооны малын толгой, аман хүзүүний яс илрэв. Энэ нь оршуулгын толгой талд тавьсан хойлгын малын яс болох нь тодорхой бөгөөд энд 7 адуу, 2 үхэр, 24 хонь, 4 ямааны толгойг зүүн зүгт хандуулан, аман хүзүү, туруу, туурайны ястай нь зэрэгцүүлэн тавьсан байв (Зураг 2).

Мөн энэ түвшинд талбайн төв хэсэгт өргөрөгийн дагуу 2.8 м, уртрагийн дагуу 1.5 м хэмжээтэй зууван дугуй нүх илэрч, түүний дээр уртрагийн дагуу зэрэгцүүлэн тавьсан олон эгнээ сургаг модон дараасны үлдэгдлүүд байсан боловч нүхний толбоны хэсгээр сүйтгэгдэж үгүй болсон байлаа. Эл нүхнээс 82-130 см гүнээс хүний өвчүү болон шууны ясны хугархай 1ш, шүд 2 ш, эгэм 1ш, хүзүү 1ш, нуруу 2ш, хавирганы яснууд, 170-210 см гүнээс адууны шүд, бага малын турууны яс болон бусад ясны жижиг хэсэг зэрэг гарснаас гадна энэ үеийн шороог шигших явцад 1ш цагаан шавар сувс, жижиг дугуй үйсэн эдлэл 1ш тус тус олдов.



Зураг 2. Бор шорооны амны
2-р дөрвөлжин булш



Зураг 3. Оршуулга илэрсэн байдал

Малтлагын гүн 200-220 см болоход эмх замбараагүй том чулуун дарааснуудын дороос анхны тавилтаараа хөдлөөгүй хөлийн яснууд, нэлээд хөдөлж эмх цэгцгүй болсон хавирга, нуруу, гарын зарим яснууд олдов. Хүний ясны хөдлөөгүй хөлийн ясны байрлалаас харахад талийгаачийг дээш харуулан, толгойг нь зүүн зүгт хандуулан тэнэгэр байдлаар тавьсан бололтой бөгөөд харамсалтай нь толгой, эрүүний яс олдсонгүй (Зураг 3).

Буган хөшөө, хиригсүүрийн тахилгын байгууламжийн малтлага судалгаа: Бид уг дурсгалт газарт буган хөшөөний 1, хиригсүүрийн 2 тахилгын байгууламж малтсан бөгөөд 1-р хиригсүүрийн 1-р тахилгын байгууламжаас хонины толгой гарсан нь урьд өмнө тохиолдодж байгаагүй ховор зан үйл байлаа.

Шатар чулууны дурсгалт газар хийсэн хиргисүүр, буган хөшөөний тахилгын байгууламжийн малтлага судалгаа


Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутаг Шатар чулууны дурсгалт газар бол буган хөшөө, хиригсүүр, дөрвөлжин булш зэрэг Хүрлийн үеийн дурсгалуудаас гадна эртний улсууд болон дундад үеийн дурсгалууд нэгэн дор оршдог эртний түүхийн чухал эх сурвалж бүхий газар юм.

Бид Шатар чулууны дурсгалт газрын дэвсгэр зургийг үйлдэж, буган хөшөөний 3, хиригсүүрийн 2 тахилгын байгууламж малтан судалж, 2 адууны толгой, ваар савны хагархай хэсгүүд, адууны шүд ясны хэсгүүд илрүүлэн судалж байна.

Мөн уг дурсгалт газар байх дугуй хэлбэрийн олон тооны жижиг чулуун байгууламжуудаас нэгийг сонгон малтсан боловч ямар нэгэн нүх, эд өлгийн зүйл гараагүй 45 см гүн болоход байгалийн хөндөгдөөгүй эх хөрс гарсан билээ.

Булган уул орчимд хийсэн судалгаа

Шоргоолжин булш: Өлзийт сумын нутаг Бага Булган уулын урд хөндийг нутгийхан Суваргын хөндий гэж нэрэлдэг. Энэ хөндийд өнчин ганц шоргоолжин булш бий. Уг булш уртааш 5 м, өргөөшөө зүүн хана 5 м, баруун хана 3.5 м хэмжээтэй (Зураг 4). Малтлагын явцад төв хэсэгт илэрсэн багавтар нүхэнд өнгөн хөрснөөс 70-115 см гүнд түрүүлгэ нь харуулан, зүүн зүгт толгой талыг хандуулан тавьсан хүүхдийн оршуулга илэрсэн бөгөөд харамсалтай нь толгойны яс нь байсангүй. Мөн чулуун хүрээний зүүн хойд булангаас бог малын хүзүүний яс 1ш, зүүн урд булангаас адууны толгой, аман хүзүүний ясны хамт гарсан (Зураг 5).




Зураг 4. Өнгөн хөрсийг цэвэрлэсний дараа



Зураг 5. Оршуулга илэрсэн байдал

Мааньт уул болон Хар сайрын амны малтлага судалгаа

Өлзийт сумын нутаг Тэмээн хүзүүний голын баруун бие Мааньт ууланд 2 булш, Хар сайрын аманд 5 булш, 1 хиригсүүр малтан судалсан бөгөөд үүнээс сонирхолтой нь Хар сайрын амны 1-р булшнаас илсэрсэн хос оршуулга юм. 4.5 м голчтой дугуй хэлбэрийн чулуун дараас дороос эртний өнгөн хөрсөн дээр чулуун хашлага дотор баруун зүг хандуулан зэрэгцүүлэн тавьсан хоёр хүний оршуулга гарсан (зураг 6). Түүнчлэн дурсгалыг малтах явцад баруун талын хүний толгойн хажуунаас 3ш хагархай ваар олдсон. Өөр ямар нэгэн олдвор гараагүй.



Зураг 6. Хар сайрын амны 1-р булшны анхны байдал болон малтлагаар илэрсэн хос оршуулга

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “БАРУУН МОНГОЛ” ТӨСЛИЙН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Жеан Лүк Хюл

Монголын үндэсний музей - АНУ-ын Баруун Кентаки их сургуультай хамтарсан энэхүү судалгааны баг 2015 оны 5 дугаар сарын 23-наас 6 дугаар сарын 18-ны хооронд Увс аймгийн Зүүнхангай сумын төв орчимд археологийн хайгуул, малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэлээ. Тус судалгааны багт Монголын талаас МҮМ-н ЭШТ-ийн дарга Ж.Баярсайхан, ЭША Т.Түвшинжаргал нар, АНУ-ын талаас Баруун Кентаки Их сургуулийн Антропологи-Угсаатны зүйн тэнхимийн доктор, туслах профессор Жеан Лүк Хюл болон бусад судлаачид хамтран ажиллаа.

Судалгааны баг сумын төв орчмын 55 км² талбайд археологийн хайгуул хийсний дүнд нийт 490 археологийн дурсгал бүртгэн баримтжуулж, 354 ширхэг ваар савны хагархай, чулуун зэвсгийн зүйлс түүврээр олж цуглуулжээ. Мөн Хүрлийн үед холбогдох 1 булш, хиригсүүрийн 8 тахилгын байгууламж, хиригсүүрийн хүрээнд 1 сорилт, буган хөшөөний 1 тахилгын байгууламж, Хүннүгийн үеийн 2 булш тус тус малтан судалжээ.

Хайгуулын явцад орчин үеийн өвөлжөөний орчмоос илэрсэн олдворт түшиглэн хоёр газарт 40 см гүнтэй туршилтын малтлага хийж ваар савны хагархай, мал амьтны яс зэрэг олдворууд илрүүлэн олов.

Хүрлийн үеийн булш: Нутгийн иргэд “Саваа хар толгой” хэмээн нэрлэх сондгой хар толгойн зүүн урд энгэрт хүрлийн үед холбогдох булш, тахилгын байгууламж цөөнгүй байдаг. Бид энд гадуураа том дугуй чулуун хүрээтэй хавтгай чулуун дураастай нэгэн булш сонгон малтсан юм. Малтлагаар булшны гол хэсгээс баруун хойд зүгт чигэлсэн 6 ширхэг цувраа том чулуу илэрч, голын дөрвөн чулууг аван доош малтахад 50 см гүнээс баруун хойд зүг хандуулан түрүүлгэ нь харуулж тавьсан оршуулга илэрсэн. Дагалдах өөр ямар нэгэн олдвор, малын яс байсангүй.

Хиригсүүрийн тахилгын байгууламж: Изотоп болон C14 он цагийн нарийвчилсан судалгаа хийх зорилготой 2 хиригсүүрийн нийт 8 ширхэг дагуул тахилгын байгууламж малтан судлав.

Хиригсүүр №1 нь сумын төвийн хойд Замба хайрханы баруун урт энгэрт байрлана. Уг хиригсүүр нь 30 x 30 м-ийн харьцаатай дөрвөлжин хүрээтэй. Голын овоолго байгууламж нь 18 м голчтой. Зүүн талдаа 7 ширхэг дугуй хэлбэрийн тахилгын байгууламжтай. Баруун талаараа 11 ширхэг цагариг хэлбэрийн тахилгын байгууламжтай. Мөн 4 ширхэг чулуугаар байгуулсан 15 ширхэг жижиг дугуй байгууламжтай. Эдгээр жижиг байгууламж нь хиригсүүрийн нэгэн өвөрмөц тахилгын байгууламжинд тооцогдоно. Уг хиригсүүрийн дугуй хэлбэрийн буюу адууны толгойт тахилгын байгууламжаас 4 ширхэгийг малтсан бөгөөд тахилгын байгууламж тус бүрээс зүүн урд зүгт хандуулан тавьсан адууны толгой, хүзүү, туурайны яс илрэв.

Хиригсүүр №257 нь Зүүнхангай сумын төвөөс зүүн урагш Замын толгой гэх газар байрлана. Уг хиригсүүр нь 31 x 23.5 м дөрвөлжин хүрээтэй, голын овоолго нь 14.5 м хэмжээтэй. Зүүн талаараа 10 ш цувраа тахилгын байгууламжтай. Бид эдгээр тахилгын байгууламжаас 4 ширхэгийг сонгон малтсан бөгөөд үүний 3 тахилгын байгууламжаас уламжлал ёсоор зүүн өмнө зүгт хандуулан тавьсан адууны толгой, хүзүү, туурай, гарсан ба зарим тахилгын байгууламжийн адууны яс үгэрч зөвхөн шүд үлдсэн байлаа.

Бүлцэнгийн хиригсүүрийн малтлага судалгаа: Саваа хар толгойгоос зүүн




хойш 5 км орчим зайд уужим хөндийд нэгэн дугуй хүрээтэй хиригсүүр бий. Уг хиригсүүрийн дугуй хүрээний голч 31х 35 м, голын чулуун овоолго 16 м голчтой, 80 см орчим өндөр. Орой дээрээсээ ухагдаж намссан ул мөртэй. Уг хиригсүүрийн хүрээний гадна талд баруун хойд талаар тойрон байрлах 9ш цагариг хэлбэрийн тахилгын байгууламжтай. Харин зүүн өмнө талд унасан 4 буган хөшөө бий. Үүнээс гадна хиригсүүрийн овоолго дээр бас нэг унасан буган хөшөө байгаатай нийлээд бүгд 5 буган хөшөө байна.

Бид энэ хиригсүүрийн орчимд туршилтын малталт хийх болсон шалтгаан нь хиригсүүрийн хүрээг 2 м орчим өргөн чулуун дараастай хийжээ. Бүлцэнгийн хиригсүүрийн хүрээний зүүн хойд хэсэгт 6.5 м урт, 4 м өргөн туршилтын малтлагын талбай сонгож, өнгөн хөрсийг цэвэрлэхэд ямар нэгэн тахилгын ул мөр илрээгүй бөгөөд зөвхөн хүрээ чулууны зохион байгуулалт илрэв. Эдгээр чулууны ёроолоос байгалийн хөндөгдөөгүй хөрс илэрсэн тул малтлагыг зогсоож нөхөн сэргээлт хийсэн болно.

Хүрдлэгийн амны буган хөшөөний туршилтын малтлага судалгаа: Зүүнхангай сумын нутаг Хүрдлэгийн аманд шинээр олсон нэгэн буган хөшөөний зүүн өмнө талд буй дугуй хэлбэрийн тахилгын байгууламжийн хүрээнд 3.5 х 3.5 м хэмжээтэй туршилтын малталт хийв. Уг малтлагын зорилго нь тахилгын байгууламжаас гарсан мал, амьтны ясаар он цаг тогтоох зорилготой байсан авч, ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрээгүй болно.

Хүннүгийн үеийн булшны судалгаа. Сумын төвийн баруун урд “Замын өтөг” хэмээх газарт гурван бүлэг нийт 92 Хүннүгийн жирийн иргэдийн булш шинээр илрүүлэн бүртгэж, эдгээрээс хоёр булшийг малтан судлав. 1-1 дугаартай булш нь эрт үед тоногдсон байсан ба булшнаас хүүхдийн оршуулга илрэв. Ямааны нэг ширхэг нүхэлсэн шагайнаас өөр ямар нэг олдвор гарсангүй. Харин 2-1 дугаартай булш нь харьцангуй бүтэн байсан ба оршуулгаас толгой нь байхгүй анатомийн байрлалаараа хадгалагдан үлдсэн нас ахисан эрэгтэй хүний оршуулга илрэв. Уг булшинд долгио хээтэй бараг бүтэн ваар, дундаа нүхтэй дугуй хэлбэрийн чулуун эдлэл, сувс, зориулалт тодорхогүй ясан эдлэлүүд зэргийг дагалдуулан тавьсан байв.


Ийнхүү судалгааны баг өөрсдийн зорилтын хүрээнд судалгаагаа амжилттай хэрэгжүүлж, малтсан судалсан булш, тахилгын байгууламж, сорилтын малтлагын бүх талбайгаа буцаан булж, орон нутагт товч тайлангийн хамтаар хүлээлгэн өгөв.



Зураг 1. Хайгуул хийсэн талбай



Зураг 2. Саваа хар толгойд малтсан хурлийн үеийн булш.



Зураг 3. 2-1 дугаартай хүннү булшны дэвсгэр болон зүсэлтийн зураг, оршуулга.

**МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “УВС НУУРЫН САВ ДАХЬ
НЭН ЭРТНИЙ ХҮМҮҮСИЙН АХУЙ ОРЧИН” ТӨСЛИЙН
ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН**

*Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал
Лукас Бартон, Кристофер Морган*

Монголын үндэсний музей, АНУ-ын Питсбургийн их сургуулийн Харьцуулсан археологийн судалгааны төвтэй хамтран 2015 оны 6 дугаар сарын 21-нээс 7 дугаар сарын 2-ны хооронд Увс аймгийн Түргэн, Тариалан, Улаангом, Зүүнговь сумын нутагт археологийн хайгуул, туршилтын малтлага судалгаа хийв. Судалгааний ангийн бүрэлдэхүүнд МҮМ-н Эрдэм шинжилгээний төвийн дарга Ж.Баярсайхан, ЭША, археологич Т.Түвшинжаргал, АНУ-ын Питсбургийн их сургуулийн доктор, туслах профессор Лукас Бартон, Невада их сургуулийн доктор, туслах профессор Кристофер Морган нар туслах ажилтнуудын хамт ажиллав.

Уг төсөл нь сүүлчийн мөстлөгийн үеэс (ойролцоогоор 50000 жилийн өмнө) Хүрлийн үе хүртэлх (2500 орчим жилийн өмнө) цаг хугацаанд эртний хүмүүсийн газар ашиглалт буюу ахуй амьдралын ул мөрийг илрүүлэх зорилготой бөгөөд энэ зорилгын хүрээнд Евро-Ази дахь орчин үеийн хүмүүсийн тархалт, Увс нуурын усны түвшиний ихсэлт, багасалт болон тивүүдийн мөстлөгийн ул мөр, ваар савны хөгжил, нүүдлийн мал аж ахуйн эхэн үе, хиригсүүр, буган хөшөөний соёлын цэцэглэн хөгжих үйл явц зэрэг тухайн цаг хугацаанд өрнөсөн түүхэн чухал үйл явцуудыг илүү тодорхой ойлгох боломжуудыг эрэлхийлж байгаа юм.


Судалгааны зорилт нь дээрх цаг хугацаанд дахь цаг уур, байгал орчины өөрчлөлт болон эртний хүмүүсийн үлдээсэн дурсгалууд, олдвор хэрэглэгдэхүүний орон зайн тархалт, өөрчлөлтийг хайж олох, эдгээр үйл явцыг ойлгоход оршино.

2015 оны зуны судалгаа нь нэлээд томоохон бүс нутгийн хүрээнд ажиглалтын судалгаа, цөөн хэдэн газарт илүү нарийвчилсан хайгуул хийсэн бөгөөд газрын хөрсөн дээрх олдворуудыг нарийвчилсан явган хайгуулын үр дүнд бүртгэн баримтжуулж, цуглуулсан болно.


Түргэн, Тариалан, Улаангом сумдын нутагт хийсэн хайгуул: Бид 2015 оны 6 сарын 13-20 хүртэл дээрх сумдын нутаг Улаан давааны зарим хэсэг, Үүрэг нуурын өмнөд хэсэг, Түргэний голын эхэн хэсэг, Хархираа Түргэний уулсын зүүн суга дахь хоёр том жалга дагуу, Хархираа голын эхэн хэсэг, Улаангом хотын өмнөд хэсэгт цөөн хэдэн хадат толгойн орчим зэрэг газарт гүймэг хайгуул хийж, зарим түүхэн дурсгал болон олдвор хэрэглэгдэхүүнийг бүртгэн баримтжуулж, цуглууллаа (Зураг 1-2). Энэ хайгуулын явцад цуглуулсан олдворын тоо 121 ширхэг бөгөөд эдгээрт чулуун зэвсэг (чулуун зэвсгийн залтас, ялтас, үлдэц, залтсан зэвсэг болон үйлдвэрлэлийн хаягдал зэрэг багтсан); ваар савны хагархай (Хүрэл, төмрийн үе болон ихэнх нь он цаг тодорхойгүй); мөн цөөн тооны төмөрлөгийн баас зэрэг багтсан болно.

Түүнчлэн хайгуулын замд тааралдсан булш хиригсүүр, тахилгын байгууламж зэрэг үл хөдлөх түүхэн дурсгалуудыг бүртгэн баримтжуулсан билээ.

Зүүнговь сумын нутагт хийсэн хайгуул судалгаа: Судалгааны баг Зүүнговь сумын нутагт 2015 оны 6 сарын 22-ноос 7 сарын 2-ны өдрүүдэд ажилласан болно. Хайгуулын явцад илрүүлсэн Баян нуурын дурсгалт газар нь түүвэр олдвороор нэн баялаг, судалгааны чухал ач холбогдолтой байсан учир, Баян нуурын урд, баруун урд, баруун, хойд зүүн хойд талаар нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийв. Мөн Бага нуурын орчимд гүймэг хайгуул хийж цөөн тооны олдвор түүврээр цуглуулсан болно (Зураг 3).



Зураг 1. Түргэн, Тарилан, Улаан гом сумын нутагт хийсэн хайгуулын зам, бүртгэгсэн болон түүвэрлэсэн дурсгалуудын байрлал



Зураг 2. Түргэн сумын нутагт хийсэн хайгуулын зам, бүртгэгсэн болон түүвэрлэсэн дурсгалын байрлал

Зүүнговь сумын нутагт хийсэн хайгуул судалгаа: Судалгааны баг Зүүнговь сумын нутагт 2015 оны 6 сарын 22-ноос 7 сарын 2-ны өдрүүдэд ажилласан болно. Хайгуулын явцад илрүүлсэн Баян нуурын дурсгалт газар нь түүвэр олдвороор нэн баялаг, судалгааны чухал ач холбогдолтой байсан учир, Баян нуурын урд, баруун урд, баруун, хойд зүүн хойд талаар нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийв. Мөн Бага нуурын орчимд гүймэг хайгуул хийж цөөн тооны олдвор түүврээр цуглуулсан болно (Зураг 3).



Зураг 3. Зүүнговь сумын нутагт хийсэн хайгуул судалгааны зам, бүртгэгсэн болон түүвэрлэсэн дурсгалуудын байрлал.

Хайгуул судалгааны үр дүнд нийт 10399 ширхэг олдвор түүв эрлэн цуглуулсан бөгөөд эдгээрийн дотор чулуун зэвсгийн зүйлс 5680, ваар савны хагархай 2230, мал, амьтны яс 2212, төмөрлөг зүйлс 63, бусад зүйлс 214 ширхэг тус тус байна.

Чулуун зэвсэг (чулуун зэвсгийн залтас, ялтас, үлдэц, залтсан зэвсэг болон маш олон үйлдвэрлэлийн хаягдал зэрэг багтсан); ваар савны хагархай (Шинэ чулууны үе, Хүрэл, Төмрийн үе болон ихэнх нь он цаг тодорхойгүй, өвөрмөц хээ дүрслэлтэй ваарны хагархайнууд цөөнгүй багтсан); мөн цөөн тооны чулуу болон тэмээн хяруулын өндөгний хальс, хясаагаар хийсэн сувс (зүүлтний), цөөн тооны хүрэл, төмөр эдлэл, төмөрлөгийн баас зэрэг болно.

Дээрх олдвор хэрэглэгдэхүүний ихэнх нь Баян нуурын сав газраас олдсон бөгөөд хайгуулын үр дүнд тулгуурлан Баян нуурын орчимд гурван хэсэгт газарт сорилтын малтлага хийж, эртний галын ор, чулуун зэвсгийн зүйлс, ваар савны хагархай, мал амьтны яс зэргийг илрүүлэн олж, нарийвчлан судалж байна.

Сорилтын малтлага 1: Эртний хүмүүсийн гал түлж байсан ором илрүүлж үүнийг дайруулсан 10х1 м хэмжээтэй малтлага судалгаа хийлээ. Малтлагаар чулуун зэвсгийн цөөн залтас, мал амьтны ясны хугархай, шатсан яс, модны нүүрс зэрэг илрэв. Модны нүүрснээс он цаг тогтоох зорилготой дээж авав.

Сорилтын малтлага 2: Энэ маш жижиг малтлага бөгөөд 2 х 1 м харьцаатай талбайд 30 см гүн, мөн 50 х 50 см хэмжээтэй 60 см гүн малтлага хийв. Малтлагаар ямар нэг олдвор гарсангүй.

Сорилтын малтлага 3: Эртний сууц байж болохоор газарт 2 х 1 м хэмжээтэй 34 см гүн малтлага хийв.

Хайгуул судалгааны үр дүнд Баян нуурын сав газар нь түүхэн олон үеийн хүмүүсийн амьдралын идэвхтэй бүс нутаг байсныг харуулах олдвор хэрэглэгдэхүүнээр баялаг байлаа. Эдгээр олдвор нь эртний хүмүүсийн олон талт үйл ажиллагааг танин мэдэх бололцоог олгож байгаа юм. Баян нуурын сав нь эртний анчид түүвэрлэгчдийн баялаг ул мөрийг газрын хөрсөн дээрээ хадгалан үлдсэн төдийгүй хөрсөн доороо тодорхой хэмжээний ул мөрийг агуулж байгаагаараа Хойд Азийн говь цөлийн онцгой дурсгалт газар болж байна.

Дараа дараагийн судалгааны ажлаар эрт үед Баян нуурын савд амьдарч байсан хүмүүсийн ахуй амьдралыг улам илүү танин мэдэх боломжийг олгоно хэмээн найдаж байна. Түүнчлэн Умард Азийн түүхийн судалгаанд Монголын өв соёл тодорхой байр суурь эзлэхэд чухал хувь нэмэр болох юм.

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “УМАРД-МОНГОЛ” ТӨСЛИЙН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

Жулиа Кларк, Г.Бүрэнтөгс, Т.Түвшинжаргал, У.Тэйлор

Монголын Үндэсний Музей – АНУ-ын Питсбургийн Их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “Умард Монгол” археологийн хээрийн шинжилгээний анги 2015 оны 7-р сарын 20-ноос 8-р сарын 10-ны хооронд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Соёо толгой, Хоригийн ам, Ренчинлхүмбэ сумын Тарган нуур, Зээрдэгчингийн хошуу зэрэг газарт археологийн малтлага судалгаа хийж гүйцэтгэлээ.

Соёо толгой: Анх Соёо толгойн неолитийн үеийн суурин бүхий дурсгалт газрыг Монгол-Америкийн хамтарсан “Буган хөшөө” төслийн баг анх 2003 онд илрүүлсэн байдаг¹. Эдүгээ уг дурсгалт газарт амралт жуулчны газар барихаар төлөвлөж, зарим үйл ажиллагаа нь эхэлсэн нь эртний соёлт давхрагыг устгаж үгүй болох байдалд хүргээд байна. Тиймээс уг дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоох, авран хамгаалах судалгаа хийх зэргээр нэн эртний хүмүүсийн түүхэн сан хөмрөгийг хадгалан үлдээх, шинжлэн судлах нь зүй ёсны тулгамдсан асуудал болжээ.

Тус судалгааны анги 2015 онд Соёо толгой орчмын 8 газарт малтлага судалгаа хийв. Соёо толгойн зүүн хойд хормой, Хөгийн голын эрэг дэх чулуун зэвсгийн сууринд тус бүр 2 x 2 м бүхий 5 талбайд сорилтын малтлага хийж чулуун зэвсгийн зүйлс, ваарны хагархай, мал амьтны яс зэргийг илрүүлэн олов. Уг олдворууд нь малтлагын талбайн өнгөн хөрс болон 20-30 см хүртэлх гүнээс илэрч олдсон. Олдворт хийсэн анализ дүгнэлтээр уг суурин нь неолитийн үеэс хүрлийн дунд үе хүртэлх хугацаанд холбогдоно хэмээн таамаглаж байна.

Олдворын нэр	Өнгөн хөрснөөс	Малтлагаар	Нийт
Яс	1	1132	1133
Ваарны хагархай	54	374	428
Чулуун зэвсэг	987	316	1303
Төмөрлөг	17	1	18
Дээж	0	19	19

Соёо толгойн суурингийн малтлагаар илэрсэн олдвор

Түүнчлэн судалгааны баг Соёо толгойн өвөрт Хүрлийн үед холбогдох 2 дурсгал, 1 тахилын байгууламжийг малтан судлав. Эдгээрээс Соёо толгойн өвөрт малтсан булш, тахилгын байгууламж дундаас “Соёо толгой булш-3” хэмээн дугаарлан малтсан булшнаас оршуулгын өвөрмөц зан үйл, сонирхолтой олдвор хэрэглэгдэхүүн олдсон билээ. Том чулуун хүрээтэй, дотор талыг жижиг чулуугаар битүү чигжсэн 8 x 8 м хэмжээтэй дурсгал юм. Булшны дараас чулууны хойд хэсэг Соёо толгойн хадан хясааны нуранга цагаан асгаар хучигдсан нь дараас чулууны хэлбэрийг тодорхойлоход төвөгтэй болгожээ. Харин өнгөн хөрсний цэвэрлэгээний дараа дурсгалын хэмжихэд 7.3 м голчтой битүү чулуун дараастай булш болох нь мэдэгдсэн ба дурсгалын баруун, зүүн талаар ямар нэгэн хүрээ том чулуу мэдэгдсэнгүй. Улмаар дараас чулууны зүүн талыг хуулан авч хөндлөн огтлолын

¹ Ц.Очирхуяг, Ж.Баярсайхан. “Буган чулуун хөшөө” төслийн Монголын талын хээрийн судалгааны тайлан. УБ 2003. Монгол үндэсний музейн ГБСХ.

зураг үйлдэв. Зүсэлтийн явцад хойд хананаас 1.2 см орчимд зүүн зүгт хандуулан тавьсан хос оршуулга илэрсэн байна. Бодгаль 1-ийн орчмоос 1 ш богийн шагай, адууны 3 шүд, хугарсан ясан арал, баруун хөлний тахилзуурын тушаагаас хүрэл эдлэл, 2 ш ясан зэв илэрсэн ба хүний нурууны яс орчимд дахин 1 хүрэл зэв, хүрэл эдлэлүүд нэг дороос гарав. Мөн бодгаль 2-ын хөл болон цээжин хэсгээс 5 ширхэг ясан зэв илрэв. Оршуулга илэрсэн түвшин 65 см байв. Мөн дараас чулуун завсраас хүрэл товруу 1 ширхэг гарсан. Улмаар оршуулгын төв хэсэгт 1.3 м гүнээс баруун тийш хандуулан тавьсан оршуулга илэрсэн боловч ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн гарсангүй.

Шинээр бүртгэсэн буган хөшөөд: Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын 2-р баг Эвдэйн голын дагуу хийсэн хайгуул судалгааны дүнд 3 буган хөшөө бүртгэсний 2 буган хөшөө нь шинээр бүртгэгдэж буй дурсгал байлаа.

Хиригсүүр, буган хөшөөний тахилгын байгууламжийн малтлага судалгаа: Хожуу хүрлийн үед холбогдох буган хөшөө, хиригсүүрийн он цагийн ээдрээт асуудлыг тодруулах, тахилгын байгууламжаас илрэх адууны ясанд зан үйл, зооархеологийн судалгаа хийх шаардлагын дагуу судалгааны баг Улаан-Уул сумын Хоригийн аманд буган хөшөөний 1, Ренчинлхүмбэ сумын Зээрдэгчингийн хошуунд хиригсүүрийн 3, Тарган нуурт² буган хөшөөний 1 тахилгын байгууламж тус тус малтан судлав.

Хоригийн аманд малтсан тахилгын байгууламжаас адууны толгойн ясны жижиг үлдэгдэл олдсон бол Тарган нуурын буган хөшөөний тахилгын байгууламжаас адууны шүд 1 ш олдов. Эдгээр нь он цаг тодорхойлох чухал хэрэглэгдэхүүн юм. Харин Зээрдэгчингийн хошууны 1-р тахилгын байгууламжаас уламжлалт ёсоор зүүн урд зүг хандуулан тавьсан адууны толгой, хүзүү, туурайн яс гарсаны сацуу нэгэн сонирхолтой олдвор илэрсэн нь адууны толгойн дагзны арын хүрээ чулууны завсраас олдсон хүрэл хутга юм. Харин 2-р тахилгын байгууламжаас адууны дээд эрүүний хэсэг олдсон бол 3-р тахилгын байгууламжаас ямар нэгэн олдвор илэрсэнгүй.

² Тарган нуурын сав газраас шинээр илрүүлсэн буган хөшөөд. //Нүүдэлчдийн өв судлал. Боть XIV, Дэвтэр 6. УБ., 2013. т.61-77.




Зураг 1. Соёо толгойн суурингийн малтлага судалгаа



Зураг 2. Эвдэй голоос шинээр илрүүлсэн буган хөшөө

Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум,
Соёо толгой, Булш-3
2015.08.07



Зураг 3. Соёо толгойн 3-р булшнаас илэрсэн оршуулга болон дагалдах олдвор

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН “ХЭРЛЭН” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

*Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Браян Миллер,
Мартен Фурхольт, Леннарт Брандштетер,*

Уг судалгааны ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас МҮМ-н Эрдэм шинжилгээний төвийн дарга, археологич Ж.Баярсайхан, ЭША, археологич Т.Түвшинжаргал, нөгөө талаас ХБНГУ-ын Боннын их сургуулийн профессор Шериль Макравич, судлаач доктор Браян Миллер, Киёлийн их сургуулийн судлаач Мартен Фурхольт, Леннарт Брандштетер, ИБУИНВУ-ын Оберлиний их сургуулийн профессор Жош Вraith нар бусад туслах ажилчдын хамт хамтран ажиллав. Судалгааны баг 2015 оны 7 дугаар сарын 12-ноос 18 хүртэл 7 хоногийн хугацаанд Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Хэрлэнбарс-2 хэрэмт суурины орчимд ажиллав.




Геомагнетийн судалгаа: Судалгааны төслийн 2015 оны хээрийн судалгааны гол зорилго нь Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт буй Хэрлэнбарс-2 эртний хэрэмт дурсгал түүний эргэн тойронд геомагнетийн судалгаа хийж, уг дурсгалын дэвсгэр зургийг өндөр нарийвчлалтай хийхээс гадна хэрэмт дурсгалын дотор болон гадна талд буй эртний барилга байгууламж зэрэг хүний үйл ажиллгааны явцад бүтээгдсэн гудамж талбай, хогийн нүх, худаг зэрэг янз бүрийн эртний үлдэцийг илрүүлэн судлах ажил байв.

Уг дурсгалт газрыг анх монголын ууган археологич, нэрт эрдэмтэн Х.Пэрлээ 60 жилийн өмнө судлан шинжилж, хэрэмт дурсгалыг тойм дэвсгэр зураг үйлдэн, хэд

хэдэн газарт туршилтын малталт хийсний үр дүнд Хүннүгийн үед холбогдуулан үзсэн. Х.Пэрлээгийн нийтэлснээр зузаан шороо дагтаршуулан хэрмийг дөрвөлжин хэлбэртэй хийжээ. Хэмжээ нь хойд тал нь 345 м, зүүн тал нь 335 м. Энэ хэрэм он удаж хулширсан боловч одоогийн өргөн нь 4-5 м, өндөр нь 1-2 м, хэрэм хойд, өмнө хоёр талдаа тус бүр нэжгээд хаалгатай байжээ. Хэрмийн хойд хэсэгт 4 барилгын ор овгор газар байна. Зүүн талын овгор дээрээс шаврын шатсан шавхруу (баас) бага сага гарч байсан боловч 10 см малтмагц алга болжээ. Бусад овгор ба хэрмийн доторх талбайд эрт цагт хүн сууж байсны ул мөрийг үзүүлэх ямар ч зүйл олдоогүй байна¹. Үүнээс хойш энд өдгөө хүртэл ямар нэгэн судалгаа хийгдээгүй.

Бидний хийсэн геомагнетиин судалгаагаар хэрэмт хотын хэмжээ болон дотоод зохион байгуулалтын талаар илүү нарийн мэдээлэлтэй болов (Зураг 1).

Туршилтын малтлага судалгаа: Судалгааны баг геомагнетиин зураглалын үр дүнд Хэрлэнбарс-2 хэрэмт хотын дотор гурван газарт бага хэмжээний туршилтын малталт хийхээр төлөвлөсөн.



Зураг 1. Геомагнетиин судалгааны үр дүнд хийгдсэн Хэрлэнбарс-2 хэрэмт дурсгалын дэвсгэр зураг (Зураг дээр туршилтын малталт хийсэн газруудыг 1-3 тоогоор тэмдэглэв.)

¹ Х.Пэрлээ. Хэрлэн Бар гэдэг эвдэрхий хотыг малтан шинжилсэн тухай. ШУХБ. НУА. №2. УБ., 1957. Тал 142-143.



Туршилтын малталтын талбай-1: Энэ талбай нь хэрэмт суурины баруун хойд хэсэгт буюу өмнө нь Х.Пэрлээгийн малтан судалсан том овгор шороон багууламжийн баруун хойд талд геомагнетийн судалгаагаар илэрсэн дөрвөлжин байгууламжийн зүүн өмнө буланд өргөрөгийн дагуу 1м, уртрагийн дагуу 3м хэмжээтэй талбай байв. Энэхүү талбайг малтах явцад 50 см гүнээс модны нүүрсний жижиг хэсэг цөөн тоогоор олдсноос өөр ямар нэгэн эд өлгийн зүйл гарсангүй. Харин малтлагын явцад 60 см гүнээс 80 см гүн хүртэл илэрсэн маш хатуу хөрсний давхарга нь геомагнетийн судалгаагаар илэрсэн дөрвөлжин байгууламжийн бүтэц болох нь илэрхий болсон бөгөөд үүнээс доош 40 см орчим зузаан хатуу хар хүрэн хөрсний дороос байгалийн цагаан шаварлаг хөрс гарснаар малтлага дууссан билээ.

Туршилтын малталтын талбай-2: Энэхүү талбай нь хэрэмт суурины төв хэсэгт илэрсэн 5 м орчим голчтой дугуй хэлбэрийн байгууламжийн урд хүрээг огтолсон уртрагийн дагуу 3м, өргөрөгийн дагуу 1м хэмжээтэй. Малтлагын явцад 30 см гүнээс зээрийн турууны яс 4 ширхэг яс гарснаас өөр ямар нэгэн эд өлгийн зүйл гараагүй. Мөн малтлагын явцад геомагнетийн үр дүнд илэрсэн дугуй нүхний хүрээ болон байгалийн хөрсний ялгаа тодорхой мэдэгдсэн бөгөөд байгалийн хөрс нь цагаан шаргал шаварлаг, элсэрхэг хөрстэй байсан бол нүхний хатуу хар хөрс доош үргэлжилж байв.

Туршилтын малталтын талбай-3: Уг талбай нь геомагнетийн судалгааны үр дүнд хэрэмт суурингийн өмнөд болон зүүн хэсэгт илэрсэн өргөрөгийн дагуу байрлалтай хэд хэдэн урт шулуун шуудуу мэт байгууламжуудын хамгийн урд талын байгууламжийг уртрагийн дагуу хөндлөн огтолсон 2х1 м хэмжээтэй.

“ДОРНОД МОНГОЛ” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ТОВЧ ҮР ДҮН

Д.Түмэн

2015 оны 06 сарын 27 өдөр хүрэлцэн ирэв. Нийт 8 монгол оюутан 5 гадаад оюутан 2 жолоочийн хамтаар ажиллав. Энэ жилийн ажил Улаанзуухын хамгийн баруун эгнээний олон булштай бүлэг оршуулгыг гүйцэд малтах зорилго тавин ажиллав. Бидний урьд малтсан байсан 16, 16а булшнаас урагш, мөн өмнө малтсан 29, 30-р булштай тулган бүх талбайгаар 19 м урт 10 м өргөнтэйгээр малтлагыг хийж гүйцэтгэлээ. Цэвэрлэгээг 20 см гүнтэйгээр хийж гүйцэтгэсэн боловч манаас, өрлөг чулууд зарим хэсгээрээ дутуу илэрч байсан хэсгүүдэд 35 хүртэлх см гүнтэй боллоо. Цэвэрлэгээний дараачаар өөр хоорондоо манаас болон хүзүүвчээр холбогдсон 4 булш илрэв.

Зарим булш хайгуулын дугаарлалтад тоологдоогүй байснаас гадна GPS багаж ашиглан дэвсгэр зургийг үйлдсэн учир алдаа мадаг ихтэй, булш хоорондын байршил хэт ойр зэргээс хамааран дэвсгэр зургийг дахин шинэчлэх хэрэгтэй болов. Шинэчлэн хийсэн дэвсгэр зургийн дагуу өнөө жил малтсан булшнуудыг 16-р булшнаас үргэлжлүүлэн DK UZ-17, 18, 19, 20 хэмээн шинээр дугаарласан болно. Дээрх дурсгалууд бүгд Улаан зуух хэв шинжийн булшны онцлогыг бүрэн харуулсан дурсгалууд байлаа.

DK UZ-17-р булш. DK UZ-16а булштай залгаа урд талд 2.2 м зайд оршино. Хашлага ба өрлөг чулуудын ихэнхи хэсэг эвдэгдсэн тул анх гаднаас танигдаагүй. Анх цэвэрлэгээг гүйцэтгэсний дараачаар гол өрлөгийн урд хэсэг илэрснийг дагуулан цэвэрлэж зарим хэсгээр 40 орчим см гүнтэй хийж байж булшны гадаад бүтцийг тоймлон харах бололцоотой болов. 18-р булшны баруун хойд булантай зүүн урд булангаараа холбогдон оршино. Булшны толгой болон хөл талдаа цөөн тооны чигжээс чулуудтай. Бусад талбайгаар чулуугүй байна. Булшны баруун хойд болон зүүн урд булангийн чулууд гойд өндөр. Газрын хөрснөөс 50 см гүнтэй цэвэрлэж байж гадна хашлага, дотор өрлөг чулуудын доод ирмэг бүрэн илрэв. Булшны гадаад хэмжээ энэ гүнд тодорхой болов. Булшны зүүн урд булангийн хэсэг харьцангуй бүтэн буюу 60 орчим см өргөнтэй бол хөл хэсгийн өрлөг чулууд эвдэгдэж 2 үе төдийхөн 25 см өндөртэй байна. булшны баруун урд булангаас цэх буюу урд зүгт татсан гээг хэлбэртэй дагуул байгууламжыг чулуудыг хавиргалан зоож хийжээ. Түүний урт 1.8 м, өргөн дунджаар 70 см байх ба үзүүр тийшээ нарийссан байдалтай байна.

Баруун хойд булангийн чулуу уналгүй үлдсэн байх ба бусдаас өндөр зоогдсон байна. Өндөр 75 см. Булшны гадна хэсгийн ихэнхи хашлага чулууд унаж алга болсон байдалтай. Байгаа үлдсэн хэсэг чулууд нь дотор өрлөгтэйгээ чацуу байгаа байдалтай. Зүүн урд булангийн хашлага 80 см өндөртэй. Булшны хэмжээ 3.3х4.1 м. Зүүн хойш чиглэлтэй. 18-р булшны баруун хойд булантай зүүн урд булангаас татсан 1.9 м урттай чулуун холбоосоор холбогдсон байна. Уг холбоосыг хийхдээ бүх чулуудыг манаас чулуудаас ялгаатайгаар босоо байдлаар хийсэн байна. Босоо чулуудыг зоогоод түүний гадуур давхар манаас чулуудыг хийжээ. Холбоосын өргөн 80 см. Өндөр 60 см. Булшны чигжээс чулуудыг байгалын хөрсөнд тултал зайлуулахад талбайн төв хэсгээс хавтгай чулуу бүхий бор хүрэн өнгийн толбо илрэв. Энэ түвшинд булшны дотор өрлөгийн байдал сайн мэдэгдэж байна. Булшны хойд хана ихэд эвдэгдэж 1 үе төдий 30-40 орчим см өндөртэй бол урд хананы өрлөг 60 см өндөртэй байна. Толбо зүүн хойш чиглэлтэй 2.1х1.1 м хэмжээтэй. Нүхийг таглаж таг чулууд тавьсан ба хөл талын таг чулуу хугарч унасан.



Ойролцоогоор 50 см хэмжээтэй. Толбыг дагуулан 15 см малтахад нүхний толгой хэсгээс хүний 1 ш үүдэн шүд илэрлээ. Уг шүдний доороос хүний гавлын яс уруугаа харсан байдалтайгаар түүний ойр орчмоос хүний эрүү, хавирга, нугалам нурууны яснууд эмх замбараагүй олдов. Мөн малын ясны хугархай хэсэг илрэв. Хүний гавлын яс муу хадгалагдсан ба нүүрэн хэсэг байхгүй болжээ. Толбо илэрснээс доош 40 см гүнд хүрэхэд оршуулга илэрлээ. Хүний бүсэлхий хэсгээс доошхи яс бүрэн үлдсэн ба нас барагчийг зүүн хойд зүгт хандуулан түрүүлэг нь хандуулан оршуулжээ. Цээжин хэсэг бүхэлдээ тоногдсон байдалтай. Мөн 2 гарын яс анхны тавилтаараа үлджээ.

DK UZ-18-р булш. Улаан зуух 19-р булштай толгой талаараа зэрэгцэн оршино. Хэмжээний хувьд жижиг. Манаас чулуудыг зайлуулах явцад булшны хойд толгой талд залган байгуулсан жижиг чулуун байгууламж илрэв. Уг байгууламжийг 18а хэмээн дугаарлав.

Уг булшны хөл хэсэг нэлээд өндөр толгой тал намхан. Толгой талын голд орших 3 том хашлага бусдаас гойд өндөр бүтэн үлдсэн байна. 19-р булштай манаас чулууд үгүйгээр шууд залгагдан байгуулсан нь сонирхолтой буюу уг булштай нэгэн доор байгуулсан болохыг илэрхийлж байна. 19-р булшны гадна хашлагыг ашиглан шууд байгуулсан ажээ. Булшны төв хэсгийн чигжээс чулууд овгор, эмх цэгцгүй байдалтай. Булшны хөл хэсгийн өндөр 40 см. Толгой талын өрлөгийн өндөр 25 см орчим. Зүүн хойд булангийн өрлөг чулуудаас нэлээд нь алга болсон. Толгой талын хашлагын өндөр 84 см, өргөн 50 см. Зүүн урд булан эвдэгдсэн тул энэ хэсгийн залгааг харах боломжгүй байлаа. Өрлөгийн хэмжээ 3.5х2.9 м. Зүүн хойш 60 хэмд чиглэсэн. Булшны толгой хэсэг яльгүй өргөссөн. Булшны чигжээс чулуудыг 2-3 үе зайлуулахад 40 см гүнд бүх талбайгаар байгалын хөрс илрэв. Талбайн гол хэсэгт бор хүрэн өнгийн толбо илэрлээ. Ирмэгийг тойруулан урт нарийн чулуудыг залган тавьсан. Булшны урд хэсэг буюу 19-р булштай залгагдах хэсэгт зөөлөн бор хөрстэй том том чулуудтай байгаа нь тонуулчдын ул мөр бололтой. Мөн энэ түвшинд мэдэгдэхгүй байсан булшны дотор өрлөгийн урд хэсгийн 2 үе чулууд тодорлоо. Ойролцоогоор 40 см орчим өндөртэй. Эдгээр нь 18, 18-р булшийг хамт байгуулсан болохыг илэрхийлж байж болох талтай. Толбоны урт 170 см, өргөн 70 см. Булшны нүх болон булшны чиглэл хоорондоо зөрөөтэй. Зүүн хойш 50 хэмд чиглэсэн. Тонуулчид нүхний урд хэсгийг нэлээд эвдэлж сүйдэлсэн. Толбыг дагуулан 15 см малтах үед цээжин хэсгээс эмх замбараагүй байдалтай хавтгай чулууд болон хүний хавирга болон гавлын ясны хэсгүүд анхны байрлалаа алдсан байдалтай олдов. 45 см гүнд оршуулга илрэв. Хүний 2 гарын болон бүсэлхий хэсгээс доош яс анхны байрлалаа хадгалан үлдсэн. Цээж болон толгой хэсгийг тонуулчид бүрэн тонож сүйдэлжээ. Хүний 2 гарыг аарцаг доор хийж, 2 хөлийг нийлүүлэн өвдгөөр нь хойд зүг яльгүй нугалсан байна. Нас барагчийг түрүүлэг нт харуулан оршуулжээ. Дагалдуулсан ад өлгийн зүйл үгүй. Нүхний цээжин хэсэгт хүний хавирга, бугалга зэрэг яснууд бөөгнөрсөн байдалтай байна. нүхний хэмжээ 1.9х40-45 см ажээ. Үүнээс доош байгалын хөрс илэрч малтлагыг дуусгав.

18а тахилга: Хэмжээ 1.5х1.2 м. Нэлээд эвдэгдсэн шинжтэй. Хэлбэр адилхан, өндөр 30 см, 2-3 үе өрлөгтэй. Хөшөө чулууны өндөр ойролцоогоор 55 см. Зүүн хойд булан эвдэрсэн, гол хэсэгтээ чулуугүй байдалтай. Байгууламжийн гол хэсэгт малтлагыг бүх талбайгаар байгалын хөрс тултал малтав. Өрлөгийн голын зай 80х55 см. Энэ хэсэгт 40 см гүнд бүх талбайгаар байгалын шар хөрс тулав

DK UZ 19-р булш. Энэ эгнээний нэлээд томд тооцогдох булш. Цэвэрлэгээг хийх явцад түүний хөл болон толгой хэсгээс 10 см гүнд бод малын шагайн яс илэрч

байв. Улаан зуух 18 болон 20-р булшны дунд оршино. 8х5.5 м хэмжээтэй. Толгой талын өрлөг чулууд дотогшоо ялимгүй хотойсон байдалтай. Гол хэсгээрээ 50 см дотогш хотойсон буюу 7.5 м урттай болж байна. Толгой талын хашлага чулууд бүгд алга болсон. Төв хэсэгтээ битүү чулуун чигжээстэй. Өрлөгийн өндөр 60 см. Гол хэсгээрээ овгор, хөл хэсгээрээ намхан байдалтай. Зүүн урд булан орчмоор өндөр хашлага чулууд үлдсэн байна. Өндөр 61см орчим. Өрлөгийг ерөнхийдөө 3 үе чулуугаар хийжээ. Зүүн хойш чиглэлтэй. 40 см гүнд булшны толгой хэсгээс адууны шүд илэрч байв. Чигжээс чулуудыг 2-3 үе зайлуулан том хэмжээтэй чулууд үргэлжилсээр 80 см гүнд хүрэхэд талбайн ихэнхи хэсгээр байгалын зөөлөн шар хөрс илэрч байх ба талбайн гол хэсэгт том, урт чулуудаар ирмэгийг нь тойруулан эмжсэн бор хүрэн өнгийн толбо илэрлээ. Хөл хэсэгт нэгэн хөндлөн чулуу байх ёстой хэдий ч алга болсон бололтой. Нэлээд том хэмжээтэй, дугариг хэлбэртэй толбо байна. Анх битүү чулуун тагтай байсан байж болзошгүй. Хашлагын урд хэсэгт байрнаасаа хөдөлсөн бололтой хавтгай чулууд байлаа. Одоо байгаа толбоны хэмжээ 2.3х1.4 м. Хашлагын гол хэсэгт малтлагыг үргэлжлүүлэхэд 10 см гүнд нүхний толгой талд бог малын шагай, шилбэ, илрэв. Шагайны хошуу хэсэг хойд зүгт чиглэсэн. 20 см гүн малтахад маш муу хадгалагдсан хүний нугалам нуруу, дал, хавирга яснууд илэрснээс гадна 2 хавтгай нэгэн гонзгой чулууг хөндлөн тавьсан байв. Түүний доороос хүний ясны хэсгүүд цухуйж байв. Урт хөндлөн чулуу 75х22 см хэмжээтэй. Энэ орчмоос олон тооны жижиг чулууд илэрч байв. Толбо илэрснээс доош 40 см гүнд оршуулга илрэв. Хүний шуу хэсгийн яснаас доош араг яс бүтэн илрэв. Цээжин хэсгийг тонуулчид сүйдэлсэн. Хүнийг зүүн хойд зүгт хандуулж /70-80 хэмд/ тэнэгэр байдалтайгаар түрүүлэг нь хандуулан оршуулжээ. Зүүн хөлний яс гадна чулуун хашлага доогуур ялимгүй шурган орсон байгаагаас үзвэл оршуулгын нүхийг ухсаны дараачаар уг чулуудыг байрлуулсан байна гэж үзүүштэй. Оршуулгын цээжин хэсэгт хүний нуруу, эгэм, хавирга болон адууны шүд тодорхой зохион байгуулалтгүй олдов. Тонуулчид хашлага чулууны зүүн урд хэсгийг эвдэн орсон бололтой. Оршуулгын нүхний хэмжээ 1.8х0.55 м. нийт гүн 1.2 м.

DK UZ-20-р булш. Улаан зуух 29, 30-р булштай холбогдох хэсэгт орших жижиг булш. 19-р булшны дунд хэсэгт 80 орчим см зайтай манаас чулуудаар холбогдоно. Цэвэрлэгээний явцад ямар нэгэн зүйл илрээгүй. Бид чулуун хашлагыг тойруулан 55 см малтаж булшийг бүрэн гаргав. Нийт хашлага чулууд дотор өрлөгтэй чацуу хийгдсэн хэдий ч баруун хойд булангийн 2 чулуу бусдаас өндөр байна. өндөр 75 см. Дотор өрлөг 45 см өндөртэй ажээ. Булшны цээжин хэсэг чулуугүй илт тоногдсон шинжтэй. Хэмжээ 2.8х2 м. Зүүн хойш чиглэсэн. Булшны чигжээс чулуудыг 3 үе зайлуулж талбайг цэвэрлэхэд 60 см гүнд 115х70 см хэмжээтэй бор хүрэн өнгийн цөөн тооны чулуудтай толбо илэрлээ. Толбыг дагуулан 25 см гүн малтахад таг чулууд бололтой хавтгай чулууд толгой болон хөл хэсэгт хугарч унасан байдалтай олдов. Нүхний хэмжээ гүн болох тусам багассаар 40 см хүрэхэд 143х60 см болов. Цээжин хэсгээс малын шилбэний ясны хугархай, хүний чамархай ясны хэсгийн хамт илэрлээ. Үүнээс доош байгалын хөрс илэрсэн тул малтлагыг зогсоолоо. Өсвөр насны хүүхдийн яс байсан бололтой. 2015 онд бидний малтан судласан дээрхи булшнаас археологийн олдвор гараагүй хэдий ч булшны гадаад, дотоод байгууламж, оршуулгын зан үйл нь өмнөх жилүүдэд малтан судласан булшнуудтай адил байлаа.

ХОВД АЙМГИЙН МЯНГАД СУМЫН “УРД УЛААН ҮНЭЭТ” УУЛАНД ХИЙСЭН ХАДНЫ ОРШУУЛГЫН МАЛТЛАГА СУДАЛГАА

Ж.Баярсайхан, Т.Түвшинжаргал, Ч.Баяндэлгэр

2015 оны 4 дүгээр сарын эхээр Ховд аймгийн Мянгад сумын Цагаанбулаг багийн нутаг “Улаан үнээт” хэмээх газарт тонуулчид хадны оршуулга эвдэн сүйтгэсэн гэх мэдээллийн мөрөөр Монголын үндэсний музейн Эрдэм шинжилгээний төвийн археологийн судалгааны баг 2015 оны 5 сарын 1-нээс 10-ныг хүртэлх хугацаанд ажиллав. Судалгааны багийг Ховд хотод очиход аймгийн цагдаагийн газарт тонуулчдаас хураагдсан хөвчтэй нум, сум, саадаг, хоромсого, сэнжтэй модон бутан сав, эвэр иштэй төмөр хутга, эмээлийн мод, эвэр зуузаатай төмөр амгай зэрэг хадны оршуулгаас олдсон олдвор эд өлгийн зүйлсийг прокуророор дамжуулан аймгийн музейд хүлээлгэн өгсөн байсыг сэргээн засварлалт, бэхжүүлэлт, судалгаа хийх шаардлагатай тул Үндэсний музейд шилжүүлэн авч ирэхээр болов.

Улмаар судалгааны баг Мянгад сумын Урд улаан үнээт ууланд буй хадны оршуулга бүхий агуйд малтлага судалгаа хийж, агуйн гадуур бусниулж орхисон олдворуудыг түүвэрлэж авав. Тус агуй нь Ховд аймгийн Мянгад сумын төвөөс зүүн хойд зүгт 20-иод км-т Урд улаан үнээт уулын зүүн энгэрт байх сэнжтэй хадны доод талд уртраг өргөрөгийн N 48°19'967; E092°10'399 солбилцолд, далайн түвшнээс дээш 1327 м өндөрт байрлана. Сэнжтэй хадны зүүн хажуу талд баруун урдаас зүүн хойд зүг чиглэлтэй 670 см урттай 230 орчим см өргөнтэй нэвт нүхтэй буюу хоёр амтай агуйн хонгил юм.


Хонгилын баруун урд талын ам нь 270 см өргөнтэй, 100 см өндөртэй. Уг амыг гурван том чулууг зэрэгцүүлэн тавьж, жижиг чулуудаар чигжиж тагласан байсны дунд талын чулууг оршуулгын толгой тал руу унагасны улмаас авсны дээд хэсгийг цааш цөм цохин эвдсэн байлаа. Баруун урд амны гадна талын дэвсгэрт хар сортой зэрлэг амьтны арьсаар хийсэн хувцасны тасархай хэсэг, арьстайгаа хатсан адууны толгой, хүзүү, туурайны доод гурван үе, сүүл буюу “Зүлд” зэргийг гарган хаясан байв.

Агуйн зүүн хойд талын ам нь 210 см өргөн, 130 см өндөртэй. Үүний ойр орчмоор авсны модны хэсгүүдийг тараан хаясан байлаа. Уг амны дунд хэрд нэгэн том чулуу байх бөгөөд том чулууны дээд талаар чулуу өрж хонгилыг хаасан байсан бололтой. Энэ том чулууны хажуу талаар жижиг чулууд гадагш нурсан байх бөгөөд зүүн урд талаар хаалт маягийн өрлөгийн хэсэг мэдэгдэж байв. Уг өрлөг хэсгийн дээд хэсгээр зүүн зүг салаалсан бага зэрэг доош чиглэлтэй гадагш нэвт гарсан бас нэгэн жижиг ам байсныг дотор талаас чигжиж тагласан байна. Энэ амны өргөн нь 100 см орчим, өндөр нь 70 см хэмжээтэй.

Уг хаалтны нуранги чулууд дээр зүүн урд хананд шахан хүний цээжний хэсэг, толгойг салгасан байдалтай дээл хувцасны үлдэгдэлийн хамт бөөгнүүлэн орхисон байв. Бид нэгэнт байрнаас нь хөдөлгөж, ил гаргасан олдворуудыг баримтжуулан авч, агуйн хоёр талын амнаас гаргасан шороог шалган цэвэрлэгээ хийв. Цэвэрлэгээ хийх явцад зүүн хойд амны үүд рүү гаргасан шороон дотроос ам нь боодолтой нимгэн арьсан ууттай зүйл олсон ба уутны цоорхойгоос дугуй болон зууван дугуй хэлбэртэй, зарим нь дээрээ тамга тэмдгийн дүрслэлтэй модон эдлэлүүд харагдаж байв. Мөн өөр нэг жижиг ширэн уут олдсон ба хоёр салаа модоор хавчуурга хийн хавчиж нарийн сураар хоёр талын үзүүрийг бөхлөн амыг нь хаасан байлаа.



Зураг 1. Модон сав



Зураг 2. Ширэн ууттай модон эдлэлүүд



Зураг 3. Авсыг цэвэрлэж гаргасан байдал.



Зураг 4. Хадны оршуулгаас олдсон эмээлийн мод



Улмаар судалгааны багийнхан тонуулчдын дотогш түлхэж унагаасан том чулууг гаргаж, авсны орчимд малтлага хийхэд авсны урд талд хүний хөлийн хэсэг анхны байрлалаа хадгалан үлдсэн байв. Авсны толгой талаас хар өнгөтэй хүний бололтой үсийг туг тугаар салаалсан үс илрэв. Үсийг үс болон нарийн сураар зангидан байсан бололтой ганц хоёр тугууд илрэв. Мөн адууны үс байж болохоор зөөлөн шаргал /зээрд/ өнгийн үс, адууны хоёр нугалам хүзүүний яс зэрэг гарав. Авсны шалаар багцаалан үзэхэд NW 320°-д буюу баруун хойд зүгт хандуулан оршуулсан байжээ. Уг авс өвөрмөц хийцтэй бөгөөд шургааган модон хүрээ зангидаж хоёр талаас нь урт нарийн ховил гарган, засаж янзалсан богино хавтгай моднуудыг хөндлөн байрлалаар ховилд суулган хийжээ. Авсны урт 192 см, толгой хэсэгийн өргөн 64 см, хөл хэсгийн өргөн 34 см хэмжээтэй.

Хадны оршуулгаас олдсон олдворууд нь маш сайн хадгалалтай. Эртний судлал болоод үзмэр үзүүллэгийн онц чухал ач холбогдолтой олдворууд юм. Эмээлийн модны хэлбэр хийцээс үзвэл Дундад этний нүүдэлчдийн буюу VI-X зууны үед холбогдож магадгүй хэмээн урьдчилсан байдлаар таамаглаж байна.

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН 2015 ОНД ХИЙСЭН
АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ МАЛТЛАГА СУДАЛГАА**

*Ж.Баярсайхан, Ц.Одбаатар, Т.Түвшинжаргал,
Г.Бүрэнтөгс, Ч.Баяндэлгэр*

Монголын Үндэсний Музей нь 2015 онд археологийн авран хамгаалах малтлага судалгаа дөрвийг, авран хамгаалах хайгуул судалгаа нэгийг хийж гүйцэтгэжээ.

Д/д	Хариуцагч аж ахуйн нэгж байгууллагын нэр	Ажлын хэлбэр	Оршин буй засаг захиргаа	Газар нутгийн нэр	Малтан судалсан дурсгал. Хайгуулаар олдсон дурсгал.
1	Алтан дорнод Монгол	Малтлага	Булган аймаг Дашинчилэн	Элст-Ар Дунд гозгор	Хүннүгийн жирийн иргэдийн булш 18, Монгол булш 5, Түрэгийн үеийн булш 1
2	Эгийн голын усан цахилгаан станцын төслийн нэгж	Малтлага	Булган аймаг Хутаг-Өндөр	Дархан уул Уургын гол Шар могойтын дэнж	Хүрлийн үеийн дурсгал-10, Дундад зууны үед холбогдох булш-1, Хадны оршуулга-1, Тахилын байгууламж-7
3	Залуус хороолол	Малтлага	Орхон аймаг Эрдэнэт хот	Эрдэнэт хот	Хиргисүүр-1
4	Эрдэнэт үйлдвэр	Малтлага	Орхон аймаг Эрдэнэт хот	Эрдэнэт хот	Тахилын Онгон, Зэл чулуу
5	“Илт гоулд”	Хайгуул	Төв аймаг, Заамар сум	Бумбат-2	Тахилын байгууламж-1



Булган аймгийн Дашинчилэн сумын Доргонот багийн нутаг Элст-ар /5 сарын 13-аас 6 сарын 10/


МҮМ Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Элст-Ар, Дунд гозгор хэмээх газруудад “Алтан Дорнод Монгол” ХХК-ны захиалгаар археологийн авран хамгаалах малтлага судалгааг хийж гүйцэтгэв.

Элст-Арын бүлэг булшийг анх 2004 онд Монголын Үндэсний Түүхийн Музейн археологийн судалгааны баг “Алтан Дорнод Монгол” ХХК-ийн уурхайн хайгуулын талбайд археологийн хайгуул судалгаагаар олжээ. 2011-2012 онд ШУТИС-ийн баг нийт 13 булш малтан судалсан бөгөөд, 2015 онд бид Элст-Арын үлдсэн 18 булшийг малтан судлав. Эдгээр нь Хүннүгийн жирийн иргэдийн булш оршуулгын дурсгалууд юм. Малтлагын үр дүнд эндээс алтан ээмэг, хүрэл хонх, хүрэл толины хагархай, төмөр зэв, ваар сав суулганы хагархай, олон төрлийн ясан эдлэл зэрэг олдвор хэрэглэгдэхүүнээс гадна хүүхдийн оршуулга, хөмөгт оршуулга зэргийг нээн илрүүлж судалгааны эргэлтэнд оруулахад бэлэн болгоод байна.

Мөн Туул голын баруун бие Доргонот, Элстийн өндөр уулсын ард сондгой орших Дунд гозгор уулын Дөрөө хавчдагийн аманд нийт 8 булш малтан судаллаа. Малтлага судалгааны үр дүнд дундад зууны монголчуудын булш оршуулга 5, Түрэгийн үед холбогдох булш 1, тахилын байгууламж 2-ыг тус тус малтаж хүрэл толь, дөрөө, амгай, Түвэдийн “ОМ” үсэг бүхий хүрэл товруу, хэд хэдэн төрлийн зэв олжээ. Элст-Ар, Дундгозгор уулын Дөрөө хавчдагийн аманд хийсэн малтлагаас олдсон олдвор хэрэглэгдэхүүнийг судалгааны эргэлтэнд оруулахаас гадна, сэргээн засварлуулж музейн сан хөмрөгийг баяжуулах ажлыг хийж байна.



Булган, Дашинчилэн, Элст-Арын дурсгал



Эгийн гол, Дархан уул, 076 хиргисүүр

Эгийн голын УЦС-ын Усан сан үүсэх талбайд явуулсан археологийн авран хамгаалах малтлага судалгаа /6 сарын 3-аас 8 сарын 1/

Эгийн голын усан цахилгаан станцын төслийн нэгжийн захиалгаар Монголын Үндэсний Музей Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг дэвсгэрт археологийн авран хамгаалах малтлага судалгааг хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааны анги Дархан Уул, Уургын гол, Шар могойтын дэнж хэмээх газруудад Хүрлийн үед холбогдох 10 дурсгал, маанийн үсэг бүхий 1 байгууламжийг малтан судалснаас гадна, Дундад зууны үед холбогдох 1 булш, 1 хадны оршуулга, 7 тахилын байгууламж шинээр илрүүлэн олж малтлага судалгааны ажлыг

гүйцэтгэлээ. Дархан уулын DU1-076 дугаартай хиргисүүрийн оршуулгаас хүний шатсан яс олдсоноос гадна хүрэл товруу, хүрэл бүсний чимэглэл зэрэг судалгааны өвөрмөц олдвор, хэрэглэгдэхүүнүүдийг баримтжуулж авчээ.

**Эрдэнэт үйлдвэрийн хиймэл нуурын ард явуулсан
археологийн авран хамгаалах малтлага судалгаа
/10 сарын 4-өөс 10 сарын 24/**

Эрдэнэт үйлдвэрийн хог хаягдлын аж ахуй буюу хиймэл нуурын ард археологийн зарим дурсгалууд байгаа талаар Орхон аймгийн музейн зүгээс бидэнд мэдээлсний дагуу үйлдвэрийн удирдалагуудтай ярилцаж, авран хамгаалж малтан судлахаар болсон юм. Тэдгээр нь Түрэгийн үед холбогдох зэл чулуутай болон жирийн овоолго чулуу бүхий тахилын онгонууд байлаа. Малтлагын явцад зэл чулуу бүхий тахилын онгоны урд талд орших жижиг чулуун байгууламжаас бага насны хүүхдийн оршуулгыг илрүүлэв. Хүүхдийг толгойгоор нь баруун хойд зүгт хандуулан, ямар нэг эд өлгийн зүйл дагуулалгүй оршуулжээ. Бусад тахилын онгоноос адууны хугархай эрүү, шүдний үйрмэг, гал түлсэн шинж тэмдгийг илрүүлэв. Мөн дугуй хэлбэрийн дараас чулуутай тахилын онгоноос газарт зоосон модон шонгийн үлдэгдлийг илрүүлсэн болно.

**Орхон аймгийн “Залуус” хорооллын орчимд явуулсан
археологийн авран хамгаалах малтлага судалгаа
/8 сарын 4-өөс 8 сарын 24/**

Орхон аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн музей болон Боловсрол, Соёлын газраас тавьсан хүсэлтийг үндэслэн “Залуус” хорооллын орчимд баригдаж буй барилгын хашаанд орсон хиргисүүрийг авран хамгаалж малтан судаллаа. Тус хиргисүүр нь хүрлийн үеийн бусад хиргисүүртэй гадаад байгууламж хийгээд тахилгын зан үйлийн хувьд үндсэндээ ижил болохыг тогтоов. Хиргисүүрийн голын овоолго чулууны малтлагаар анхны байрлалаа алдсан хүний цөөн яс, мөн зарим тахилын байгууламжаас зүүн зүгт хандуулан тавьсан адууны толгой болон богийн эвдэгдсэн яс зэрэг зүйлсийг илрүүлэв.

**Төв аймгийн Заамар сумын нутаг “Бумбат-2” ашигт малтмалын
талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгаа
/9 сарын 28-аас 10 сарын 5/**

Тус музейн судалгааны баг “Илт Гоулд” ХХК-ний захилгаар Төв аймгийн Заамар сумын нутаг Бумбат уулын зүүн талд орших “Бумбат-2” ашигт малтмалын, 690.4 га талбайд археологийн хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэв. Дээрх талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны үр дүнд тахилын байгууламж бололтой дугуй хэлбэртэй, овоолж тавьсан чулуун байгууламж нэгийг бүртгэсэн байна.

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН “ЭРТНИЙ МОНГОЛ ХҮН” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ТОВЧ ҮР ДҮН

Ц.Амгалантөгс, Миямото Казуо, Н.Батболд,
Л.Дэлгэрмаа, Э.Амарболд

2009 оноос эхлэн Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн (хуучнаар), Япон улсын Кюүшүгийн Их Сургуультай хамтран “Эртний Монгол хүн” төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Уг төслийн хүрээнд Монголын хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булш, шоргоолжин булшны малтлага судалгааг Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Дарам уул, Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвш уул, Баянхонгор аймгийн Богд сумын нутаг Орог нуурын хойд эрэгт орших Бор овоо хэмээх газруудад хийсэн юм. Төслийн зорилго нь Дорнод Монголын хээр талаас, Говь болон Алтайн уулархаг бүс нутгийн Хүрэл зэвсгийн үеийн (НТӨ III мянганаас НТӨ VII зуун) эртний нүүдэлчдийн угсаа гарвал, тэдгээрийн үлдээсэн дурсгалуудын хоорондын холбоо хамаарал, палеоантропологийн хэв шинж, нүүдэл, суурьшил, эрхлэх аж ахуй, хамаарах он цаг зэргийг илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурлан гаргаж ирэхэд чиглэгдэнэ.

Малтлага судалгааны үр дүн

Говь-Алтай аймгийн Тонхил сум нь Монгол Улсын баруун хязгаар, Монгол Алтайн нурууны уул, тал, говь хээр хосолсон нутагт оршдог. Хойт талаараа Дарви сумтай, зүүн талаараа Төгрөг, Бугат сумтай, баруун талаараа Ховд аймгийн Цэцэг, Алтай сумтай, урд талаараа БНХАУ-тай тус тус хил залгана.

Сумын баруун урд зүгт 45 км-т Бүс багийн нутагт хойт талаараа улаан хүрэн өнгийн боржин хадтай, зүүнээс баруун хойш үргэлжилсэн уулыг Хяр хараач



Хяр Хараачийн цогцолбор дурсгалуудын дэвсгэр зураг

хэмээн нэрлэнэ. Энэхүү уулын зүүн урд бэлд дугуй болон дөрвөлжин хэлбэрийн хүрээтэй дөрвөн талдаа хөшөө чулуутай хиргисүүр болон буган хөшөө, тахилын байгууламжууд нийлсэн 30 тооны дурсгалууд цогцолбор болон оршино. Дурсгалуудыг баруунаас эхлэн дугаарлан 1, 18, 19, 20-р дурсгалуудыг сонгон малтлаа.

Дурсгал-1. Дөрвөлжин хэлбэрийн чулуун хашлагатай, дөрвөн буландаа хөшөө чулуутай бөгөөд зүүн хойт талын хөшөө чулуу унаж үгүй болсон байна. Хашлаганы дотор талд жижиг чулуугаар битүү чигжэн үйлдсэн ба он цагийн явцад хөрсөнд дарагдаж газрын хөрстэй ижил түвшинтэй болжээ. Дурсгалын төв хэсэгт том хавтгай чулуунуудыг давхарлан дарж тагласан ба эдгээр чулуунууд нь газрын хөрснөөс дээш бага зэрэг ялгарч харагдана. Дурсгалын байрлах газар нь хойноос урагш үл ялиг хазгай бөгөөд урд талын хүрээ бусад хэсгээсээ мэдэгдэхүйц өндөр ажээ. Газарзүйн солбицол: хойд өргөрөгийн $45^{\circ}56'48.1''$, зүүн уртрагийн $093^{\circ}56'15.5''$ солбицолд оршино. Хэмжээ: 900 см х 800 см. Баруун хойд талын хөшөөний өндөр 50 см, өргөн 28 см, баруун урд талын хөшөөний өндөр 89 см, өргөн 80 см, зүүн урд талын хөшөөний өндөр 73 см, өргөн 46 см. Олдвор, эд өлгийн зүйлс: Уг дурсгалаас ямар нэгэн олдвор, эд өлгийн зүйл гараагүй бөгөөд хадгалалт сайн хүний оршуулга илэрсэн. Хүний ясны товч судалгаа: Хүний ясанд хийсэн анхан шатны судалгааны үр дүнд 50-55 орчим настай, 167.3 см дундаж өндөр, эрэгтэй хүн болохыг тогтоов.

Тахилын байгууламж-18. 20-р дурсгалын баруун урд 4 м зайд байрлана. Уг тахилын байгууламж нь зүүнээс баруун тийш чиглэлтэй, дөрвөлжин хэлбэрийн хашлагатай бөгөөд дараасыг жижиг шаргал өнгийн боржин чулуугаар битүү чигжиж, дээр нь жижиг цагаан өөхөн чулуунуудыг тараан үйлджээ. Газарзүйн солбицол: хойд өргөрөгийн $45^{\circ}56'46.4''$, зүүн уртрагийн $093^{\circ}56'20.0''$ солбицолд оршино. Хэмжээ: Чулуун байгууламж 700 х 900 см, зэл чулуудын дундаж өндөр 8-26 см. Олдвор, эд өлгийн зүйлс: Уг дурсгалаас ямар нэгэн олдвор, эд өлгийн зүйл, хүний яс гараагүй бөгөөд бог малын шатсан яс цөөн тоотой гарсан.



1-р булш



20-р булш

Тахилын байгууламж-19. 18-р дурсгалын зүүн талд 3 м зайд зэрэгцэн байрлана. Хавтгай том чулуунуудыг хажуу бөөрөөр нь босгон дугуй хэлбэрт оруулж дотор талд нь том том чулуунуудыг битүү чигжэж хийжээ. Энэхүү дурсгал нь 18-р дурсгалын дагуул тахилын байгууламж бололтой. Газарзүйн солбицол: Хойд өргөрөгийн $45^{\circ}56'46.4''$, зүүн уртрагийн $093^{\circ}56'20.5''$ солбицолд оршино. Хэмжээ: Голч 400 см. Хашлага чулууны дундаж өндөр 35- 62 см. Олдвор, эд өлгийн зүйлс: Уг дурсгалаас ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн гараагүй.

Булш-20. 19-р тахилын байгууламжны баруун хойд талд 3 м зайд дугуй хэлбэрийн чулуун хашлагатай, дөрвөн талдаа хөшөө чулуутай, баруун хойд талын хөшөө чулуу унаж алга болжээ. Энэхүү дурсгалыг үйлдэхдээ хашлаганы дотор



талд жижиг чулуугаар битүү чигжиж, төв хэсэгт хавтгай том чулуугаар даржээ. Газарзүйн солбицол: хойд өргөрөгийн 45°56'46.8", зүүн уртрагийн 093°56'20.0" солбицолд оршино. Хэмжээ: голч 800 см. Зүүн хойд талын хөшөөний өндөр 70 см, өргөн 35 см, зүүн урд талын хөшөөний өндөр 79 см, өргөн 32 см, баруун урд талын хөшөөний өндөр 42 см, өргөн 35 см. Олдвор, эд өлгийн зүйлс: Уг дурсгалаас ямар нэгэн олдвор, эд өлгийн зүйл гараагүй ба маш сайн хадгалалттай хүний оршуулга илэрсэн. Хүний ясны судалгаа: Хүний ясанд хийсэн анхан шатны судалгааны үр дүнд 50-55 орчим настай, 165.1 см дундаж өндөр, эмэгтэй хүн болохыг тогтоосон.

Дүгнэлт

2015 онд “Эртний Монгол хүн” төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутаг Хяр хараач хэмээх газарт байрлах хүрэл зэвсгийн үед холбогдох цогцолбор дурсгалуудаас 4 тооны дурсгал сонгон малтахаар төлөвлөж, малтлага судалгааг 2015 оны 8-р сарын 10-наас 26 хүртэл нийт 16 хоногийн хугацаатай хийж гүйцэтгэлээ. Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас тус хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Амгалантөгс, доктор Н.Батболд, Л.Дэлгэрмаа, Э.Амарболд, Японы талаас Кюүшүгийн Их Сургуулийн доктор, профессор К.Мяamoto тэргүүтэй 4 судалаач, туслах ажилтан, жолооч, тогооч гэсэн нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

2015 оны хээрийн судалгааны ажлын хүрээнд малтлага судалгаанаас гадна дурсгалуудын 3D зураглал хийж, мөн цогцолбор дурсгалуудын дэвсгэр зургийг нарийвчлан хийлээ. Малтлага судалгаагаар дөрвөн буландаа хөшөө чулуутай хиргисүүрийн соёлд хамаарах булш 2, дөрвөлжин дараастай, тойроод хөшөө чулуутай тахилын зориулалттай чулуун байгууламж нэгийг малтсан бөгөөд малтлага судалгааны үр дүнд дээрх 2 булшнаас баруун хойд зүг хандуулан тавьсан оршуулга илэрсэн. Тахилын байгууламжаас гал түлж, тахил үйлдэж байсан ул мөр болох шатсан хөрсний давхарга болон уг давхаргаас бог малын шатсан ясны үлдэгдэл цөөн тоогоор гарсан. Малтлагаас илэрсэн хүн болон малын яснаас дээж авч Япон улсын Кюүшүгийн Их Сургуулийн лабораторид илгээн холбогдох он цаг болон бусад нарийвчилсан судалгааг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

“МОНГОЛЧУУДЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН БА МОНГОЛЧУУДЫН УГСАА ГАРЛЫН ЦОГЦ СУДАЛГАА” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЭРДЭНЭ УУЛ БА ХӨХ НУУРТ МАЛТЛАГА ХИЙСЭН ТУХАЙ

Ц.Төрбат, Н.Эрдэнэ-Очир, Д.Батсүх, Г.Энхбаяр

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын Ц.Төрбат, Н.Эрдэнэ-Очир, Д.Батсүх, Г.Энхбаяр нарын судлаачид 2015 оны 8-р сарын 19-нөөс 9-р сарын 1-ны хооронд Төв аймгийн Эрдэнэ сумын Эрдэнэ уул, Хэнтий аймгийн Батширээт сумын Эгийн Живхээстэй, Дорнод аймгийн Гурванзагал-Чойбалсан сумын Хөх нуурын дурсгалт газруудад судалгаа хийв. Энэхүү судалгааг профессор А.Очирын удирдсан “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон монголчуудын угсаа гарлын цогц судалгаа” суурь судалгааны төслийн хүрээнд хийсэн болно. Судалгааны зорилго нь өвөг ба түрүү монголчуудын археологийн дурсгалыг илрүүлэн олох, угсаа гарвалын судалгааны эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд оршиж байна.

Судалгааны баг Эрдэнэ ууланд 3 дөрвөлжин булш, Хөх нуурт 4 дөрвөлжин болон дугуй булш малтав. Эрдэнэ уулын булшнууд хэдийгээр хэлбэр төрхийн хувьд хэв шинжит дөрвөлжин булш боловч харамсалтай нь олдвор хэрэглэгдэхүүн ба хүн малын яс илрээгүй болно.

Харин Хөх нуурын 1 ба 2-р булшнаас хүн малын яс, болон эд өлгийн зүйлс гарсан болно. Онцлон дурдууштай нь Хөх нуурын 2-р булш бөгөөд өвөрмөц хийцтэй бүтэн шавар сав, мөн өвөрмөц хийцтэй төмөр дөрөө, жижиг төмөр сумч хутга зэрэг гарсан төдийгүй палеогенетикийн судалгааны дээж болохуйц хүний яснууд илэрсэн юм. Уг булш баруун зүг харуулж оршуулсан бөгөөд содон өвөрмөц хийцтэй эд өлгийн зүйлсээрээ онцгой анхаарал татаж байгаа юм.



Эрдэнэ уулын 23 ба 24-р булш



Энэхүү булш нь Өгөөмөр толгойн дээр байх чулуун овооны урд хэсэгт оршино. Өгөөмөр толгойн орой ерөнхийдөө тэгшивтэр ба ертөнцийн зүгээр зүүн тийш намссан бөгөөд орой дээрээ бага зэрэг хонхор ажээ. Энэ орчимд хэд хэдэн намхан хавтгай дараастай булштай ба мөн тус толгойн урд энгэрт 10 гаран дугуй, тэгш өнцөгт, зууван дугуй дараастай булш бий. Эдгээрийн зарим нь зууван дугуй, дөрвөлжиндүү хэлбэртэй ба дараас чулуу эвдэрсний улмаас магадгүй зохион байгуулалт нь эвдэрч зууван дугуй мэт хэлбэртэй болсон бололтой. 2-р булш нь орчин тойрныхоо булшнуудаас хамгийн дээд хэсэгт нь байрлана. 3.1 x 2.8 м хэмжээтэй зууван дугуй хэлбэрийн чулуун дараастай бөгөөд төв хэсэгтээ чулуу үгүй хотгортой. Булшны нүх нь өргөргийн дагуу байрлалтай 2.1x0.8 м хэмжээтэй байжээ. Нүхэн дотор нэгэн хүнийг толгойгоор нь баруун зүгт чиглүүлэн нүүрээр нь хойд зүгт хандуулан тавьсан оруулга илэрчээ. Уг хүний гавал, хөлийн савхан яс нь анхны байрлалаараа байсан бол их бие, гарын яснуудыг гавлын ясны урд талд бөөгнүүлэн овоолж шидсэн байлаа. Нүхний төв хэсгээс жижиг зэвэрсэн төмөр эдлэл хутга, гавлын ясны харалдаа хойд талд анхны байрлалаар буй шавар сав тус тус илэрсэн юм. Түүнчлэн оршуулгын нүх илэрсэн түвшинд чулуун дараасны доороос өвөрмөц хийцтэй төмөр дөрөө гарсныг дурдах нь зүйтэй. Уг булшнаас гарсан эдлэлүүдээс үзэхэд энэхүү дурсгал түрүү дундад зууны үед холбогдож болох юм.



Хөх нуурын 2-р булшнаас гарсан
төмөр дөрөө



Хөх нуурын 2-р булшнаас гарсан
шавар сав

Төслийн хүрээнд судлахаар төлөвлөсөн гуравдахь дурсгал бол Хэнтий аймгийн Батширээт сумын Эгийн Живхээстэйн дөрвөлжин булш байсан билээ. Гэвч эндэхийн булшнуудын ихэнхийг урьд өмнө малтсан байсан төдийгүй сүүлийн үед тоносон шинжтэй байв. Энд Түрэгийн үеийн 4 хүн чулуудыг дахин баримтжуулж, тахилын цогцолборын дэвсгэр зургийг хийсэн болно.

**“МОНГОЛЧУУДЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН МОНГОЛЧУУДЫН
УГСАА ГАРЛЫН ЦОГЦ СУДАЛГАА” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД
ХӨВСГӨЛ, ӨМНӨГОВЬ АЙМАГТ АЖИЛЛАСАН
ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС**

Г.Эрэгзэн, Ч.Амартүвшин, Ч.Ерөөл-Эрдэнэ, Б.Батдалай

Хөвсгөл аймагт хийсэн малтлага судалгаа

2002 оны зун Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутагт судалгаа хийж байсан Монгол-Орос-Америкийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны ангийн судлаачдад нутгийн иргэн Манлайбаатар Худгийн халзан хэмээх газраас газар шорооны ажлын явцад илэрч олдсон төмөр тогоо, төмөр амгай, зуузай, дөрөө, арал, ясан хярны хугархай, шор, төмөр зэв, билүү, зоос зэрэг олдворуудыг авчирч өгснийг тус шинжилгээний ангид ажиллаж байсан судлаачид хөрш бүс нутгаас илэрсэн зарим олдворуудтай харьцуулан он цагийг нилээд хожуу үед буюу Түрэгийн үед холбогдуулан үзэж “Түүхийн сэтгүүл”-ийн 2003 оны дугаарт хэвлүүлсэн байдаг.

Худгийн халзангаас олдсон олдворууд нь өдгөө ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа бөгөөд бид уг олдворуудын холбогдох цаг хугацааг харьцуулалтын аргаар нарийн нягтласны үндсэн дээр Жужаны үед холбогдох бүрэн боломжтой хэмээн үзэж өөрсдийн таамаглал, харьцуулсан судалгааны үр дүнг нэгтгэн 2014 онд “Археологийн судлал” сэтгүүлийн 34-р ботьд нийтлүүлсэн юм¹.

Мөн энэ дурсгал оршин байсан газрыг нарийвчлан шалгах, өөр төстэй дурсгал үлдсэн эсэхийг нягтлах зорилгоор нэр бүхий судлаачдын баг бүрдүүлэн тухайн газарт бэсрэг хайгуул судалгааны ажлыг 2014 оны 5-р сард зохион байгуулсан. Уг хайгуул судалгааны үр дүнд олдворууд илэрсэн газрын ойр орчимд хүний гар хүрч ухсан хэд хэдэн хонхор буйг тодруулж, дурдан буй дурсгалтай төстэй булш байх магадлалтай хэмээх дүгнэлтэнд хүрсэн юм². Гэвч тухайн үед цаг хугацаа, байгаль, цаг уурын боломжоос шалтгаалан сорил малтлага хийж амжаагүй билээ.

Бид энэ учир байдлыг “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон монголчуудын угсаа гарлын цогц судалгаа” төслийн удирдлагад танилцуулсан бөгөөд төслийн зүгээс уг дурсгалын судалгааны ач холбогдлыг үнэлэн цөөн хоногоор малтлага судалгаа хийх төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж тусалсан юм.

Тус хээрийн шинжилгээний баг Жужаны үед холбогдох олдворууд илэрсэн Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг Худгийн халзан хэмээх газарт хүрэлцэн очиж олдвор илэрсэн газрыг нягтлан шалгах, улмаар ойр орчимд нь өөр дурсгал бий эсэхийг үзэх, боломжтой тохиолдолд археологийн сорил малтлага судалгаа хийх зорилготой ажилласан. Түүнээс гадна тус хээрийн шинжилгээний баг нь Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутаг Өгөөмөрийн голд шинээр илрүүлсэн өвөрмөц хэлбэрийн чулуун байгууламжит дурсгалаас 1 дурсгалыг сонгон малтан шинжлэж холбогдох цаг хугацааг тодруулах, боломжтой тохиолдолд дурсгалын дэвсгэр зураг үйлдэх зэрэг ажлуудыг гүйцэтгэх давхар зорилготой ажиллав.

Судалгааны баг Худгийн халзанд хүрэлцэн очиход дурсгал илэрсэн нүх буюу

¹ Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн. Худгийн халзангийн олдворын холбогдох он цаг ба Жужаны археологийн дурсгалын судалгааны асуудалд. //Археологийн судлал, Том XXXIV, fasc 21, Улаанбаатар.

² Г.Эрэгзэн, Ч.Амартүвшин, А.Энхтөр, Г.Батболд, Б.Батдалай. Архангай, Булган, Дархан-Уул, Хөвсгөл аймгийн нутагт археологийн мэдээ шалгах хээрийн шинжилгээний ангийн тайлан. УБ., 2014, АХГБСХ.



эртний булш хэмээн таамагласан газарт малын хөрзөн их хэмжээгээр асгасан тул шалгаж үзэх боломжгүй болж, улмаар уг дурсгалаас холгүй орших газарт сорил малтлага хийхээр тогтсон. Сорил малтлага хийх болсон нь сонгосон газарт хүний гараар ухсан байх магадлалтай хэд хэдэн хонхор байсантай холбоотой юм. Худгийн халзангийн дурсгалыг анх илрүүлсэн н.Манлайбаатарын өгүүлснээр олдвор илэрсэн газар нь анх ямар нэгэн таних тэмдэггүй байсан бөгөөд сэжигтэй зүйл гэвэл бага зэрэг хонхорхой байжээ. Тиймээс налуу энгэрийн наран ээвэр хэсэгт мэдэгдэж байсан 2 хонхорыг дайруулан 10 м урттай сорилын суваг татсан. Газар хөлдүү байснаас сорилын суваг малтах ажилд цаг хугацаа харьцангуй их зарцуулсан юм. Сорилын сувгийн гүн 50 см орчим болоход сувгийн хойд болон өмнөд хэсгээс 2 ч газарт ухсан нүхний ором тод хар өнгөөр тодорсон. Бид эхний удаад хойд хэсэгт илэрсэн толбыг даган талбайг тэлж цэвэрлэсэн бөгөөд толбоны ерөнхий байдал нь булшны нүхтэй их төстэй харагдаж байсан. Гэвч доош шалгаж үзэхэд 1.2 м гүнд байгалийн хөрсөнд тулсан бөгөөд уг нүхнээс адууны толгойн ясны үлдэгдэл, шатсан модны нүүрс зэрэг илэрснээс өөр зүйл олдоогүй. Дараа нь сорилын малтлагын өмнө захад илэрсэн толбыг шалгасан боловч мөн л ямар нэгэн олдвор болон оршуулга байсангүй. Эдгээр нүх нь хүний гараар ухсан гэхээс илүүтэй тарвага зэрэг амьтны ухсан нүх болох нь малтлагын явцад тодорхой болсон юм. Ийнхүү Худгийн халзангийн олдвор илэрсэн газарт хийсэн сорил малтлага ямар нэгэн амжилт олоогүй бөгөөд энэ үед нутгийн иргэн н.Манлайбаатар өөр нэгэн газар зааж өгсөн нь уг дурсгалаас зүүн хойш 3 км орчим зайд орших өнгөн хөрсөн дээр ил цухуйн мэдэгдэх цагариг хэлбэрийн чулуун хүрээ бүхий дурсгал байв. Дурсгалын гадаад байгууламжийг ил гарган цэвэрлэж, баримтжуулалт хийсний дараа төв хэсэгт малтлагыг явуулсан бөгөөд өнгөн хөрснөөс доош 40 см гүнд төв хэсгээс чигжээс бололтой хэдэн чулуу илэрсэн ба түүний дороос хойноос өмнө тийш чиглэлтэй урт гонзгой хэлбэрийн нүхний толбо илэрсэн. Уг толбыг даган цэвэрлэхэд 80 см гүнд байгалийн хөрсөнд тулж мөн л ямар нэгэн эд өлгийн зүйлийн ул мөр илэрсэнгүй. Худгийн халзан хэмээх дурсгалт газарт хийгдсэн дээрх 2 сорил малтлагын ажил нь хэдийгээр ямар нэгэн олдвор эд өлгийн зүйлс илрүүлж чадаагүй ч тухайн газарт байх сэжиг бүхий газруудыг шалгаж, дурсгал мөн эсэхийг тогтоосноор судалгааны ач холбогдолтой ажил болсон хэмээн үзэж байна.

Худгийн халзангийн малтлагыг дуусгасны дараа судалгааны багийнхан Мөрөн сумын нутагт орших Өгөөмөрийн голд шилжин бууж, тус газарт өмнө нь илэрсэн өвөрмөц хэлбэрийн булшнууд бүхий дурсгалт газрын булшны тархацын дэвсгэр зураг хийх, мөн 1 дурсгалыг сонгон малтан шинжлэх ажлыг гүйцэтгэсэн. Энэ газар уртааш 350 м, өргөөш 100 м орчим талбайд нийт 52 дурсгал тархсан байв. Эдгээр дурсгал нь гадаад хэлбэрийн хувьд 3 төрөлд хуваагдана. Эхнийх нь дугуй хэлбэрийн чулуун дарааст дурсгал бөгөөд ийм хэлбэрийн дурсгал 7 байна. Энэ хэлбэрийн дурсгал нь гадаад хэлбэрийн хувьд Хүннүгийн жирийн жижиг булшнуудтай их төстэй юм. Эдгээр нь дурсгалт газрын зүүн өмнө болон зүүн талаар, газрын өндөрлөг хэсэгт тархан байрлаж байв. Дараагийн хэлбэр нь гадуураа дугуй чулуун хүрээ бүхий гонзгой хэлбэрийн чулуун хашлага юм. 2 дахь хэлбэрийн дурсгал нийт 9 тэмдэглэгдсэн. 3 дахь хэлбэрийн дурсгал нь 2 дахь хэлбэрийн дурсгалтай төстэй хэлбэрийн гонзгой чулуун хашлага бөгөөд ялгаа нь гадуураа чулуун хүрээгүй ажээ. 3 дахь хэлбэрийн дурсгал нь хамгийн олон тоотой, нийт 38 дурсгал бүртгэгдсэн. Бид 3 төрлийн дурсгалыг тус бүрд нь хэмжилт хийн, солбицолыг нь тогтоож, гэрэл зургаар баримтжуулалт хийсний үндсэн дээр тархацын дэвсгэр зургийг үйлдсэн. Улмаар уг газрын дурсгалын он цагийг тогтоох зорилгоор гадаад хэлбэр нь харьцангуй сайн хадгалагдсан ӨГ-

13 дугаарт дурсгалыг сонгон малтлага судалгааны ажил хийсэн юм. Малтлага хийсэн дурсгал нь хэлбэрийн хувьд бидний хийсэн ангиллаар 2 дахь хэлбэрт багтах бөгөөд гадуураа дугуй чулуун хүрээтэй, хүрээний төв хэсэгт хүн багтах хэмжээний гонзгой хэлбэрийн чулуун хашлагатай байв. Чулуун хүрээний голч 4.5-5.7 м, төв хэсгийн чулуун хашлага 2.4x0.9 м хэмжээтэй юм. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэсний дараа төв хэсгийн чулуун хашлагын дотор талыг малтан шалгаж үзсэн. Чулуун хашлагын дотроос нүхний толбо ялгарч мэдэгдсэн боловч оршуулга болон ямар нэгэн олдвор эд өлгийн зүйлс илэрч мэдэгдээгүй. Дурсгалын ерөнхий байдлаас үзвэл оршуулгатай байсан нь гарцаагүй боловч чулуун хашлагыг газрын хөрсөнд гүн суулгаагүй, дотроос нь илэрсэн нүхний гүн ч их гүехэн байсан зэрэгт тулгуурлавал уг булшны оршуулгын хэсэг нь газрын өнгөн хөрснөөс төдий л гүн бус хэсэгт байсан бололтой бөгөөд он цагийн уртад устаж үгүй болсон хэмээн таамаглаж байна. Энэ удаад Өгөөмөрийн голд хийсэн малтлага судалгаа нь төдий л амжилт олоогүй ч дурсгалт газрын дэвсгэр зургийг үйлдэж судалгааны эргэлтэнд оруулах ажлыг хийсэн ба 3 хэлбэрээс 1 хэлбэрийн дурсгалын бүтэц, зохион байгуулалтын онцлогийг тодруулж чадсан хэмээн үзэж байна. Цаашид Өгөөмөрийн голын 1 болон 3 дахь хэлбэрийн дурсгалаас сонгон малтлага судалгаа хийх шаардлагатай байна.

Өмнөговь аймагт хийсэн малтлага судалгаа

2010 оны зун Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Булан тойром хэмээх газар нэгэн булшийг малтан шинжилж Сяньбигийн үед холбогдохыг байгалийн шинжлэлийн лабораторийн аргаар тогтоосон билээ. Иймээс энэ газарт өмнөх булштай ижил дурсгал байгаа эсэхийг нягтлан үзэх зорилгоор 2015 оны 9-р сард цөөн хоногийн судалгааны ажлыг гүйцэтгэв. Судалгааны багийнхан BT-1, BT-48 BT-6, BT-8, BT-9 дугаартай талбайд сорилтын малтлага судалгааны ажлыг гүйцэтгэсэн боловч шинээр булш оршуулга олсонгүй. Гэхдээ Булан тойромын булшийг байгуулах үед орчин тойронд хүн амьдарч байсан болохыг гэрчлэх түүвэр олдворууд(зураг 7) илрүүлэн олсон юм.

Булан тойром-1 (BT-01). Өнгөн хөрсөн дээр цөөн тооны шавар савны хагархай байсан ба хамгийн их олдворын нягтрал байгаа газарт 4x3 м талбай сонгон малтлагыг эхлүүлэв. Малтлагыг дан жижиг багажаар гүйцэтгэлээ. Малтлагын гүн 10-15 см болоход хөрсөн дээр малтлагын талбайн хойд болон төв хэсэгт үл мэдэг жижиг ялгарал байснаас өөр ямар нэгэн тоймтой ялгарал илрээгүйгээс гадна эд өлгийн зүйлс олдсонгүй. Малтлагыг цааш дээр дурьдсан ялгарлуудад үргэжлүүлэхэд байгалийн шаварлаг хатуу хөрсөнд тулсан тул малтлагын ажлыг зогсоов. Газарзүйн байршил хойд өргөргийн 43 25 40.8, зүүн уртрагийн 107 33 08.5 байна. Малтлагын талбайгаас нийт 22 ш 2 төрлийн шавар савны хагархай илэрсэн.

Булан тойром-6 (BT-06). Энэхүү газарт харьцангуй цөөн тоотой эд өлгийн бөөгнөрөл байсан ба нэг сэжигтэй зүйл байсан нь өнгөн хөрсөн дээр авсны модны хэсэг байж болохуйц модны хэсэг цухуйсан байв. Малтлагыг 4x3 м хэмжээтэй талбайд, малтлагын жижиг багажаар хийж гүйцэтгэсэн ба мөн 10-15 см гүн малтахад өнөөх модны хэсэг маань ургамлын үндэс болох нь мэдэгдсэн ба өөр ямар нэгэн тоймтой ялгарал илрээгүйгээс гадна эд өлгийн зүйлс олдсонгүйд малтлага судалгааны ажлыг зогсоов. Газарзүйн байршил хойд өргөргийн 43 25 40.7, зүүн уртрагийн 107 33 10.0 солбицолд байна.

Булан тойром-4 (BT-04). Өнгөн хөрсөн дээр ясны жижиг үйрмэг, төмрийн баас мэт зүйлс байна. Энэхүү хэсэгт бид харьцангуй том талбайг сонгон малтахаар ярилцсан билээ. Үүний дагуу 1x50 м хэмжээтэй уртрагийн дагуу чиглэлтэй талбайн



сонгон малтав. Малтлагыг том багажаар үргэлжлүүлэн 10 см гүн малтсан боловч мөн л тодорхой зүйлс мэдэгдсэнгүй. Газарзүйн байршил хойд өргөргийн 43 25 40.9, зүүн уртрагийн 107 33 10.6 солбицолд байна.

Булан тойром-8 (BT-08). Булан тойром-4 (BT-04) талбайгаас зүүн хойд зүгт 50 орчим метрийн зайд 2х20 м талбайд сорилын малтлагыг хийсэн ба мөн ямар нэгэн тоймтой ялгарал илрээгүйгээс гадна эд өлгийн зүйлс олдсонгүйд малтлага судалгааны ажлыг зогсоов.

Булан тойром-9 (BT-09). 2011 оны зун тухайн газраас санамсаргүй байдлаар илрүүлсэн эртний нүүдэлчдийн үлдээсэн булш оршуулгын дурсгал илэрсэн газрын дэргэд сорилын малтлага хийхээр болов. Малтлагыг 2х5 м хэмжээтэй талбай сонгон хийхэд мөн ямар нэгэн тоймтой ялгарал илрээгүй тул баруун зүгт дахин 5 м сунган малтсан ч ямар нэгэн сэжигтэй зүйл илрээгүй тул малтлагыг зогсоов. Газарзүйн байршил хойд өргөргийн 43 25 41.9, зүүн уртрагийн 107 33 13.0 солбицолд байна.

Булан тойром-10 (BT-010). Булан тойром-9 (BT-09) малтлагын талбайн чанх хойд талд 5 м зайд 2х5 м хэмжээтэй талбайд дахин сорилын малтлага хийсэн боловч мөн л ямар нэгэн ул мөр илрээгүй тул малтлагын ажлыг зогсоов.



Зураг 1. Худгийн халзан хэмээх газрын байдал



Зураг 2. Худгийн халзан хэмээх газарт хийсэн сорилын малтлагын талбай



Зураг 3. Худгийн халзангийн ойролцоо орших чулуун дараас бүхий дурсгалын гадаад байдал (цэвэрлэгээ хийсний дараа)



Зураг 4. Худгийн халзангийн ойролцоо орших чулуун дараас бүхий дурсгалын малтлагын явц



Зураг 6. Өгөөмөрийн голд орших өвөрмөц хэлбэрийн чулуун байгууламжит дурсгалын гадаад байдал (цэвэрлэгээ хийсний дараа)



Зураг 7. Булан тойромын дурсгалт газраас илрүүлсэн зарим шавар савны хагархай

АРХАНГАЙ, ГОВЬ-АЛТАЙ, ЗАВХАН АЙМГИЙН НУТАГТ ХИЙСЭН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Ч.Ерөөл-Эрдэнэ, Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Б.Батдалай

Шинжлэх ухаан технологийн сан, ШУА-ийн захиалгаар хэрэгжсэн “Хүннүгийн язгууртны булш шинээр малтахтай холбоотой урьдчилсан судалгаа” төсөлт ажлын хүрээнд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний баг Архангай, Говь-Алтай, Завхан зэрэг аймгийн нутагт 2015 оны 5-р сарын 3-12-ны өдөр хүртэл хайгуул судалгаа хийсэн. Судалгааны явцад Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод, Говь-Алтай аймгийн Тайшир сумын Овооно хар зэрэг газруудад буй Хүннүгийн язгууртны булшнаас малтлага хийх боломжтой булшийг сонгож ажиглалт болон хэмжилт хийхийн зэрэгцээ тархацын дэвсгэр зураг үйлдэх, агаарын зураг авах зэрэг ажлуудыг хийсэн. Мөн дурдсан аймгуудын нутагт Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгал байх магадлалтай хэд хэдэн газрыг шалгасан юм. Судалгааны явцад мөн шинээр хэд хэдэн дурсгалыг илрүүлэн баримтжуулав. Доор судалгааны ажлын онцлох үр дүнгийн талаар дурсгал тус бүрээр товч танилцуулья.

Овооно харын дурсгал. Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт оршино. Энэхүү дурсгалт газрыг 2011 онд Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн судлаачид илрүүлж гүймэг хайгуул судалгаа хийж урьдчилсан судалгааны үр дүнг мэдээлжээ¹. Тайширын усан цахилгаан станцаас зүүн тийш Гэгээн нуурын хойд талд баруунаас зүүн тийш сунаж тогтсон Овооно хар уулын зүүн урд талын өндөрлөг дэвсгэр буюу уулын ар шилд нийт 46 булш байгаагийн 16 нь үүдэвтэй дөрвөлжин хашлагатай булш, 8 нь дунджаар 9 м голчтой дугуй том булш, үлдсэн 22 нь 3-5 м голчтой жижиг дугуй булш байна. Овооно харын дурсгалт газарт малтлага болон нарийвчилсан хайгуул судалгаа хийгээгүй байсан юм. Тиймээс бид булшны тархацын дэвсгэр зургийг үйлдэж, агаарын зураг авахын зэрэгцээ малтан шинжлэх боломжтой 4 булшийг сонгон нарийвчилсан хэмжилт, ажиглалт хийсэн.

Шургын голын дурсгал. Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нутагт орших Шургын голын зүүн биед уулын урд энгэрт хүннүгийн цагариг хэлбэрийн чулуун байгууламжтай 100 гаруй булшнаас бүрдэх оршуулгын газар буйг шинээр илрүүлэн олж, дэвсгэр зургийг үйлдсэн. Эдгээр булшнууд хэд хэдэн бүлэг болон орших бөгөөд чулуун байгууламжийн хэмжээ нь дундажаар 3-8 м орчим байна.

Түдэвтэйн дурсгал. Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт уулын ар бэл газраас өмнө нь тэмдэглэгдэж байгаагүй өвөрмөц хэлбэрийн дурсгалыг илрүүлж тодорхойлолт хийн, агаарын болон гэрэл зургийн баримтжуулалт хийсэн. Энэхүү дурсгал нь цагариг хэлбэрийн чулуун дараас, түүнээс баруун урагш чиглэн 3 эгнээгээр жижиг чулууг хөшөө мэт босгосон байв. Уг хөшөө чулууд нь Түрэгийн үеийн балбалтай төстэй харагдах боловч 3 эгнээ байгаа нь сонирхолтой бөгөөд чулуун байгууламжийн хэсгээс эхлэн гадагш тэлэх тусам эгнээнүүдийн хоорондын зай өргөсчээ. Ийм төрлийн дурсгал өмнө нь тэмдэглэгдэж байгаагүй тул он цаг болон зориулалтын талаар таамаг дэвшүүлэх боломжгүй байна.

Даагатын давааны хиргисүүр. Даагатын давааны хойд биед хадтай уулын зүүн энгэрт жалганы ирмэг дээр байсан хиргисүүрийн зүүн талын хэсэг жалга даган нурсан байна. Хиргисүүрийн гол хэсгээс 1 самбар чулуу олдсон.


¹ Монголын соёлын өвийн судалгаа IV. Тал 142

Уг тариа цайруулах самбар чулуу нь хавтгай бөгөөд нэг талын үзүүрлүү нарийссан зууван дугуй хэлбэртэй юм. Нүүрэн талын хэсэгт тариа цайруулж байснаас элэгдэж хонхойсон байна. Урт 43 см, өргөн доод хэсэгт 24 см, дээд хэсэгт 12 см, зузаан 7 см.

Гол мод нэртэй газруудыг шалгасан тухайд. Хээрийн шинжилгээний явцад Завхан аймгийн Яруу, Баянхайрхан сумд, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Цагаан уул, Бүрэнтогтох, Арбулаг сумдын нутагт байрлах “гол мод” нэртэй газруудыг зорьж очин үзэж танилцав. Учир нь одоогоор илэрсэн Хүннүгийн язгууртны булш бүхий 2 ч газар ийм нэртэй бөгөөд энэ нь газрын онцлогтой холбоотой өгөгдсөн нэр байж магадгүй хэмээн үзсэн тул хайгуулын явцад шалгаж үзсэн юм. Ялангуяа, эдгээрээс Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт орших Гол мод хэмээх газар нь элсэрхэг хөрстэй, ой модтой бөгөөд эртний булш, хиргисүүр байх магадлалтай талаар нутгийн иргэд мэдээлсэн байдаг нь судалгаа хийх шаардлагыг бий болгосон билээ.

Гэвч бидний шалгаж үзсэн Гол мод хэмээн нэр бүхий 4 газраас ямар нэгэн дурсгал илрээгүй бөгөөд Завхан аймгийн Яруу, Баянхайрхан сумдын заагт орших Гол мод хэмээх газар нь уулын арын хэсэг төдийгүй элстэй, шинэсэн ой модтой зэрэг шинжээр Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод, Өндөр-Улаан сумын Гол мод-2 зэрэг Хүннүгийн язгууртны булш илэрсэн дурсгалт газруудтай их төстэй байсныг дурдах хэрэгтэй юм.


Тус хээрийн шинжилгээний баг нь дээр дурдсан судалгааны ажлуудыг төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэж, тайлан болон цаашид малтан шинжлэх боломжтой Хүннүгийн язгууртны булшны талаарх саналаа захиалагчид хүргүүлсэн болно.



Зураг 1. Овооно харын Хүннүгийн
язгууртны булш бүхий дурсгалт газрын
дэвсгэр зураг



Зураг 2. Овооно харын дурсгалт газрын агаарын зураг



Зураг 3. Шургын голын Хүннүгийн жижиг булш бүхий дурсгалт газрын дэвсгэр зураг



Зураг 4. Түдэвтэйн дурсгалын
ерөнхий байдал

“ОНОН-2015” ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

С.Өлзийбаяр, Б.Батсүрэн, Б.Очир, Г.Одмагнай

2015-2017 онд хэрэгжүүлж буй ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Хүннү ба эртний түүхийн судалгааны салбарын “Эртний Дотоод Азийн түүхэн орон зай дахь монгол аймгууд” суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд тус экспедицийг зохион байгуулав.

Эртний түрэг хэлтэн аймгууд Төв Азийн нүүдэлчдийн ертөнцийг манлайлж байх үеийн монгол хэлтнүүдийн түүх, соёлын асуудлууд нь Монголын түүх бичлэгт хамгийн бага хөндөгдсөн сэдвүүдийн нэг хэвээр байгаа өнөө үед тэдний үлдээсэн түүх, соёлын дурсгалыг судлах, шинээр илрүүлэх явдал шинжлэх ухааны үлэмж ач холбогдолтой болох нь тодорхой асуудал билээ. Дурдсан зорилтын хүрээнд зохион байгуулагдсан “Онон-2015” хээрийн судалгаагаар Онон голын сав Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг Мэргэн хөтлийн даваа, Ламын ухаа болон мөн аймгийн Батширээт сумын нутаг Баянголын адаг, Эрхий толгой зэрэг газруудад археологийн малтлага хийв.

А. Мэргэн хөтлийн даваа: Биндэр сумын төвөөс зүүн урагш, Онон голын зүүн бие Мэргэн хөтлийн давааны урд хормой болох Тахилтын өмнө захын үзүүрийн тэгш дэвсгэг дээр 10 гаруй дөрвөлжин булш бүлэглэн оршино. Энэ бүлэг дурсгалыг Дэлүүн болдог судлалын “Эрхин төв” ТББ-ын тэргүүн, судлаач Д.Мишүүлэн агсан, Биндэр сумын харъяат багш Д.Үржинсүх нар 2014 онд “Дэлүүн болдогийн байршил тогтоох” төслийн хүрээнд илрүүлэн, хамтран малтан судлахыг санал болгосон юм¹. Эдгээрийг орчны боржин чулуу ашиглан хийсэн бөгөөд чулууны хэлбэрээс хамааран хавиргалан босгох бололцоогүй тул дөрвөлжин хүрээ хийх маягаар өрлөг хийсэн онцлогтой байна. Энд хоёр дурсгал малтан судлав. Эдгээр байгууламжаас оршуулгын зан үйл гүйцэтгэсэн ул мөр илрээгүй боловч эхнийхээс нь харьцангуй нэг дороос бөөн байрлалтай ваарны хагархайнууд дараас чулууны дороос илэрсэн байна. Шулуун амсартай, тогоо хэлбэрийн эдлэл болох ба амсрын ирмэгээс 5 см доош үргэлжилсэн ташуу байрлалтай зууван хонхор бүхий параллель эгнээнүүд, түүний доогуур бүслүүрдсэн байдалтай 3 зэрэгцээ эгнээ болон хоорондоо тасалдсан мөн бүслүүртэй. Дараагийн байгууламжаас мөн ижил хээтэй ваарны хагархайнууд илэрсэн билээ (зураг № 1. Мэргэн хөтөл. Булш № 1,2-оос илэрсэн ваарны хагархайнууд).

Б. Ламын ухаа: Монголын олон судлаачид сүүлийн жилүүдэд их Чингис хааны мэндэлсэн “Дэлүүн болдог”-ийг Биндэр сумын төвийн урд талын Ламын ухааг мөн гэж үзэх хандлагатай болж байна. 2014 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Дэлүүн болдог судлалын “Эрхин төв” ТББ хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд энд хайгуул судалгаа хийж, Ламын хүрээг эртний ямар нэгэн соёлт ул хөрсөн дээр барьсан байх магадлалтай хэмээн үзсэн юм. Хийдийн барилгын үлдэц, ул мөрийн хадгалалтын зэрэглэл харилцан адилгүй. Тухайлбал, илүү эртнийх байх магадлалтай бараг мэдэгдэхээ больсон байгууламж (№2, 3, 4), илт мэдэгдэх буюу Ламын хүрээнийх байж болох байгууламжийн үлдэц (№1) болон хийдийн туурийн төвөөс зайдуу, тусгаар орших өвөрмөц байдалтай буурь (№ 5,6) зэргийг тус бүр сонгон малтсан болно. Малтлагаар Ламын хүрээний үеийн соёлт давхарга (модон шон, төмөр хадаас, дагтаршмал цагаан шохойжсон хөрс) № 1, 3, 4-р хэсгийн талбайгаас илэрсэн байхад тус хийдийн ул мөр хөрсөн дээрээ эдгээрээс гадна № 2, 5-р талбайд үлдсэн байна. Сорилт малтлагын дүнд хийдийн зарим барилгын

¹ Мишүүлэн Д. “Дэлүүн болдогийн байршил тогтоох” төслийн тайлан // ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн БМТ. УБ., 2014.

төрхийг сэргээх боломж бүрдсэн гэж үзэж болох байна. Хийдийн барилгууд бүгд дүнзээр хийгдсэн ба зарим гол дугана тусгайлан зассан шороон довжоон дээр байрлана. Гадуураа шургааг нэг талыг шовхлон газарт шааж, эгнүүлэн хийсэн хашаатай ба мөн хашаагаар эгнэн зэллэсэн гудамжуудаар зааглагддаг байжээ. Ламын хүрээг анх байгуулахдаа өмнөх үеийн нүүдэлчдийн үлдээсэн бууц суурин, хотын туурь, үлдэц дээр хараахан бариагүй бололтой. Гэхдээ бидний хийсэн малтлагын талбай хүрээний туурийн нийт хэмжээтэй харьцуулахад хэт бага



Зураг №1. Мэргэн хөтөл. Булш №1, 2-оос илэрсэн ваарны хагархайнууд

байгаа нь асуудлыг бүрэн шийдсэн гэсэн үг биш болох нь тодорхой билээ (зураг № 2. Ламын ухаа. Малтлагын цооног).

В.Баянгол: Баянголын адаг, Улаан үзүүр уулын зүүн хөндийд орших дөрвөлжин хашлагатай 7 ш нэг эгнээ үүсгэсэн байгууламжийн голын 2 дурсгалыг малтан судлав (зураг № 3. Баянгол №1. 1а. Чулуун дараасыг хөндлөн хуваасан нь). Эхнийх нь 7х7 м хэмжээтэй төвийн гол байгууламж. Хашлага дотор чулуугаар дүүргэхдээ харьцангуй томыг доогуур, голын жижиг хайрган мөлгөр чулуудыг дээгүүр нь асгаж хучих маягтай хийжээ. Хашлагын төвд 1х1 м орчим хэмжээтэй чулуун хашлага хэлбэртэй өрсөн байгууламж илэрсэн ба түүний дотор хоосон бөгөөд доош 70-аад см гүн нүх ухаж, 3-4 жижиг чулууг 7 давхарлан өрж дүүргэжээ. Түүний ёроолд ямар нэгэн зүйл шатаасны илрэл болох нимгэн үнсэн давхарга үлджээ. № 1а байгууламж нь 3,5 х 3,5 м хэмжээтэй, хашлагын дотор зүүн этгээдээс 50 х 80 см харьцаатай нимгэн хавтгай чулуугаар өрсөн хайрцаг илэрсэн бөгөөд түүний дотроос нэгэн төмөр зэв, төмөр хөрөөний хугархай, төмөр гархины өөдөс зэрэг зүйлс илрэв (зураг № 4. Эд өлгийн зүйлс).


Ийнхүү Баянголын орчимд хийсэн малтлагаар оршуулгын зан үйл илрээгүй бөгөөд тэдгээрийн гадна хэлбэр, зэл чулуу босгосон байдал болон түүний орчимд түрэг хүн чулуу байрлана. Мөн түрэгийн оршуулга урьд өмнө түүний хавь орчмоос илэрч байсантай холбогдуулан бид үүнийг монгол нутагт МЭ VI-VIII зууны эхээр оршиж байсан эртний түрэгүүдийн үлдээсэн тахилын онгон байж болно хэмээх дүгнэлт хийлээ.

Г. Эрхий толгой № 1. Чингисийн хэрмийн урд дэв, Эрхий толгойн арын шилд өнгөн хөрсөн дээр үл мэдэгдэм хэдэн чулуу цухуйх төдий харагдана. Түүнийг тойруулан өнгөн хөрний хуулалт хийж цэвэрлэхэд дунджаар 6х5 м хэмжээтэй дугуйвтар хэлбэртэй, дан чулуун өрлөг тодров. Чингисийн хэрмээс мөн ийм дан өрлөг бүхий Бурхотуйн соёл гэгдэх дундад эртний үед холбогдох хэд хэдэн булш илрүүлж малтаж байсан бөгөөд мөн үүнийг дээр дурдсан булшны төлөөлөл хэмээн урьдчилан үзсэн болно. Чулуун дараасыг бүх талбайгаар хуулан авч булшны нүхний толбо илрүүлэх зорилгоор дунджаар 50 см орчим



Зураг №2. Ламын ухаа. Малтлагын зарим цооног

гүн малтахад дараасын төв хэсгээс адууны тоног бололтой төмөр хэл, хүрэл арал бүхий гархины хугархай, түүний доороос шатсан модны нүүрсний багавтар өөдөс зэрэг илрэв. Цэвэрлэгээний явцад чулуун дараас болон түүний дор эртний хөрсөн дээр олон хэсэг газраас адууны шүд, эрүүний хугархай таарч байв. Гэрэл зураг дээр адууны шүд илэрсэн газрыг жижиг улаан дарцаг хатгаж тэмдэглэсэн болно. Энэхүү байгууламж нь монгол орны нутагт хүрэл төмрийн түрүү эрин үеийн оршин суугчдын үлдээсэн хиргисүүр, дөрвөлжин булш зэргээс эхлэн дундад үеийн түрэгийн тахилын онгон хүртэл урт удаан хугацааны туршид нүүдэлчдийн дунд хадгалагдсаар ирсэн адуу шүтлэгт зан үйлийн илрэл болох тахилын байгууламж гэж үзлээ. Хүрэл, төмрийн холимог бүхий гархины хийцээс үзэхэд уг байгууламжийг МЭ VII-VIII зууны үеийн нүүдэлчдийн үлдээсэн тахилын



Зураг №3. Баянгол №1. 1а. Чулуун дараасыг хөндлөн хуваасан нь



Зураг №4. Байгууламжийн гадаад хэлбэр

байгууламж гэж урьдчилсан байдлаар үзлээ (зураг № 5. Байгууламжийн гадаад хэлбэр).

Мөн сумын нутаг Ламын ухаад буй хуучны хүрээний тууринд хэд хэдэн газар сорилтын цооног малтаж үзэхэд өмнөх үеийг гэрчлэх соёлт давхарга хараахан илрээгүй байна. Гэхдээ энэ нь тус хүрээг XIX зууны 60-аад онд байгуулахаас өмнө


нүүдэлчдийн төвлөрөл, суурин байгаагүй гэсэн үг биш бөгөөд цооног хийсэн газар зөвхөн хүрээ оршиж байсан туурийн багахан хэсэгт л хийгдсэн болохыг дурдахад илүүц бизээ. Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Баянголын адаг орчимд хийсэн судалгаагаар он цаг баримжаалан тогтоох хэрэглэгдэхүүн илрүүлээгүй боловч нарийвчлан үзвэл зохих шаардлагатай хэд хэдэн байгууламжууд бүртгэсний дотор хөрсөн дээр чулуун бүтэцгүй, үл мэдэгдэм болсон шороон далан, хонхор зэрэг онц сонирхолтой судлагдахуунууд байгаа нь цаашдын бидний судалгааны голлох чухал хэрэглэгдэхүүн болох юм. Эрхий толгойд хийсэн малтлагаар хөрсөн дор орсон булш, тахилын байгууламжууд цөөнгүй байх бололцоотой болохыг тогтоосон болно. Ийнхүү “Эртний Дотоод Азийн түүхэн орон зай дахь монгол аймгууд” сэдэвт ажлын хүрээнд хийгдсэн “Онон-2015” хээрийн судалгаа нь хүннүгийн дараа үед холбогдох эртний нүүдэлчдийн үлдээсэн дурсгалыг малтан судлахад чухал хэрэглэгдэхүүнийг бий болгосон үр дүнтэй судалгаа болсон хэмээн үзэж байна.

“МОНГОЛ УГСААТАН БҮРЭЛДСЭН БОЛОН МОНГОЛЧУУДЫН ГАРАЛ ҮҮСЛИЙН ЦОГЦ СУДАЛГАА” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭНТИЙ АЙМАГТ АЖИЛЛАСАН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

С.Өлзийбаяр, Б.Батсүрэн, Б.Очир, Г.Одмагнай

Энэхүү хээрийн судалгааг профессор А.Очирын удирдсан “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон монголчуудын угсаа гарлын цогц судалгаа” үндэсний төслийн хүрээнд зохион байгуулав. Тус экспедиц нь Монгол нутгийн зүүн нутгаар тархсан дөрвөлжин булшны соёлын эздийн он цагийг урьдчилсан байдлаар тогтоох болон генетикийн шинжилгээнд хамруулах судалгааны дээж хэрэглэгдэхүүн олж илрүүлэхэд чиглэгдсэн болно. Энэ хүрээнд зүүн бүсийн урьд өмнө судалгааны эргэлтэнд орсон хэд хэдэн газрын дурсгалаас малтан судлах захиалгыг төслийн удирдлагаас бидэнд тавьсан болно. Үүнд, Хэнтий аймгийн Норовлин сумын Баруун Буурал уул, Хэнтий аймгийн Биндэр сумын Сэрүүн, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Ханан уулын дөрвөлжин булшнууд болно.

А. Буурал уул: Норовлин сумын төвөөс зүүн хойш Улз голын хөндийд 40 орчим км алслагдсан Буурал хэмээх холбоо уул байх бөгөөд нутгийнхан ертөнцийн зүгээр баруун, зүүн хэмээн ялган нэрлэх аж. Бидний томилолтонд Баруун Буурал уулын дөрвөлжин булш гэж тэмдэглэгдсэн байх боловч тэнд ямар нэгэн дурсгал байсангүй. Харин Зүүн Буурал ууланд хүрэл, төмрийн түрүү үед холбогдох 20 орчим дөрвөлжин булш, тахилын байгууламж түүний дотор эртний түрэгийн үед хамаарч болох хөшөө бүхий 3 байгууламж (ухагдсан) зэргийг бүртгэж, үүнээс 4 дурсгалыг малтан шинжилсэн болно. Энэ газрын дудсан дурсгалууд нь Буурал уулын боржин чулуун хадыг шууд газар дээр нь ашиглах замаар хийсэн байна. Дурсгалууд нь Зүүн Буурал уулын баруун хэсгийн зэрэгцээ 2 аманд байрлана. Баруун амны дээд хэсэгт нарийн хийц бүхий гоёмсог зассан чулуун хөшөө бүхий байгууламжууд оршино.



Хөшөөний дүрслэл нь өвөрмөц бөгөөд нэг талдаа эвшээлгээгүй нум, түүний эсрэг талд халбага маягийн буюу навчин хэлбэрт мөс бүхий сум хэлбэрт зүйлийг дээш харуулан сийлжээ. Газарт булагдсан хэсгийн хамт 140 см өндөр болно. 2-р хөшөө мөн гоёмсог зассан, нэг талдаа онгин тамга, доогуураа битүү ороосон бүс, түүний дороос хэл нь доош харсан гурвалжин дүрстэй, түүний өндөр 1м бөгөөд унасан байсныг бид босгож чулуугаар чигжив (Зураг № 1. Хөшөөний дүрслэл).

Эдгээр хөшөө нь зассан байдлын хувьд түрэгийн хүн чулуутай төслөг мэт боловч дүрслэлийн хувьд хүрэл, төмрийн үеийн буган хөшөөн дээрх бүс, онгин дүрс ба нум сумны дүрсийг илүү санагдуулам. Тиймээс үүнийг бид буган хөшөөний нэгэн төрөл байж болох тухай дүгнэлт хийв. Эдгээр хөшөөтэй хамт байх дөрвөлжин байгууламжуудыг тонуулчид

Зураг №1. Зүүн Буурал. 17, 18

(ухагдсан)-р байгууламжийн хөшөөн дээрх дүрслэл

сүйтгэсэн учраас түүнийг дөрвөлжин булш эсвэл түрэгийн хүн чулуу бүхий тахилын байгууламж аль болохыг бид хараахан тогтоож чадсангүй. Ийнхүү хөшөөтэй 2 байгууламжийн урд мөн ухагдсан дөрвөлжин хашлага бүхий дурсгал байсныг бид түүхэн он цаг, зориулалтыг тогтоох оролдлого хийх үүднээс Буурал № 4 хэмээн дугаарлаж, ухсан нүхний дор малтаж үзэв. Тонуулчид энэ хашлага дотор ухахдаа том үхэр чулууны сэрвээнд тулган орхисон нь тодорхой болов. Буган чулуун хөшөөний гарал үүсэл улмаар ДБС-ыг үлдээгчидтэй угсаа-соёлын хамааралтай эсэхийг тодотгон үзэж болох бололцоотой байсан үнэт хэрэглэгдэхүүнийг ийнхүү бусниулсан нь туйлын харамсалтай бөгөөд ноцтой гэмт хэрэг болно.

Эдгээр тоногдсон байгууламжуудын дээд талд нэг дөрвөлжин булш (булш № 3), түүний зэргэлдээ зүүн аманд хосоор байрлах байгууламжуудыг (булш № 1,2) тус тус малтан судалсан боловч оршуулгын зориулалттай бус ямар нэгэн эд өлгийн зүйлгүй тахилын байгууламжууд болох нь тодорхой болов.



Зураг №2. Сэрүүн. Байгууламжийн гадаад бүтэц (Булш №1, 6)

Б. Сэрүүн: Биндэр сумын нутаг Сэрүүний хөндийн Хөшөө чулуут хэмээх газарт хүрэл, төмрийн түрүү үед холбогдох 40 гаран дөрвөлжин булш, тахилын байгууламжийг бүртгэж, үүнээс 6 дурсгалыг малтан шинжилсэн болно. Энэ газрын дудсан дурсгалуудыг үйлдэхдээ хавтгай билүү чулууг тээвэрлэн авчирч хийсэн бөгөөд Галттайн голын зүүн бие Баян хошуу уул буюу даруй 10-аад км-ын цаанаас зөөвөрлөжээ. Дурсгалуудын нийтлэг онцлог нь нимгэн хавтгай чулууг хавиргалан босгохдоо аль нэгэн талын хашлагыг бусдаас өндөр хийх (бидний малтсан №5 булшны урд хана ийнхүү анх өндөр хийгдсэн бололтой байсан бөгөөд арагш унахдаа булшны таглаа мэт болсон байдалтай байв), бараг тал хувьд нь зүүн хашлагын ханаас 10-аад метр зайд чулуу босгож, хөшөө сэргэ маягийн зүйл гозойлгон босгосон онцлогтой байна. Эдгээр дурсгалуудын дундаж хэмжээ манаас чулууг оруулан тооцоход 3х6 м хэмжээтэй бөгөөд Монгол, Өвөрбайгалын нутагт тархсан мөн дурсгалын дундаж хэмжээтэй дүйцнэ. Энэ газрын дурсгалуудын зарим хэсгийг урьд өмнө ухаж төнхсөн ул мөр илт мэдэгдэх бөгөөд магадгүй өмнөх үеийн судалгаанд хамрагдсан байж болох талтайг үгүйсгэх аргагүй бөгөөд судалгааны тайлангуудыг нягтлан шүүж үзэх нь зүйтэй болно. Бидний энд хийсэн 6 байгууламжийн 5 нь оршуулгын зориулалтгүй бол зөвхөн 1 –ээс (булш №6) дусал хээ бүхий дутуу шатаалттай ваарны хагархай, хүний гавлын суурь ясны хагархай, дунд чөмөгний толгой зэрэг үлдэгдэл илрэв (Зураг № 2. Булш №6. Гадаад бүтэц, ваарны хагархай).

В. Ханан: Дэлгэрхаан сумын төвөөс баруун тийш 20 гаран км зайд Хэрлэн Баянулаан уулын урд үзүүр Ханан уулын энгэрт хүрэл, төмрийн түрүү үед холбогдох 50 гаран дөрвөлжин булш, тахилын байгууламж, эртний түрэгийн 1 хос




тахилын онгон зэргийг бүртгэж, үүнээс 4 дурсгалыг малтан шинжилсэн болно. Энэ газрын дурдсан дурсгалуудыг Ханан уулын хавтгай цуулбар хадыг шууд газар



Зураг №3. Сэрүүн №6. Булшнаас илэрсэн ваарны хагархай

дээр нь ашиглах замаар хийсэн байна.

Дурсгалууд төвлөрсөн амны дээд хэсэгт хавтгай чулуудыг ханаруулан өрж тусгай тавцан засаж томхон хашлага бүхий дурсгалуудыг хийсэн байна. Мөн жижиг хэмжээтэй хэд хэдэн дурсгалууд бий. Уулын шил болон зүүн суганд хэмжээгээр харьцангуй том 4 байгууламжийг ухаж, нүхийг булалгүй хаяжээ. Бид сүрлэг, бараа ихтэй төвлөрсөн байгууламжууд их төлөв тахилын зориулалттай, хоосон байх магадлал их байдгийг тооцож, төвлөрлийн доод захаар тусгайдуу байрлах дундаж хэмжээтэй 3 байгууламжийг сонгон малтлав. Ханан №1 нь бүлэг булшны зүүн хойд зах Ханангийн Бор үзүүрт байрлана. Өргөрөгийн дагуу сунаж байрласан, хашлагын гадна ханыг хамруулан дунджаар 3х6м хэмжээтэй. Бидний энд малтсан 3 байгууламжийн 2-нь оршуулгын зориулалтгүй эсвэл тоногдож сүтгэгдсэнээс араг ясны үлдэгдэл байхгүй болсон бололтой. Ханан №1 булшнаас хүний өсгийний яс, зарим дутуу хавирга илэрсэн бөгөөд оршуулгын хандуулсан чиглэл, нас хүйс тодруулах бололцоотой хэрэглэгдэхүүн байсангүй. Ханан № 2 дурсгалаас хашлагын дотор битүү хавтгай чулуугаар нямбай чигжиж дүүргэсэн



ба дунджаар 110 см гүнээс хөндлөн нарийн хавтгай чулуугаар хийсэн авс илэрсэн бөгөөд зүүн тийш харуулан тавьсан бололтой араг ясны үлдэц илрэв. Хос шилбэ, гавлын ясны нүүрэн хэсэг алга болсон үлдэц илрэв. Ямар нэгэн эд өлгийн зүйл эс илрэв. Ханан №3 нь урьд өмнө хонхор үүсгэж байсан бололтой байсан нь тэр хавийн айл үнс, хогоо хийж дүүргэжээ. Үнс хогийг цэвэрлэж өнгөн хөрсний цэвэрлэгээ хийхэд гол хэсэгтээ чулуун дарлагагүй байгаа нь тоногдсоны илрэл бололтой. 80-аад см гүнээс нарийн хар толбо илэрсэн боловч шалган үзэхэд ямар нэгэн зүйл эс илрэв (Зураг № 4. Ханан булш № 2. Дотоод бүтэц).

Дүгнэлт: Он цаг тогтоох дээжний шаардлага хангах зохих хэрэглэгдэхүүн Сэрүүн № 6, Ханан № 1, 2-р булшнуудаас илрүүлсэн нь тус экспедицийн өмнөх зорилтоо биелүүлсэн хэмээн үзэж байна.

Зураг №4. Ханан №2.
Булшны дотоод бүтэц

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, ЦАХИМ УДИРДЛАГЫН СИСТЕМ

Г.Энхбат, Г.Анхсанаа, Б.Алтансүх

Аливаа соёлын өв, түүн дотроо түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж хамгаалах нь бүртгэх, судлан шинжлэх, сэргээн засварлах, сурталчлах зэрэг цогц ажлуудаас бүрдсэн цаг хугацаа, хүч, хөрөнгө ихээхэн шаардсан ажил байдаг.

Манай улсын хувьд өргөн уудам газар нутагт тархан байршсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалаар арвин баялаг бөгөөд энэ дотор археологийн дурсгалууд ихэнх хэсгийг эзэлдэг. Өмнө нь эдгээр дурсгалуудыг бүртгэх, судлан шинжлэх, сэргээн засварлах, сурталчлах, хадгалах, хамгаалах ажлыг яам, агентлаг, судалгааны байгууллагууд, орон нутгийн захиргаа дор бүр өөр өөрийн төвшинд тал бүрээс нь хийсээр ирсэн байна. Гэсэн хэдий ч хоорондын ажлын уялдаа холбоо, мэдээлэл солилцох арга хэлбэр болоод идэвхи санаачлага хангалтгүй байдгаас шалтгаалж түүх, соёлын үл хөдлөх дурсгал тэр дундаа археологийн дурсгалт газруудын урт хугацааны хадгалалт хамгаалалтын (бүртгэх, судлан шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах г.м) цогц бодлого, түүнийг хянах, хэрэгжүүлэх, төлөвлөх нэгдсэн систем (тогтолцоо) үгүй явж иржээ.

Дэлхийн нийтийн хөгжил, технологийн дэвшлийг ашиглан, мэдээллийн шуурхай, хүртээмжтэй байхыг удирдлага болгон өнөөдрийн бодит нөхцөл байдалд нийцсэн дурсгалт газрын хадгалалт хамгаалалтын байдлыг хянах, удирдах, төлөвлөх зорилго бүхий үндэсний хэмжээний цахим удирдлагын мэдээллийн системийн боловсруулж, түүний онцлог, системийн хамрах хүрээ болон хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлох шаардлага урган гарч байна. Бид энэ үүднээс “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг төлөвлөх цахим удирдлагын систем”-ийн хэрэглэгчийн шаардлага-ыг эхний байдлаар боловсрууллаа.

Мэдээлэл дээр суурилсан аливаа үйл ажиллагааны хамгийн гол нь мэдээллийн системийг байгуулж, түүний тусламжтай компьютерын системд мэдээллийг оруулах, нэгтгэн боловсруулах боломжтой болгох явдал юм.

Бидний боловсруулсан цахим удирдлагын систем нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын тухай мэдээллүүдийг нэгтгэн боловсруулахад зориулагдсан систем буюу веб-д суурилсан програм хангамж юм. Програм хангамж нь доорх хоёр дэд системээс бүрдэнэ. Үүнд:

1. Засгийн газрын тогтоолоор батлагддаг Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамрах систем (Схем 1).
2. Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгаанд хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамрах систем (Схем 2).

Дэд систем тус бүр дараах 3 модультай байна.

- Бүртгэл мэдээлэл, тохиргооны модуль
- Хадгалалт хамгаалалтын чиглэл тодорхойлох модуль
- Тайлангийн модуль

Энэхүү систем нь Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 21 аймгийн боловсрол, соёлын газар, палеонтологи, археологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудыг хамрах болно (Хүснэгт 1).

Системийн хэрэглэгчийн зүгээс оруулж буй мэдээлэл дараах агуулгатай байж болно.



- Хадгалалтын байдал
- Хадгалалтын нөхцөл байдал
- Хадгалалтыг сайжруулах санал
- Ашиглалтын байдал
- Ашиглалтын одоогийн нөхцөл байдал
- Ашиглалтын байдлыг сайжруулах санал
- Судлагдсан байдал

Судалгааны баримт материалууд (тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, ном г.м)

- Цаашдын судалгааны төлөвлөгөө
- Сэргээн засварлалтын байдал
- Сэргээн засварласан байдал
- Сэргээн засварлалтын цаашдын төлөвлөгөө

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын байдлын мэдээллийн нэгдсэн сан үүсгэснээр бодит мэдээлэлд тулгуурлан дурсгалын хадгалалт хамгаалалтыг урт хугацаанд төлөвлөх, түүнийг удирдах боломж бий болох юм. Түүнчлэн соёлын өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн мэргэжлийн болоод орон нутгийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирч тэр хэрээр дурсгалын хадгалалт хамгаалалтад бодит ахиц гарах юм.

Системийн ач холбогдол:

- Палеонтологи, археологийн малталт судалгааны түүх, судлагдсан ийн талаарх нэгдсэн мэдээллийн сан бий болсноор соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгэм, эдийн засгийн бусад салбар, орон нутгийн удирдах байгууллагын бодлого, боловсруулах, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтныг мэдээллээр хангах, тэдэнд мэдлэг олгох боломжийг хангана,
- Палеонтологи, археологийн малталт судалгааны тайлан мэдээ, үр дүнг нэгтгэх боломжтой болно,
- Эртний хотын туурь, сүм хийд, дурсгалт уран барилгын хадгалалт, хамгаалалт, ашиглалт, сэргээн засварлалатын талаарх мэдээллийг нэгтгэн, цаашид авах арга хэмжээг төлөвлөнө,
- Палеонтологи, археологийн бүртгэл, тандалт, малталт судалгааны талаар нэгдсэн бодлого, төлөвлөлтийг боловсруулна, (Үндэсний судалгаа, хамтарсан судалгааны төсөл)
- Дурсгалт газар, дурсгалыг уул уурхай, дэд бүтэц зэрэг нийгмийн эрэлт хэрэгцээнд нь зориулж зөөж шилжүүлэх, археологийн нөөц газар, нээлттэй музей, газар дорх музей, археологийн үндэсний парк, байгаль соёлын өвийн парк гэх мэт соёлын бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлалд ашиглах, гэх мэт хэрхэн хадгалах, хамгаалах, ашиглах зэрэг төлөвлөлтийг хийх боломжтой болно,
- Судалгааны байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа бий болно,
- Дурсгалт газар, дурсгалыг сэргээн засварлах талаар төлөвлөлт хийх,
- Палеонтологи, археологийн малталт, судалгаагаар илэрч олдсон олдвор, эд өлгийн зүйл, музейн үзмэр зэрэг түүх, соёлын хөдлөх дурсгалтай холбон бүртгэл, судалгааг нэгтгэн, төрөлжсөн мэдээллийн сан бий болгох боломжтой болно.

Иймд энэ талын үйл ажиллагаа дагнан эрхэлдэг судалгааны байгууллагууд “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг төлөвлөх цахим удирдлагын систем”-ийн хэрэглэгчийн шаардлага”-д өөр өөрсдийн ажлын

онцлогийг тусгасан саналаа нэгтгэснээр дээрх мэдээллийн систем амьдралд илүү нийцсэн, тогтмол, хамтын үйл ажиллагаатай байх болно хэмээн бид үзэж байна.

Хүснэгт 1

№	Байгууллагууд	Байгууллагын тоо
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
1	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	1
Судалгааны байгууллага		
1	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн	1
2	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн	1
3	Монголын үндэсний музей	1
4	МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим	1
5	Улаанбаатарын Их сургууль	1
6	ШУТИС-ийн БУХС	1
7	Ховд Их сургууль	1
Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан		
1	Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан (Соёлын өвийн төв)	1
2	Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан	22
Орон нутгийн соёлын өвийн асуудал эрхэлсэн байгууллага		
1	Аймгийн Боловсрол соёлын газар	21
	Нийт	52

СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ БА ТҮҮНИЙ ТАЛААР ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ


Б.Наранбаатар, О.Энхбаяр, Д.Баярбат

Цагдаагийн ерөнхий газар Эрүүгийн Цагдаагийн газар нь Соёлын өвийн эд өлгийн зүйлийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, ашиг олохоор хууль бусаар олж авах, зарж борлуулах, зохих зөвшөөрөлгүй хууль бусаар малтах зэрэг гэмт хэргийг шалгаж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилготой ажиллаж байна.

Монгол улсын хэмжээнд 2015 оны байдлаар 21 аймагт тухайн орон нутгийн онцлог, хүн амын уламжлал, зан заншлыг харуулсан 1000 гаруй чулуун зэвсгийн бууц суурин, 600 орчим хүн чулуу, 600 орчим буган чулуу хөшөө, 300 орчим хот суурины ор үлдэц, хадны зурагтай томоохон дурсгалт газар 200, судласан булш, хиргисүүр 500, тайлгын онгон 110, төрөл бүрийн бичээс бүхий хөшөө дурсгал 200, сүм хийдийн үлдэгдэл, туурь 941 судлагдаж бүртгэгдээд байгаа гэсэн тоон мэдээ бидэнд байна.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор түүх болон шинжлэх ухаан, уран сайхны ач холбогдолтой 450 дурсгалыг улс, аймаг, нийслэлийн хамгаалалтанд авсанаас 175 нь улсын хамгаалалтанд, 275 нь аймаг орон нутгийн хамгаалалтанд тус тус аваад байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хууль бусаар булш, бунхан, хиригсүүр ухаж сүйтгэх гэмт хэргийн талаарх судалгааг орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдээс авч гаргахад 2014 онд нийт 13 гомдол мэдээлэл, хэрэг, 2015 онд нийт 16 гомдол мэдээлэл, гэмт хэрэг бүртгэгдэж эдгээр хэрэгт 2014 онд 14 сэжигтэн, 2015 онд 20 сэжигтэн шалгагдсан байна. Эдгээрээс заримыг онцлон дурдвал,





- Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Агар багийн Их азарга гэх газар байсан эртний булшийг тус багийн иргэн Г.Ууганбат, Э.Базаррагчаа нар ухаж сүйтгэн соёлын өвийг авч бусдад зарж борлуулсан эрүүгийн 201522000010 тоот хэрэг,

- Э.Энхтөр нь Архангай аймгийн Цахир сумын Содномдаржаа уулын оройд байсан эртний булш ухаж сүйтгэн занданшуулсан хүний шарилыг хулгайлан авч их хэмжээний мөнгөөр худалдахаар завдсан эрүүгийн 2015260000678 тоот хэрэг,

- Булган аймгийн Сайхан сумын нутаг Өргөөт гэх газраас 2015 оны 05-р сарын 28-ны өдөр Ж.Галмандах нь бусадтай бүлэглэн хадны оршуулга ухаж сүйтгэсэн гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэг.

- Ховд аймгийн Мянгад сумын Улаан үнээт гэх газраас 2015 оны 04 дүгээр сарын 2-ны өдөр тус сумын иргэн Д.Батсүх нар нь хадны оршуулга ухаж сүйтгэн эмээл, нум сум, хоромсог зэрэг эд зүйл авсан хэргүүд юм.

Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, аймгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд 2014 он, 2015 оны байдлаар нийт 29 хэрэг бүртгэгдэж шалгагдсанаас “бүх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг” хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон Прокурорын шатанд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа сэжигтэнүүд нь ял завших боломж бүрдэх, дахин энэ төрлийн гэмт хэргийг давтан байнга үйлдэх боломжийг бүрдүүлж байсан.

Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа сэжигтэнүүд ихэвчлэн тухайн орон нутгийн иргэд байгаа нь 2014, 2015 онуудад Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргүүдээс харагдаж байна.

Нийт булш ухаж сүйтгэх гэмт хэрэг үйлдэн шалгагдсан сэжигтэнүүд бүгд тухайн орон нутгийн иргэд байгаа бөгөөд нутаг, усаа мэддэг иргэд газарчилж өгөх, хамтран ухаж сүйтгэх зэргээр ямар нэгэн байдлаар тухайн гэмт хэрэгт оролцоотой байна.

Дээрх байдалд дүгнэлт хийж шинээр батлагдах Эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэргийн талаарх саналаа холбогдох байгууллагуудад хүргүүлж батлуулсан бөгөөд Монгол улсын Гэмт хэргийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”-ийн талаар бүлэг болгон оруулж батлуулан 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөхөөр шийдвэрлэгдсэн байна.

Монгол улсын Гэмт хэргийн тухай хуулийн хорин зургаадугаар бүлэг
“Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”

26.1 дүгээр зүйл. Соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэж гэмтээх, устгах

1. Монгол Улсын соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Улс, орон нутгийн хамгаалалтад авсан соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг нийтэд аюултай аргаар үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

26.2 дугаар зүйл. Соёлын өвийг нуух

1. Үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны явцад соёлын биет өвд хамаарах эд өлгийн зүйл, олдворыг олсон хүн зориуд нуусан бол нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

26.3 дугаар зүйл. Хууль бусаар соёлын өвийн хайгуул, малтлага хийх

1. Хууль бусаар соёлын өвийн хайгуул, малтлага, судалгаа хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Хууль бус соёлын өвийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн, зуучилсан, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр үйлчилсэн, газарчилсан, орчуулга,

хөтөч хийсэн, хууль бус олдворыг тээвэрлэсэн, хадгалсан бол нэг жилээс таван жил хүртэл хорих ял шийтгэнэ.

26.4 дүгээр зүйл. Соёлын өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах

1. Соёлын өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

26.5 дугаар зүйл. Соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх

1. Соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаандаа улсын хилээр оруулж ирээгүй бол нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Археологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа сайжируулах зорилгоор нэгдсэн мэдээллийн сан үүсгэн бий болгох буюу археологийн хууль бус малтлагын талаар, хууль бусаар булш, бунхан, хиригсүүр ухаж сүйтгэж байгаа иргэд ААН-ийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдэгдэж хэвших, тогтмол харилцаж байх мэдээллийг урсгалыг зохион байгуулах.

Энэ талаар төрийн бусад холбогдох байгууллагад санал хүргүүлэн эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг хамтран зохион байгуулах.

Археологчидын хөдөө орон нутагт ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цагдаагийн байгууллага, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах, ойлголцох боломжийг бүрдүүлэх ажлыг БСШУЯ, ШУА-ын Түүх, Археологийн хүрээлэнтэй хамтран хийх, Түүх, Археологийн алба хаагч нараас санал авах.

Шинээр батлагдсан эрүүгийн хуулийг түүх, археологийн чиглэлийн их, дээд сургуулийн төгсөх курсын оюутнуудад сурталчилан таниуулах тал дээр анхааран ажиллах зүйтэй байна.

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМАНД ХИЙСЭН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН


Л.Эрдэнэболд, Р.Төгссайхан

Монгол угсаатны бүрэлдэн тогтсон түүхэн асуудлыг шинжлэх ухааны үүднээс системтэй цогцоор нь судлах асуудал өнөөгийн даяарчлалын эрин зуунд хурцаар тавигдаж байна. Монголчуудын угсаа гарлын асуудлыг XIX-XX зуун хүртэл дотоод гадаадын олон арван эрдэмтэн судлаачид тодруулахыг оролдож хэдэн зуун эрдэм шинжилгээний өгүүлэл, ном бүтээл туурвисан боловч өнөөг хүртэл тодорхой бус олон асуудлууд байсаар байгаа юм.


2014 оноос манай эрдэмтэн судлаачид өөрийн угсаа гарвалын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх зорилготой “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн, угсаа гарвалын цогц судалгаа”-ны төслийг санаачлан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд Монголчуудын угсаа гарвалын түүхийг хүрэл зэвсгийн үеийн Монгол нутагт тархсан дөрвөлжин булшны соёлоос эрж хайх ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд зүүн болон төв Монгол, говийн хэсгээр дөрвөлжин булшны дурсгалыг малтан судлаж палеоантропологийн болон он цаг тогтоох хэрэглэгдэхүүн цуглуулахыг зорьсон билээ.

Энэхүү төслийн судалгаааны хүрээнд бид Төв аймгийн Алтанбулаг сумын Эрдэнэ хайрхан ууланд 10 нийт 14 хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш малтан судлав. Эрдэнэхайрхан ууланд 2014 онд бид малтлага судалгаа эхлүүлж, оршуулгын газрын дэвсгэр зургийг үйлдэн, 5 булш малтан судалсан юм. 2015 онд тус судалгаааны ажлыг үргэлжлүүлэв.

Эрдэнэ хайрхан уул: Уг дурсгал Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт, сумын төвөөс баруун тийш 80 км зайтай байх Эрдэнэхайрхан уулын ар, Бортолгой хэмээх жижиг толгойн ар бэлд Туул голын урд эрэгт бий. Энд нийтдээ хэлбэр төрхийн хувьд болон гадаад байдлын элэгдлийн хувьд ойролцоо 200 орчим булш бий. Эдгээр булшнуудын дунд нэгэн том хиргисүүр байх ба мөн тэгш өнцөгт хэлбэрийн дараас чулуутай 2 дурсгал байна. Хиргисүүрийг тойрсон эдгээр дурсгалууд нь тодорхой дэс дараа, зохион байгуулалтгүй хэд хэдээрээ бүлэглэж байрлажээ.



Эрдэнэхайрханы 9-р булшнаас
олдсон ясан эдлэл




Эрдэнэхайрханы 9-р булшнаас олдсон ясан эдлэл

Булшнуудын хэмжээ харилцан адилгүй бөгөөд хамгийн жижиг нь 2х3 м байх бол хамгийн том нь 9х9.5 м хэмжээтэй байна. Дараасыг гол төлөв уулын хадны хэлтэрхийгээр хийжээ. Зарим булшны төв хэсэгт чулуу цөөнтэй хонхорхой бий. Ихэнх булшнуудын дараас өргөргийн дагуу сунасан байна. Бид 2015 онд 10 булшийг сонгон малтлага судалгаааны ажлын хийсэн юм.

Морин толгой: Уг дурсгал Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт, сумын төвөөс баруун тийш 71 км зайтай байх Туул голын хойд эрэгт 1 км зайд, Морин толгойн баруун талд байх Халзан хайрхан хэмээх уулын өмнөд энгэрт оршино. Энэ Халзан хайрхан уулын энгэрт нэг доор 120 дөрвөлжин булш, 3 буган хөшөө,


тэдгээрийн зүүн талд зэргэлдээ 24 хүннү булш бүхий дурсгалтай. Бид энэ дурсгалт газар нийт 4 дөрвөлжин булш малтсан юм. Морин толгойн эртний оршуулгын газраас баруун урагш түрж орсон нэг жижиг хошуу бий. Жижиг хошууны баруун урд талаар он жилийн уртад борооны усанд элэгдэн гарсан нэгэн жалга байх ба уг жалганаас чанх баруун тийш 400 м орчим зайд Морин толгой уулын үргэлжилсэн уулын зүүн бэлд наран эзвэр газар зүүн урдаасаа зүүн хойш цуварсан тал саран хэлбэртэй бүлэг дөрвөлжин булш байна. Энд 11 дөрвөлжин булш, дугуй хүрээтэй нэг хиргисүүр байна. Бид эдгээр бүлэг Дөрвөлжин булшны хамгийн зүүн хойд талд байрлах зүүн хойд талдаа 0.4 м өндөр, 0.2 м өргөн хөшөө чулуутай 1 дөрвөлжин булшийг сонгон малтлага судалгааны ажлыг хийсэн юм.



Морин толгойн 2-р булшнаас олдсон ваарны хагархай



Морин толгойн 2-р булшны гар зураг



Морин толгой 2-р булшны оршуулгын гар зураг



Морин толгойн 2-р булшны оршуулга



Товч үр дүн: Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Эрдэнэхайрхан, Морин толгойн булшнууд нь гадаад байгууламжийн хувьд Г.П.Сосновскийн ангилалын 2-р төрлийн булш буюу “намхан дөрвөлжин чулуун хашлага, түүний гадуур хавтгай чулуун дараасаар хүрээлсэн булш”-д хамаарна. Гадаад болон дотоод зохион байгуулалын хувьд дөрвөлжин булшний гол хэв шинж болох тэгш өнцөгт хэлбэрийн чулуун хашлага хүнээ тавьсан чиглэл, илэрсэн олдвор зэргээс харвал эдгээр булш нь хүрлийн үеийн дөрвөлжин булшны зан үйлийн нийтлэгийг илэрхийлж байна.

Эрдэнэхайрхан, Морин толгойд бидний малтсан дөрвөлжин булшны гүн 0.3-1.1 м (Морин толгойн 2-р булш 110 см) байгаа нь Монгол болон Буриадын нутагт малтсан дөрвөлжин булшны хэрэглэгдэхүүнтэй харьцуулвал хэмжээ, гүний хувьд дунд зэрэгт орж байна. Ихэнх булш эрт цагт тоногдож, сүйдсэн нь булшийг тойрсон олон тооны жижиг том чулууд эмх замбараагүй тарсан байгаа нь тоногдсоныг илтгэж байгаа бололтой. Эрдэнэхайрханы 7,8-р булшны оршуулгын зүүн хойд булан орчмоос, мөн Морин толгойн 2-р булшнаас хоёр төрлийн хэдэн янзын хээтэй ваарны хагархай гарсан нь энэ соёлын булшнаас илэрч олддог ваарны материалын найрлага, хээ чимэглэлтэй адил байна.

Бидний малтсан 14 булшнаас Эрдэнэхайрханы 6,7,8,9-р булш, Морин толгойн 2-р булшнаас хүний яс, ваарны хагархайнууд, ясан эдлэл илэрсэнээс Морин толгойн 2-р булшнаас хөндөгдөөгүй хүний яс бүтэн гарсан нь чухал юм.

Тиймээс энэхүү булшны олдворт байгалийн ухааны шинжилгээг хийж он цагийг нарийвчлан тогтоох нь Монгол угсаатны бүрэлдэн тогтсон түүхэн асуудлыг шинжлэх ажилд дөхөм болж байгаа юм.

ТЭРЭЛЖИЙН ДӨРВӨЛЖИН БАЛГАСАНД ЯВУУЛСАН 2015 ОНЫ АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГАА

*Л.Эрдэнэболд, Ц.Бямба-Очир, Н.Н.Крадин, А.Л.Ивлиев,
С.А.Васютин, Е.В.Ковычев, А.В.Харинский*

Монгол улсын нутагт илрэн олдсон түүх, соёлын арвин их дурсгалууд дотор хот суурин томоохон байр суурийг эзэлдэг. Төв Азийн нүүдэлчдийн өвөг дээдэс эртнээс бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтөлж түүнийг өөрсдийн үндсэн амин зуулга болгосоор иржээ. Гэсэн хэдий ч нүүдлийн соёл иргэншлийг цогцлуулсан нүүдэлчин малчид нь суурин иргэншлийг ерөөс мэддэггүй байсан гэж бас үл болно. Тэд зах залгаа суурин ард түмнүүдтэй байнга харилцан, тэдэнд нөлөөлөхийн хамтад өөрсдөө тэдний соёлын үр шимээс ч хүртдэг байжээ. Тэгэхдээ тэд газар тариалан голлон эрхэлдэг суурин ард түмний соёлыг тэр чигээр нь хуулбарлан авдаггүй, өөрсдийн нүүдлийн иргэншлийн нөхцөлд тохируулан өвөрмөц маягаар хөгжүүлэн хэрэглэдэг онцлогтой байв. Үүний нэг жишээг нүүдэлчдийн хот суурингуудаас харж болно.

Иймээс эртний судлалын судалгаанд Төв Азийн ард түмнүүдийн нүүдлийн нийгэмд тухайлбал, хүннүчүүдийн дунд хот суурин хэрхэн үүссэн асуудал судлаачдын сонирхолыг зүй ёсоор татдаг билээ. Тиймээс хүннүгийн үед холбогдох эдүгээ олдсон хот суурингуудыг судалснаар нүүдэлчдийн хот байгуулалтын арга барил, барилгын хэв загвар, чимэглэл, хэрэглэгдэхүүний хувирал өөрчлөлт, хот суурины тухайн үеийн үйлдвэрлэлийн хөгжил, гадаад харилцаа зэрэгт гүйцэтгэж байсан үүрэг зэрэг олон асуудлыг нягтлан тодруулах боломжтой юм.

Монгол-ОХУ-ын хамтарсан “Монгол нутаг дахь Хүннүгийн эзэнт гүрний хот суурин” төслийн хүрээнд 2016 оны 8-р сард Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн дөрвөлжин хэмээх дурсгалд малтлага судалгаа явуулсан юм.

Тэрэлжийн дөрвөлжин хэмээх энэхүү хуучин хотыг анх 1930-аад оны үед Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов, буриад эрдэмтэн Базар Бараадин нар илрүүлэн олсон байдаг. Дараа нь Монголын эрдэмтэн Х.Пэрлээ 1960-аад оны үед бага хэмжээний сорьц малтлага хийж Хүннү улсын үед холбогдох боломжтой гэсэн дүгнэлтийг гаргажээ.

Тэрэлжийн дөрвөлжин хот нь Мөнгөнморьт сумын нутаг, Хэрлэн голын зөв талаас цутгадаг Тэрэлж голын зүүн хөвөөнд Баянжаргалан уулын урд дэвсгэрт оршино. Тэрэлжийн дөрвөлжин хэмээх уг хот нь шороо дагтаршуулсан дөрвөн тал хэрэм бүхий дөрвөн талдаа дөрвөн хаалгатай байсан бөгөөд хэрмийн дотор талд 3-4 барилгын үлдэц, хэрмийн гадуур гүн бус сувагтай байжээ.

2007, 2008 онуудад Монгол Оросын хамтарсан Хүннүгийн дурсгал судлах ангийнхан дээрх дурсгалт газарт өргөн хэмжээний малтлагыг тус хотын тууринд хийсэн бөгөөд хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлжээ. Бидний 2015 оны судалгаа нь дээр өгүүлсэн Монгол Оросын эрдэмтдийн судалгааны ажлын үргэлжлэл болно.

Энэ удаагийн малтлагыг бид малтлага-3 хэмээн нэрийдэв. Учир нь эл хотод өмнө хэд хэдэн удаагийн археологийн малтлага судалгааны ажил явагдсан бөгөөд 1950-иад онд хийсэн Х.Пэрлээгийн малтлагыг малтлага-1, 2007, 2008 онуудад С.В.Данилов, Л.Эрдэнэболд нарын малтлагыг малтлага-2, 2015 оноос эхлүүлсэн Н.Н.Крадин, Л.Эрдэнэболд нарын ажлыг малтлага-3 хэмээн нэрийдэв.

2015 онд бид Тэрэлжийн дөрвөлжин хотын тууринд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд,

- Тэрэлжийн дөрвөлжин хотын ерөнхий дэвсгэр зургийг нарийн мэргэжлийн



багаж хэрэгсэлийн тусламжтайгаар хийж гүйцэтгэв. Тус хотын төдийгүй хэрмийн ойр орчимд байх балгас туурийн үлдэгдэлийг хотын дэвсгэр зурагт оруулан нарийвчлав.

- Тэрэлжийн дөрвөлжин балгасны орчин тойронд археологийн нарийвчилсан хайгуул судалгааг явуулав.

- Хэрмийн дотор болон ойр орчимд нь геофизикийн болон гео соронзоны орны судалгааг явуулах,

- Тэрэлжийн дөрвөлжин хотын хэрмийн дотор нэгэн жижиг балгасны тууринд 12х12 метр хэмжээтэй малтлагыг явуулж уг хотын түүхэн он цаг барилгын бүтэц зохион байгуулалт, барилга архитектурын онцлог, эдийн соёлын хөгжил, мэдлэг ухаан зэрэг олон асуудлуудад хариулт өгөхийг зорьлоо.

Тэрэлжийн дөрвөлжинд өргөн хэмжээний малтлага судалгаа хийх, энэ төрлийн судалгааг шинэ эх хэрэглэгдэхүүнээр баяжуулан тодруулах нь дээрх хамтарсан төслийн гол зорилго байв. Цаашилбал, Хэрлэн голын сав нутгаас өгүүлэн буй үед холбогдох хот суурины үлдэцийг шинээр илрүүлэх, өөрөөр хэлбэл Хүннүгийн хот



суурины тархалтыг тодруулах асуудалд дөхөм болох нь дамжиггүй юм.

Бидний малтан судалсан барилга нь хотын туурийн зүүн хойт талд байрлах бөгөөд сууриараа 20х25 метр хэмжээтэй бөгөөд бидний барилгын бүтэц зохион байгуулалт, өмнөх барилгатай холбоотой зам мэт гүвгэрийн бүтэц зохион байгуулалтыг үзэх зорилгоор туурийн өмнө талд 12х12 м хэмжээтэй малтлагыг явуулав. Малтлагын гүн дунджаар 25-50 см үргэлжилсэн бөгөөд уг барилга нь шар шавар дэлдэн босгосон өндөр тавцан дээр байрлаж байсан ба түүхий тоосгоор өрсөн ханатай байсан нь мэдэгдэнэ. Тэрчлэн эл барилга нь бүхэлдээ сайтар шатаасан вааран дээвэртэй байжээ. Тиймээс малтлагаар илэрсэн голлох олдвор нь барилгын хэрэглэгдэхүүн байлаа. Барилгын хэрэглэгдэхүүнийг дотор нь нөмрөг, тосгуур, нүүр ваар, өнгөлгөөний хавтан тоосго гэж ангилж болмоор байна.

Малтлагаас илэрсэн дээврийн тосгуур ваарууд нь ихэвчлэн тууш самнасан сам хээтэй, түүний дээгүүр нь хөндлөн усан буюу долгион хэлбэрийн хээтэй байв. Дээврийн вааруудын хагархай хэсгүүдийг ажиглахад хэлбэр хэмжээ, хээний хувьд хоорондоо ялгаатай хэд хэдэн төрөл байсан нь мэдэгдэнэ.

Дээврийг хучсан нөмрөг ваар нь нумарсан гүдгэр гадаргуутай, түүний дээр нь янз бүрийн тууш урт зураасан хээг дүрсэлсэн байжээ. Мөн түүний дундуур хөндлөн долгион усан хээг мөн дүрсэлжээ. Басхүү дээврийн нөмрөг ваарны бөгжин хэсгийг даавуугаар бүрж бороо уснаас хамгаалж байсан бололтой бөгөөд энэ нь дээврийн бага зэрэг төвийсөн хэсэгт ул мөр нь үлдсэн байна.



Барилгын гадна өнгөлгөөний хавтангууд нь ихээхэн өвөрмөц гоёмсог хийцтэй байжээ. Тэдгээр нь ихэвчлэн саарал шавраар хийж сайтар хатууруулсан 20х20х2-3 см хэмжээтэй ажээ. Малтлагаас илэрсэн дээрх хавтангууд ихэд нимгэн, нэг талдаа хээтэй, өнгөлгөөний зориулалтай, хананд нааж чимэглэдэг байсан бололтой. Бас дээврийн ваарны төгсгөл хэсгийн нүүр ваарыг өвөрмөц хээ угалзаар чимэглэсэн байжээ. Уг нүүр ваарууд хоорондоо адил бус 2-3 төрлийн хээтэй байна. Тэдгээрийн голч нь дунджаар 17 см. Барилгын нүүр вааран дээр дүрсэлсэн хээ нь хүннүгийн оршуулгын дурсгалуудаас илэрсэн эсгий ширдэгний хээтэй зарим талаараа ижилсэж байлаа.

Тэрэлжийн дөрвөлжин хотын турийн малтлагаас илэрсэн олдвор хэрэглэгдэхүүн, дээврийн ваарны хагархайнууд болон хотын бүтэц зохион байгуулалт олон зүйлүүд нь Монгол улсын нутаг дэвсгэрт өдгөө малтан судлаж байгаа болон өмнө малтан судлагдсан хүннүгийн хот суурины дурсгалуудтай ижил байна.

Энэ туурь нь өмнө талын 60х32 метр хэмжээтэй том барилгатай зурвас зам мэт гүвгэрээр холбоотой болохыг өмнөх эрдэмтэд ажигласан байдаг бөгөөд тэрхүү гүвгэрийг бид энэ жил бага зэрэг малтаж үзвэл 2,0 метр өргөнтэй, 40 орчим см зузаан шавар дагтаршуулсан зам болох нь мэдэгдсэн юм. Бидний таамаглаж байгаагаар энэ нь дорно дахины ард түмнүүдийн дунд багагүй дэлгэрсэн хаад ноёдын ордны зохион байгуулалтыг илтгэх бөгөөд өмнө талын барилга нь хаад язгууртнуудын үндсэн ордон, залгаа барилга нь тэдний амарч сэрүүцэх бусад зорилгоор ашигладаг туслах чанарын ордон аж. Эдгээр барилгуудыг хооронд нь тусгай замаар холбон түүний хоёр хажуугаар олон тооны багана босгож дээгүүр нь саравч хийдэг уламжлалтай. Энэ уламжлалт барилга байгуулалтын онцлог Тэрэлжийн дөрвөлжин хотод ажиглагдаж байна.

Бидний 2015 оны малтлага судалгааны ажил уг барилгын туурийг өргөн хэмжээгээр хамарч чадаагүй учир барилгын бүтэц зохион байгуулалтын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломж хомс байлаа. Гэсэн хэдий ч хоёр барилгыг холбосон замын хоёр хажуугаар 4 тооны баганын чулуун суурь илрүүлж олсон нь дээр өгүүлсэн таамаглалыг батлах боломжтой. Тэрчлэн малтлагаас илэрсэн мэдээлэл дээр үндэслэн эл барилга нь их галд өртөж шатсан болох нь тодорхой байна. Учир нь барилгын шар шавар дэлдэж босгосон тавцангийн ойр орчмоос олон тооны барилгын хэрэглэгдэхүүн илэрсэн бөгөөд тэдгээрийн зарим нь ихээхэн түлэгдэж харласан, ойр орчмын хөрс нь ихэд түлэгдэж шатсан нь мэдэгдэж байна.

2007 оноос бидний эхлүүлсэн Тэрэлжийн дөрвөлжин хотын туурийн малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээр энэ хотод оршин суугчид төдийлөн удаан хугацаагаар төвлөрч суугаагүй буюу эсвэл тахил тайлгын шинжтэй улирлын



чанартай суурин байсан болов уу хэмээн таамаглаж байна. Нөгөө талаар эрдэмтэн Х.Пэрлээ Тэрэлжийн дөрвөлжинг Хүннүгийн үеийн шүтлэгийн чанартай суурин байсан гэж үзжээ¹. Энэ нь ч бидний малтлагаас голчлон барилгын хэрэглэгдэхүүн их хэмжээгээр олдож байснаас бус ахуйн чанартай эдлэл цөөхөн илрэв. Бидний малтлага судалгааны ажил хараахан дуусаагүй бөгөөд дараа дараагийн жилүүдэд дахин уг хотод малтлага судалгааг өргөжүүлэн тэлж, нарийвчлан судлах ажил хийгдэх юм. Бидний энэхүү малтлага судалгааны ажлын эцсийн үр дүнд Тэрэлжийн дөрвөлжин хэмээх энэхүү хотын он цагийн хамаадал, бүтэц зохион байгуулалт, үүрэг зориулалтын асуудал тодорхой хэмжээгээр ил болох бөгөөд ингэснээрээ Монголын эх түүхийн судлалд өчүүхэн ч атугай хувь нэмэр болж эх түүхийн бодит дурсгалын талаарх бидний мэдлэгийг тэлэх боломжтой болох юм.

Бидний 2015 оны археологийн малтлага судалгаагаар 1 ширхэг төмөр эдлэл, 2 ш бод малын яс, барагцаалбал 18 мянган ширхэг барилгын дээврийн ваарны хагархай хэлтэрхий илэрч олдлоо.

¹ Х.Пэрлээ. Монгол ард улсын эрт дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961. 32-33-р тал

“ГУА ДОВ”-ЫН ДУРСГАЛТ ГАЗАРТ ХИЙСЭН МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

*Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд, Д.Мандах
Сон Ый-жон, У Сэй-ён, Ким Сан-мин, Хуанбо Чансо*

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Солонгосын Үндэсний музей хамтран хэрэгжүүлж буй Мон-Сол төсийн хээрийн шинжилгээний анги 2013 оноос “Гуа дов” хэмээх Хүннүгийн үеийн хотын турийг судлах ажлыг эхлүүлж, 2014, 2015 онд нийтдээ 3 жилийн хугацаанд малтлага судалгаа хийж байна.


“Гуа дов” хэмээх дурсгал нь Төв аймгийн Баянжаргалан сумын нутаг, сумын төвөөс зүүн хойш 28 км зайд Хэрлэн голын баруун эргийн Цагаан арал хэмээх газарт байрлана. Энэ дурсгалт газрыг анх Судар бичгийн хүрээлэнгийн дарга байсан Жамьян сайд аман түүхийн мэдээг мөшгөн явж олж үзсэн гэдэг. Харин 1952 онд Х.Пэрлээ агсан малтлага судалгаа хийж, дурсгалын ерөнхий бүтэц зохион байгуулалт болон үүрэг зориулалтын талаар өөрийн дүгнэлтийг хийсэн байдаг. Энэхүү судалгааны үр дүнгийн талаарх хэрэглэгдэхүүн өмнө нь хэд хэдэн удаа хэвлэгдсэн төдийгүй бид өмнөх илтгэлд энэ талаар дурдсан тул дахин өгүүлэлгүй зөвхөн 2015 онд хамтарсан төслийн хүрээнд хийгдсэн малтлага судалгааны үр дүн болон дурсгалын талаар өөрсдийн дэвшүүлж буй шинэ таамаглалын талаар товч өгүүлье.

Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн судалгааны баг 2013 онд Гуа довын хэрмийн өмнөд хаалга хэмээн таамагласан хэсэгт малтлага судалгаа хийж 16 багана бүхий том хэмжээтэй барилгын турийг ил гарган цэвэрлэсэн. Гэвч цаг хугацааны боломжоос шалтгаалан барилгын өмнө хэсгийг бүрэн ил гаргаж амьжаагүй ба барилгын зориулалт, бүтэц зохион байгуулалтын онцлог зэрэг олон асуудлыг ч хөндөж чадалгүй судалгааны ажлыг түр зогсоосон. 2014 онд дутуу орхигдсон ажлыг үргэлжлүүлэн хийсэн ба барилгын зориулалт, зохион байгуулалтыг илүү тодруулахаар хичээн ажиллав. Мөн уг барилгатай залгагдаж буй хэрмийн бүтцийг мэдэх зорилгоор барилгаас зүүн тийш 50 м зайд хэрмийг хөндлөн зүссэн малтлагыг ч хийсэн юм. 2015 онд хаалганы хэсгийн малтлага судалгааг үндсэнд нь бүрэн дуусгаж, уг хаалганаас хоёр тийш үргэлжлэх хэрэм хэмээн таамаглаж ирсэн хэсгийг малтан шинжлэх ажлыг хийв.


Хаалганы хэсэгт хийсэн малтлагын талбай 33 м урт, 14.5 м өргөн хэмжээтэй юм. Хаалганы үлдэгдэл хэмээн таамаглаж буй барилгын ором нь төв хэсэгт зүүнээс баруун тийш (ертөнцийн зүгээр баруун хойноос зүүн өмнө тийш) цуварч байрлах тус бүр 10х5 м хэмжээтэй 2 хэсэг дагтаршуулсан шавар суурь, түүнийг тойрон байрлах дээврийн шавар хавтан бүхий хэсэг, мөн дагтаршуулсан шавар хэсгийн 2 захад тулган барьсан улаан тоосгоор барьсан хос тасалгаа зэргээс бүрдэнэ. Тэгш өнцөгт хэлбэрийн дагтаршуулсан шавар суурийн 4 буланд тус бүр 1, төв хэсгийн 2 захад хоорондоо 1.5 м зайтай хос гэх мэтээр 1 суурьт 8 баганын чулуун суурь мэдэгдсэн бөгөөд 2 хэсгийн баганын суурийг нэгтгэн үзвэл уг барилга 16 баганатай болох юм. Уг 2 дагтаршуулсан хэсэг нь хоорондоо 5 м зайтай байна. Дагтаршуулсан 2 шавар суурийн гадна талаар 2-3 м талбайд дээврийн ваарнууд битүү дэвссэн мэт илэрсэн. Мөн 2 дагтаршуулсан шавар суурийн зүүн баруун талаас залган хэрмийн үлдэгдэл хэмээн таамагласан 1.4 м өргөн шавар зурвас 2 тийш үргэлжлэх бөгөөд дагтаршуулсан шавар суурь болон хэрмийн залгагдах хэсэгт улаан өнгийн тоосго ашиглан барьсан тасалгаа байрлана.



Ийм тасалгааны ул мөр дагтаршуулсан шавар суурийн 2 захад тус бүр 2 мэдэгдсэн (Дэвсгэр зургийг өмнөх жилийн илтгэлээс үзнэ үү).



Зураг 1. Гуа довын дурсгалын ерөнхий байдал (агаарын зураг)



Зураг 2. Малтлага судалгаа хийсэн талбайн байдал (агаарын зураг)

Малтлага судалгааны явцад хийсэн ажиглалтаар хаалганы ерөнхий төрх нь тус бүр 8 баганатай тэгш өнцөгт хэлбэрийн хос байгууламж, орж гарах хэсэг нь түүний дундуур байжээ. Хос байгууламжийн 2 захад буюу хаалганы зүүн, баруун жигүүрт хэрмийн хананд тулган дотор, гадна талд нь улаан тоосгоор барьсан

жижиг тасалгааг байгуулсан байна. Дээврийн ваарыг цэвэрлэх явцад хаалганы баруун урд булангийн хэсэгт 3 үе дээврийн нүүр ваар илэрсэн нь сонирхол татсан. Энэ байдал нь уг хаалга 2-3 давхар үелэсэн дээвэртэй болохыг харуулж буй юм. Малтлагын хэрэглэгдэхүүнд тулгуурлан төсөөлөхөд Гуа довын хэрэмний хаалга нь хэлбэрийн хувьд Чойжин ламын сүм музейн гол хаалга зэрэг орчин үед уламжлан ирсэн зарим нэг эртний барилга байгууламжийнхтай төстэй байх магадлал өндөр байна.

Энэ жил хаалгаас 2 тийш үргэлжлэх хэрэм хэмээн таамаглаж ирсэн хэсэгт малтлага судалгаа нэмж хийсэн. Ингэхдээ хаалганаас зүүн өмнө тийш чиглэлээр үргэлжлэх хэсэгт булан хүртэл 160 м газарт хөрсийг бүрэн хуулж цэвэрлэсэн ба хаалганаас баруун хойш чиглэлээр үргэлжлэх хэсэгт 10 м тутамд хөндлөн суваг татаж судалгаа хийв. Үүний үр дүнд өмнө нь хэрэм хэмээн таамаглаж ирсэн 1.4 м орчим өргөнтэй дагтаршуулсан шавар хэсэг хаалганаас 2 тийш ижил урттайгаар 2 булан хүртэл үргэлжилж буй нь мэдэгдсэн бөгөөд уг дагтаршуулсан зурвасын 2 талаар дээврийн ваарнууд гарсан. Зурвасын 2 талаар үргэлжилсэн дээврийн ваарнуудыг авч цэвэрлэхэд доороос нь хоорондоо 1.3-1.5 м орчим зайтай модон баганы оромууд илэрсэн.

Судалгааны явцад нисэх төхөөрөмж дрон ашиглан зураг авч баримтжуулалт хийсэн бөгөөд агаарын зураг авсны үр дүнд хэрэм хэмээн таамаглаж байсан дөрвөлжин хүрээний зүүн өмнөд булангийн хэсэгт хүний гараар бүтээсэн цөөрөм байсны ул мөрийг илрүүлсэн юм.


Өнгөрсөн 3 жил хийсэн судалгааны үр дүнг нэгтгэн үзэхэд Гуа дов нь гадуураа хэрмээр хүрээлэгдсэн барилга бүхий хотын үлдэгдэл бус 4 талдаа маш сүрлэг хаалга бүхий олон баганатай вааран дээвэртэй саравч маягийн хашаагаар хүрээлэгдсэн болох нь тодорхой болж байна. Энэхүү вааран дээвэртэй олон багана бүхий саравч маягийн хашаа нь 180х200 м хэмжээтэй юм. Уг саравчит хашааны дотор баруун хойд талыг эзлүүлэн 50х40 м хэмжээтэй нүсэр том барилга байсан ба уг барилгын зүүн талд 30 м орчим урттай нарийхан сууц байсан нь мэдэгдэж байна. Мөн саравчит хашааны гадна талд ч 2-3 том барилга байсан ором мэдэгдэнэ. Саравчит хашааны зүүн өмнөд буланд хиймэл нуур буюу цөөрөм байгуулсан байжээ.

Газар зүйн байрлалд түшиглэн үзэхэд Гуа довын төв барилга нь ертөнцийн зүгээр зүүн өмнө тийш харсан хаалгатай байсан бололтой бөгөөд гадуур нь тойруулж барьсан олон багана бүхий вааран дээвэртэй саравчит хашаа нь барилгын байрлах чигийг даган талууд бус өнцөгүүд ертөнцийн зүгийг чиглэсэн байдлаар баригдсан байна. Тиймээс гол барилгын хаалганы чанх урдаас харан байрлах хаалгыг хашааны төв хаалга гэж үзэх нь зүйтэй бололтой. Хэрэв тийм бол бидний малтлага судалгаа хийсэн хаалга нь хашааны баруун хаалга болох юм. Хэмжилт судалгаа хийхэд төв хаалга хэмээн үзсэн ертөнцийн зүгээр зүүн талд орших хаалга нь бидний малтлага судалгаа хийсэн хаалганаас харьцангуй том байсан явдал ч энэ таамгийг батлаж байв.

Малтлага судалгааны үр дүнд тулгуурлан үзэхэд Гуа дов нь Х.Пэрлээ агсаны тодорхойлсончлон “тахилын газар” биш бололтой. Энэ дурсгал нь 2-3 давхар, сүрлэг харагдах 4 хаалгатай, зэрэгцээ олон баганатай, хаалгатай ижил вааран хавтангаар хучсан дээвэр бүхий саравч маягийн хашаагаар хүрээлэгдсэн их том хэмжээтэй нэг том барилга, түүний зүүн хойд талд туслах барилга бүхий ордон байсан бололтой байна. Түүнээс гадна саравчит хашааны зүүн өмнөд буланд хиймэл нуур буюу цөөрөм байрлах ба хашааны гадна талаар ч хэд хэдэн барилгын ором мэдэгдэж байгаа нь дурсгалыг тахилын газар бус язгууртны орд өргөө байсныг давхар батлах баримт юм.




*Зураг 3. Малтлага судалгаа хийсэн
хаалганы хэсэг (агаарын зураг)*




*Зураг 4. Хашааны зүүн өмнөд булангийн малтлагын
ерөнхий байдал (агаарын зураг)*

Бид Гуа довын дурсгалт газарт жил бүр 8 сард малтлага судалгаа хийсэн бөгөөд байх хугацаанд хийсэн ажиглалтаар байнгын сэвэлзүүр салхитай газар болох нь мэдэгдсэн. Хэрлэн голын баруун эрэг, голын жижиг салаа баруун талаар урсдагаас арал байдалтай болсон хэсэг тул нутгийн иргэд энэ газарт зөвхөн зун л зусах бөгөөд бусад улиралд ойр орчмын ууланд шахаж нутагладаг ажээ. Тиймээс Гуа довын дурсгалыг язгууртны орд өргөө хэмээн үзвэл “зуны ордон” байсан болов уу хэмээн таамаглаж болохоор байна.

Мон-Сол төслийн хувьд 2016 онд Гуа довын дурсгалт газарт гео-физик, георадарын судалгааг хийх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд эдгээр нэмэлт судалгааны үр дүнд дурсгалын үүрэг зориулалт, бүтэц зохион байгуулалтын талаар илүү нарийн мэдээлэл өгөх боломжтой болно хэмээн найдаж байна.



Зураг 5. Гуа довын дурсгалт газрын ерөнхий байдлыг
сэргээн зурсан байдал (Зурсан Б.Батцоож)



Зураг 6. Гуа довын дурсгалт газрын малтлагасудалгаа хийсэн хаалганы
ерөнхий байдлыг сэргээн зурсан байдал
(Зурсан Б.Батцоож)


МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “ДОРНОД МОНГОЛ: АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН 2015 ОНЫ ТОВЧ ҮР ДҮН

Ч.Амартүвшин, Г.Галдан, Б.Батдалай, У.Ханичёрч, Ж.Врайт

2015 онд тус төсөлд Монголын талаас ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Археологи, Угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Археологийн судалгааны төвийн музей-лабораторийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Галдан, Баримт мэдээллийн төвийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Молор, Археологи, угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Батдалай, МУИС-ийн Археологи-Антроплогийн тэнхимийн багш, доктор, профессор З.Батсайхан, АНУ-ын талаас Ийелийн Их сургуулийн профессор, доктор У.Ханичёрч, Их Британи улсын Абердины Их сургуулийн доктор Ж.Врайт нар оролцон ажилласан ба хайгуул судалгааны ажлын хүрээнд 143 дурсгал шинээр илрүүлэн бүртгэсэн ба 2013 оны хайгуулаар шинээр илрүүлсэн Хавчиг бууцны хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгалаас 3 тооны булшийг малтан судаллаа.

Хайгуул судалгаа

2015 тус хээрийн судалгааны ангийнхан нийт 36 км² талбайг шалгасан ба үүнээс 11 км² талбайд нарийвчилсан хайгуул судалгааг хийсэн бол үлдсэн 25 км² талбайд гүймэг хайгуулыг хийсэн.




Зураг 1. Дэлгэрхаан ууланд хийж буй хайгуул судалгааны талбайн сансарын ерөнхий зураг

Энэ хугацаанд нийт 143 хайгуулын дугаарт, 215 ширхэг дурсгал шинээр илрүүлэн бүртгэсэн ба үүнээс 73 хайгуулын дугаарт 144 ширхэг түүхийн олон үед хамаарах чулуун байгууламжит дурсгал илрүүлснээс 78 ширхэг хэд хэдэн төрлийн хүрэл зэвсгийн үед хамаарах чулуун байгууламж байна. Үүнээс, 7 хиргисүүр, 5 шоргоолжин булш, 64 ширхэг Улаан зуух хэлбэрийн булш, 1 дугуй булш, 1 Чандмань Хар уулын хэв шинжит булш байна. Хүннүгийн үед холбогдох 6 чулуун байгууламж, 1 ширхэг эртний Түрэгийн үеийн чулуун байгууламж байгаа бол дундад зууны үеийн 31 булш оршуулгын дурсгал байна. Мөн 28 ширхэг он цаг тодорхойгүй чулуун байгууламжууд байна.

Харин 68 газраас эртний нүүдэлчдийн бууц суурингийн дурсгал илрүүлэн бүртгэсэн байна. Эдгээрээс хуучин чулуун зэвсгийн үед хамаарах бууц суурин 2, шинэ чулуун зэвсгийн үеийн 14, хүрэл зэвсгийн үеийн 7, хүннүгийн үеийн 5, түрэгийн үед холбогдох 11, дундад зууны үеийн 22 байгаа бол цөөнгүй тооны аль үед хамаарах нь тодорхойгүй бууц суурингийн дурсгал байна.

Мөн энэ оны хээрийн судалгааны үр дүнд нилээд олон тооны хятаны үед хамаарах шавар сав суулганы хагархай бүхий бууц суурингийн дурсгал бүртгэсэн бөгөөд эдгээрийн манай судалгааны багийнхан бүгдийг Хятаны үед хамааруулан авч үзэхээс татгалзсан билээ. Учир нь манай орны археологийн үечлэлд Хятаны үеийн дараагийн үеийг XIII зууны монголын үе хэмээн тодорхойлсон байдаг боловч тухайн түүхэн үеүд цаг хугацааны хувьд ойролцоо, зэрэгцэн орших, Их Монгол улсын үед ч тэр эзэнт гүрний үед ч тэр хилийн чанадаас гар урчуудыг олзлон эх нутагтаа үйлдвэрлэл эрхлүүлж байсан сурвалжийн мэдээнд үндэслэвэл тухайн хэв шинжийн шавар сав суулга нь урт хугацааны туршид хэрэглээнд байсан байх талтай бөгөөд үүнийг дараа дараачийн судалгаагаар илүү тодорхой болгох бизээ.



Зураг 2. Хайгуул судалгаагаар илэрсэн дурсгалуудын тархалтын зураг




Энд нэг зүйлийг дурьдах нь зүйн хэрэг болов уу. Хятан маягийн саарал, хөх саарал өнгөтэй дусал хээ бүхий шавар савны хагархайтай дурсгалт газруудын ойролцоо чулуун хороо маягийн чулуун байгууламжууд олдох давтамж нилээдгүй тохиолдож байгаа ба энэ нь магадгүй тухайн хоёр дурсгал хооронд хамааралтай байх боломжтой гэсэн таамаг төрж байна. Учир нь тус чулуун хороо маягийн дурсгалыг өмнөх судлаачид болон манай төслийн судлаачид анхандаа илүү хожуу үеийн дурсгал хэмээн таамаглаж байсан боловч хэмжээний хувьд жижиг ойролцоо болон дэргэдээс нь харьцангуй эртний хэв шинжит эх хэрэглэгдэхүүн илэрч байгаа нь сонирхол татаж эхлээд байна.

Малтлага судалгаа

Дэлгэрхаан уулын баруун урд хэсэгт байх Хавчиг бууц хэмээх газарт хүннүгийн үед холбогдох жижиг хэмжээтэй бүлэг булш бий. Энэхүү дурсгалыг тус хээрийн судалгааны ангийнхан 2013 онд шинээр илрүүлэн олсон юм. Энэ жил (2015) уг бүлэг булшны зүүн урд хэсэгт байх зэрэгцээ 3 булшийг сонгон малтав. 1-р булшнаас 30-35 орчим насны эмэгтэй хүний оршуулганд төмөр зэв, ясан хонгио, шавар савны хагархай зэрэг эд өлгийн зүйлс дагалдуулсан байна. Булшны нүхний хойд талын тахилын хэсгээс 3 ширхэг хонины толгой, 1 ширхэг ямааны толгой болон бусад жижиг яснууд илэрсэн юм.



Зураг 3. Хавчиг бууцны 1-р булш



Зураг 4. Хавчиг бууцны 2-р булш

Харин 1-р булшнаас хүний хоёр гавлын яс гарсан нь тун сонирхолтой бөгөөд цаашдын судалгаагаар илүү нарийвчлан авч үзэх шаардлагатай юм. Гавлын ясанд хийсэн палеоантропологийн хэмжилтээр нэг нь 40-50 насны эмэгтэй, нөгөө нь 20-30 насны эрэгтэй хүн хэмээн тодорхойлов. Гэхдээ дагалдуулсан эд өлгийн зүйлс зэрэгт тулгуурлан тухайн булшны эзэн нь 40-50 насны эмэгтэй байсан бололтой хэмээн урьдчилсан байдлаар таамаглаж байна. Түүний өндөр ойролцоогоор

162.6 см. Тухайн булшны тахилын хэсгээс хоёр бод малын толгой болон бусад жижиг ясны хэсэг, шавар савны хагархай тус тус илэрсэн юм.

*Хүснэгт 1.Малтлага судалгаа хийсэн хүннү
булшны товч мэдээлэл*

№	Булшны дугаар	Дараасны хэмжээ	Нүхний гүн	Нүхний хэмжээ	Олдвор	Малын яс
1	Ех.15.01	6.0 м	1.6 м	2.1x0.9 м	Төмөр зэв, ясан хонгио, төмөр эдлэл, шавар ваарны хагархай	Хонины толгой 3, ямааны толгой 1
2	Ех.15.02	5.0 м	2.2 м	2.1x0.9 м	Шавар ваарны хагархай	Бодын толгой 2, сээр
3	Ех.15.03	6.0 м	2.4 м	2.3x1.0 м	Шавар ваар 2, ваарны хагархай, хүрэл эдлэл, чий будагтай мод	Үхрийн толгой 2, шийр, дал

Хавчиг бууцны 3-р булшнаас хоёр ширхэг бүтэн шавар сав болон хүрэл эдлэл, чий будагтай модны хэлтэрхий, тахилын хэсэгт хоёр үхрийн толгой, дал шийрний хамт дагалдуулжээ.

**МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “ТАРВАГАТАЙН ХӨНДИЙН
АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2015 ОНЫ
АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН**

Б.Жаргалан, У.Гарднер, Д.Бөхчулуун

Зорилго

Тус төслийн зорилго нь Булган аймгийн Тэшиг сумын нутагт орших Тарвагатайн голын хөндийд археологийн нарийвчилсан хайгуулыг гүйцэтгэж эртний дурсгалуудыг бүртгэн судалгааны эргэлтэнд оруулахаас гадна эртний хүн амын амьдралын хэв маяг, ахуй хэрхэн өөрчлөгдөж ирсэн болохыг судлах явдал юм. Ингэхдээ зөвхөн газрын хөрсөн дээр ил харагдах дурсгалуудыг хамруулахаас гадна Монголын археологид харьцангуй бага судлагдсан бууц суурингийн судалгааг түлхүү хэрэгжүүлж байна. Олон зууны турш хөрсөн давхаргуудад дарагдсан байдлаас болж эдгээр эртний бууц суурингууд нүдэнд үл харагдах учир төслийн анхан шатнаас эхлүүлэн хайгуул, дурсгал бүртгэх арга зүй дээр анхаарлаа хандуулсан юм.

2015 оны хээрийн шинжилгээний хүрээнд ерөнхий хоёр зорилго тавин ажиллав. Нэгдүгээрт, Тарвагатайн хөндийн салаа амнуудад буй бүртгэгдсэн хиргисүүрүүдээс сонгон нарийвчилсан он цагийг тогтоох. Хоёрдугаарт, нарийвчилсан хайгуулаар илэрсэн бууц суурингуудаас сонгон сорилтын малтлага хийж он цаг болон тухайн дурсгалын байдлыг олж тогтоох болно.

Хүрэл зэвсгийн үед хамрагдах хиргисүүрүүдийн нарийвчилсан он цагийг тогтоох нь Тарвагатайн хөндийд уг дурсгалыг босгох заншил хэдий үеэс ямар шатлалтайгаар эхэлсэн болохыг олох ач холбогдолтой юм. Ингэснээр зөвхөн хиргисүүрийн ерөнхий он цагийг тодорхой болгохоос гадна тэдгээрийг барих болсон нийгмийн шалтгаануудыг тогтоох ач холбогдолтой.

Мөн төслийн судалгааны ерөнхий асуултуудын нэг бол Монгол ба Өвөрбайгалын нутагт өргөн тархсан хиргисүүрийг тухайн үеийн хүмүүс ямар нийгэм, ахуй, соёлын үндсэн дээр барьж босгосон болохыг тогтоох явдал юм. Хэдийгээр тэдгээрийг оршуулгын болон тахилгын зориулалтаар барих болсон гэсэн онол зонхилоод байгаа хэдий ч энэ нь тухайн үеийн хүн амын эрхлэх аж ахуй, амьдралын хэв маягийн талаарх ойлголт дутмаг байдалтай шууд холбоотой хэмээн үзэж байна. Иймээс эртний бууц суурингийн судалгааг түлхүү анхаарах шаардлагатай байгаа юм.

Энэхүү төсөл эхэлснээс хойш нийт 74 км² талбайд нарийвчилсан хайгуул хийж 90 гаруй бууц суурин бүртгээд байна. Харин эдгээрээс чухам аль нь хиргисүүртэй нэгэн он цагт хамрагдах болохыг тогтоохын тулд сорьцын малтлагуудыг хийж, нарийвчилсан он цаг тогтоох шаардлага бий болсон юм. Ингэснээр цаашид өргөн хэмжээний малтлага судалгаанд хамрагдах бууц сууринг олж тогтоож, хиргисүүртэй нэг он цагт холбогдох хүн амын өдөр тутмын амьдралын талаарх ойлголтыг баяжуулж судалгааны олон асуултын хариултыг олж болох ач холбогдолтой.

Судалгааны арга зүй

Хиргисүүрийн малтлага. Тарвагатайн хөндийд хэд хэдэн газарт том хэмжээний хиргисүүрийн төвлөрөл бүртгэгдсэн. Эдгээр нь голдуу 5-6 хиргисүүрээс бүрдэнэ. Тус бүртээ дөрвөлжин хашлагатай, 8-24 ширхэг дагуулуудтай болно. Хиргисүүрийн он цагийг тогтооход бүрэн хэмжээний малтлага шаардагддаг боловч олон тохиолдолд он цаг тогтооход хэрэгтэй органик дээж олддоггүй. Дээрээс нь Тарвагатайн

хөндийд бүртгэгдсэн хиргисүүрүүдийн голын овгор чулуунаас тонуулын ул мөр мэдэгддэг. Хэдийгээр дагуул байгууламжуудаас тахилд өргөсөн амьтдын яс зэрэг зүйлс олддог боловч эдгээр дагуул байгууламжууд гол чулуун овгортой нэгэн цаг үед боссон эсэх асуудал шийдэгдээгүй байна. Иймээс энэ төслийн хүрээнд хиргисүүрийн гол овгор чулуунаас гадна бусад хэсгүүдийн (хашлага чулуу, дагуул байгууламж) он цагийг тогтоох арга зүйн дагуу малтлагуудыг явуулсан болно. Уг арга зүй нь чулуун дор буй хөрс хамгийн сүүлд хэдэн жилийн өмнө наранд ил гарсан байсан эсэхийг тогтооход чиглэсэн байдаг тул хиргисүүрийн хэсэг болгоны чулууг хэдэн жилийн өмнө тавьсан болохыг мэдэж болно. Энэ арга зүй цаанаа олон дагуул байгууламжтай том хэмжээний хиргисүүрүүдийг удаан хугацааны турш эртний хүмүүс босгож уу, эсвэл олон хүний хүч хөдөлмөрийг төвлөрүүлэн нэг удаагийн “дайралтаар” барьсан уу гэсэн асуудлыг шийдэхэд чиглэсэн.

Тарвагатайн аманд энэ зун ажилласан цөөн хоногт нийт 3 хиргисүүрээс он цагийн дээж авахаар төлөвлөв. Ингэхдээ тус бүрийг нь тодорхой судалгааны зарчмын дагуу сонгов. Хамгийн эхэнд малтлага судалгаанд хамрагдсан хиргисүүр буюу TVP 76 дурсгал нь Тарвагатайн голд цутган нийлдэг Төмрөнгийн голын адагт буй хавчиг аманд байрлана. Зүүнээс баруун зүгт чиглэн буй энэ аманд хоёр том хэмжээний хиргисүүр байх бөгөөд энэ амнаас урьд нь бид бууц суурингийн судалгаа хийж байлаа. Уг аманд айлууд өвөл, хаврын улиралд ирж суурьшина. Тиймээс энэ аманд нүүдэлчид ирж улирлын чанартайгаар суурьшиж байсан болов уу гэсэн таамаг дэвшүүлж болох юм.

Малтлага судалгаанд хамрагдсан дараагийн хиргисүүр нь Тарвагатайн голд хойноос ирж цутгадаг хамгийн том гол буюу Хужиртын голын хөндийд байрлана. Хужирт багийн төвийн хойно буй намхан товгор дээр байрлах энэ хиргисүүр бусад газраас харагдах орчин сайтай байсан тул сонгох болов. Гурав дахь хиргисүүр нь Тарвагатайн хөндийн баруун захад, Төмрөнгийн голын хөндийн хойд хэсэгт баруунаас зүүнд сунаж тогтсон өндөр уулын урд энгэрт байрлана. Энэхүү налуу энгэрийн дэвсгэ нь Төмрөнгийн голын хөндийн бүх хэсгээс харагдах учраас уг байгууламжийг малтан шинжилсэн юм.

Өнгөн хөрсөн дээрх анхны зохион байгуулалт нь харьцангуй бага хөндөгдсөн дагуул байгууламжуудыг гол төлөв сонгон малтлаа. Учир нь Тарвагатайн хөндийд бүртгэгдсэн хиргисүүр болон тэдгээрийн дагуул байгууламжууд нь тонуулчдын гарт ихээр өртсөн болох нь ажиглагдсан. Дараагийн нэг шалгуур нь дагуул байгууламжийн байршил юм. Бидний сонгон судалсан хиргисүүрүүд дотор дөрвөлжин хашлагатай, дөрвөн талдаа дагуултай хиргисүүр байсан бөгөөд дагуулууд нь урд талдаа хамгийн ихээр төвлөрч байв. Чулуун хашлаганы өөр өөр талд байрлах дагуулуудыг сонгон малтаж он цагийг нь тогтоосноор тухайн хиргисүүрийг хэдий хугацаанд байгуулсан болохыг тогтоох боломжтой болно. Дагуул байгууламж болгоны гадна талаар хүрээ татаж бүрэн талбайгаар нь цэвэрлэн малтлагыг гүйцэтгэв. Малтлагын үе болгон дээр гар ба фото зураг, нарийн тодорхойлолтыг гүйцэтгэв.


Шинээр хэрэгжүүлж буй он цаг тогтоох арга зүйн дээжийг авахдаа аль болох хөндөгдөж хөдлөөгүй чулуу сонгож байлаа. Сонгосон чулууны нэг талын ёроол хэсгийг ил гарган дээж авахад шаардлагатай хэмжээний нүх ухав. Үүний дараагаар 8 см голчтой төмөр хоолойг чулууны хажуу талаас ёроол доогуур алхаар нүдэн оруулж шорооны дээж авав. Хоолойг гаргахдаа гэрэлд цохиулахгүйн тулд дээжийг авч байгаа хүнтэй хамт бүрэн хучиж байв. Он цагийн дээж авсан нүхний хажуунаас мөн хөрсний чийгшилт, сансрын цацраг идэвхийн дээжийг мөн авав. Эдгээр нь он цагийн нарийвчлалыг бататгах нэмэлт дээжнүүд болно.

Бууц суурингийн сорьц малтлага. Өмнө нь хэлсэнчлэн эдгээр сорьц малтлагууд




нь хайгуул судалгааны үр дүнд илэрсэн бууц суурингуудын нарийвчилсан он цагийг тогтоох, тухайн дурсгалын байдлыг тогтоох зорилготой болно. Ингэснээр цаашид өргөн хэмжээний малтлага явуулах бууц сууринг олж хүрэл зэвсгийн үеийн хүн ам ямар аж ахуйтай байсан, хөдөлмөрийн ямар багаж зэвсэг хэрэглэдэг байсан, ямар ахуйн эд хэрэглэл ашигладаг байсан зэргийг өдөр тутмын амьдралын үйл ажиллагааны үр дүнд үлдсэн олдвороос тогтоож болох юм.

Аливаа бууц суурингийн дурсгалын он цаг, онцлогийг тогтоохын тулд хоёр төрлийн шатны сорьцын малтлага явуулав. Юуны өмнө газрын хөрсөн дээр болон дороос олдсон олдворын төвлөрөл ихтэй газарт 30х30 м талбай татаж 3 м болгонд өрмөн шалгалтыг хийж гарсан шороог бүрэн шигшинэ. Ингэснээр тухайн дурсгалын олдворын тархалтыг улам нарийсгаж байгаа юм. Ваарны хагархай, малын яс болон чулуун зэвсэг зэрэг олдвор гарсан сорьц болгон дэр туг зоосноор энэхүү нарийвчилсан тархалтыг ажиглаж болно. Үүний дараагаар олдворын хамгийн их төвлөрөлтэй хэсэгт тугны тархалтын байдлаас хамаараад 1х1 м юмуу бусад хэмжээний талбайг татан сорьц малтлага гүйцэтгэв. Энэ нь зөвхөн тухайн газарт эртний хүмүүс оршин сууж байсан эсэхийг тогтоохоос гадна он цаг тогтоох найдвартай дээжийг олоход чиглэсэн алхам болно. Малтлагын үр дүнд гарсан бүх шороог шигшиж олдсон олдворуудыг бүртгэлийн дугаарын дагуу савлан хадгалав.




265-р дурсгалын нэгдүгээр дагуул



Нэгдүгээр дагуулын адууны доод эрүүний яс
илэрсэн байдал



265-р дурсгалын хоёрдугаар дагуул
байгууламж



74-р дурсгалын галын ормын хөндлөн
зүсэлт

Урьдчилсан үр дүн

2015 оны зуны хээрийн шинжилгээний судалгаагаар нийт 3 хиргисүүрээс хөрсний дээж авч, 5 дагуулж байгууламж болон 1 эртний бууцыг малтлага судалгаанд хамруулав. Хиргисүүр болгонос нэг эсвэл хоёр дагуул байгууламж малтаж радиокарбон ба OSL он цагийн дээж авав. Эдгээрээс гадна хиргисүүрийн хашлага чулуунаас мөн OSL дээжийг дангаар авав. Ингэснээр эдгээр он цаг тогтоох арга зүйнүүдийг хооронд нь харьцуулж тухайн дурсгалын он цагийг илүү нарийвчлалтай тогтоож болох юм. Гарсан он цагийн дээжүүдийг шинжилгээний газруудад явуулахаар бэлтгэж байгаа болно.

Бууц сурингийн малтлагын хувьд 74-р дурсгалд анхан шатны шалгалтуудыг хийсний дараагаар 4х2 м харьцаатай талбайг олдвор хамгийн их нягтралтай хэсэгт татаж сорилтын малтлагыг гүйцэтгэсэн. Малтлагын явцад олон удаа ашиглаж байсан галын ормыг илрүүллээ. Дунджаар 0.8 м голчтой уг галын ором чулуугаар хүрээлэгдсэн байлаа. Чухам ямар давтамжтайгаар энэ газарт гал түлж байсан, мөн уг газарт үнэхээр нүүдэлчид улирлын шинж чанартайгаар буудаллаж байсан эсэхийг шалгахын тулд хэдэн төрлийн дээж авлаа. Үүнд хөрсний найрлага, хөрсний бичил давхарга, хөрсний тослог зэрэг дээжнүүд багтана. Эдгээрийг одоогоор лабораторийн шинжилгээнд явуулахаар бэлдэж байна. Эдгээр дээжнүүд уг дурсгалын он цаг тогтоохоос гадна ямар нэгэн амьтны мах чанаж байсан эсэх, хэд хэдэн гал түлсэн давтамжууд хоорондоо ямар зайтай байсан зэрэг зүйлсийг тогтоох ач холбогдолтой юм. Ингэснээр эртний нүүдэлчдийн ахуйн байдал, ямар үйл ажиллагаа явуулж байсны талаар анхан шатны ойлголттой болно. Энэ нь цаанаа мал аж ахуйн үүсэл гарал, онцлог, өнөөгийн мал аж ахуйн байдалтай төстэй эсэх зэрэг олон асуудлын хариуг өгөх давхар ач холбогдолтой болно.

НИЙСЛЭЛИЙН СХД-ИЙН ЗҮҮН САЛААН ДАХЬ ХҮННҮГИЙН ЖИРИЙН ИРГЭДИЙН БУЛШ ОРШУУЛГЫН ДУРСГАЛЫГ АВРАН ХАМГААЛАХ МАЛТЛАГА СУДАЛГАА

Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, Ч.Ванчигдаш

Судалгааны түүх

2013 оны хавар СХД, Зүүнсалааны гэр хорооллын гудамжинд байх цөөн булшийг санамсаргүй тохиолдлоор анх илрүүлжээ. Энэ үед цас бүрэн ханзраагүй байсан хэдий ч уул дурсгалуудыг машин зам дайран гарч байсан тул булшны чулуун дараасны зарим хэсгүүд танигдахаар байдалтай байв. Үүнээс 2 сарын дараа ШУТИС-ийн НТС-ийн (хуучнаар) Түүх-Соёл судлалын профессорын багийн судлаачид Зүүн салааны Одонтын гудамжны орчимд хайгуул судалгаа гүйцэтгэж, 29 дурсгал байгаа болохыг тоолон бүртгэж, анхны эрдэм шинжилгээний тодорхойлолт үйлдсэн юм. Ихэнх булш гудамны гол хэсэгт байрлах тул машин замд дайрагдаж эвдэгдсэн төдийгүй зарим хэсэг нь айлын хашаанд гэр болон байшингийн сууринд дарагдсан, дээр нь хог шороо асгасан, машин гарах хаалганы довжоо болгон ашигласан, тэр ч бүү хэл айлын бие засах газартай зэрэгцэн байрлаж байлаа. Эдгээр дурсгалуудын зарим нь харьцангуй бүтэн үлдсэн бол дийлэнхи булшны чулуун дараасны 30-90 хувь нь сүйтгэгдсэн байлаа.

Хот суурин газраас олдсон энэхүү Хүннүгийн бүлэг дурсгалыг авран хамгаалах тухай хүсэлт, товч тайлангийн хамтаар ССАЖЯ-ны Соёлын өвийн хэлтэст хүргүүлсэн нь үрдүнгээ өгч нэн даруй угажлыг зохион байгуулах, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдэж өгсөн билээ. Ийнхүү ССАЖЯ-ны дэмжлэгээр тус ажил 2 жил дараалан амжилттай хэрэгжсэн ба энэхүү ажилд Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар хотын музей зэрэг газрууд хамтран ажилласан болно. 2015 оны хувьд ШУТИС-ийн БУХСургууль, Батлан Хамгаалах Яамны харьяа Монгол Цэргийн Музейн хамтын гэрээний хүрээнд хийгдсэн ба Нийслэлийн харьяа байгууллагууд болох нийслэлийн мэргэжлийн хяналт, соёл урлагийн газрууд уг ажлыг дэмжин ажилласан билээ.



Хийгдсэн ажил

Хүннүгийн жирийн иргэдийн булш оршуулгын төрөлд хамаарагдах тэдгээр дурсгалуудыг яаралтай авран хамгаалах ажлын хүрээнд 2013 онд 10 дурсгал (ЗС-14, 15, 16, 17, 18, 19, 21, 22, 23, 24), 2014 онд 10 дурсгал (ЗС-7, 8, 9, 10, 11, 11б, 13, 13а, 23а, 25) малтан судалсан бол 2015 онд 7 дурсгалыг (ЗС-1, 2, 5, 20, 28, 29, 30) авран хамгаалав. Ийнхүү 3 жилийн хугацаанд устах аюул тулгараад байсан нийт 28 дурсгалыг авран хамгаалах ажлыг гүйцэтгээд байна. Үүний дүнд Сонгинохайрхан дүүргийн Одонтын 23, 24-р гудамжинд орших бүх дурсгал хамрагдаж чадсан төдийгүй оршин суугчдад хүндрэл багатайгаар малтаж болох зарим нэгэн айлын хашаанд орсон булшийг ч мөн авран хамгаалж чадлаа.

Дурсгалт газрын байршил зүйн тодорхойлолт: Тус дурсгалт газар нь Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 25-р хорооны нутаг дэвсгэрт Зүүн салаа, Одонтын 23, 24-р гудамж хооронд оршино. Газрын байцын хувьд уулын урд энгэрийн тэгш дэвсэгт харьцангуй бөөн байдалтай байрлах аж. Харин сүүлд илрүүлэн олсон 2 булш нь оршуулгын газраас нэлээд зайдуу, урд уулын ар бэлд байрлаж байлаа. Хуучин нэршлээр Сонгино уулын баруун салаа ам буюу Байшинтын ам хэмээн нэрлэгддэг газар ажээ.

Тус амны эхэнд энэхүү оршуулгын газрын гол хэсэг төвлөрөн байрлах ба ойролцоогоор 500 м орчим зайд тархан байрласан байна. Ихэнхи булш оршуулга машин зам явах хэсэгт байрлах төдийгүй айлын хашааны хаалга, довжоо, хог хаях цэг, хашаа байшингийн доор орсон дарагдсан байдалтай байлаа. Булш 14, 15, 16, 17, 18 бөөн маягтай оршуулгын газрын зүүн хойд хэсэгт байрлалтай. 19, 21-р булш дээрх бүлэг таван булшнаас ялимгүй баруун урд хэсэгт зэрэгцээ байсан бол 22, 23, 24-р булш оршуулгын газрын баруун талд орших ажээ. Гэхдээ эдгээрээс өөр гаднаа таних тэмдэггүй, бүрэн эвдэгдсэн дурсгалууд болон айлын хашаанд орших зарим булш бүртгэгдээгүй үлдсэн байх бүрэн магадлалтай.



2015 оны малтлага судалгаа: 21 хоногийн хугацаанд нийт 7 дурсгал малтан судалсны 4 нь машин замд дайрагдсан байсан бол 3 булш айлын хашаанд байрлаж байв. Айлын хашаанд орших булшийг малтахын тулд хашааны зэрлэг цэвэрлэх, банзан хашааг буулгах, буцаан босгох зэрэг ажлуудаас гадна оршин суугчдын аюулгүй байдлыг хамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай болсон билээ. Зүүн салааны 29-р булшнаас бусад дурсгалуудын чулуун дараас бүрэн эвдэгдсэн тул цөөн хэдэн чулуугаар баримжаа хийж, оршуулгын нүхийг илрүүлэхээс өөр аргагүй байв. Гэхдээ урьд жилүүдэд малтсан ЗС-15, 17, 18, 19, 21, 22-р булшны ерөнхий байдлаас үзвэл Хүннүгийн үеийн жирийн иргэдийн булшны нийтлэг шинж болох цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байсан болох нь тодорхой байна.

Малтлагаар толбо илэрсэн хэдий боловч оршуулгын зан үйл гүйцэтгэсэн гэх шинж тэмдэггүй 3 дурсгал байв. Дээрх дурсгалууд нь бүлэг оршуулгын төвлөрлөөс



нэлээд зайдуу байрлаж байсан ба гадаад зохион байгуулалтын хувьд цагариг хэлбэртэй, Хүннү булштай ижил болно. Оршуулга илэрсэн дурсгалуудад нас барагчийг хойд ба зүүн хойд зүгт хандуулан тэнэгэр байдалтай оршуулсан байх ба банз ба дүнз ашиглан авс хийсэн байлаа. Зүүн салааны 5-р булш нь толгой хэсэгтээ чулуун таг бүхий жижиг хөмөгтэй байсан агаад түүндээ малын яс зэрэг хойлгын эд зүйлсээс гадна дугуй хүрэл эдлэл, бог малын нүхлэсэн шагай зэрэг зүйлсийг байршуулсан байсан нь сонирхолтой зан үйлд тооцогдоно. Эд өлгийн зүйлсийн хувьд уг булшнаас илэрсэн бүтэн вааран сав, даавуунд ороосон хүрэл аяга зэрэг үнэт эд зүйлсээс гадна нумын ясан наалт, төмөр эдлэл, бугын эвэр, бүсний арал зэрэг зүйлс олдсон болно.


Товч үр дүн

Малтан судалсан бүх булш оршуулга эрт үед тоногдож оршуулгын зохион байгуулалт эвдэгдсэн байсан хэдий ч оршуулгын газрын ерөнхий дүр төрхийг сэргээн харах боломжтой байлаа. Дээрх дурсгалт газар нь оршуулгын газрын ерөнхий зохион байгуулалт, гадаад хэлбэр, хэмжээ, оршуулгын нүх болон модон болон чулуун авсны зохион байгуулалт, гүн, оршуулгын зан үйл, олдворын хэлбэр, хэв шинж зэрэг бүхий л талаараа Монгол нутагт өргөн тархсан Хүннүгийн жирийн иргэдийн төрөлд хамаарагдах оршуулгын газар болох нь тодорхой байна.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ, БАЯНГОЛЫН ХӨНДИЙД ХИЙГДСЭН МАЛТЛАГА СУДАЛГАА


Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, Ч.Ванчигдаш

ШУТИС-ийн судлаачид Монгол улсын “Эко-Алт” ХХК-ийн ашиглалтын талбайд өртсөн археологийн дурсгалуудыг авран хамгаалах малтлага судалгааг 2015 оны 05 сарын 26-наас 06 сарын 26 хүртэлх хугацаанд зохион явуулав. Хээрийн шинжилгээний бүрэлдэхүүнд 3 судлаач, 2 туслах судлаач, 12 оюутан оролцон ажиллалаа.



Баянгол нь Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн төвөөс зүүн хойш 27 км зайд орших, зүүнээс баруун тийш сунасан 10 орчим км үргэлжилсэн нарийвтар хөндий юм. Хөндийн эхэн хэсгийг иргэд Улаан Шивэр гэх ба түүний урд аманд МНО ХХК – ийн олборлолтын талбай байрлана. Уг хөндий нь ургамлын бүрхэвч сайтай, зузаан, шимт бор хөрстэй. Хөндийн дунд биеэс нутгийнхны Ходоодны рашаан гэж нэрлэдэг ус сайтай булаг урсаж, Туул голд цутгадаг байсан боловч одоо тасарчээ. Уг хөндийн эх Бор-Толгой гэх газарт “Эко-Алт” ХХК-ийн ашиглалтын талбай оршино. Бид хайгуулаар Бор-Толгой орчмоос 3 хиргисүүр, 2 чулуун байгууламж, Улаан шивэр хэмээх газраас 16 булш бүхий Хүннүгийн жирийн иргэдийн жижиг оршуулгын газрыг илрүүлэн олж, малтан судалсан болно.

Хиргисүүр: Авран хамгаалах судалгааны хүрээнд 3 хиргисүүр малтан судлав. Хоёр хиргисүүр нь ашиглалтын талбайн дотор орших ба биднийг судалгаа хийхээр очиход хиргисүүрийн төв байгууламжийг тойруулан тус уурхайн удирдлага хөрс хуулалтын ажлыг эхлүүлсэн байв. Ингэхдээ Хиргисүүрийн гадна хүрээг хүнд техникээр сэт татсан, хиргисүүр бүхий талбайд өрөмдлөг хийсэн зэрэг зөрчил гаргасан байхаас гадна малтлагын явцад хөрс хуулалтын ажил зэрэг явагдаж байсан нь ажиллах нөхцлийг хүндрүүлж байсан билээ.




Дээрх хиргисүүрүүд нь голдоо дугуй хэлбэрийн овгор чулуун дараастай, гадуураа дөрвөлжин хэлбэрийн чулуун хүрээтэй байв. Дараасны төв дунд баруун хойш чиглэсэн чулуун хашлагатай хэдий ч уг хашлаганаас оршуулга хийгдсэн гэх ул мөр илрээгүй. Гэхдээ бүх оршуулгыг тоногдсон гэж үзэх бүрэн үндэстэй. Хиргисүүрийн зүүн ба зүүн урд хэсэгт цөөн тооны дагуул байгууламжийг хийсэн байх ба түүний заримаас адууны толгой болон шүдний хэсэг илэрч байв. Гадаад хэмжээ дунджаар 11 м.

Хүннү булш. Энэ газарт уугуул оршин суугчид үлдээгүйгээс орчны уул, усны нэрийг тодорхой оноож мэдэхгүй болжээ. Баянголын хөндийн эхэнд байрлах зүүнээс баруун тийш 2 км орчим сунаж тогтсон амыг Улаан Шивэр гэнэ. Уг амны төгсгөлд 16 булш бүхий хүннүгийн жирийн иргэдийн багавтар оршуулгын газар байрлана. Бид хайгуул судалгааны үед уг оршуулгын газарт байрлах булшуудыг зүүн талаас нь эхлүүлэн 1-16 хүртэл дугаарлан бүртгэж авсан болно. Тус оршуулгын газарт байрлах булшны нягтралыг ажиглавал баруун, төв, зүүн гэсэн гурван хэсэгт хувааж болохуйц байв. Баруун хэсэгт, Хүннү 16, 15, 14, 13, төв хэсэгт, 12, 11, 10, 9, 8, 7, 6 зэрэг том хэмжээтэй булш багтах бол оршуулгын газрын зүүн хэсэгт 5, 4, 3, 2, 1 буюу харьцангуй жижиг хэмжээтэй булш байрлана. Гадаад чулуун дараасыг ажиглавал баруун хэсгийн булш хэмжээний хувьд том бөгөөд шигүү хийгдсэн, зүүн болон өмнө хэсгийн булшны чулуун дараас харьцангуй бага,

цөөн чулуутай ажээ.

Малтан судалсан булш бүгд ямар нэг хэмжээгээр тоногдож, оршуулгын зохион байгуулалт эвдэгдсэн хэдий ч оршуулгын газрын бодит дүр төрхийг сэргээн харах боломжтой байлаа. Ерөнхийдөө цагариг хэлбэрийн чулуун дараастай, төв хэсэгтээ яльгүй хонхор зохион байгуулалттай. Оршуулгын газрын хамгийн том булш 10 м (УШ 9, 16 булш) голчтой байсан бол хамгийн жижиг нь 5 м голч бүхий Улаан шивэр 14 болон 5-р булш байлаа.

Булшны гүн 2-4 м хооронд хэлбэлзэх ба хамгийн гүн булш 4.2 м гүнтэй Улаан Шивэрийн 8-р булш байлаа. 2 м гүнтэй 2 булш байсны нэгнээс хүний яс илрээгүй. Гэхдээ оршуулгын бусад зан үйлийг ягштал гүйцэтгэсэн байв. Үүнийг бид төлөөлүүлсэн оршуулга байж магад хэмээн үзэж байна.



Оршуулгын нүхийг харьцангуй том, уужим хийдэг. Нүхний хэмжээ дунджаар 3x1.5 м. Нас барагчийг ихэнх тохиолдолд банзан авсанд хийж, толгойг нь хойд зүгт хандуулан тэнэгэр байдалтай оршуулдаг байжээ. Чулуун хашлаганд хийж оршуулсан ганц тохиолдол илэрсэн. Нийт 11 булшинд хөмөг хийсэн байх оршуулгын толгой хэсэгт хийж, түүндээ хэд хэдэн бог, бод малын толгой, туурай зэргийг, зарим тохиолдолд өөр бусад амьтны толгойн ясыг тавьдаг болох нь ажиглагдаж байлаа. Улаан шивэрийн 5-р булшны хөмөгт 4 ш адууны толгой, 1 үхрийн толгой, 3 ш хонины толгой тавьсан байсан нь хөндөгдөөгүй байдлаар олдсон билээ. Мөн бод малын толгойн доод талд 4 ш туурайн яс байршуулдаг тогтвортой зан үйл хэд хэдэн удаа тэмдэглэгдсэн билээ.

Эд өлгийн хувьд аж ахуй, гоёл чимэглэл, сүсэг бишрэл, дайн тулааны хэмээн ангилж болно. Олдворуудын дийлэнхийг вааран сав суулга, нумын бариул болон гичрийн наалт, төмөр эдлэлүүд эзлэх ба гоёл чимэглэлийн зүйлс ч мөн цөөнгүй тохиолдож байлаа.

Ийнхүү Баянголын хөндийд хийгдсэн авран хамгаалах малтлага судалгаагаар Хүннүгийн жирийн иргэдийн оршуулгын цогцолборыг бүтнээр малтсан явдал нь цаашдын Хүннү гүрний археологийн судалгаанд тэр дундаа тэдний хүн амын доторх энгийн иргэдийн аж байдлыг тодруулахад чухал нэмэр болох юм.

**УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН АРХЕОЛОГИЙН ТЭНХИМИЙН 2015
ОНД ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТАЛБАЙД ЯВУУЛСАН
АВРАН ХАМГААЛАХ СУДАЛГАА**

*Т.Идэрхангай, Э.Мижиддорж, С.Оргилбаяр,
Д.Эрдэнэбаатар, Б.Галбадрах*

Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбайн болон Эрдэнэт-Эг, Сэлэнгийн бэлчир чиглэлийн хатуу хучилттай авто замын трассын дагуу орших дурсгалуудын өмнөх бүртгэлийг шинэчлэн нарийвчилсан хайгуул судалгааны ажлыг 2014 оны хавар мэргэжлийн судалгааны гурван байгууллага хамтран хийсний үндсэн дээр 2014 болон 2015 оны зуны улиралд авран хамгаалах ажлыг мөн мэргэжлийн судалгааны таван байгууллага бүрэн хэмжээгээр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд эдгээр байгууллагуудын нэг нь Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн баг байсан юм.

Ингэснээр тус сургуулийн судалгааны баг 2014 оны зун авто замын трассын дагуу Булган аймгийн Бугат сумын нутаг Ухаа шороот уулын орчимд орших өөрт ноогдсон 9 дурсгалыг, усан цахилгаан станцын талбайд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Хантай баг орчмын буюу Эгийн голын баруун талд Дамиран уулаас Оцонгийн нурууны хоорондох дурсгалуудыг, харин голынхоо зүүн талд Моностойн нуга, Харуулын гозгор уулын орчмын 46 дурсгалыг буюу хүрэл зэвсгийн үеэс түрэгийн үеийн хоорондох үе үеийн түүхэнд хамрах нийт 55 дурсгалыг малтан судлаж тайланг монгол, англи хэлээр бичиж товч мэдээллийг хэвлүүлсэн болно.



Улмаар 2015 оны зун Археологийн тэнхимийн багш, археологич Т.Идэрхангайгаар ахлуулсан Археологийн тэнхимийн багш Э.Мижиддорж, С.Оргилбаяр, Түүхийн тэнхимийн багш Б.Галбадрах, туслах эрдэм шинжилгээний ажилтан 4, Археологи, Түүхийн тэнхимийн оюутан 25, тогооч 2, жолооч 2 нарын болон Археологи, Түүхийн тэнхимийн дадлагын оюутнуудын хамт нийт 50 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг 2015 оны 6-р сарын 3-аас 8-р сарын 1-ний хооронд 60 хоногийн хугацаатайгаар Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбайд ажилласан юм.

Энэ ажлын хүрээнд Эгийн голын баруун талд Эрээн хайлааст хүннүгийн

үеийн дурсгал 12, Булангийн дэвсэгт хүрлийн үеийн тахилын байгууламж 5, Хантай багийн төв орчимд хиргисүүр 2, хүрлийн үеийн тахилын байгууламж 3, дөрвөлжин булш 1, Дамиран уулын бэлд хиргисүүр 5, тахилын байгууламж 4, Неолитын үеийн булш 1, Мөнгөнтайга хэлбэрийн булш 1 зэрэг нийт 34 дурсгалыг, голынхоо зүүн талд Хайлантын голын дэргэд хиргисүүр 3, хүрлийн үеийн тахилын байгууламж 1, Ганга цагаан эрэгт хиргисүүр 4, хүрлийн үеийн дугуй хэлбэрийн булш 2, маанийн үсэгтэй хөшөө чулуу 1, Моностойн нугад хиргисүүр 3, Харуулын гозгорт неолитын үеийн булш 3, он цаг тодорхойгүй булш 1, дөрвөлжин булш 2, Мөнххайрхан хэлбэрийн булш 1, Бурхан толгойд¹ хүннү булш 1, он цаг тодорхойгүй тахилын байгууламж 8 зэрэг нийт 32 дурсгалыг буюу Неолитын үеэс Хүннүгийн үеийн хоорондох түүхэнд хамаарах нийт 66 дурсгалын авран хамгаалах малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нийт малтсан дурсгалыг он цаг болон соёлын онцлогоор нь дараах байдлаар задлан ангилж болохоор байна. Үүнд:

- Неолитын үед хамаарах булш 4
- Хүрлийн үед хамаарах
- Хиргисүүр 17, эдгээрийн нийт 190 дагуул байгууламж
- Дөрвөлжин булш 3
- Мөнгөнтайга хэлбэрийн булш 1
- Мөнххайрхан хэлбэрийн булш 1
- Дугуй хэлбэрийн булш 2
- Тахилын байгууламж 15
- Хүннүгийн үеийн
- Булш 6
- Тахилын байгууламж 9
- Хожуу үеийн маанийн үсэгтэй чулуу 1
- Он цаг тодорхойгүй
- Булш 1
- Тахилын байгууламж 6-г тус тус малтан судалжээ.

Эдгээрээс онц сонирхолтойг нь доор товч өгүүлэв.

Неолитын үеийн булшны талаар. Тус сургуулийн судалгааны баг 2015 оны зун Эгийн голын баруун талд 1, зүүн талд 3, нийт 4 булшийг малтан судлаж өргөн хэмжээний мэдээллийг хуримтлуулсан юм. Энэ нь Монголын түүхэнд сүүлийн 40 гаруй жил илрэн олдоогүй онцлог хэрэглэгдэхүүн байлаа. Булшны гадаад зохион байгуулалтын хувьд газрын хөрсөн дээр 3-4 м голч бүхий цөөн хэдэн чулуун дараастай байв. Харин оршуулгыг үйлдэхдээ газарт жижиг дугуй нүхийг 1 м орчмын гүнтэй ухаж талийгаачийг тавьжээ. Оршуулгын хувьд Марзын хөтлийн 1-055-1 дугаартай булшинд 4 хүнийг хос хосоор нь хоёр тийш харуулан тэнэгэр байдлаар, Харуулын гозгорын 1-116 дугаартай булшинд 1 хүнийг баруун талаар биеийг нь хураасан байдлаар, 1-117 дугаартай булшинд 6 хүнийг нэг нүхэнд суугаа байдлаар хамтад нь, харин 1-117-1 дугаартай булшинд 1 хүнийг зүүн хажуугаар нь атийлган хэвтүүлсэн, нөгөө хүний яс эмх замбараагаа ихэд алдсан бөгөөд гавлын яс нилээд дээд төвшингөөс илрэн олдсон юм. Малтлагын явцад 4 булшнаас нийт 13 хүний яс, зуулга ир бүхий хутганууд, нэхмэлийн ясан зүү, зуулга ирнүүд, сувс олон тоогоор илэрсэн бөгөөд оршуулгуудыг жижиг дугуй нүхэнд үйлдэж дээгүүр нь улаан зос цацсан нь сонирхолтой юм.

Хүрлийн үеийн дурсгалууд. 2015 оны зун тус судалгааны баг хүрлийн үеийн хиргисүүр 17-г малтсан нь нийт 190 тахилын байгууламжтай байлаа.

¹ Энэ нь археологийн нэршилд орсон Бурхан толгой хэмээх Хүннүгийн бүлэг оршуулга бүхий газартай нэр ижил, газрын байршил төстэй боловч өөр газар юм



Эдгээрийн заримаас хүний оршуулга илэрч байсан бөгөөд харин 1-055 дугаартай хиргисүүрээс 2 оруулмал оршуулгын хамт нийт 3 хүний яс илэрсэн нь судалгааны өндөр ач холбогдолтой дурсгал байсан юм. Нийт хиргисүүрийн 10 нь дөрвөлжин, 6 нь дугуй хүрээтэй байсан бол 1 хиргисүүрт хүрээ илэрсэнгүй.



1-037 дугаартай хиргисүүрийн цэвэрлээгээний дараах болон тахилын байгууламжуудыг тодорхой ялган гаргасан байдлаас

Малтлага судалгааны хувьд хиргисүүрийг хэд хэдэн малтлагын аргыг туршин судалгааны ажлыг явууллаа. Тухайлбал зарим хиргисүүрийг бүтэн талбайгаар, заримыг нь голын дараас чулууг хагаслан цэвэрлэх, харин чулуун хайрцаг өнгөн хөрсний дараа бүрэн ялгарч байвал хөндлөн огтлолын хамрын хажуугаар 0.5-2 м-ийн зүсэлт хийн голын чулуун хайрцгийг цэвэрлэн гаргаж байсан болно.

Түүнчлэн бидний малтан судласан Хантай багийн төвийн дэргэд орших 1-037 дугаартай хиргисүүр нь Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбайд орших нийт булш оршуулга, тахил тайлгын дурсгалуудын хувьд хэмжээгээрээ хамгийн том бөгөөд хамгийн олон дагуул тахилын байгууламжтай дурсгал байснаараа онцлог байв. Тухайлбал уг хиргисүүрийн дугуй хүрээний голч 48 м, голын дараасны голч 26 м, өндөр 1.5 м орчим, хиргисүүрийн зүүн, зүүн урд талаар хоёр эгнээ, бусад талаар ганц эгнээ байдлаар зэрэгцүүлэн өрсөн, дунджаар 3-4 м голч бүхий нийт 57 тахилын байгууламжтай бөгөөд 58 дахь тахилын байгууламж нь хүннүгийн жирийн иргэний оршуулга байлаа.

Дөрвөлжин булшны соёлд хамаарах 3 булш малтан судалснаас зарим онцлох хэрэглэгдэхүүн илэрч олдож байв. Тухайлбал Хантай багийн дэргэд, 1-037 дугаартай хиргисүүрийн баруун урд талд орших 1-038-1 дугаартай дөрвөлжин булшны хойд талын хашлага чулууны ёроолоос 2.7 см урттай хүзүүний алтан сондор илэрч олдлоо.

Мөн хүрлийн үеийн тусдаа соёлууд болох Мөнххайрхан болон Мөнгөнтайгын соёлуудад хамаарах тус бүр нэг булш малтан судалснаас Мөнгөнтайгын хэлбэрийн булшнаас ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илрээгүй бол Мөнххайрханы соёлын булшнаас хүний яс, ясан халбага, хүрэл хутга зэрэг олдворууд илэрсэн нь Мөнххайрханы соёлын булшны зүүн хязгаарыг тэлсэн судалгаа боллоо.

Хүннүгийн үеийн дурсгалуудын талаар. 2015 оны зун малтлага судалгаа хийсэн дурсгалууд дунд Эрээн хайлааст нийт Хүннүгийн үед хамаарах 12 дурсгал, Бурхан толгойд 1 булш, 2 тахилын байгууламжийг тус тус малтан судалсан юм. Нийт 6 оршуулга, 9 тахилын байгууламж малтан судалснаас Эрээн хайлаасын нэгэн

булшнаас 3-5 насны хүүхдийн тоногдоогүй оршуулга илэрсэн нь онцлог байв. Булшнуудын ерөнхий зохион байгуулалт болон булшны зүг чиг нийтлэг хүннү булштай ижил байлаа. Мөн булшнуудын ихэнх нь тоногдсон байдалтай байсан тул бидэнд өгөх мэдээлэл нь хомс байсан юм. Эрээн хайлаасын болон Бурхан толгойн хүннү булш нь газрын хөрсөн дээр нарийн мэдэгдэх тодорхой шинж тэмдэггүй, армаг тармаг цөөн хэдэн чулууд мэдэгдэж байсан бөгөөд оршуулгын нүхний хувьд харьцангуй гүехэн байдалтай байв.

Антропологийн хэрэглэгдэхүүний талаар

2015 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг Эгийн голын савд Неолитын үеийн булш оршуулга, хүрлийн үеийн Хиргисүүр, Дөрвөлжин булш, Мөнгөн тайга, Мөнххайрхан соёлын булш, Хүннүгийн жирийн иргэдийн булш гэх мэт нийт 66 булш малтан судласнаас 22 оршуулганаас 33 хүний ясны хэрэглэгдэхүүн илрүүлсэн болно.

Эдгээрийг товч дурдвал:

- Неолитын 4 булшнаас 13 хүний оршуулга илэрсэн (эрэгтэй-7, эмэгтэй-1, хүүхэд-4, хүйс тодорхойлох боломжгүй 1),
- Хиргисүүрээс 7 хүний яс илэрсэн (эрэгтэй-2, эмэгтэй-1, хүүхэд-1, хүйс тодорхойлох боломжгүй 3),
- Дөрвөлжин булшнаас 2 хүний яс (20-30 насны эрэгтэй хүн, оруулмал оршуулга 30-40 настай эмэгтэй)
- Мөнгөнтайгын соёлын булшнаас 1 хүний яс (нас, хүйс тодорхойлох боломжгүй),
- Мөнххайрханы соёлын булшнаас 1 хүний яс (20-30 насны эрэгтэй хүн),
- Хүннү 6 булшнаас 6 хүний яс илэрсэн (эрэгтэй 4, эмэгтэй 1, хүүхэд 1) тус



Харуулын гозгорын 1-117 дугаартай Неолитын үеийн булшны малтахаас өмнөх үеийн ерөнхий байдал



Харуулын гозгорын 1-117 дугаартай Неолитын үеийн булшны оршуулгын ерөнхий байдал

тус илэрсэн болно.

Эдгээр яс нь хадгалалтын хувьд муу байсан хэдий ч цөөн тооны ясанд хэмжилт судалгаа хийж болохуйц байна.

Дээрх хүний ясны олдворууд нь тухайн түүхэн үеийн хүн амын угсаа гарлыг нөхөн сэргээх боломжийг олгох ба ялангуяа Неолитын булшнаас гарсан 13-н эртний хүний ясны хэрэглэгдэхүүн нь Монголын Шинэ чулуун зэвсгийн хүн ам зүйн асуудал, монголчуудын угсаа гарлын асуудлыг тодруулахад чухал хэрэглэгдэхүүн болно.

**МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН “ЭРТНИЙ МОНГОЛЧУУДЫН
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮҮХ” ТӨСЛИЙН 2015 ОНЫ
ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС**

*Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн, Г.Галдан,
П.Алдармөнх, М.Нямхүү, Т.Сасада, И.Үсүки, Н.Сагава*

Тус төслийн хээрийн шинжилгээний анги Төв аймгийн аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Зүүн Байдлагийн голын хөндийд 2015 оны 9-р сарын 1-нээс 7-ны өдрүүдэд амжилттай ажиллаа. Энэ жил төмрийн хүдэр хайлуулах зуух, шавар шатаах зуух, булш оршуулга, бууц суурин, геоморфологи гэсэн нийт 5 хэсэг багт хуваагдан ажиллав.

Төмрийн хүдэр хайлуулах зуухны малтлага судалгаа

Ех.15.01. Өмнөх жил малтлага хийсэн Ех.14.01, Ех.14.02 талбайн баруун талд үргэлжлүүлэн шинээр Ех.15.01 талбайд судалгааны ажлыг хийсэн юм.

Тус талбайн өнгөн хөрсийг авсны дараа 2-р үеэс хойд ханын хэсэгт өндөр халалтаас үүдэн улайссаж шаргалтсан ором илэрсэн. Энэхүү оромын хэлбэр хэмжээ, дотроос нь гарч байгаа хөөрөгний шавар хошууны хэсгүүд, төмрийн хаягдал зэргээс үзвэл 1-р хэлбэрийн зуухны суурь байх магадлалтай байна. Зуухны суурийн ихэнх хэсэг хойд ханын доогуур орсон ажээ.



Зураг 1. Ех.15.01 талбай (Хойд талаас)

Талбайн өмнөд хананаас илэрсэн зуухны хана, хөөрөгний шавар хошуу, төмрийн хаягдал агуулсан нүх илэрсэн нь зуухны хаягдал агуулсан нүх бололтой байна. Энэ жилийн малтлага судалгааны цаг хугацаа давчуу байсан тул ирэх жил үргэлжлүүлэн хийхээр төлөвлөн малтлага судалгааг дуусгав.

Ех.14.01. Өмнөх жилийн малтлага судалгаагаар илэрсэн 6-р төмрийн хүдэр хайлуулах зуух нь малтлагын 5-р үе буюу талбайн өмнөд хэсгийн цагаан хөрсөн үеэс хоорондоо 70 см зайтай зуйван дугуй хэлбэртэй өндөр хэмд халж шатсан ором илэрсэн юм. Өмнөд ханын зүсэлтээс үзвэл 5-р үеийн дээд талын хар шаргал үеэс доошоо ухсан маягтай эхэлсэн ажээ. Уг хоёр зуйван дугуй хэлбэрийн нүхэнд зуухны хана, хөөрөгний шавар хошуу, төмрийн хаягдал зэрэг олдворууд гарч шатаж түлэгдсэн хар шороогоор дүүрсэн байна. Төмрийн хаягдал хэсгүүд

нь өндөр хэмд халж шатсан байгаа нь төмрийн хүдэр хайлуулах зуух хэмээн таамаглан малтлагыг үргэлжлүүлэв.



Зураг 2. *Ех.15.01 талбай (зүүн талаас) Төмрийн хүдэр хайлуулах 6-р зуух, дагуул нүхны хамт*


Өмнө талын хаягдал агуулсан нүх нь анх мэдэгдэх хэлбэр нь дугуй хэлбэртэй боловч гүйцэд малтлага хийсний дараа тэгш өнцөгт хэлбэртэй байсан нь тодорхой болсон ба зуухтай холбоо бүхий олдворууд их хэмжээтэй гарч байгаа нь зуухыг нураах үед гарсан хаягдлыг тус нүхэнд зориудаар хийж байсныг харуулж буй хэмээн үзэж байна. Зуухны суурь нүхний ёроол дахь тунель нь 2 үетэй ба доод үеэс нь хагас шатсан модны нүүрс их гарсан байна. Төгсгөл хэсгийг том чулуугаар тагласан бөгөөд хагас шатсан модны нүүрснээс улбаалан тус хэсгийн халалтын хэм зуухны дээд үеэс харьцангуй бага байсныг тодорхойлж болохоор байна.

Ех.15.01 талбайн хойд хэсэг болон зүүн хэсгээс тус бүр нэг ширхэг зуухны үлдэгдэл, мөн хаягдал агуулсан нүх нэгийг илрүүлсэн ба Ех.15.01 талбайгаас 6-р зуухыг хаягдлын нүхний хамт бүрэн малтаж дуусгав. Судалгаагаар зуухны хана, төмрийн хаягдал, хөөрөгний шавар хошууны хэсгүүд зэрэг олдворууд илэрсэн юм. Тус зуухны ёроолын тунель хэсгийн модны нүүрснээс авсан дээжийг лабораторын нарийвчилсан судалгааг хийлгэхээр Япон улс руу илгээгээд байна.

Хустын булагт хийсэн малтлага судалгааны хөрсний бүтцээс үзвэл II үеэс 1-р хэлбэрийн зуух, III үеийн доод хэсэг болон IV үеийн дээд хэсгээс 2-р хэлбэрийн зуухнууд илэрч байгаа нь илэрхий ажээ. Малтлага судалгаагаар илэрсэн модны нүүрсний C14 он цагийн дээж нь НТӨ I-НТ I зуунд эдгээр зуухнууд хамаарах нь тодорхой болсон нь эдгээр зуухны хэлбэрийн өөрчлөлтийг давхар баталсан нэгэн чухал зүйл хэмээн үзэж болно.

Ваар сав шатаах зуух KBS3-р талбайн малтлага судалгаа

Ваар сав шатаах зуухны малтлага судалгааг энэ жил KBS3-р талбайд шинээр малтлага судалгааг хийхээр төлөвлөн ажиллалаа. Тус талбай нь өмнөх жил малтсан KBS2 талбайгаас баруун хойш 850 метр зайд эргийн налууд байрлана. Талбайн хэмжээ 3 x 0.5 метр эргийн доош налууд судалгааг хийв. Тус талбайн баруун хэсэг өндөр хэмд халж улайссан ба дээврийн нөмрөг ваар, модны нүүрс ирхээр тархсан улаан хөрсөн давхраг зүүн талын хана хүртэл тархасан байна. Бид тус хар хөрсөн давхрагыг бүтэн талбайгаар гаргах үүднээс дахин 3 x 0,5 м



Зураг 3. KBS3 талбайн дэвсгэр зураг



Зураг 4. KBS3 талбайнгаас илэрсэн
ваар савны үлдэгдэл

талбайг зүүн тийш сунгав. Ингэснээр өндөр хэмд халж улайссан ором нь өмнөөс хойш чиглэлтэй болох нь тодорхой болов. Талбайн хойд тал руу улайссан ором үргэлжилж байсан тул талбайг хойш нь 1,5 м дахин сунган талбайг доош үргэлжлүүлэн малтсан. Малтагаар ахуйн хэрэглээний ваар савны үлдэгдлүүд болон дээврийн нөмрөг ваарны үлдэгдлүүд их хэмжээтэй гарч байлаа. Мөн дутуу шатсаж хатуурсан шаварны үлдэгдэл гарч байсан нь тус газарт үйлдвэрлэл явуулж байсныг илтгэх баримт хэмээн үзэж болохоор байна. Судалгаагаар илэрсэн эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан үзвэл тус газарт барилгын болон ахуйн зориулалтанд ашиглах ваар савыг шатааж байсан зуухны үлдэгдэл байх боломжтой хэмээн урьдчилан таамаглаж байна. Энэ жилийн малтлага судалгааны хугацаа давчуу байсны улмаас талбайг бүрэн гүйцэд малтаж дуусгаагүй бөгөөд ирэх жил судалгааг нийт талбайгаар дуусгаахаар төлөвлөсөн болно.

Бууц суурингийн судалгаа

2011 оноос эхлэн төслийн судлаачид тухайн бүс нутагт археологийн нарийвчилсан хайгуулыг гүйцэтгэж олон тооны дурсгалыг бүртгэн баримтжуулсаар ирсэн билээ. Хайгуулын үр дүнгийн дийлэнхи хувийг олон цаг үед хамаарагдах чулуун байгууламжит дурсгалууд эзлэж байгаа бол тэдгээр дурсгалыг үлдээгч нийгмийн бүлгүүдийн амьдарч сууж байсан бууц суурингийн дурсгал тун цөөн тоотой тэмдэглэгдсэн юм. Ялангуяа Хустын булагийн төмөр болон шавар үйлдвэрлэлийн газрын оршин суугчдын амьдралын хэв маягийг тодорхойлох ул мөр гэх зүйл олддоогүй хэвээр байна. Иймээс энэ жил судалгааны багийнхан газрын хөрсөн дээрх түүвэр олдворыг цуглуулахаас гадна тодорхой зарим газруудад сорилтын малтлага хийсэн билээ.

Тогос уулын баруун бэлд Хустын булагийн төмөр хайлуулах зуухны зүүн хойд талд хоёр газарт сорилтын малтлагыг гүйцэтгэв. Тус сорилтын малтлагын 1-р үед 17x12 м хэмжээтэй талбай сонгон авч 1 м² хуваан дугаарлав. Тухайлбал, уртрагын дагуу англи цагаан толгойн дарааллаар “A-R” хүртэл, өргөргийн дагуу араб үсгийн дарааллаар “0-12” дугаарласан ба тухайн талбайн 1 м бүрт “auger”-р (өрмөөр) 221 цэгт хөрсний шалгалт хийн, гарсан шороог 100 % шигшсэн болно. Хөрсний шалгалтын хүрээнд 15 цэгээс яс, шавар савны хэсэг, төмрийн баас зэрэг цөөн тооны олдвор хэрэглэгдэхүүн илэрсэн.

Харин 2-р үед харьцангуй их олдвор гарсан хоёр хэсэгт бага хэмжээний

сорилын малтлагыг хийв. Эдгээр талбай нь өмнө сонгосон 17х12 хэмжээтэй талбайн зүүн болон баруун талуудад байсан ба баруун талд 2 м2 (AB, AD), зүүн талд 2 м2 (OB, QB) талбай сонгон малтав.

AB талбайг доош 12 см гүн малтахад шавар савны 3 ш хагархай, 4 ширхэг төмрийн баас илэрсэн бол, харин AD талбайн 16 см гүнээс модны нүүрс болон төмрийн баас 2 ширхэг илэрснээс өөр ямар нэгэн зүйл илэрсэнгүй.



*Сорилын малтлага хийсэн газрын
ерөнхий байдал*



*2-р үеийн сорилын малтлагын
бэлтгэл ажил*

Ерөнхий талбайн зүүн хэсэгт байх OB талбайд 16 см гүн малтахад нийт 13 ширхэг төмрийн баас илэрснээс өөр эд өлгийн зүйлс болон хөрсний ялгарал, хүний үйл ажиллагаанд хөндөгдсөн ул мөр илэрсэнгүй. Мөн QB талбайг 15 см гүн малтахад 3 ширхэг шавар савны хагархай, 2 ширхэг төмрийн баасны жижиг хэсэг илэрснээс өөр зүйлс илрээгүйд дахин дээрх талбайнуудыг доош 35 см гүн болтол малтахад ямар нэгэн хүний үйл ажиллагааны ул мөр болон эд өлгийн зүйлс илрээгүй учир сорилын малтлагыг зогсоосон юм.

Геоморфологийн судалгаа

Хустын булаг орчмын нутаг дэвсгэр нь Хэнтийн мужийн Хэнтийн баруун, Хэнтийн зүүн дэд мужид оршино. Судалгаа явуулсан нутгийг геоморфологийн хэв шинжийн хувьд 3 ангиллаа. Үүнд:

- Тектоник-элэгдлийн хэв шинжит хотгор гүдгэр
- Элэгдэл-хуримтлалын хэв шинжит хотгор гүдгэр
- Хуримтлалын хэв шинжит хотгор гүдгэр

Үндсэн 3 хэв шинж нь дотроо 10 дэд хэв шинжийн хотгор гүдгэр болон хуваагдана.

Геоморфологийн хэв шинжийн тархалтын авч үзэхэд уулт-атираат өргөгдлийн тектоник-элэгдлийн гаралтай хотгор гүдгэр – 851 км²; тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулс дотоодын хотгор дахь элэгдэл-хуримтлалын гаралтай хотгор гүдгэр – 111 км²; тэгширмэл газар, уулс хоорондын ба уулс дотоодын хотгор, голын хөндий дэх хурмал хурдаст хотгор гүдгэр 29 км² талбайг эзэлнэ.

Энэхүү хэв шинжийн хотгор гүдгэр нь Хэрлэн голын баруун болон зүүн талаар тархжээ. Хэрлэн голын баруун гарын цутгал голууд болох Баруун Байдлаг, Дунд Байдлаг, Зүүн Байдлаг голын дунд орших Баруун Залаа (1709.8 м), Хулхын нуруу, Байцын нуруу, Хушийн Улаан даваа, Баруун Бүрхийн голын баруун, зүүн тал болон Мөнгөнморьт сумын хойд хэсгийн уулс багтана. Эндэхийн үнэмлэхүй өндөр нь 1500-2000 метр бөгөөд Хэнтийн гол нурууг бодвол намхан, баруун хойноос зүүн урагшаа чиглэн тогтжээ. Харин Хэрлэн голын зүүн талд 1600-1800 үнэмлэхүй өндөртэй Ламын өвөлжөө нуруу, Суварга Булгийн өндөр нуруу, тэдгээрийн



салбар уулс зүүн хойноос баруун урагш чиглэн тогтжээ. Энэ хэв шинжийн уулсын хойд хажуу нь ойтой, эртний мөсдлийн үйлчлэлээр уулсын орой нь бөмбөгөрдүү, хавтгай хэлбэртэй ба мөсдлийн гаралтай жижиг нуурууд тархжээ.

Булшны малтлага судалгаа

Төслийн булшны малтлагын баг энэ жил Тогос уулын баруун хажууд байрлах нэгэн булшийг сонгон малтлага судалгаа хийсэн. Уг булш нь хүний нүд, хөлөөс зайдуу нууцлагдмал газарт байрлах бөгөөд гадаад чулуун дараасын хэлбэрээр Монголын үед холбогдох дурсгалуудтай төстэй байв. 1 м орчим гүнд нүхний төв хэсгээс хүний гавлын ясны үлдэгдэл, мөн мөчний ясны үлдэгдэл илэрсэн бөгөөд ихэд хөндөгдөж сүйтгэгдсэн тул ясны анхны тавилтыг мэдэх боломжгүй болжээ. Түүнчлэн булшны нүх ч тодорхой мэдэгдэхгүй байсаар 1.2 м гүнд байгалийн хөрсөнд тулсан тул малтлагыг зогсоосон. Энэ булшнаас дурдсан хүний ясны үлдэгдлээс өөр олдвор эд өлгийн зүйл гараагүй бөгөөд оршуулгын нүх ч тодорхой мэдэгдээгүй тул он цагийг таамаглах боломж үгүй байв. Илэрсэн хүний ясыг нас тогтоолгохоор лабораторийн шинжилгээнд илгээсэн юм.

МОНГОЛ-ФРАНЦЫН ХАМТАРСАН “ТАМИР” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС

*Д.Батсүх, Б.Эрдэнэ, Г.Энхбаяр,
Ц.Төрбат, С.Дюшен, Д.Николаева*

Монгол-Францын хамтарсан “Тамир” төсөл 2013 оноос хэрэгжиж байгаа билээ. Тус төслийн Францын талын хамтрагч нь Тулузийн их сургуулийн профессор Э.Крюбезын удирддаг Антропобиологийн төв болно. Монголын талаас доктор Ц.Төрбат удирдан ажиллаж байна. Төслийн зорилго нь хүннүүдийн угсаа гарлыг археологи, антропологи, палеогенетикийн үүднээс судлаж тодруулахад оршино.

Тус төслийн хүрээнд 2013-2015 оны хооронд Тамирын Улаан хошууны оршуулгын газарт 31 булш малтан судлаад байна. Үүнээс 10 булшийг нь 2015 оны 6-7-р сард малтан судлав.

Тамирын Улаан хошууны оршуулгын газар нь Монгол нутагт байх Хүннүгийн хамгийн том оршуулгын газруудын нэг бөгөөд нийгмийн дунд зиндааныхан, жижиг язгууртнуудын оршуулга булшнуудтай. 2015 онд бидний малтсан 25-р булш нь 19 м голчтой чулуун дараасны доор 5,5 м гүнтэй, 25 м² талбайтай булшны нүхтэй байжээ. Мөн 2014 онд малтсан 13-р булш дээрхэд дөхөж очих хэмжээтэй бөгөөд 5,0 м гүнтэй, 20 м² талбайг эзэлсэн булшны нүхтэй байжээ.


Хэдийгээр Тамирын Улаан хошууны булшнууд ихэвчлэн дугуй болон цагирган хэлбэрийн дараастай боловч зарим булшнуудад жижиг хэмжээний үүдэвч ажиглагддаг нь Хүннүгийн том язгууртны үүдэвчтэй булшнуудыг дуурайн дагасан зүйл бололтой.

2015 оны малтлагаас нийт 207 ширхэг эд өлгийн зүйлс гарсны зэрэгцээ сайн хадгалалттай хүн, малын яс илэрчээ. Эд зүйлсийн дотор импортын гаралтай улаан шаргал өнгийн шавар сав, бүсний алтан арал, төмөр ба хүрэл эдлэлүүдийг онцлон дурдаж болно. Мөн холбоотой хос шавар ваар хоёр ширхэг, хоёр төрлийн арцны ширмэн бойпор нь урьд өмнө олдож байгаагүй ховор нандин олдворууд юм. Ерөнхийдөө энэ жилийн малтлагаас гарсан олдворуудын дотроос шавар сав суулгыг онцлон үзэх шаардлагатай. Учир нь өмнөх жилүүдийн малтлагатай зүйрлэхгүй их хэмжээний бөгөөд олон төрөл зүйлийн, түүний дотор шинэ төрлийн шавар эдлэлүүд олон тоотой гарсан билээ.

Шавар сав суулгууд. 2015 оны малтлагаас нийтдээ 51 шавар савны зүйл гарсны дотор 8 бүтэн, 22 сэргээн засварлаж босгосон ваар, 21 сэргээн засварлах боломжгүй шавар савны жижиг хэлтэрхийнүүд бий. Эдгээрийн дотор Хүннүгийн хэв шинж шавар савнууд байхын зэрэгцээ хэлбэр төрх, үүрэг зориулалт, гарал үүслийн хувьд онцлог, цоо шинэ шавар савнууд цөөнгүй илрэв. Зориулалтын үүднээс ангилбал: шингэн зүйл хадгалах сав 32 ш, вааран тогоо 13 ш, өвөрмөц хийцтэй бөгөөд тусгай зориулалттай шавар эдлэл 6 ш байна.

Тухайлбал, 25-р булшны том хэмжээтэй, шингэн зүйл хадгалах хар өнгийн шавар савыг юуны өмнө дурдах нь зүйтэй. Энэ ваарны хэлбэр нь хэв шинжит боловч хээ чимэглэл нь урьд өмнө тохиолдож байгаагүй өвөрмөц болно. Энэ нь нийт гадаргыг битүү бүрхсэн хэвтээ зурвас үүсгэсэн тууш зураасууд бөгөөд зурвас бүр нь сөөлжлөн гялгар ба бүрсгэр өнгийг үүсгэсэн байна.

Мөн 25-р булшнаас гарсан том хэмжээтэй задгай амсартай, цорготой ваар урьд өмнө илэрч байгаагүй онцгой өвөрмөц шавар эдлэл болно. Савны амсар хэсгээс гаргасан задгай цорго ба түүний доохон мөрний орчимд гаргасан гурван хэсэг бариул зэрэг нь уг ваарны шинж төрхийг тодорхойлно.



28-р булшны дараас
чулууны орто-зураг



28-р булшнаас илэрсэн импортын
шавар сав ба хүннү ваарнууд

Мөн 25-р булшнаас гарсан том хэмжээтэй задгай амсартай, цорготой ваар урьд өмнө илэрч байгаагүй онцгой өвөрмөц шавар эдлэл болно. Савны амсар хэсгээс гаргасан задгай цорго ба түүний доохон мөрний орчимд гаргасан гурван хэсэг бариул зэрэг нь уг ваарны шинж төрхийг тодорхойлно.

27-р булшнаас гарсан намхан, давхар ханатай дэнгийн цөгц харьцангуй цөөн гардаг олдворын нэг билээ. Уг шавар цөгцний дотор талын хэсэгт удаан хугацаанд дэн барьж байсны ул мөр хар толбо, хөө ис сайн хадгалагджээ.

28-р булшнаас гарсан улаан өнгийн шавар сав урьд өмнө Хүннүгийн дурсгалуудаас илэрч байгаагүй олдвор юм. Энэхүү ваарны амсар хажуу бөөрөндөө байгаа нь уг эдлэлийн үүрэг зориулалтыг хянан нягтлахад хүргэж байна. Ваарны шавар маш нарийн, хийц өндөр түвшинтэй, хэлбэр онцгой өвөрмөц зэргээс үзэхэд уг эдлэл Хүннүгийн зүйл биш харин гадаад орноос импортолж ирсэн зүйл болох нь илэрхий байна. Нэлээд өргөн хүрээтэй эрэл хийж байж үүнтэй ижилсэх ваар Узбекистанаас илрүүлсэн болно.



24-р булшнаас илэрсэн Сасанидын
мөнгөн зоос (НТ 488-531 он)

28-р булшнаас гарсан холбоотой ихэр ваар урьд өмнө илэрч байгаагүй хосгүй эдлэл мөн юм. Хүннүгийн хэв шинжит шингэн зүйл агуулах хоёр ваарыг мөрний орчимд хоолойгоор холбоод, хүзүүний орчимд нуман бариулаар давхар холбож

бэхэлсэн байна. Мөн 29-р булшнаас үүнтэй ижилсэх ихэр ваарны өрөөсөн нь олдсон билээ. Уг ваарны мөрний орчимд нөгөөхтэй нь холбож байсан нүх ба ором хадгалагдан үлдсэн төдийгүй хүзүүний орчимд холбож байсан нуман бариул бүтнээрээ хадгалагджээ. Харин ихрийн өрөөсөн нь алга болсон нь харамсалтай. Уг ваарны нуман бариул дээр хайнгадуу үйлдсэн хүний нүүрний дүрс байгаа юм. Ингэхдээ хүний нүд ба амыг хонхойлгон хийгээд чих ба нүүрийн тигийг сараачин гаргаж, харин хамрыг товойлгон дүрсэлжээ.

Мөн 28-р булшнаас гарсан нэгэн шингэн зүйл агуулах ваарны мөрний орчим “ширээтэй сэрээн тамга” гэж нэрлэж болох дүрсийг нэлээд тод сийлэн гаргажээ. Ийм дүрс Хүннүгийн вааран эдлэл болон ерөнхийдөө археологийн дурсгалуудаас илэрч байгаагүй болно. Мөн уг ваарны хүзүү хэвийн бус өндөр байх бөгөөд багалзуурын орчим нь нарийн товгор бүслүүртэй байгаа нь 2013 онд малтсан 2-р булшнаас гарсан өндөр хүзүүтэй хар ваарыг санагдуулам юм.

Эцэст нь, 29-р булшнаас гарсан өөр нэг өвөрмөц шавар сав бол богино цорготой эгц хавчиг амтай гүц юм. Мөрний орчим гурван хэсэг товойлгон гаргасан бариултай болно. Ийм эдлэл урьд өмнө Хүннүгийн дурсгалаас хараахан илэрч байсангүй.

Сувснууд. 2015 оны малтлагаас олон төрлийн материалаар хийсэн сувсны баялаг цуглуулга илрэв. Нийт 7 булшнаас 88 ширхэг сувс байхаас хамгийн олон тоотой нь 29-р булшнаас 58 ш шилэн ба тугалган сувс гарчээ. Эдгээр сувснууд хув, шил, чулуу, хар тугалга, органик зэрэг олон төрлийн материалаар хийгдсэн байна. Тэдгээрийн дотор хар тугалган сувс 28-р булш (5 ш) ба 29-р булшнаас (45 ш) гарсан нь тооны хувьд хамгийн олон юм. Үүний дараа мөнгө гүйлгэсэн шилэн сувс 12 ш, алт гүйлгэсэн шилэн сувс 6 ш, органик сувс 8 ш тус тус бий. Хуван сувс 3 ш, явуу 2 ш тус тус байгаагаас гадна нүдтэй хөх шилэн сувс зэрэг нь ганц ширхэгээр илэрсэн юм.

30С-р булшнаас илэрсэн органик сувснууд онцгой анхаарал татаж байна. Үүнийг малын хорголоор хийсэн байх үндэслэл бий. Ямар боловч органик гаралтай зүйл гэдгийн ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнд хийлгэсэн шинжилгээ гэрчилж өгнө.

Сасанидын мөнгөн дирхам зоос. 2015 оны малтлагын нэгэн сонирхолтой олдвор бол 24-р булшны малтлагын явцад тонуулчийн нүхнээс илэрсэн Эртний Ираны Сасанид улсын 1-р Кавад хааны (НТ 488-531 он) үеийн мөнгөн зоос юм. Хэдийгээр уг зоос тухайн булшийг анх байгуулах үед хамаарахгүй боловч археологийн хувьд хэрэглэгдэхүүн багатай Монголын Жужан буюу Нирун улсын үед холбогдохын хувьд анхаарал татаж байна.

НОЁН УУЛЫН ХҮННҮГИЙН ДУРСГАЛЫН ДАГУУЛ БУЛШНЫ МАЛТЛАГА СУДАЛГАА

Н.Эрдэнэ-Очир, Г.Одмагнай

Төв аймгийн Борнуур, Батсүмбэр, Сэлэнгэ аймгийн Мандал сумдын нутгийг дамнан орших нуруулдан үргэлжилсэн сүрлэг том модтой уулыг эрт үеэс нутгийн ардууд Ноён уул хэмээн хүндэтгэн нэрлэж иржээ. Энэхүү хөвч хангайд тэртээх 2000 гаруй жилийн өмнө оршин тогтнож, цэцэглэн мандаж асан бидний өвөг Хүннү гүрний язгууртан ихэс дээдсийн онгон дагшин дурсгал оршин байдаг билээ.

1901 онд Хятад, Орос тэргүүтэй “Монголор” хэмээх олон улсын нийгэмлэг Манж хаанаас Сэлэнгийн сав нутагт алт олборлох зөвшөөрөл авч анх Монгол нутагт алт олборлож эхэлсэн түүхтэй. 1912 онд “Монголор”-ын уурхайн техникч Е.Баллод гэгч Ноён ууланд алтны судал хайж яваад Хүннүгийн язгууртны булшийг анх малтаж, улмаар 1924-1925 онд Оросын аялагч П.К.Козлов Ноён ууланд хэд хэдэн язгууртны булш малтан судлаж ховор нандин олдворууд илрүүлсэн н XX зууны дэлхийн их нээлтийн нэгд тооцогдох болсон юм.

Үүний дараа 1925 онд Ленинградын Эрмитаж музейн судлаач С.А.Теплоухов, Г.И.Боровка нар, 1926-1927 онд А.Д.Симуков, 1954-1955, 1961-1964 онуудад ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Доржсүрэн, Д.Наваан нар Унгарын археологич И.Эрделийн хамт малтлага судалгааны ажлыг тус тус хийсэн байдаг. Дээрх судалгааны явцад илэрсэн олдвор хэрэглэгдэхүүний цөөн хэсэг Монголын Үндэсний Түүхийн Музейд, ихэнх нь ОХУ-ын Ленинградын Эрмитажид хадгалагдаж байна.



Ийнхүү 1964 оноос хойш өнөөг хүртэл 50-иад жилийн хугацаанд Ноён уулын Хүннүгийн дурсгалд судалгаа огт хийгдээгүй бөгөөд тус бүс нутагт ажилласан археологичдын судалгаагаар Хужирт, Зурамт, Сүжигтийн аманд хүннүгийн язгууртны болон жирийн иргэдийн нийт 200 гаруй булш буй нь тогтоогдсон байдаг.

2005 оноос Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, Угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран «Монгол

нутаг дахь Ноён уулын булшны археологийн судалгаа» эрдэм шинжилгээний төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тус төслийн хүрээнд 2006, 2009, 2011, 2012 онуудад Ноён уулын Сүжигтийн аманд хүннүгийн язгууртны 20, 31, 11, 22-р булшыг шинжлэх ухааны өнөөгийн төвшинд малтан судлаж, олон чухал олдвор хэрэглэгдэхүүнийг нээн илрүүлж, сэргээн засварлан, судалгааны эргэлтэнд оруулаад байна.

2015 онд дээрх төслийн хээрийн шинжилгээний анги Ноён уулын Зурамтын аманд орших хүннүгийн язгууртны булшны хэд хэдэн дагуул булшинд малтлага судалгааны ажлыг гүйцэтгэсэн юм. Зурамтын амны зүүн дээд эхэнд нилээд өндөрлөг газарт, бусдаас сондгой нэгэн язгууртны булш орших бөгөөд үүнийг 1924 онд С.А.Кондратьев (П.К.Козловын ангийн бүрэлдэхүүн) цооног нүхний тусламжтай малтжээ. Улмаар энэхүү булшнаас баруун өмнө зүгт Зурамтын амны баруун дээд эхэнд гол руу орсон эрэг бүхий тэгш дэвсгэрт 11 язгууртны булш орших бөгөөд тэдгээрийн хамгийн дээд талын булшийг 1912 онд “Монголор” нийгэмлэгийн техникч Е.Баллод, бас өөр хоёр булшийг Андреев (П.К.Козловын ангийн бүрэлдэхүүн), А.Д.Симуков нар тус тус малтан судалсан байдаг. Баллодын малтсан язгууртны булш нь газрын өнгөн хөрсөн дээр өмнө зүгт хандсан урт үүдэвчтэй, дөрвөлжин чулуун хүрээтэй бөгөөд түүний зүүн талд хойноос урагш цуварсан 6 дагуул булш, баруун талд мөн хойноос урагш цуварсан 9 дагуул булштай байна. Эдгээр нь эрт үед тонуулчдын гарт сүйдсэнийг гэрчлэх тогоо хэлбэрийн хонхор нүхтэй, түүнээс гарсан шороон овоолготой юм.

Бид энэ удаад энэхүү язгууртны булшны баруун (9 дагуул булш) болон зүүн талаар (6 дагуул булш) орших дагуул булшнаас сонгон бүрэн хэмжээгээр малтан, хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын дагуул булшны гадаад, дотоод зохион байгуулалт болон олдвор эд өлгийн зүйлсийг нарийвчлан судлах зорилго тавин ажиллав.

Малтлага судалгааны ажил 5-р сарын 06-28-нд үргэлжилсэн бөгөөд судалгааны үр дүнд Ноён уулын Зурамтын аманд далайн төвшинөөс дээш 1414 метрийн өндөрт, N 48° 33' 06.0", E 106° 31' 44.7"-т орших, урд зүгт хандсан 15 м урт үүдэвчтэй, 30х23 м дөрвөлжин чулуун хашлага бүхий хүннүгийн язгууртны булшны зүүн талд орших 6 дагуулын 2, 3-р булшийг (дагуул булшийг хойноос урагш дугаарласан бөгөөд зүүн талын 1-р дагуулыг 2007 онд малтан судалсан), баруун талд орших 9 дагуулын 9-р булшийг бүрэн хэмжээгээр тус тус малтан судлаж, сонирхолтой олдвор хэрэглэгдэхүүнийг нээн илрүүлсэн юм. Эдгээрээс хамгийн сонирхол татахуйц 9-р дагуул булшны малтлагыг товч танилцуулья.

Баруун талын 9-р дагуул булшны малтлага

Энэхүү дагуул булш нь язгууртны булшны баруун талд 25 м зайд, 20° налууд модон дотор, хойноос урагш цуварсан нийт 9 дагуул булшны хамгийн урд талд оршино. Энэхүү булш нь газрын хөрсөн дээр ямар нэгэн чулуун байгууламж байхгүй бөгөөд тонуулчдын ул мөр болох хонхор нүхтэй байв. Бид анхны байдлаар баримтжуулж, уртрагийн дагуу хөндлөн хамар үлдээн малтлага ажлыг эхлүүлэв. Өнгөн хөрсийг цэвэрлэхэд 300 см х 150 см хэмжээтэй, жижиг чулуурхаг цайвар өнгийн хөрстэй булшны нүх илэрсэн бөгөөд малтлагын явцад 220 см гүнд булшны хойд хананд дараас чулууны хэсгүүд илэрч мэдэгдэв. Цэвэрлэх явцад тонуулчид булшны толгой болон төв хэсгээр цөмрөн орсон нь тодорхой болсон бөгөөд тонуулчдын нүхнээс ваарны хагархай хэсгүүд, хүний дунд чөмөгний яс, төмөр болон лakan эдлэлийн хэсгүүд илэрч байв. Булшны зүүн хананы дээд хэсэгт саарал өнгийн шавар ваарны хэсэг илэрсэн бөгөөд оршуулганд 3 ширхэг ваар дагалдуулж тавьсан болох нь тонолтын явцад хагарч бутарсан ваарны хагархай



үлдэгдэлээс мэдэгдэж байлаа. Булшны хөл хэсэгт анхны байрлалаа хадгалан үлдсэн цөөн хэдэн дараас чулуу илэрсэн юм. Бид баримтжуулалт үйлдэн дараас чулуу болон олдвор хэрэглэгдэхүүнийг авч малтлагыг цааш үргэлжлүүлэхэд өнгөн хөрснөөс 310 см гүнд байгалийн чулуун үе гарч, түүнийг ухаж авс хийсэн өвөрмөц бүтэцтэй оршуулгын байгууламж илэрсэн юм.



Энэхүү байгалийн чулуун үе нь 300 см х 150 см хэмжээтэй оршуулгын нүхний бүх талбайг хамрах бөгөөд чулуун үеийг хүннүүд 20 см гүн доош нямбайлан зүсэж, 235 см х 85 см хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэртэй хайрцаг гарган, чулуун хайрцагны гадна хойд талд нь 60 см, баруун талд 35 см, өмнө талд 20 см, зүүн талд 30 см өргөн чулуун тавцан гарган, улмаар баруун болон зүүн хананы дагуу тус бүр хоёр, нийт 4 ширхэг 30 см голчтой, 5-8 см гүн тэгш дугуй хэлбэрийн нүхнүүдийг ижил зайд нямбайлан ухаж хийсэн нь малтлагын явцад тодорхой болсон юм.

Чулуун хайрцагны дотор малтлагыг үргэлжлүүлэхэд өнгөн хөрснөөс 330 см гүнд буюу шалны төвшинд хар саарал өнгийн органик эдлэл (хивсний хэсэг), хүний шилбэ, хөлийн яс анхны байрлалаараа илэрч, чулуун хайрцагны дотор талын 4 буланд төмөр тоногтой модон эдлэлийн булан хэсгүүд, хөлний хэсэгт бүсний төмөр арал тус тус илэрч мэдэгдэв. Энэ бүгдээс үзэхэд оршуулгыг анх үйлдэхдээ чулуун хайрцагны шаланд битүү хивс дэвсэж, хүнээ толгойг нь хойд зүг хандуулан дээш харуулж тэнэгэр байдлаар тавьж, эд өлгийн зүйлсийг дагалдуулан, улмаар чулуун хайрцагны дотор талд 4 буланд төмөр тоногтой жижиг модон багана хийж, магадгүй түүний дээр дээвэр, хаалт үйлдэн (ширээ маягийн), 4 талд орших дугуй нүхэнд идээ ундаа бүхий ваар сав эсвэл дэн гэрэл байрлуулан тодорхой зан үйлийг гүйцэтгэсэн мэт сэтгэгдэл төрж байв. Улмаар авсны дээд төвшинд чулуун дараас тавьж, шороогоор булж газрын өнгөн хөрсөн дээр чулуун байгууламж үйлдсэн бөгөөд энэ бүгд нь тонуулчдын гарт ихэд сүйдэн

эвдэрч, доош сууж хонхор үүсэн, ус байнга тогтон олдвор эд өлөг, органик гаралтай зүйлс удаан хадгалагдах боломжгүй нөхцөл байдлыг бий болгосон нь тодорхой болсон юм. Ийнхүү 330 см гүнд малтлагыг зогсоон, бүх талын баримтжуулалт үйлдэж, булшны нүхийг буцаан дарав.

Товч дүгнэлт

Тус төслийн 2015 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүнд Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Ноён уулын Зурамтын аманд хүннүгийн язгууртны булшны 3 дагуул булшийг бүрэн хэмжээгээр малтан судаллаа. Ноён уулын хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын цогц судалгаанд дагуул булшны малтлага судалгаа хангалтгүй төвшинд байсан бөгөөд энэ удаад хэд хэдэн жижиг булшны малтлага судалгааг гүйцэтгэсэн нь шинжлэх ухааны чухал ач холбогдолтой болсныг тэмдэглэх нь зүйтэй.



Малтлага судалгааны үр дүнд дагуул булшны гадаад болон дотоод зохион байгуулалтыг тодруулсан бөгөөд дундажаар 200 см х 350 см хэмжээтэй тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэрийн оршуулгын нүхийг 330 см - 350 см хүртэл гүн ухаж банзан авс болон байгалийн чулуун авсанд хүнээ хойд зүгт хандуулан, тэнэгэр байдлаар оршуулж, адуу малын яс, эд өлгийн зүйлсийг дагалдуулан, улмаар түүний дээгүүр битүү чулуун дараас хийж, шороогоор булшны нүхийг дүүргэн, газрын өнгөн хөрсөн дээр чулуун байгууламж байгуулж томоохон язгууртны булшны баруун болон зүүн талаар гинжин цуваагаар байрлуулан дагалдуулан оршуулдаг байсан нь судалгааны үр дүнд тодорхой болсон юм.

Малтлагын үр дүнд илэрсэн эд өлгийн зүйлсийг дотор нь морины тоног хэрэгсэл, зэв зэвсгийн зүйлс, ваар сав, чулуун болон металл эдлэлийн үлдэгдэлүүд хэмээн ерөнхийлөн ангилж болох бөгөөд энэ удаад нийт 40 гаруй хүннү гүрний нийгмийн амьдралыг нэхэн судлахад түлхэц болохуйц эд өлгийн зүйлс, олдвор хэрэглэгдэхүүнийг илрүүлэн олсон билээ. Хээрийн судалгааны явцад илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнийг сэргээн засварлан, нарийвчлан судлаж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах бөгөөд эдгээр эд өлгийн зүйлс нь Хүннү гүрний цэцэглэлтийн үеийн нүүдэлчдийн ахуй амьдрал, зан үйл, эдийн болон оюуны соёлыг нэхэн судлахад чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

АЙРАГИЙН ГОЗГОРТ ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

Ц.Одбаатар, С.Энхболд, Г.Бүрэнтөгс

Монголын Үндэсний Музейн судлаачид Орхон аймгийн ЗДТГ, Боловсрол, соёлын газар, Орхон аймгийн музейтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, тус аймгийн нутаг дахь эртний түүх, соёлын өвийн судалгааг хамтран хийж байна. Бид Орхон аймгийн Жаргалант сумын нутаг Айрагийн гозгор хэмээх газарт орших эртний оршуулгын дурсгалыг 2014 оноос малтан судалж эхэлсэн юм. Нарийвчилсан хайгуулын явцад тус оршуулгын газарт 97 булшийг бүртгэсэн байна. Айрагийн гозгорт буй дурсгалууд нь үндсэн хоёр хэлбэртэй. Үүнд:

- Үүдэвч бүхий дөрвөлжин чулуун өрлөгтэй овгор булшууд
- Цагирган хэлбэрийн дараас чулуутай жижиг булшууд

Бид 2015 оны 8 сарын 1-нээс 9 сарын 20 хүртэл нийт 7 дурсгал малтан судалснаас 2 [АГ9, АГ11] нь зүүн талдаа үүдэвчтэй, дөрвөлжин хэлбэрийн чулуун өрлөгтэй, 5 [АГ95, АГ51, АГ81, АГ67, АГ44] нь цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байлаа. Малтлагаар 3 хөмөгт оршуулга илэрсэн нь АГ11, АГ9, АГ44-р булшууд болно. Тэдгээрээс АГ11, АГ9 нь үүдэвч бүхий дөрвөлжин чулуун өрлөгтэй том булшууд, АГ44 нь цагираг хэлбэрийн чулуун дараастай жижиг булш юм. Хөмөгт булшийг үйлдсэн арга барил нь хоёр хэлбэртэй. Тэдгээр хөмөгт булшны 2 [АГ9, АГ11] нь үүдэвчний дагуу чигт хөмөгтэй, харин АГ44-р булшны хөмгийг их биеийн хажуу талаас хөндийлөн үйлдсэн байна. Хөмгийн амыг хавтгай чулуугаар даруулж хаасан байжээ [зураг 3].



*Зураг 1. Айрагийн гозгорын
оршуулгын газар*

Айрагийн гозгорын оршуулгаас илэрсэн тэдгээр хөмөгт булшууд Монгол улсад судалсан ойролцоо цаг үеийн булшны малтлагаар тэр бүр илрэхгүй байгаа нь тус оршуулгын газрын өвөрмөц онцлог, гол ялгагдах шинж тэмдэг болж байна.

Айрагийн гозгорын үүдэвч бүхий дөрвөлжин чулуун хашлагатай дурсгалуудын гадуур ус зайлуулах суваг татсан байдаг. Бидний малтсан АГ9, АГ11-р булшны гадуур мөн ус зайлуулах суваг үйлдсэн байв.



Зураг 2. АГ11-р булшны
үүдэвчний малтлага

АГ11-р булшны үүдэвч нь тэгш налуу хэлбэртэй, малтлагаар тэрэгний эвдэрхий модон эд анги хэд хэд гарснаас үзвэл гуяа, олон хигээс бүхий бул зэрэг зүйл байсан нь тодорхой мэдэгдэж байлаа.


2015 онд бидний малтан судалсан бүхий л булшууд эрт цагт тоногдож, оршуулгын зан үйлийг тодруулахад хүндрэлтэй болсон байв. Булш бүрийн голд их бага хэмжээний хонхор байгаа нь эрт үед толгой дараалан тоносоныг илтгэхээс гадна их хэмжээний үнэт эд өлгийн зүйл дагалдуулсан байх бололцоотойг харуулдаг. Бидний төсөөллөөр нас барсан хүнийг тэнэгэр байдлаар, гэдрэг харуулан, толгойгоор нь голдуу баруун, баруун хойт зүгт хандуулан тавьжээ.

Айрагийн гозгорын хөмөгт оршуулгад дагалдуулсан эд өлгийн зүйлс харьцангуй сайн хадгалагдсан байдаг. Оршуулгаас гарсан зарим банзан авсны хийц, хэлбэрийг тодорхойлох бүрэн бололцоотой төдийгүй заримынх нь торгон доторлогоо хадгалагдан үлджээ. Зарим булшны авсыг үйлдэхдээ ёроол хийлгүй, дөрвөн банз зангидаад, нас барсан хүнийхээ доор цайвар шаргал шороог тусгайлан дэлдэж дэвссэн байв. Илэрч олдсон олдворуудыг үзвэл судлаачдын Хүннүгийн үед холбогдуулан үздэг булш оршуулгаас гардаг зүйлтэй үндсэндээ адил. Тухайлбал, нумын ясан гичир, шавар ваар, үсний ясан шор, үйсэн сав суулга, шилэн сувс, сумын төмөр зэв, хазаарын амгай зэрэг нь онцын ялгагдах зүйлгүй байна.

Антропологич Кристине Ли Айрагийн гозгорт малтан судалсан 7 булшнаас гарсан 5 бодгалийг судалж тэдгээрээс 3 [АГ95, АГ81, АГ51.1] гавлын ясны хэмжилт



болоод нүүрний хэв шинжээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны нутагт судалсан Сяньби булшны эх хэрэглэгдэхүүтэй таарч байна хэмээн дүгнэсэн байна. Тэрчлэн эрчүүд нь биеийн хөгжил сайтай булчинлаг, морь унадаг, явган алхдаг, нум харваж байсан шинж тэмдэг тодорхой илэрсэн байна. Харин эмэгтэйчүүд нь биеийн хүчний ажил бага хийдэг, оёх хатгах үйл хийдэг байсан байж болзошгүй хэмээн дүгнэжээ.



Зураг 3. AG44-р булшны
хөмөөт оршуулга

Айрагийн гозгорт малтан судалсан булшны оршуулгын байгууламж, зан үйл, гарсан олдвор хэрэглэгдэхүүнээр нь харьцуулан үзвэл ӨМӨЗО-ны нутагт малтан шинжилсэн Сяньби нарын оршуулгатай төстэй байгаа нь ажиглагдаж байна. Судалгааны ажил үргэлжилж байгаа бөгөөд дурсгалын харьцангуй он цагийг тогтоох, палеогенетикийн шинжилгээ хийлгэхээр ажиллаж байна.

**МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН “СОЁЛЫН ӨВИЙГ СУДАЛЖ,
ХАМГААЛАХ” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН**

*Н.Батболд, Б.Өмирбек, Л.Эрдэнэбат,
Бён Ён Хуан, Вүэ Мен Хуан*

Төслийн тухай

Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран “Соёлын өвийг судалж хамгаалах” эрдэм шинжилгээний төслийг 2009 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд 2009-2013 онд Говь-Алтай аймгийн Чандмань, Бигэр, Халиун, Баян-Уул, Төгрөг, Бугат, Тонхил, Дарви, Есөнбулаг, Эрдэнэ, Цогт, Алтай, Шарга, Цээл, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Дэлгэр зэрэг сумдын



*2015 онд үзэж танилцсан дурсгалт
газруудын байршил*

нутгаар археологийн хайгуул судалгааг явуулж тухайн бүс нутагт буй археологийн дурсгалуудыг илрүүлэн бүртгэж баримтжуулах ажил хийсэн.

2014 онд Монгол-Солонгосын хамтарсан төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутаг Зүрх ууланд буй хүрэл зэвсгийн болон хүннүгийн үед холбогдох оршуулгын дурсгалт газар археологийн малтлага судалгаа, мөн Алтай, Жаргалан сумдын нутагт археологийн хайгуул судалгааг үргэлжлүүлэн хийсэн болно.

Археологийн хайгуул судалгааны явцад Говь-Алтай аймгийн 18 сумын нутгаас нийт 5000 орчим дурсгал илрүүлэн бүртгэж улмаар “Монголын соёлын өвийн судалгаа” 5 боть цуврал тайлан, “Говь-Алтай аймгийн Жаргалан сумын археологийн дурсгалууд” товхимлыг хэвлүүлээд байна.

2015 оны археологийн судалгаа

Тус төслийн хээрийн шинжилгээний анги 2015 оны 06-р сарын 02-ноос 06-р сарын 22-ныг дуустал хугацаанд Баян-Өлгий аймгийн Сагсай, Цэнгэл, Улаанхус,



Ногооннуур сумдын нутгийн зарим газруудад буй түрүү төмрийн үед холбогдох дурсгалуудыг археологийн хээрийн шинжилгээний энгийн, хялбаршуулсан хайгуул судалгааны арга зүйг ашиглан бүртгэн баримтжууллаа.



Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум,
Загастайн голын пазырык булш



Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум,
Шивээт хайрханы пазырык булш

Төмөр зэвсгийн түрүү үед Евразийн тал нутагт эртний нүүдэлчдийн бие биетэйгээ адил төстэй олон соёл оршин байсан билээ. Эдгээрийн нэг нь пазырыкийн соёл юм. Баян-Өлгий аймгийн нутаг дахь түрүү төмрийн үед холбогдох түүх соёлын дурсгалуудыг анх 2004 онд Монгол-Францын хамтарсан “Евразиа” төслийн археологийн хээрийн шинжилгээний анги илрүүлж улмаар нэлээд тооны булш малтан судалсны үр дүнд Баян-Өлгий аймгийн нутагт пазырыкийн соёлын дурсгалууд байгаа болохыг баттай нотолж, ингэснээрээ Монголын түүхийг нэгэн хуудсаар баяжуулж чадсан юм. Монгол, Орос, Казакстан, Хятадын Алтай нь эрт үеэс угсаа соёлын нэгдмэл бүс нутаг байсан нь тодорхой бөгөөд пазырыкийн соёлын тархалт, он цаг, соёлын ба угсаатны онцлог зэрэг асуудлуудыг тодруулан судлахад Монгол улсын нутаг дахь пазырыкийн булшны хэрэглэгдэхүүн зайлшгүй дутагдаж буй юм. Мөн түүнчлэн сүүлийн үеийн дэлхий нийтийг хамарсан их дулаарлаас болж Алтайн нурууны мөнх цэвдэг бүхий булшнууд тун удахгүй бүрэн үгүй болно гэдгийг Оросын судлаачид удаа дараа анхааруулж байгаа билээ¹. Иймээс Монгол Алтайд пазырыкийн үеийн дурсгалуудыг малтан судалж түрүү төмрийн үеийн эртний нүүдэлчдийн түүхэнд холбогдох баримт хэрэглэгдэхүүн бүрдүүлэх шаардлагатай байгаа учраас Монгол-Солонгосын хамтарсан тус хээрийн шинжилгээний анги Баян-Өлгий аймгийн нутаг дахь Монгол Алтайн нурууны өндөрлөг бүсэд орших түрүү төмрийн үед холбогдох пазырык булштай оршуулгын газруудыг үзэж танилцах, улмаар дараа жил малтлага судалгаа хийх оршуулгын дурсгалт газрыг сонгох зорилготой ажилласан болно.

Судалгааны ажлын үр дүн

Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж, хамгаалах” төслийн хээрийн шинжилгээний анги дээр дурдсан үндэслэл, зорилгын хүрээнд ажиллаж Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Харганатын гол – 1, Цагаан асгат - 42, Хар чулуутын гол - 6, Халагаш – 4, Улаанхус сумын Чулуут булаг – 11, Сүм дайрахын уул – 12, Их Ойгорын голын хойд дэнж – 5, Есөн нуурын Үнхэлцэг – 3, Усай буюу Олон гүүрийн гол – 5, Цагаан салаагийн ам – 2, Бага ойгор гол – 1, Шар булгийн ам – 4, Хар ус – 3, Цэнгэл сумын Сүм дайрахын гол – 9, Хулбайн арал – 7, Бага

¹ Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, П.Х.Жискар. Монгол Алтайн археологийн дурсгалууд – I. Баян-Өлгий аймаг. Улаанбаатар, 2009. Тал 78.

Түргэний гол – 20, Сыргал – 3, Билүүт – 2, Хүйтэний гол – 10, Цагаан ус – 7, Цагаан усны ам – 5, Арал толгой – 2, Хотон нуурын баруун эрэг – 17, Загастайн гол – 14, Шар дэвсэг – 7, Их хатуу – 6, Цагаан голын урд дэнж – 11, Шивээт хайрхан – 9, Цагаан голын эх – 24, нийт 242 пазырык булшны гэрэл зургийг авч газарзүйн солбицлыг тогтоон бүртгэн баримтжуулсан.Эдгээрийг нэгтгэн хүснэгтээр доор үзүүлэв.

*Баян-Өлгий аймгийн зарим сумдын
нутаг дахь пазырык булшны тоо*

№	Сум	Газрын нэр	Булшны тоо
1		Харганатын гол	1
2	Сагсай	Цагаан асгат	42
3		Хар чулуутын гол	6
4		Халагаш	4
5		Чулуут булаг	11
6		Сүм дайрахын уул	12
7		Их Ойгорын голын хойд дэнж	5
8	Улаанхус	Бага ойгор гол	1
9		Шар булгийн ам	4
10		Хар ус	3
11		Сүм дайрахын гол	9
12		Хулбайн арал	7
13		Бага Түргэний гол	20
14		Сыргал	3
15		Билүүт	2
16		Хүйтэний гол	10
17		Цагаан ус	7
18	Цэнгэл	Цагаан усны ам	5
19		Арал толгой	2
20		Хотон нуурын баруун эрэг	17
21		Загастайн гол	14
22		Шар дэвсэг	7
23		Их хатуу	6
24		Цагаан голын урд дэнж	11
25		Шивээт хайрхан	9
26		Цагаан голын эх	24
	Нийт		242

Тус төслийн хээрийн шинжилгээний ангийнхан археологийн хайгуул судалгааны үр дүнг хэлэлцэн Шивээт хайрхан уулаас урагш Цагаан голын урд дэнжид 3 болон 7-гоор бүлэглэн хоёр хэсэг газар байрлах пазырык булш бүхий газрыг сонгож 2016 онд малтан шинжлэхээр тогтсон болно.

МОНГОЛ, БНХАУ-ЫН ХАМТАРСАН АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН 2015 ОНЫ ТОВЧ ҮР ДҮН

А.Очир, Б.Анхбаяр, Х.Цэрэнбямба

Танилцуулга

Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны сайдын А/ 181 тоот тушаалын дагуу Археологийн эрдэм шинжилгээний хайгуул малтлага судалгааны ажил хийх зөвшөөрөлөөр, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Соёлын өв, Археологийн хүрээлэнтэй хамтарсан хээрийн шинжилгээний анги 2015 оны 6 сарын 29-нөөс 9-р сарын 10-нд хооронд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт Булгийн толгой, Архангай аймгийн Өгийнуур сумын Хэрмийн хөндийд Талын гурван хэрэм хэмээх дурсгалд археологийн малтлага судалгаа хийлээ. Хээрийн шинжилгээний ангид Монголын талаас судлаач А.Очир, Б. Анхбаяр, Х.Цэрэнбямба, Хятадын талаас судлаач Чен Ёнжи, Саранбилэг, Дандар, Чэн Пэн фэй нар болон 2 тогооч, 1 жолооч, 14 туслах ажилтан оролцов.

Булгийн толгойн дурсгалд хийсэн судалгаа

Дурсгалын байдал: Булган аймгийн Бүрэгхангай, Хишиг-Өндөр сумдын зааг Бүрэгийн нурууны ард, Шувуутынгол зүүн эрэгт Булгийн толгой хэмээх жижиг овоотой толгойн ард шороо овоолон үйлдсэн нэгэн дурсгал бий. Шороон овгорын зүүн талд залгуулан мөн шороо овоолж хийсэн гүвгэр байгууламжтай. Шороон овгорын дээр хэдэн тонуулын цооног мэдэгддэг. Шороон овгороос холгүй 2 томоохон ухмал бий.

Малтлага: Булгийн толгойн дурсгал бол гадаад зохион байгуулалтын хувьд Заамарын Шороон бумбагар, Улаан хэрмийн бунхант булштай туйлын төстэй харагддаг. Булгийн толгойн дурсгалын “бунхны үүдэвч” хэмээн таамагласан шороон гүвгэр дээрх малтлагын үр дүнд бунханы үүдэвч биш харин тухайн үеийн өнгөн хөрсөн дээр, холгүй орших ухмалаас шороо зөөн авчирч баруунаас зүүнш чиглүүлэн зориуд асгаж хатууруулсан дээгүүрээ хавтгай, хоёр хажуугаар налуу зохион байгуулалттай урт гонзгой байгууламж болох нь мэдэгдэв. Тэрхүү урт шороон байгууламж нь баруун талын шороон барилгад нийлэх хэсгээрээ зузаан, өргөн бол зүүншлэх тусам намхан, нарийн болж байгалийн хөрсний төвшинд хүрдэг.

Дурсгалаас үүдэвч мэдэгдээгүй тул том шороон овгорт малтлагыг үргэлжлүүлэв. Шороон овгор баруунаас зүүн зүг гонзгой зуувин хэлбэртэй, 24 х 21 м орчим хэмжээтэй, 3 м орчим өндөр. Шороон овгорын талбай өнгөн хөрсийг хуулах явцад байгууламжийн орой дээрээс дунд зэргийн хэмжээтэй 10 гаруй хавтгай чулуу олдсон нь баганын суурь аж. Хавтгай чулууг авчирч шороон овгор дээр барьсан барилгын нурууны модон баганы суурь болгожээ. Мөн шороон овгорын дээгүүр дөрвөлжин хэлбэртэй, тойруулсан түүхий тоосгон өрлөг байсныг тогтоолоо. Түүхий тоосгуудыг зузаан талаар нь хавиргалан босгож, өөд өөдөөс нь угтуулан давхарлаж өржээ. Шороон овгор дээр тоосгон хана, модон баганатай барилга байсныг тогтоосны дараа шороон овгорын бүтэц, зохион байгуулалтыг тодруулахаар зорьсон юм. Шороон овгорыг бүтнээр нь малтахад цаг хугацаа, хүч их шаардлагатай байгааг харгалзан босоо болон хэвтээ тэнхлэгийн дагуу сорилын суваг малтав.



*Булгийн толгойн дурсгал
(өмнө талаас)*



Малтлагын явц

Шороон овгорын бүтцээс харахад 17,5 x 17,5 м хэмжээтэй дөрвөлжин суурьтай, түүний дээр 2 м орчим өндөр, 10 x 10 м хэмжээтэй тэгш хавтгай тавцан засчээ. Шороон овоолгыг зориуд чулууг нь ялгасан шороог авчирч сууриаас нь эхлэн бага багаар давхарлан асгаж босгожээ. Малтлагын байдлаас харахад, шороон овгорын дээрх хавтгай талбай дээр модон баганаар тулсан нуруу бүхий модон дээвэртэй, түүхий тоосгон өрлөгтэй, намхавтар дөрвөлжин хэлбэртэй хана бүхий барилга байжээ хэмээн сэргээж болохоор байна. Өндөр шороон тавцан дээр модон дээвэр баганатай барилгын зүүн талаас зориуд шороо овоолсон замаар



Зуухны малтлагын явц

дамжин зугуухан өгсөж барилгад хүрдэг бололтой.

Малтлага 2: Шороон байгууламжийг судлах явцад өмнө талын ухмалын (U2) дунд хэсэгт буйулаан өнгийн тоосгоны хэлтэрхий ихтэй, цагираг мэт хэлбэртэй, голдоо хонхор тогоо мэт зүйл байгааг мэдэж, тэр орчимд малтлага явуулав. Малтлагын дунд уг байгууламж нь газар ухаж үйлдсэн, тоосго шатаах зориулалттай зуух болохыг тогтоолоо. Хэлбэрийн хувьд зуувин дугуй, 1 амтай, 2 яндантай аж. Зуухны ханын өрлөг 30 - 170 см зузаан. Зүүн тийшээ газрын уруу тул гулгаж хазайхаас сэргийлж зузаалсан бололтой. Одоо мэдэгдэж байгаа зуухны



өрлөгийн өндөр 150-170 см, дотор талын цэвэр хэмжээ баруунаас зүүн тийш 390 см, өмнөөс хойш 340 см байв. Зуухны дотор үүдний орчимд их хэмжээний шатсан мод, модны нүүрс, үнсний хог хуралдсан байв. Зуухыг байгалийн хөрсийг дугуйлж ухаад, тэр хэлбэртээ захируулан түүхий тоосго олон үе өрж босгосон байна. Харин тоосгуудыг өөр хооронд нь цайвар шаргал өнгийн шавраар нааж барьцалдуулжээ. Тоосгоны дотор хэсэг шатаж улаан өнгөтэй болсон бол гадна тал түүхий шавар хэвээр аж. Зуухны зүүн талд буюу газрын уналт их хэсэгт тоосгоор арк мэт хэлбэртэй өрсөн үүдтэй. Үүдний эсрэг талд буюу баруун талд хоорондоо зайтай хос яндан байжээ. Шатсан улаан тоосгоны хэмжээ нь дунджаар 38 см урт, 28 см өргөн, 7 см зузаан бөгөөд, 2-3 төрлийн хэв ашигласан нь мэдэгддэг. Тоосгууд дээр гарын хээ болон бусад өвөрмөц тэмдэгтүүд бий.

Зууханд шатааж бэлтгэсэн тоосгыг чухам юунд ашигласныг одоогоор шууд хэлэх бололцоогүй байна. Шороон овгорыг малтаж байгалийн хөрсөнд хүргэхэд шатаасан тоосгууд хэрэглэсэн нь огт мэдэгдсэнгүй. Ийм тоосгыг Булгийн толгойн дурсгалтай гадаад зохион байгуулалттай төстэй бусад бунхант оршуулгад түгээмэл хэрэглэдэг.

Тоосгыг ашиглаж болох өөр нэг боломж бол тэндээс холгүй хот суурин, эсвэл нууцлаг оршуулгын дурсгал байж болох юм. Гэвч энэ нь таамаг төдийгөөс хэтрээгүй бөгөөд нарийвчилсан судалгаа шаардлагатай байна. Зуух барьж, ухмал авсан эргээс наалдах чанар сайтай шаварлаг хөрсийг олборлож, ойролцоох булгийн усаар зууран хэвлээд, Бүрэгийн нуруунаас мод авч галлаж байсан бололтой. Өөрөөр хэлбэл, тоосго хийх, шатаах үйлдвэрлэл эндээ явагдаж байсан нь тодорхой юм. Тоосго шатаах зуух олдсон явдал нь нүүдэлчдийн дунд барилгын олон төрөл материалыг өөрсдөө боловсруулах гар үйлдвэрлэл хөгжиж, хот суурин, тахилын онгон, бунхант оршуулгад хэрэглэж байсныг батлах баримт болсноороо энэ удаагийн судалгааны нэг амжилт болов. Булгийн толгойн дурсгалын холбогдох он цагийн талаарх судалгаа хийгдэж байгаа тул тусгайлан



Булшны малтлагын явц



Булшнаас илэрсэн хазаарын төмөр амгай, ясан зуузай

эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэхдээ дэлгэрүүлэн танилцуулах болно.

Малтлага судалгаа 3: Шороон овгор дурсгалын орчимд зураглал хийх явцад баруун хойш 600 м орчим зайд, 4 м голч бүхүй дугуй хэлбэртэй, дунд зэргийн хэмжээтэй чулуун дараастай нэгэн булш байгааг илрүүлж, шороон овгор дурсгалтай холбоотой байж болох юм хэмээн таамаглаж малтлав. Чулуун дараасыг цэвэрлэж баримтжуулаад зайлуулахад 160 см гүнд баруун хойш 280 хэмд толгойгоор нь чиглүүлэн хоньчилж хэвтүүлсэн бүтэн адуу гарлаа. Адууны аманд ясан зуузайтай төмөр амгай, буруу талын хаа орчмоос төмөр дөрөө 1 ш илэрсэн бол зөв талын дөрөөлөх орчмоос оломны 1 ш ясан арал, хондлой орчмоос 4 хуваагдаж бяцарсан төмөр эдлэл тус бүр олдлоо. Мөн адууны толгойн дэргэдээс үзүүрээр нь баруун хойш чиглүүлэн тавьсан төмөр жадны гилбэр, түүний чигтээ

модон иштэй байсныг гэрчлэх үлдэгдэлийн хамт адууны хойд мөчний хажуугаас төмөр булцуу маягын эдлэл илрэв. Эндээс жадны ерөнхий байдлыг сэргээвэл; төмөр гилбэртэй, урт модон иштэй, түүнийхээ хойд үзүүрт төмөр булцуутай морин жад байсныг багцаалж болохоор байна. Мөн адууны хүзүүний ясны дунд бог малын сээрний 4 залгаатай үе гарлаа. Хүн оршуулдагтай ойролцоо хэлбэр хэмжээ бүхүй нүх ухаж бүтэн адууг зарим тоног хэрэгсэлийн хамт хийгээд, эзнийх нь хэрэглэдэг зэр зэвсгийн хамт оршуулсан явдал нь нүүдэлчийн түүхэнд үзэгддэг сонирхолтой хэрэглэгдэхүүн юм.

Талын гурван хэрмийн судалгаа

Хамтарсан шинжилгээний анги өнгөрсөн жил Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт буй Талын хэрэмийн Баруун хэрэмд археологийн малтлага явуулсан билээ. Харин энэ жил Баруун хэрмийн голын байгууламжийг үргэлжүүлэн малтаж,



Малтлагын явц



Сорилын малтлагын явц

бүтэц зохион байгуулалтыг тодруулах зорилго тавьж ажиллаа.

Малтлага. Хэрмийн дотор байгаа шороон овгоруудын дотор хамгийн том байгууламж бол 1-р буюу Голын байгууламж юм. Хэмжээ нь 45 x 32 м, өндөр 3 м юм. Баруунаас зүүн тийш сунасан ялимггүй гонзгой зуувин хэлбэртэй. Овгорын орой дээр 180 см орчим голчтой чулуун дараастай, дугуй хэлбэртэй булш мэт байгууламж мэдэгддэг.

Бид малтлагын талбайг голын овгор шороон байгууламжийн төвд буй 0 цэгийг дайруулан, хэвтээ тэнхлэгийн дагуу зүүн тийш 20 м (10А, 10В), баруун тийш 26 м урт (10С, 10D, 10Е), 2 мөргөн сорилын тиг татаж, 10 м бүрт хуваагаад 50 см өргөн зүсэлтийн далан үлдээж малтав. Малтлагын үр дүнд улаан шороог зориуд зөөн авчирч асган дагтаршуулсан, овгорыг босгоод гадуур нь 1,6-1,7 м босоо ханатай, голдоо 3,2 м өндөр, 32 x 19 м хэмжээтэй байгууламж байсан нь тодорхой боллоо.

Талын гурван хэрмийг урьдах эрдэмтэд хот суурины үлдэц хэмээн үзэж байсан ч бидний малтлага судалгаагаар хотын үлцэц биш болох нь тодорхой болов. Харин ямар зориулалттай байгууламжууд болох нь дараагийн судалгаагаар тогтоогдох болов уу.

“МОНГОЛ АЛТАЙН ТҮРҮҮ БА ТҮҮХЭН ҮЕИЙН ОРШИН СУУГЧДЫН ЦОГЦ СУДАЛГАА” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЧ ҮР ДҮН

Ц.Төрбат, Н.Баярхүү, С.Лелец, В.Бернард

Монгол-Францын хамтарсан экспедиц нь “Монгол Алтайн түрүү ба түүхэн үеийн оршин суугчдын цогц судалгаа” төслийн хүрээнд 2014 оноос Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт малтлага судалгааны ажлыг хийж байгаа билээ. 2014 онд тус сумын нутаг, Их Хатуугийн голд ажилласан бол 2015 онд мөн сумын Бургастын гол болон Увс аймгийн Сагил сумын нутаг, Сагилын голын хөндийд тус тус ажиллав.

Бидний малтлага судалгаа хийсэн эхний дурсгалт газар нь Бургастын голын аманд, сумын төвөөс баруун хойш 40 орчим км-т голын урсгалаар зүүн талын өндөр дэнж дээр оршино. Уг дурсгалт газарт Түрэгийн үеийн тахилын онгон, хавтгай дараастай булш, овгор дараастай булш байхын зэрэгцээ эдгээрээс холгүй Хүрлийн үеийн хиргисүүр, хөшөө чулуу гэх мэт түүхийн нэлээд олон цаг үеийг хамарсан цогцолбор дурсгал бий.

Бид дээрх цогцолбор дурсгалын баруун хэсэгт орших Түрэгийн үед холбогдох зэрэгцээ байрласан 4 тахилын онгон, түүний баруун талд зэрэгцээ байдлаар орших 7 булш, нэг байгууламж, эдгээрээс зүүн хойш 500 орчим метрт орших бас нэг байгууламжийг тус тус малтан судлав (Зураг 1). Малтан судалсан булшнууд анх өнгөн хөрсөн дээр 4-5 булш байгаа мэт харагдаж байсан боловч өнгөн хөрсний цэвэрлэгээгээр хөрсөнд дарагдаж мэдэгдэхгүй болсон зарим дурсгалууд нэмж илэрснээр нийт 7 булш байгаа нь тодорхой болов.

Булшнууд нь гадаад хэлбэрийн хувьд дараасны бусад чулуунаас том хэмжээтэй чулуугаар дөрөө мэт хэлбэртэй хүрээ үүсгэж уг хүрээний дотор талд ямар нэг дараас чигжээсгүй, харин хүрээ чулууны гадна талаар жижиг чулуугаар хийсэн дараас болон жижиг хайрган чулуугаар хаяаг нь манасан байдаг байна (Зураг 2).

Одоогоор бидний малтан судалсан булшнуудтай гадаад зохион байгуулалтаар ижил эсвэл адил төстэй булш малтан судалсан тохиолдол манай оронд харьцангуй цөөн, бараг үгүй гэж хэлж болохоор байгаа бөгөөд урьдчилсан байдлаар он цаг нь Сяньбийн үед холбогдох бололтой байна. Малтлагаар булш тус бүрээс хүний оршуулга (бүрэн болон бүрэн бус) оршуулгыг ерөнхийдөө уртрагийн дагууд буюу зүүн эсвэл баруун зүгт хандуулж нуруугаар тэнэгэр байдалтай оршуулдаг байсан бололтой. Ойролцоогоор 1.5-1.8 метр хүртэл гүнд чулуу болон модоор хийсэн авсанд оршуулдаг байжээ.

Дагалдуулсан эд өлгийн зүйлсийн хувьд торго даавуун эдлэлийн өөдөс, түүн дээр оёж тогтоосон мөнгөн чимэглэл олонх булшнаас цөөн тоотой гарч байгаа нь гоёл чимэглэл бүхий хувцас өмсгөлтэй нь оршуулдаг байсан бололтой. Мөн хүзүүний шавар зүүлтийн ширхгүүд цөөн хэд, нэг ширхэг хүрэл гархин ээмгээс өөр металл эд зүйлс илрээгүйгээс харахад оршуулгад металл эд зүйлсийг төдий л их дагалдуулдаггүй байсан бололтой.

Нийт долоон булшны дөрөв нь чулуун австай, гурав нь модон австай байсан бөгөөд модон авсны модноос болон булш тус бүрийн хүний яснаас он цаг тогтоох дээж авч Франц Улсын Үндэсний Байгалийн Түүхийн Музейн болон Ренний Их Сургуулийн лабораториудад нарийн шинжилгээ хийлгэхээр илгээгээд байна. Тиймээс лабораторийн нарийн шинжилгээний дүн гарснаар бид тухайн дурсгалууд чухам хэдий үед холбогдохыг нарийн тодорхой тогтоох боломж бүрдэх юм.

Түрэгийн үеийн 4 тахилын онгоны тухайд урагш-хойш чиглэлд цувраа байдалтай орших 3, тэдгээрийн хойд талд бага зэрэг зайтай сондгой орших нэг

тахилын онгон байв (Зураг 3). Уг тахилын онгонуудад малтлага судалгаа хийж үзэхэд хоёр тахилын онгоны дөрвөлжин хашлагын яг төв хэсэгт модон шон буюу “сэргэ”-ийн үлдэгдэл, хоёр тахилын онгоноос модон сэргэ байсны ором, нүх илэрсэн нь нэлээд сонирхолтой бөгөөд дээрх хоёр тахилын онгоны модноос дээж авч нарийвчилсан он цагийг тогтоох, түүнчлэн нэг цаг үед бүтээгдсэн үү эсвэл харилцан адилгүй цаг үед бүтээгдсэн үү гэдгийг тогтоох зорилготой ажиллаж байна. Мөн хойд хэсэгт орших сондгой тахилын онгоноос өрөөсөн төмөр дөрөө гарсан нь урьдчилсан байдлаар түрүү түрэгийн үед холбогдох магадлалтай байна.

Бидний судалсан дараагийн дурсгал бол (№8) дээрх цувраа 7 булшны баруун урд талд буй дугуй хэлбэрийн нэлээд овгор дараастай байгууламж юм. Малтлагыг эхлүүлж өнгөн хөрсний цэвэрлэгээг хийх явцад дараас чулууны завсраас зарим нэг бод малын ясны хугархай илэрч эхэлсэн ба улмаар уг дурсгалын төв хэсэгт адууны яс илэрч бүрэн цэвэрлэж гаргахад дан ганц морины оршуулга болох нь тодорхой болов (Зураг 4). Оломны ганц ширхэг төмөр арлаас өөр тодорхой дагалдуулсан эд өлгийн зүйлс үгүй тул зөвхөн үүнд тулгуурлан харьцангуй он цаг тогтоох боломжгүй юм. Тиймээс уг морины яснаас дээж авч он цаг тогтоохоор ажиллаж байна.


Мөн эдгээрээс гадна энэ орчимд гадаад зохион байгуулалтын хувьд өвөрмөц нэгэн байгууламжийг сонгон авч судлав (Зураг 5). Өнгөн хөрсөн дээрх байгууламжийг ажиглахад эрт цагт тоногдсон шинжтэй, гадаад зохион байгуулалт урд хэсгээрээ эвдэрсэн байсан боловч бид бүрэн судалж он цагийг тогтоох зорилготой байсан юм. Харамсалтай нь малтлагын явцад ямар нэг зүйл илрээгүй боловч хүний гараар хөндөгдсөн хөрс болон байгалийн эх хөрс холилдсон байдалтай гарсаар малтлагын гүн 1,8 метр хүрч цааш байгалийн эх хөрсөнд хүрсэн тул малтлагыг зогсоож зохих нөхөн сэргээлтийг хийсэн болно.

Эдгээрээс гадна энэ жил бид малтлага судалгаа хийхийн хажуугаар тухайн дурсгалт газарт нарийвчилсан хайгуул хийж теодолит буюу тахеометр багажны тусламжтайгаар дурсгалын өндөр нарийвчлалтай дэвсгэр зургийг хийсэн нь бас нэг чухал ач холбогдолтой ажил болсон юм.


Харин Сагилын голын хөндийд хийсэн судалгаа нь 2014 онд анх удаа хийсэн хайгуулын үеэр илэрсэн цогцолбор дурсгалын он цагийг тогтоох, Чандмань-Уюк-Саглын соёлын судалгаанд шинэлэг, байгалийн шинжлэлийн арга зүйд тулгуурласан хувь нэмэр оруулах зорилготой ажилласан билээ. 2015 оны зорилтот ажил амжилттай болж бид Сагилын голын хөндийд нэг жижиг булшийг малтан судалж сайн хадгалалттай хүний оршуулга, шатаасан модноос гадна оломны ясан арал зэрэг эд өлгийн зүйлс илрүүлэв (Зураг 6).

Сагилын булшинд хүнээ тавихдаа ямар нэг чулуун болон модон авс хэрэглээгүй, харин нүхний ёроолд хавтгай хайрган чулуунуудыг тусгайлан дэвсэж түүн дээр толгойгоор нь баруун зүг чиглүүлж баруун хажуугаар нь хэвтүүлжээ. Хүний ясны байдал анх тавьсан байдлаараа илэрсэн бөгөөд баруун хажуугаар нь хэвтүүлэхдээ хоёр хөлийг нэлээд атийлгасан байх ба хоёр гарыг мөн адил нугалж тавьсан байв. Булшнаас илэрсэн хүний яс болон шатсан модноос он цаг тогтоох дээж авч Франц улсад илгээгээд байна.


Ийнхүү Монгол-Францын хамтарсан судалгааны анги Монгол нутагт төдий л сайн судлагдаагүй Сяньбийн үед холбогдох бүлэг булш, мөн харьцангуй бага судалсан түрэгийн үеийн тахилын онгон, Сагилын соёлын булш зэргийг малтан судалсан нь шинэлэг судалгаа болсныг дурдах нь зүйтэй. Тиймээс 2015 оны хээрийн шинжилгээний ажил чамлахааргүй амжилттай болсон. 2016 онд малтлага судалгааны ажлыг дээрх газруудад үргэлжлүүлэн явуулах төлөвлөгөөтэй байна.




Зураг 1. Малтан судалсан дүрсгалууд (байгууламж 20-оос бусад нь).




Зураг 2. Булш №1-ээс булш №7, дэвсгэр зураг




Зураг 3. Тахилын онгоны дэвсгэр зураг




Зураг 4. Байгууламж № 8



Зураг 5. Байгууламж № 20



Зураг 6. Сагилын гол, булш № 1




МОНГОЛ-ГЕРМАНЫ “ОРХОН” ТӨСЛИЙН 2015 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

У.Эрдэнэбат, Т.Батбаяр, К.Франкен

Монгол-Германы хамтарсан “Хархорум” төсөл нь 1999 оноос эхлэн хэрэгжиж 2007 оноос Хархорум төдийгүй нийт Орхоны хөндийн түүх соёлын баялаг дурсгалыг нарийвчлан судлах, хадгалж хамаалах зорилгоор Монгол-Германы Орхон Экспедици болон өргөжсөн билээ.

Тус шинжилгээний анги нь 2015 оны 7-р сарын 5-наас 8-р сарын 15-ны хооронд эртний Уйгурын нийслэл Хар Балгаст археологийн малтлагын ажил явуулснаас гадна Хархорумын их сүмийн туурийг ил музей болгохтой холбоотойгоор уг дурсгалыг хадгалж хамгаалах зарим ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Хээрийн шинжилгээнд Монголын талаас, төслийн удирдагч, доктор, профессор У.Эрдэнэбат, эрдэм шинжилгээний ажилтан Т.Батбаяр, Германы талаас, ХБНГУ-ын Археологийн хүрээлэнгийн Европын бус Соёлын Археологийн Комиссийн археологич, доктор К.Франкен тэргүүтэй 8 судлаач оролцон ажиллав.

Тус төслийн хээрийн шинжилгээний анги 2009 оноос хойш Хар Балгасын дэвсгэр талбайн хэд хэдэн газарт орших барилга байгууламжийн үлдэгдлийг малтан судлаад байна. Эдгээрийн нэг нь 2011 оноос эхлэн судалж буй хотын их хэрмийн зүүн урд булан дахь байгууламж буюу цитадель бөгөөд 2015 оны судалгааны хүрээнд энд гүйцэтгэсэн өмнөх жилүүдийн малтлага судалгааг үргэлжүүлэн хийлээ. Энд явуулж байгаа малтлага судалгааны гол зорилго нь өвөрмөц сонин байдлаар төлөвлөгдсөн хотын энэ хэсгийн бүтэц зохион байгуулалтыг судлан шинжлэх, үүрэг зориулалтыг тодруулахад чиглэгдэж байна.



Зураг 1: Архангай, Хотонт, Хар Балгасын дэвсгэр зураг болон агаараас авсан гэрэл зурагт Монгол-Германы Орхон Экспедицийн 2015 онд малтлага судалгаа явуулсан газрыг тэмдэглэсэн нь



Энэхүү цитадель нь хотын цайзат их хэрмийн зүүн урд буланд шавар, хайрга, элс шороо үелүүлэн дэлдэж хийсэн бараг 7 м өндөр 60х70 м орчим аварга том тавцан бөгөөд дөрвөн талаараа хүрээлэгдсэн хэрэмтэй. Хэрмэн хана нь баруун болон хойд талдаа хаалга үүдтэй байжээ. 2013-2014 онд баруун талын хаалганы байгууламжийг бүрэн хэмжээгээр малтаж гаргасан юм. Харин 2015 оны хээрийн шинжилгээний ажил хэрмийн хойд хаалганы орчимд төвлөрч явагдсан юм.



Зураг 2: Монголын эртний нийслэл Хархорум хотын Бурханы шашины “Цогт их сүмийн гэр” буюу “Юань улсыг мандуулах асар”-ын буурийг ил музей болгон сэргээж олон нийтэд үзүүлэхэд бэлэн боллоо.

Энд 11х16 м хэмжээ бүхий өргөн талбайгаар малтлагын ажлыг эхлүүлэв. Хэрмийн хойд ханыг багтаан шинээр малтсан талбайн энэхүү хэсэгт хэрэмт хотын дотроос энэхүү байгууламж руу нэвтрэн орох хаалга үүдний үлдэгдэл нэлээд сайн хадгалагдсан байдалтай илэрч олдов. Энэ нь өмнө илэрсэн баруун талын хаалганаас илүү бат бэх, маш хүчирхэг, бэхэлсэн хаалга болох нь илэрхий байлаа. Эндээс хаалганы зохион байгуулалтууд болох хатавч, хатавчийг бэхэлсэн дүнз модны үлдэгдлүүд, хаалга руу очдог тоосгон замын үлдэгдэл илэрч олдсон. Мөн хэрмийн дотор талаас бороо цасны ус тогтохгүй урсаж гарахаар тооцоолж хийсэн гадаргуу бүхий тоосгон шалтай талбайн үлдэгдэл илэрч гарлаа. Энэхүү хэрмийн хаалга нь 3 м гаруй өргөн, 0,8-2 м орчим өндөр хадгалагдан үлдсэнийг урьдчилсан байдлаар тогтоов.

Барилга байгууламжийн эдгээр зохион байгуулалтаас гадна малтлагын явцад, барилгын хэрэглэгдэхүүн болох төмөр хадаас, шатаасан болон түүхий тоосго, дээврийн нөмрөг ба тосгуур ваар, шавар сав суулганы хагархай, дээврийн чимэглэл болох цэцгэн хээтэй нүүр ваар, домгийн амьтны шавар баримал дүрсийн хэсгүүд, өнгийн будаг бүхий ханын шаваасны хэсгүүд, элдэв янзын тамга тэмдэгтэй дээврийн ваарны хагархай, дээрээ маш уран гоёмсог хээ чимэгтэй гантиг болон боржин суурь чулууд, төмөр сөргөө, алт суулган сийлж бичсэн хятад бичээстэй хэд хэдэн гантиг чулууны хугархай зэрэг онцлог содон олдворууд илэрч олдсон юм.

Энэ оны хээрийн шинжилгээний ажлын нэг гол үр дүн бол өмнөх жилүүдэд

эхлүүлсэн Хархорумын их сүмийн турийг хадгалж хамгаалах, сэргээх ажлыг үргэлжлүүлэн хийсний үндсэнд бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгаж, ил музей нээгдэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлсэнд оршино. Тус төслийнхөн археологийн малтлага судалгаанаас гадна дурсгалуудыг сургалт танин мэдэхүй, аялал жуулчлалын зорилгоор сэргээн босгох ажилд онцгойлон анхаарч ажиллаж байгаагийн нэгэн жишээ нь энэхүү ажил болж байна. Энэ нь цаашид гадаад дотоодын жуулчин, өргөн олон түмэн сонирхон үзэж өвөг дээдсийн бүтээн байгуулсан түүх соёлын өвөөр бахархан түүхийн гүн рүү аялах орчин үеийн нээлттэй музей болж байгаа юм.



Зураг 3: Архангай, Хотонт, Хар Балгас.
Цитадель дээрх малтлага судалгааны явц



Зураг 4: Архангай, Хотонт, Хар Балгас.
Цитадель дээрх хэрмэн ханын өрлөг, баганын чулуун сууриуд, тоосгон шалны үлдэгдэл, баруун талаас



Зураг 5: Архангай, Хотонт, Хар Балгас.
Цитадель дээрх хэрмэн ханын өрлөг, баганын чулуун сууриуд, тоосгон шалны үлдэгдэл, баруун урд талаас



Зураг 6: Архангай, Хотонт, Хар Балгас. Хээ чимэглэл бүхий суурь чулууны хагархай



Зураг 7: Хар Балгас. Хятад бичээстэй гантиг чулууны хугархай, домгийн амьтны дүрст барилгын чимэглэлийн хэсэг



Зураг 8: Архангай, Хотонт, Хар Балгас.
Домгийн амьтны дүрст барилгын чимэглэлийн хэсэг

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН “ДОРНОД МОНГОЛЫН ЭРТНИЙ ТҮРЭГИЙН ҮЕИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2015 ОНЫ МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

*Б.Цогтбаатар, Н.Эрдэнэ-Очир, Г.Лхүндэв, Б.Батдалай, Ц.Буянхишиг,
Г.Ангарагдөлгөөн, Э.Амарболд, Т.Осава, Ш.Сайто*

2015 онд “Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Агуйт уулын бэлд орших эртний Түрэгийн үеийн жирийн иргэдийн тахилын онгон, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Донгойн ширээ хэмээх газарт буй цогцолбор дурсгалын малтлага, болон хайгуул судалгааны урьдчилсан үр дүнгийн талаар танилцуулж байна.

Агуйтын тахилын онгоны малтлага судалгаа

Уг дурсгал нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэнбаян-Улаан уулын Агуйт хэмээх уулын бэлд оршино. Агуйт уулыг баруун талаар нь ороон урсах жижиг голын (Агуйтын гол) баруун эргийн тэгш дэнж газарт хүрэл зэвсгийн үеийн булш, хиргисүүр, эртний Түрэгийн дөрвөлжин хашлага бүхий тахилын онгон зэрэг дурсгалууд бий. Эдгээр дурсгалуудыг 2005 онд Хангай, Хэнтий нурууны археологийн дурсгалуудыг судлах грант ажлын хүрээнд илрүүлэн олжээ¹. Агуйт уулын бэлд эртний Түрэгийн жирийн иргэдийн гэгдэх хавтгай чулуудыг дөрвөлжлөн хайрцаглаж дотор нь чулуу хийж дүүргэсэн, зүүн талаас нь наран ургах зүг цувуулан босгосон балбал буюу зэл чулуутай тахилын онгон 2 бий. Эхний тахилын онгон нь дугуй хэлбэрийн овгор дараас чулуутай, гадна талаараа хүрээгүй хиргисүүрийн өмнө талд байрлах бөгөөд өргөргийн дагуу цувуулан үйлдсэн 4-н тахилын хашлаганаас бүрдэнэ. Уг тахилын онгоны өмнө талд 100 орчим метр зайд нумарсан хэлбэртэй байгуулсан тахилын онгон байрлана (зураг.1, 2).

Агуйтын тахилын онгон нь эртний Түрэгийн үеийн эгэл жирийн гэгдэх тахилын онгоны хамгийн энгийн бөгөөд нийтлэг хэлбэртэй боловч гадаад зохион байгуулалтын хувьд онцлог шинжтэй дурсгал юм. Нэг эгнээнд 14 тахилын онгоныг нумарсан хэлбэрт оруулан эгнүүлэн байгуулжээ. Ингэхдээ зүүн хойд талын 3-н тахилын онгоныг бага зэргийн ташуу байдлаар хийжээ. Хэмжээний хувьд (том нь 420х360 бол жижиг нь 210х190 см) ойролцоо бөгөөд зүүн хойд талын 12, 13-р тахилын онгон нь харьцангуй жижиг байна. Тахилын онгоныг байгуулахдаа хавтгай чулуудыг дөрвөлжлөн хайрцаглаж дотор нь чулуу хийж дүүргэсэн ба зүүн болон өмнө талд нь 1 юм уу 2 хөшөө чулуу (хүний дүрслэлгүй) босгожээ. Дээрх хөшөө чулуунаас эхлэн зүүн урагш цувуулан босгосон зэл чулуутай. Хэдийгээр тахилын онгонууд нь өөр өөрийн хөшөө чулуутай, түүнээс улбаалсан зэл чулуутай байх боловч 9-р тахилын онгонд тэдгээрийн аль аль нь мэдэгдэхгүй байна. Нумарсан хэлбэртэй тахилын онгонуудын 2 захын зэл чулуунууд сайн мэдэгдэх бол төв хэсгийн зэл чулуу нь хоорондоо холилдож (хугарсан, газарт унасан, мэдэгдэхгүй болсон г.м), аль онгоны зэл чулуу болохыг ялган тодорхойлоход хүндрэлтэй болжээ. Зэл чулуу нь 1-р тахилын онгонд хамгийн цөөн буюу 3 ш байгаа бол 4-р тахилын онгонд 2 эгнээндээ 24 ш байгаа нь хамгийн олон нь болно. Түүнчлэн 2-р тахилын онгоноос зүүн урагш хандуулан босгосон зэл чулууд хамгийн урт буюу

¹ Б.Цогтбаатар, А.Энхтөр, Ж.Гантулга, Г.Лхүндэв. Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан, Дэлгэрхаан, Жаргалтхаан сумдын нутагт ажилласан археологийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. Улаанбаатар, 2005, ТАХБМТ. т. 6-7.

155 м үргэлжлэх бол 5-р тахилын онгоны зэл чулуу 12 м байв.




Зураг.1. Агуйтын тахилын онгоны дэвсгэр зураг


Малтлагын өмнө геофизикийн судалгааны соронзон аргаар G-856AX протон, градиент сонголттой соронзон метр, хэт урт үелзлэл (VLF)-ийн AD-C Natural VLF detector багажийг ашиглан тандалт судалгаа хийж өгөгдлүүдийг Magmap-2000, Grapher-4 программ ашиглан боловсруулсан юм². Геофизикийн судалгааны үр дүн болон гадаад зохион байгуулалтын хувьд харьцангуй бүтэн байгаа 2 (зураг.3), 4 (зураг.4), 10 (зураг.5), 13 (зураг.6), 14 (зураг.7)-р тахилын онгоныг малтан судалсан юм.

Тахилын онгонуудыг байгуулахад ашигласан материал, онгоны ерөнхий бүтэц, зориулалт, хэмжээ зэрэг нь хоорондоо ижил төстэй боловч хөшөө чулууны тоо, байршил, тахил тайлга үйлдэж байсан ул мөр зэрэг нь харилцан адилгүй байгаа нь сонирхолтой юм. Малтлагаас гал түлсэн ором, үлдэгдлүүд нийтлэг гарч байв. Тэдгээрийг тахилын онгоны төв хэсэгт нүх ухаж гал түлж тахил тайлга үйлдэж байсан эсвэл зориуд шатааж бэлдсэн үнс нурмыг ухсан нүхэнд хийж дээр нь жижиг чулууг босоо байдлаар тавьж дээрээс нь шороогоор хучсаны дараа том хавтгай чулуугаар дарж тавьжээ. Нэг хөшөө чулуутай тахилын онгонд 1, хоёр хөшөө чулуутай бол 2 нүхэнд галын оромны үлдэгдэл илэрч байгаа зүй тогтол ажиглагдаж байсан бөгөөд дунджаар 40-80 см гүнд илэрч байна. Галын оромныг дарсан хавтгай чулууны дээрээс дундаж хэмжээтэй чулуугаар захын дөрвөлжин хашлагыг дүүртэл нь жигд дарж овоолжээ. Дараас чулууны дундаас малын яс, ваар савны жижиг хагархай илэрч байгаа нь тахил болгон өргөсөн зүйл бололтой. Эдгээр нь эртний Түрэгийн үеийн тахилын онгоноос гардаг нийтлэг олдворууд юм.


² Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах "Агуйт" нэртэй газарт археологийн судалгааны чиглэлээр хийгдсэн геофизикийн судалгааны үр дүнгийн тайлан. Улаанбаатар, 2015. т.1-2.



Зураг.2. Агуйтын тахилын онгоны гэрэл зураг




Зураг.3. Агуйтын 2-р тахилын онгон




Зураг.4. Агуйтын 4-р тахилын онгон



Зураг.5. Агуйтын 10-р тахилын онгон



Зураг.6. Агуйтын 13-р тахилын онгон



Зураг.7. Агуйтын 14-р тахилын онгон

Төв Монголын том онгонууд хийгээд Алтай нутгийн эгэл жирийн чулуун хашлагын төв дунд модон багана суулгасан тохиолдол тун нийтлэг байдаг³ ажээ. Харин бидний малтсан зүүн Монголын бүсэд хамаарах энэ дурсгалт газрын 5 тахилын онгоны малтлагаас модон багана суулгасан тохиолдол илрээгүй. Эртний Түрэгийн тахилын онгоны гадаад, дотоод бүтэц, зохион байгуулалтанд ялгаатай зүйл ажиглагдах ба энэ нь нийгмийн ямар анги давхаргад зориулагдсан, бүтээж босгосон цаг хугацаа, оршин буй бүс нутаг зэргээс хамааралтай бололтой.

Эртний Түрэгийн тахилын онгоныг судалсан олон жилийн судалгааны хэрэглэгдэхүүнээс үзвэл эдгээр нь хүний булш оршуулга бус харин тэднийг дурсан санаж тахил өргөх зан үйлийн ёслол гүйцэтгэдэг шүтлэгийн чанартай дурсгал болохыг тогтоосон байдаг. Бид энэ удаа зүүн Монголын бүс нутагт орших гадаад зохион байгуулалтын хувьд өвөрмөц хэлбэртэй тахилын онгоны малтлага судалгааны үр дүнд уг дурсгалын бүтэц, зохион байгуулалтыг тодруулсны зэрэгцээ галын ором, малын ясны үлдэгдлээс дээж авч он цагийн хамаарлыг нарийвчлан тогтоох лабораторийн шинжилгээ хийгдэж байна.

“Донгойн ширээ”-ний цогцолбор дурсгалын малтлага судалгаа

2010 онд МУИС-ийн Археологи-антропологийн тэнхимийн хээрийн шинжилгээний анги хайгуул хийх явцдаа Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын орчимд олон хөшөө, цэцэг хээ дүрсэлсэн хавтан бүхий цогцолбор дурсгалыг олжээ⁴.

2011 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор Ц.Болорбат, МУБИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Ж.Гэрэлбадрах нарын бүрэлдэхүүнтэй хайгуулын баг Дэлгэрхаан уулын хавьд хайгуул хийхдээ уг дурсгалын хөшөөнд эртний түрэг бичээс буйг илрүүлсэн⁵ байна.

Уг дурсгалт газарт ил байсан хөшөө чулуунуудаас 2013 оны 06 дугаар сард цаасан хэв авч баримтжуулалт үйлдэн урьдчилсан байдлаар уншсан⁶ ба 09-10 дугаар сард геофизикийн тандалт судалгаа хийж малтан судалжээ⁷.

Монгол-Японы хамтарсан “Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн хүрээнд 2015 оны 09 дүгээр сарын 02-21-нийг хүртэлх хугацаанд “Донгойн ширээ”-ний цогцолбор дурсгалын ерөнхий бүтэц, зохион байгуулалтыг бүрэн тодруулах, гэрэлт хөшөөдийг бүртгэн баримтжуулж, эртний бичээс болон тамганы хэв хуулга авах, ойр орчмын газарт хайгуул судалгаа хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэв.

Малтлага судалгааны үр дүнд гадна талаараа ялимгүй товойж харагдах 12х14м хэмжээтэй, баруун хойноос зүүн урагш чиглэлтэй дөрвөн талдаа бага зэргийн хотгор далантай болох нь тодорхой болсон юм (зураг 1). Далангийн өргөн нь дунжаар 200 см. Далангийн гадна талаар баруун хойноос зүүн урагш чиглэлтэй гүн суваг байгаа нь уртрагийн дагуу малтсан туршилтын малтлагаас мэдэгдэж

³ Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, П.Х.Жискар. Монгол Алтайн археологийн дурсгалууд-I. Баян-Өлгий аймаг. Улаанбаатар, 2009. т.157.

⁴ Р.Мөнхтулга, Т.Оосава. Донгойн ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан нь. // Эртний Түрэгийн түүх, соёл. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Улаанбаатар, 2015, т.21.

⁵ Дурдсан зохиолд. т.21.


⁶ Д.Цэвээндорж, Ц.Болорбат, Р.Мөнхтулга, Ц.Буянхишиг. Донгойн ширээний судалгаа. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Донгойн ширээн гэрэлт хөшөө бүхий дурсгалд хийсэн малтлага судалгааны ажлын урьдчилсан тайлан. Улаанбаатар, 2013, ТАХБМТ. т-2.

⁷ Дурдсан зохиолд. т.21.



байв. Уг суваг нь 170-200 см гүн. Далангийн дотор талаар мөн баруун хойноос зүүн урагш чиглэлтэй тойрог маягийн дөрвөлжин хэлбэртэй 7 хөшөөний суурь (нийт 13 хөшөө) илэрсэн (зураг 2). Анх суулгасан байрандаа буй 7 хөшөөний суурийн (нийт 13 хөшөө) төв хэсэгт зүүн өмнө талдаа нарийн сувагтай тогоо хэлбэрийн гүн нүх байгаа нь тодорхой болсон юм. Уг нүх нь дээд хэсгээрээ 3,5 м орчим голчтой. Нүхийг бүрэн малтаж дуусаагүй.

Уг цогцолбор дурсгалт газрыг хожим эвдэн сүйтгэж хагас дутуу булж орхисон нь малтлагын явцад тодорхой болсон юм. Хөшөө чулуунуудыг хурц үзүүртэй багажаар хугачин унагаах, сууриар нь булга татан дараа нь хэд хэд хугалах зэргээр эвдэж тараажээ. Хөшөө чулууны үлдэгдлүүд нь анх босгосон суурийн ойролцоо нь байх боловч зарим нь өөр хөшөө чулуутай холилдсон, мөн харилцан адилгүй гүнээс илэрч байна. Анхны байрандаа буй 7 суурийг оролцуулан 13 хөшөө нь 43 хугархайгаас бүрдэнэ. Мөн гадна талдаа цэцгэн хээтэй тахилын хавтан чулууг ч олон хэсэг болгон эвдэж тараан хаясан байна. Хээтэй хавтангийн том жижиг хагархай 20 орчим олдсон ч эвээр нийлж бүтэн болох боломжгүй. Тахилын хашлага нь хөшөө чулуунуудын зүүн талд байсан боловч уу хэмээн таамаглаж байна.



Зураг.1. Донгойн ширээний гадаргын зураг



Зураг.3. 5-р хөшөө, тамга болон руни бичээс



Зураг.4. Тахилын малын яснууд

Хөшөө чулуудыг хэд хэдэн төрлийн боржин чулуу ашиглан хийсэн ба гол төлөв хажуу ирмэгийг нь мөлийлгөн зассан гонзгой, зууван эсвэл 3-4 талт хавтгай хэлбэртэй. Хэмжээний хувьд хамгийн өндөр хөшөө нь 641х55х41 см байна. Хамгийн багад тооцогдох 1-р хөшөө нь 243х58х33 байх боловч энэ нь бодит хэмжээ биш юм. Учир нь хөшөөний дээд хэсгийн хугархай нь их биетэйгээ шууд нийлэхгүй байгаа мөн суурь хэсгийн газарт зоолттой үлдсэн хугархайн хэмжээг тооцоогүй болно. Хөшөө чулуунууд нь дунджаар нь 3-5 м урт байна (зураг 3).

Нийт 13 хөшөө чулууны 12-т нь тамга, бичээс сийлсэн байгаа бол нэг хөшөөнд чухам юу сийлэгдсэн нь тодорхойгүй. Ихэд бүдэг дүрслэгдсэн тамга байх боломжтой. Хөшөөнүүдийн өргөн нүүрэн талд эсвэл 2 хажуу тал дээр нь тамга, бичээсийг дангаар нь эсвэл хамтад нь сийлсэн байна. Тамга болон бичээсийг хөшөө чулууны дотогш харсан талд дүрсэлжээ. Ингэхдээ хөшөө чулуунаа эхлээд тамга дүрсэлсэн байснаа хожмоо нэмж бичээс сийлжээ. Тамга болон бичээсийг хамтад нь сийлсэн 6-н хөшөө, зөвхөн тамга сийлсэн 6-н хөшөө байна. Эдгээр хөшөөний 3-аас эртний руни бичээсийн⁸, 1 хөшөөний хятан бага бичээсийн⁹ (хар зосон) анхны уншилтыг хэвлүүлжээ. Энэ жилийн малтлага судалгаагаар эртний руни бичээст хөшөө 1, хятан? үсэг бичээс сийлсэн хөшөө тус бүр нэгийг шинээр илрүүлэн олсон. 2013 оны малтлагаар илэрсэн хятан бичээс хар бэхээр бичигдсэн бол шинээр олдсон бичээсийг сийлжээ.

Бараг бүх хөшөөнд тамга сийлсэн ба тодорхой мэдэгдэж буй 21 төрлийн (дан болон үүсмэл байдлаар) 135 тамга, тодорхойгүй дүрсийг 7 удаа дүрсэлсэн байна. Үүнээс онгин (34), дором (18), дөрвөлжин (18), янгир (14), саран (13), сэрээ (10) тамгыг хамгийн олон дүрсэлжээ. Нэг хөшөөнд 1-21 хүртэлх тамгыг сийлжээ. Тамгыг хөшөөний дунд хэсэгт голчлон дүрслэх боловч дээд болон доод хэсэгт дүрслэсэн тохиолдол ч бий. Харин хөшөөний ар өвөр талд дүрслэсэн тохиолдол 2 байна.

Малтлагын явцад талбайн урд хэсэгт бог малаар тахил тайлга өргөж байсныг гэрчлэх хоёр хонины яс бүтэн бус, эмх цэгцгүй байдалтай илэрсэн (зураг.4). Мөн энэ орчмоос болон талбайн бусад хэсгээс хонь, ямаа, адууны яс, шагай, ваар савны хагархайнууд харилцан адилгүй гүнээс илэрч байв. Ваар савны хагархай нь харьцангуй олон бөгөөд орц материал, хэлбэр төрх, хээ, шатаалт зэргээрээ адилгүй 3-4 төрлийн ваар байна. Дээврийн ваар болон тоосгоны хагархай цөөн олдсон.

Хайгуул судалгаа

“Донгойн ширээ”-н цогцолбор дурсгалын малтлага судалгааны зэрэгцээ Түвшинширээ сумын Үнэгд багийн нутагт хайгуул хийж эртний Түрэгийн үед холбогдох 3-н дурсгалт газрыг шинээр илрүүлэн олсон юм.

Үнэгдийн дурсгал: Энэ дурсгалт газарт 4 хөшөө чулуу бий. Тэдгээр нь бүгд газарт унаж хагас булагдсан байдалтай. Зарим хөшөө чулууны гадаргууд эртний руни бичээс болон янгир тамга дүрсэлжээ.

Гүн хоолойн Хөшөөтийн дурсгал: Энд 9 хөшөө чулуу байх бөгөөд тэдгээрийн захаар далан байж болохуйц овгор шороо мэдэгдэнэ. Хөшөө чулуунууд нь бүгд газарт унажээ. Тэдгээрийн нэг нь хүн чулуу бөгөөд хэвлий орчимд дором (гурвалжин) тамга дүрсэлжээ. Бусад хөшөөдөөс нэг нь л руни бичээстэй.

⁸ Р.Мөнхтулга, Т.Оосава. Донгойн ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан нь. // Эртний Түрэгийн түүх, соёл. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Улаанбаатар, 2015, т.21-42

⁹ Р.Мөнхтулга. Монгол улсын нутгаас илэрсэн Хятан бичээсийг тайлан унших нь. // Хятаны өв соёл. (Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл). Улаанбаатар, 2014, т.114-115



Болцгорын дурсгал: Энд 1 тахилын онгон байна. Хавтан чулууны 2 нь босоо байдалтай бол 2 нь унажээ. Хавтангийн гадаргуу нь хээ дүрслэлгүй. Уг тахилын онгон нь гадуураа 10 орчим метр голч бүхий дугуй хэлбэрийн овгордуу шороон далантай.

Товч дүгнэлт: Малтлага судалгааны үр дүнд “Донгойн ширээ”-н цогцолбор дурсгалын ерөнхий бүтэц, зохион байгуулалтыг илүү нарийвчлан тодруулсан. Мөн хөшөө чулуудын байрлал, тахил тайлга үйлдэж байсан баримт илрүүлж он цагийг тодруулах нэмэлт хэрэглэгдэхүүн олж чадсан юм. Бичээст хөшөө чулуу, тамганы хэв хуулгыг бүрэн авч тайлж унших ажил үргэлжилж байна. Нарийн зохион байгуулалт бүхий бүтэцтэй, олон арван тамга, үсэг бичээстэй сүрлэг өндөр хөшөө чулуутай, өвөг дээдэс, газар нутаг, орд өргөө зэрэг тахилын үгсийг олон давтаж бичсэн эл цогцолбор нь Монгол нутгаас олдсон эртний Түрэгийн анхны бөгөөд хамгийн зүүн талын дурсгал болж байна.

Эртний руни бичээсийн үсэгзүй, хэлзүйн онцлог, тамгын хэлбэр, хашлагын чулуун хавтангийн дүрслэл зэрэгт үндэслэн Донгойн ширээн дурсгалыг 735-745 оны үед эртний Түрэгийн хожуу хаант улсын, хааны дараа орох ихэс язгууртанд зориулан байгуулсан¹⁰ нь тодорхой болж байна.

Цаашид “Донгойн ширээ”-н цогцолбор дурсгалыг бүрэн малтан судлах, ерөнхий бүтэц, зохион байгуулалтыг тодруулах, бичээсийг тайлж унших, тамганы харьцуулсан судалгаа хийх, энэ бүс нутгаас шинээр илэрч олдсон ижил төрлийн дурсгалуудыг харьцуулан нягтлах, хөшөө чулуудыг сэргээн засварлах, хадгалж хамгаалах чиглэлээр олон талын ажлууд төлөвлөж байна.

¹⁰ Р.Мөнхтулга, Т.Оосава. Донгойн ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан нь. // Эртний Түрэгийн түүх, соёл. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Улаанбаатар, 2015, т.21-42

2015 ОНД МОНГОЛ-ТУРКИЙН ХАМТАРСАН “МОТАР-2” ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

*Ц.Баттулга, М.Эрдэнэ, Р.Мөнхтулга,
Ахмэт Ташагыл, Алпаслан Ашык, Адил Йылмаз*

Тус шинжилгээний анги Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Баян Цогтын хөндийд орших Билгэ Тоньюкукийн тахилын цогцолборын үндсэн зохион байгуулалт, барилга байгуулалтын ерөнхий онцлогийг тодруулахын тулд хэрэм, сувгаар хүрээлэгдсэн тавцангийн уртын тэнхлэгийн дагуу 15.4 м урттай нэг, өргөний тэнхлэгийн дагуу 16 м урттай бас нэг суваг, нийт зүсэлтийн хоёр ерөнхий суваг татаж малтав. Энэ хоёр талбайг үүсгэн малтахдаа гол тавцанг огт хөндөлгүйгээр түүнээс гадагших талбайн зүсэлтийн бүрэн зураг гаргахыг зорьсон билээ.

Олдворыг баримтжуулахад амар хялбар, цаг хугацаанд хэмнэлттэй, оновчтой байхыг бодолцож малтлагын талбай бүрийг 1 метрийн өргөнтэй суваг болгож суваг бүрийг хавтгай дөрвөлжин метрийн хэмжээтэй нүднүүдэд хуваав. Энэ нь ч малтлагын явцад хөрсний үе давхаргын ялгаа, урт мөртлөө газрын уруу байрлуулсан хоолойн ваарууд, татаал сувгийн зах хязгаар, гүн зэргийг нарийн нягт баримтжуулахад ашиг тустай болох нь батлагдсан юм.

Малтлагын 1-р суваг. 1-р суваг буюу тавцангийн уртын тэнхлэгийн дагуу, гэхдээ тэнхлэгээс ялимгүй хойш татсан сувгаар дараах зүйлүүдийг тодруулав. Үүнд:

1. Барилга байсан гол тавцангийн зүүн зах энэ хэсэгт ямар байдалтай байсныг тогтоов.

2. Гол тавцангаас зүүн тийш үргэлжилсэн үүдэн хэсэг сувгийн хойд урд хоёр үзүүр, хэрмийн хоёр үзүүрийн дундуур гарсан нь ойлгомжтой болов.

3. Гол тавцанг тойрсон сувгийн үзүүр байж болох газрыг малтлагын 1-р сувгаар зориуд дайруулан шалгаж үзэхэд хойд талын жинхэнэ үзүүр илэрсэн ба түүний тухай тодорхой ойлголт өгөх чухал мэдээллүүдийг олж авлаа.

4. Гол тавцангаас зүүн тийш, дээврийн ваар залган хийсэн, ус гадагшлуулах хоолой анхны байрлалаараа илрэв. Үүнийг, гол тавцангийн ус газрын уруу, сувгийн хойд үзүүрийн баруун талын ханыг даган орохоор тооцоолон хийсэн нь тодорхой боллоо. Ус гадагшлуулах хоолойн ваарууд сувгийн үзүүр рүү ойртох тусам хадгалалт нь илүү сайн байгаа нь мэдэгдэж байв.

1957 онд Н.Сэр-Оджавын удирдсан ангийн малтлагаар тавцангийн дээр байсан барилгын турын дотроос, ус зайлуулах зориулалттай, ваар залган үйлдсэн хоолой илэрсэн байна. Бидний илрүүлсэн хоолой тэр хоолойтой залгалдан холбогддог байсан эсэх, ер тавцан дээрх ямар нэгэн хоолой буюу байгууламжтай хэрхэн холбогддог байсан нь одоогоор тодорхойгүй байна.

1-р сувгийн зүүн хагасын малтлага, баримтжуулалтыг бүрэн гүйцээсэн ба баруун хагаст илэрсэн ус гадагшлуулах хоолой сувгийн ёроол хүртэл үргэлжлэх төлөвтэй болсон тул энэ удаагийн малтлагыг зогсоож хамгаалалт хийн булав.

1-р сувгаас хойш түүнтэй ойрхон, зэрэгцээ болон хөндлөн байдалтай татсан малтлагын сувгууд нь уг ерөнхий сувгаас олж авсан мэдээллийг нягтлах, шалгах зорилгоор малтсан багавтар талбайнууд болно.

Малтлагын 2-р суваг. Гол тавцангаас хойш, тавцангийн өргөний тэнхлэгтэй параллель 2-р сувгийг татав. Үүнийг урагш тавцанг дайруулан үргэлжлүүлсэн бол тавцангийн дээр байсан барилгын малтлагын ормын зүүн захтай давхцахаар болгож малтав.

2-р сувгийн малтлагаар тавцангийн тоосгон шалны хойд зах, түүний хойно



тавцангийн захыг “манаж” шавар дагтаршуулан үйлдсэн тавцангийн далан мэт зах, тавцанг хүрээлсэн суваг, сувгийн гадуурх шороон далан зэрэгт холбоотой хийгээд тэдгээрийн хоорондын харьцааг тодорхойлох чухал мэдээллүүдийг олж авсан билээ.


Малтлагын 10-р суваг. Цогцолборт хийсэн геофизикийн судалгаагаар, хамгаалалтын хашааны дотор талд, хэрмийн үүднээс урагш, хэрмийн бараг гадна, түүнтэй зэрэгцээ том хатуу биет илэрч байна гэсэн тул тэр хэсэгт нь 4 м-ийн урттай 10-р сувгийг татаж ул хөрс гартал малтсан боловч геофизикийн судалгааг батлах ямарваа биет илэрсэнгүй.

Малтлагын 11-р суваг. 1957 оны малтлагаар, цогцолборын голд байсан, Тоньюкукт зориулсан тахилын сүмийн турийг бүрэн малтаж дуусгасан байна. Тэрхүү сүм байсан дөрвөлжин ормын эргэн тойронд, тоосгон шал байсны зарим нь одоо ч газрын хөрсөн дээр ил харагдана. Уг тоосгон шал нь, цогцолборыг хүрээлсэн сувгаас дотогш, тэгшивтэр тавцангийн дээр байсан нь илэрхий боловч хэр зэрэг талбайг хамарч тавцангийн аль хэсэг хүртэл үргэлжилсэн нь тодорхойгүй байсан юм.

Тавцангийн баруун хойд буланд 11-р суваг хэмээх талбайг нээн малтаж дээр дурдсан тоосгон шал тавцангийн баруун захад байгаа эсэх, энэ талд ер аль хүртэл үргэлжилснийг тодруулахыг зорив. Малтлагын өмнө малтлагын талбайд георадарын судалгаа хийлгэхэд өнгөн хөрснөөс гүн бус түвшинд, хэвтээ тэнхлэгийн дагуу хөрсний нягтралын эрс ялгаа байгаа нь мэдэгдсэн юм. 7 м урттай, 3-Б чиглэлтэй сувгаар малтахад сувгийн баруун хэсэгт бор шороон хөрс, түүнтэй залган зүүн тийш хатуу саарал шавар илэрч байв. Тэрхүү хатуу саарал шаврыг хусахад доороос нь тавцангийн бусад хэсэгт байгаа шалны тоосготой хэлбэр хэмжээ ижил тоосгыг эгнүүлэн суулгасан шал гарав. Лавшруулан малтахад зориуд дагтаршуулсан саарал шавраас зүүн тийш малтлагын сувгийн зүүн хана хүртэл тоосгон шал үргэлжилсэн нь мэдэгдэв. Энэ сувгийн малтлагаар, тавцан, түүнийг тойрсон суваг хоёрыг дагтаршуулсан шавар үе зааглаж түүнтэй залгаад тавцанг бүрсэн тоосгон шал байсан нь тодорхой болов. 11-р сувгийн малтлагаар илэрсэн шалны тоосгонууд нь тавцангийн бусад хэсгийнхтэй адил боловч өнгө нь өөр, хадгалагдсан байдал нь харьцангуй сайн байна. 1957 оны малтлагаар ил гаргасан тоосгонууд нь олон арван жилийн хугацаанд байгаль, хүний нөлөөгөөр элэгдэж хадгалалтын байдал нь маш муудаж өнгө нь ч өөр болсон байна. Тоосгон шалны шинээр илэрсэн хэсэг бусад чиглэлд аль хүртэл үргэлжлэхийг хойшдын судалгаагаар тодруулахаар төлөвлөж байна.




1-р сувгийн 2-р үе, ус дамжуулах ваар хоолой



1-р сувгийн 2-р үе, ус дамжуулах ваар хоолой



2-р суваг



11-р сувгийн 2-р үе, тоосгон шал

БУЛГАН АЙМГИЙН БАЯН - АГТ СУМЫН НУТАГТ ОРШИХ ШИВЭЭТ УЛААНЫ ДУРСГАЛТ ГАЗАР ХИЙСЭН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ УРДЬЧИЛСАН ҮР ДҮН

*Д. Цэвээндорж, А.Энхтөр, Т. Эрдэнэцогт, З. Самашев,
Н. Базылхан, А. Онгар, Г. Киясбек, М.Ахметов*

2015 онд Монгол улсын ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн нь Казахстан Улсын Түрэгийн Академитай хамтран ажиллах гэрээ байгуулсаны дагуу энэ оны 9 дүгээр сард Монгол Улсын Булган аймгийн нутаг Шивээт улааны дурсгалд хайгуул, хэмжилт судалгааг Монгол талаас доктор, профессор Д.Цэвээндорж, доктор А.Энхтөр, Т.Эрдэнэцогт, Казахстаны талаас Дорно дахины судлалын хүрээлэнгийн доктор профессор З.Самашев, доктор, профессор Н.Базылхан, А. Онгар, Г. Киясбек, М.Ахметов нар оролцон ажиллав.

Шивээт Улааны дурсгал нь Хангайн нуруунаас эх аван урсдаг Хануй, Хүнүй голын уулзвар Шивээт Улаан уулын орой дээр байрлах байгууламж юм. Хануй, Хүнүй голын бэлчир нь Булган аймгийн Баян-Агт сум, Архангай аймгийн Хайрхан сумын хилийн зааг нутагт оршидог.

Шивээт Улаан хэмээх энэхүү уул нь байгалийн улаан боржин чулуу тул нутгийнхан Шивээт Улаан /Улаан уул/ хэмээн нэрлэдэг байна.

Шивээт Улааны дурсгалт газар нь далайн түвшнээс дээш 1340 м өндөрт, хойд өргөргийн 47° 04' 221", зүүн уртрагийн 102° 04' 189" солбицолд орших уулын орой дээр чулуугаар барьж байгуулсан дурсгал юм.

Эл дурсгалыг XX зууны эхэн 1912 онд Г.И.Рамстед дэвсгэр зургийг хийн нийтэлжээ. Үүний дараа тус дурсгалын талаар судалгааг 1934 онд Д.Д.Букинич, Зүүн Түрэгийн хаант улс унасны дараах үед холбогдоно гэсэн бол С. Г. Кляшторный 691 оны үед байгуулагдсан хэмээн үзсэн байна. В.В.Войтов Шивээт улааны дурсгалыг Түрэгийн хаад язгууртанд зориулсан хэмээн үзсэн байна. 20-р зууны сүүлээр В.Д. Кубарев, Д. Баяр нарын судалгааг судалгаа томоохон байрыг эзэлж байна.

2010 онд Соёлын өвийн төв нь Шивээт улааны дурсгалд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын танилцуулга чулуун самбар босгох явцад нутгийн иргэдтэй нэгэн хүн чулууны толгойг шинээр олж илрүүлэн Булган аймгийн Баян-Агт сумын Засаг даргын тамгын газар хүлээлгэн өгсөн байна.

Дурсгалын тодорхойлолт

Шивээт Улааны цогцолбор дурсгал нь зүүнээс баруун тийш 116 метр өргөн нь 47 метр Шивээт Улаан уулын орой дээр байгуулсан дурсгал юм. Энхүү чулуун байгууламжын хана нь сууриараа 2 метр, дээд хэсгээр 1 метр зарим газраар 50 см байна. Шивээт Улааны дурсгал нь төв хэсэгтээ 8 талтай чулуун байгууламжтай болох нь энэ удаагийн хэмжилтээр тодорхой болсон юм. Төв байгууламжийн өндөр 3 метр 8 талтай одоо байгаа тойргийн голч 36х52 байна. Энэ байгууламж нь хойд талаасаа их нурж эвдэрсэн байна.

Уг байгууламжтай ижил дурсгал Архангай аймгийн Хотонт сумын Хотонт уулын оройд байна. Шивээт Улааны цогцолборт дурсгалын тамгатай гэрэлт хөшөөг бараан саарал өнгийн боржин чулуугаар 2.35 метр өргөн 93 см, зузаан 31 см хэмжээтэй хийж хөшөөний нэг талд олон тооны тамгийг дүрсэлсэн байна. Мөн бидний 2015 оны судалгааны зорилго нь Шивээт Улааны дурсгалт газарт нийт 9900 хавтгай дөрвөлжин талбайгаар геодезийн зураглал судалгаа хийх байсан юм. Мөн Шивээт Улааны цогцолборт дурсгалын дэвсгэр зургийг үйлдэж тамгатай

гэрэлт хөшөө, чулуун арслан дээрх тамганы дардасны цаасан хуулгийг авах ажлыг хийсэн юм.

Шинээр олдсон хүн чулууны толгойн тодорхойлолт

Уг хүн чулуун хөшөөний толгой нь бүчтэй малгай өмссөн хүнийг дүрсэлжээ. Хүний нүүр эрүү түүш зузаан, хүзүү бүдүүн, хацарын хэлбэр төвгөр, магнай өргөн, дүрлэгэр нүдтэй хүнийг дүрсэлжээ, малгайн гурвантал шилэвчтэй хоёр талын буулгыг ард нь шилэвчлэн бүчилсэн байна. Энэ нь Монголын хэрээн живэр малгайтай адил байна. малгайн магнайн дээд талд далавчаа дэлгэсэн шувууны дүрсийг дүрсэлсэн байна. энэ хүн чулууны толгойтой ижил дурсгалыг 1912 онд Г.И.Рамстед эл дурсгалт газраас олж нийтэлсэн байна. Энхүү Г.И.Рамстедийн нийтэлсэн хүн чулууний толгой одоогийн Казахстан улсын Евразийн их сургуульд (хууль бусаар) хадгалагдаж байна. (Зураг 1)




Зураг 1.

Газарзүйн соронзон зургийн үр дүн

Бид 2015 оны судалгааны зорилго нь Шивээт Улааны дурсгалт газар орчмын хөрсний давхарга дор байгаа объектыг тодорхойлон судлахад газарзүйн соронзон зурагны судалгааны гол зорилго байв. Бид FOERSTER компанийн FEREX 4.032 дугаарын тусгай төхөөрөмжийн тусламжтайгаар археологийн судалгааг геофизикийн судалгаан дээр үндэслэн гүйцэтгэх боломж бүрдэж буй юм. Цаашилбал, энэхүү төхөөрөмжийг ашиглан ерөнхий бүтцийн онцлогийг тодорхойлж болно.

Энэ жилийн судалгаа нь газарзүйн соронзон зургийн гол чиглэл Шивээт Улааны дурсгалт газрын хэв шинж, зохион байгуулалт, зориулалтыг багтаав.

FOERSTER компани нь цахилгаан соронзон аргачлалыг өнгөрсөн зууны 30-аад оноос хэрэгжүүлж ирсэн байна. Энэхүү төхөөрөмж нь газар доорхи бичил соронзон талбайг хэмжих нарийн мэдрэгчтэй ба хөрсний бага зэргийн өөрчлөлт, гажилтыг нарийн тодорхойлох боломжтой. Уг аргачлалыг соронзон хэмжүүр буюу магнитометр гэж нэрлэдэг байна.



Мөн 4.032 Ferex төхөөрөмжийн тусламжтайгаар бүх төрлийн металлыг илрүүлэх боломжтой. Үүнд хуйларсан урсгалын зарчмыг ашигладаг. Цахилгаан соронзон орны эх үүсвэрийг бий болгож бага металлын агууламж объектыг ч илрүүлэхийн тулд ашигладаг байна.

Газарзүйн соронзон судалгааны үйл явц нь судалгааны зорилгод нийцүүлэн тооцооллыг цогцолборт дурсгалын бүхий л хэсэгт хуваана. Цогцолборын газар дэвсгэр шинжилгээний үед хамгийн тохиромжтой байсан нөхцөл байдал дээр үндэслэн хуваагдсан байна.

Хөшөө дурсгал нь өндөрлөг бүхий ажиллахад хэцүү толгод дээр орших ба чулуурхаг, хад чулуу бүхий хөрс орой дээр байрлаж байсан нь ажиллах нөхцөлд хүндрэл учруулж, зарим талаар нь газарзүйн сорон зурагны судалгааны үр дүнд нөлөөлж байлаа.


Цогцолбор газар нь харагдах өнцөгт нийт зүүнээс хойш 120 метр, урдаас хойд зүгт 60 гаруй метр талбай байв. Судалгаанд тус тус 70-130 метр талбайг хамруулсан болно. Талбайг 8 хувааж соронзон зураг авсан ба баруунаас зүүн зүг рүү сканнер зураг авалтыг хийлээ. Замнал тус бүрийн өргөн нь 50 см ба хоорондын зай 20 см байв. Үүнээс гадна хойд зүгт 20-40 метрийн хэмжээтэй талбайн зургийг нэмж авсан болно. Ийнхүү судалгааны нийт талбай нь 9900 метр хавтгай дөрвөлжин болсон байв.

Зураг авалтын явцад хөрсний давхарга дор байрлах чулуун байгууламж, нуранганаас гадна дурсгалт цогцолборын хил хязгаарыг илрүүлэн тогтоосон билээ (Зураг 1.2).

2015 онд Монгол орны төв хэсэгт Шивээт Улаанд хийсэн бидний хайгуул судалгаа нь өргөн хүрээний археологийн малтлага судалгаа хийх шаардлагыг нотлох урьдчилсан үр дүнг гаргах зорилготой ажил байсан юм. Энэ дурсгалт газар урьд өмнө судалгаа хийсэн сулаачид эрдэмтэдийн гаргасан он цаг, зохион байгуулалтын онцлог зэргийг тодорхойлсон нь бидний ажлын үр дүнтэй зөрөөтэй байгаа гэдгийг энэ ажилд тусгасан болно.

Төвийн найман талт байгууламж дотор болон гадна талаарх чулууг гараар цэвэрлэх, түүвэрлэх, амьтны загварт болон домгийн амьтны дүрстэй хөшөө,

хаалганы хамгаалагчийн дүрс бүхий хөшөө зэрэг олдсон газар малтлага судалгаа хийж, энэхүү сүм (байгууламжийн) хөшөөдийн анхны байрлалыг нэхэн сэргээх оролдлого хийх явдал юм.



Олон төрлийн үүрэг зориулалт бүхий шүтэх, тахилга хийх зориулалт бүхий байгууламж нь Шивээт Улааны адил хаад болон язгууртнуудын дурсгалд зориулан босгож байв. Энэ эртний Түрэгт домгийн шинжтэй тахилгын байгууламж байсан тухай гэрчилнэ. Энэхүү шүтлэг, зан үйлийн цогцолборын зарим нэг барилгын хийц, хэлбэрээс харахад эртний Түрэгийн нийгэм дэх ертөнцийг үзэх үзэл, чиг баримжааны дагуу баригдсан харагдана. Мөн энэ дурсгалын төв дунд барьсан найман талт байгууламж, хүрээлсэн хэрмийн зохиомж, хаалга, цонжны байдал нь Уйгурын үед холбогдох хотын зохион байгуулалттай адил байна. Найман талт байгууламжтай адил дурсгал нь Архангай аймгийн Хотонт сумын Хотонт уулын оройд байна. энэ нь Уйгуруудын дунд буддын шашин Торгоны зам даган баруун талаас хөгжих үед дэлгэрсэн барилгын хэлбэр бололтой.

Энэхүү чулуун хүрээ бүхий байгууламж нь Уйгурын шороон хэрэмт хотын жижигрүүлсэн хэлбэр болох нь ажиглагдаж байна.

Энэ дурсгалт газар бидний таамаглаж буйгаар Кутлук \Хятадын Тан улстай 679-689 оны хооронд дайтаж, Түрэгийн хаант улсыг сэргээсэн гавьяатан\ зориулж байгуулсан бололтой. Түүний дараагаар Элтерис хаан хэмээх цол хүртжээ. Дурсгалт газар Элтерис хаанд зориулж босгосон болохыг гэрчлэх ямар нэгэн баримт, бичээсийг бид хараахан илрүүлээгүй бөгөөд судалгааны ажил явуулсны үр дүнд таамаглалаа батлах эсвэл няцаах хэрэгцээ гарах юм.

МОНГОЛ-ТУРКИЙН ХАМТАРСАН “ТОНЬЮКУК” ТӨСЛИЙН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТУХАЙ

*А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Г.Батболд,
Т.Эрдэнэцогт, С.Гүнэри*

Төслийн хүрээнд бид Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Тоньюкукийн тахилын онгоны орчимд археологи, геофизикийн хайгуул судалгаа, мөн археологийн малтлага судалгаа, Тоньюкукийн тахилын онгон болон Цагаан овоогийн тахилын онгон зэргийн дэвсгэр зургийг үйлдсэн. Хээрийн судалгааны бүрэлдэхүүнд Монгол талаас Түүх, Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын доктор А.Энхтөр (Ph.D), Л.Мөнхбаяр, Г.Батболд, Т.Эрдэнэцогт нар оролцон ажиллав.

Эртний Түрэгийн хаант улсын гурван хааны зөвлөх байсан мэргэн сайд Тоньюкукт зориулан босгосон нэгэн дурсгал Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Баянцогт уулын баруун хойд /Налайх хотоос зүүн тийш 20 орчим км зайд/ ард оршино.


Тоньюкукийн бунхант эл булш дурсгал нь Түрэгийн язгууртны нэрд гарсан иж бүрэн дурсгалын нэг бөгөөд түүнд багтах гэрэлт хөшөөний Орхон, Енисейн бичээс дэлхийд нэр гарсан цөөн тооны бичиг дурсгалын нэгд тооцогддог. Гэрэлт хөшөө нь хоёр чулуун дээр нийт найман талд нь 62 мөр бичсэн руни бичээстэй бөгөөд тухайн үеийн Түрэгийн нийгмийн байдлыг Тоньюкукийн намтартай холбогдуулан бичсэн агуулгатай юм.

Эл дурсгалыг анх 1897 онд оросын судлаач Е.Н.Клеменц олж, булшин дээрх гэрэлт хөшөөний бичээсийг цаасаар хэв авч гэрэл зураг татсаныг академич В.В.Радлов орчуулжээ. 1909 онд Г.И.Рамстедт бага зэрэг малтан шинжилсэн бөгөөд 1925 онд Б.Я.Владимирцов, Барадийн Базар нар тэндээс тоосго дэвссэн шал, дээврийн төрөл бүрийн ваар олжээ. Тэр цагаас хойш П.Аалто /1957/, Е.И.Убрятова, В.Н.Нагделяев /1960/ нар газар дээр нь биечлэн очиж хөшөөний бичээсийг нарийвчлан судлах үйлст хувь нэмрээ оруулжээ. Эдгээр эрдэмтдийн бүрдүүлсэн эх хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан Е.С.Малов, Г.Айдаров зэрэг эрдэмтэд уул бичээсийн орчуулгыг дахин нягтлан үзсэний гадна, уул бичээсийг түүх хэл шинжлэлийн үүднээс судлахад олон эрдэмтэд анхаарч иржээ.

1957 онд доктор Н.Сэр-Оджав Тоньюкукийн бунхант булшийг нэлээд өргөн хүрээтэй малтан шинжлэх ажлыг удирдан зохион байгуулжээ. Малтлагаар хөх тоосгыг нэг эгнээгээр өрж хийсэн ханатай барилгын нуранги гарсан бөгөөд шалыг тэг дөрвөлжин хөх тоосгоор өрж зассан, барилгын дээврийг шатаасан хөх саарал өнгийн ваараар хучиж, ханын гадна талыг хар, улаан, цагаан шаргал, зосон улаан зэрэг хурц өнгийн будгаар будсныг илрүүлсэн. Мөн шар хуваар хийсэн сувс, хөх хээтэй шаазангийн хагархай, болхидуу хийцтэй том шавар ваарын хагархай, хонины шилбэ, чөмөгний яс, засаж хэрчээс татсан бог малын бугалаг яс зэрэг зүйлс олноор олдсон. Тэндээс олдсон ваар савны ихэнх нь дэрэвгэр амсартай, хавтгай ёроолтой, цар маягтай байжээ. Барилгын шал дундаас нөмрөг, тосуур ваарын захыг нийлүүлэн нааж цувруулан тавьсан усан хоолой гарсан байна. Барилгын чимэглэлээс баганы толгойд нааж чимж шавраар хийсэн өтгөн хөмсөгтэй, том бүлтгэр нүдтэй, хурц соёотой, сартгар хамартай нүүрэн чимэг зэрэгтээ хоёр ба гурван гүвгэр татаж хийсэн шавар чимэг, мөн товойлгож гаргасан давхар дөрвөлжин зоосон хээтэй нүүр ваар зэрэг олон сонирхолтой олдворууд гарчээ.

Бид энэ удаагийн судалгаагаар Тоньюкукийн тахилын онгоны дэвсгэр зургийг

шинэчилэн үйлдсэн бөгөөд тахилын онгоны төв хэсгийн 1957 оны малтлагаар ил гаргасан тоосгон шалны хэсгээс хэмжилт хийх зорилгоор 3 х 5 м талбайд бага зэрэг цэвэрлэн фото, гар зургаар баримтжуулсан юм. Мөн уг тахилын байгууламжийн хаалганы баруун талын далан дээр 1 х 1 м хэмжээтэй өнгөн хөрсийг нь цэвэрлэн далангийн шорооны бүтцийг тодорхойлох сорил хийсэн болно. Тус цэвэрлэгээний үед өмнөх судалгааны явцад илэрч байсан зоосон хээ бүхий дээврийн нүүр ваар хоёр ширхэг илэрсэн юм (зураг 1).



Зураг 1. Тоньюкукийн тахилын онгоны дээврийн нүүр ваар



Зураг 2. Цагаан овоо.
1-р булшнаас илэрсэн малын яс.




Зураг 3. Цагаан овоо.
1-р булшнаас илэрсэн төмөр амгай

Бидний судалгааны нэгэн зорилго нь Тоньюкукийн тахилын онгоны ойр орчимд буй газрын өнгөн хөрсний өөрчилөлттэй газарт геофизикийн тандалт судалгаа хийх байсан юм. Мөн Цагаан Овоо хэмээх Тоньюкукийн дурсгалаас Зүүн хойш 2 км орших тахилын онгоны дэвсгэр зургийг үйлдэж тахилын хавтны хээ болон балбал чулуун дээрх тамганы дардас хэв хуулгийг авах ажлыг явуулсан болно.

Цагаан-Овоо тахилын онгон нь урдаасаа хойш 34 м, баруунаас зүүн тийш 20 м талбай хамарсан бөгөөд үүний гадна талаар одоо байгаа өргөн нь 5 м орчим өргөн, 10 см орчим өндөр шороон далантай. Шороон далангийн гадна талаар 5 м орчим өргөн суваг мэдэгдэх бөгөөд түүний шороог гадагш гаргасан бололтой 2 м орчим өргөн далан байна. Тус Тахилын онгоны хаалга тай байсан гэх ором сайн мэдэгдэхгүй болон хулширчээ. Тус тахилын онгон нь нэгэн байгууламжид хоёр зэрэгцээ тахилын хавтантайг нь нилээд онцлог дурсгал юм. Монгол нутгаас нэгэн тахилын онгонд хоёр тахилын хавтантай тахилын онгон байдаг ч судлаачид нэг нь түрүүлж үйлдээд дараа нь нөгөөг нь үйлдсэн байж болох юм гэсэн судалгаанууд байдаг. Гэвч энэхүү тахилын онгоноос харахад тус хоёр тахилын онгон цугтаа үйлдсэн бололтой 34х20 метр талбайд хоёулаа зэрэгцээ тэгш хэмтэй үйлдэгдсэн байх бөгөөд хоёр тахилын хавтангаас хоёулангаас нь зүүн тийшээ балбал чулуу гарсан байна.

Хоёр тахилын хавтан 3х3 м хэмжээтэй байсан бөгөөд одоо нилээд эвдэрсэн байна. Тахилын хавтангийн өмнө талын хавтан цэцгэн хээтэй бол хойд талын хавтан ханан хээтэй байна.



Цагаан-Овооны тахилын онгон

Хоёр тахилын хавтан 3×3 м хэмжээтэй байсан бөгөөд одоо нилээд эвдэрсэн байна. Тахилын хавтангийн өмнө талын хавтан цэцгэн хээтэй бол хойд талын хавтан ханан хээтэй байна. Бид өмнө талын тахилын хавтанг №1 хэмээн дугаарласан болно. 1-р тахилын хавтан хойд болон ур талын хавтан одоо босоо байдалтай хэвээрээ хадгалагдан ирсэн бөгөө нөгөө хоёр хавтангийн хагархайнууд ойр орчимд нь байна. Балбалын тоо 250 м зайд одоо хэвтээ, босоо 28 ширхэг балбалтай бол 2-р тахилын хавтан нь 250 м зайд одоо мэдэгдэж буй нь хэвтээ босоо 11 орчим мэдэгдэж байна. 1-р тахилын хавтангийн 9-р балбал дээр дэгээ тамга сийлсэн байна. Үүнтэй адил тамга 2-р тахилын хавтангийн буланд мөн сийлсэн байна.

Уг тахилын онгоноос баруун тийш 200 м орчим зайд хоёр зэрэгцээ дугуй хүрээтэй булш байсан бөгөөд тус хоёр булшийг малтан судласан юм. Тус хоёр булш эрт цагт бүрэн тоногдсон байсан бөгөөд булшны амсар дарсан дараас чулууны доод үеэс жижиг төмөр хазаарын амгай илэрсэнээс өөр ямар нэгэн олдвор илрээгүй болно (Зураг 3).

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН “ШИНЭ ЗУУН” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ТОВЧ ҮР ДҮН

*Б.Цогтбаатар, Л.Ишцэрэн, Г.Батболд, Б.Эрдэнэ
Н.Ширайши, Т.Миякэ, Т.Сагада*

Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн хээрийн шинжилгээний анги нь 2001 оноос эхлэн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь “Хэрлэний Хөдөө арал”-ын орчны бүсийн археологийн дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалт, чулуун зэвсгийн бууц суурин, хүрэл, төмөр зэвсгийн үе, Монгол гүрний үеийн хот суурин, булшны судалгаа зэрэг чиглэлээр хайгуул болон малтлага судалгааг амжилттай гүйцэтгэж ирсэн билээ.

2015 оны малтлага судалгааны ажил нь “Аваргын балгас”-ын туурийн талбайн малтлага, Хэрлэн Баян-Улаан уулын “Таван хайлаастын ам”-ны Монгол булшны малтлага судалгаа гэсэн үндсэн 2 хэсэгт хийгдсэн юм.

Аваргын балгасын малтлага судалгаа

“Аваргын балгас”-ын малтлага судалгаа нь 2015-оны 8-р сарын 19-нөөс 28-ныг хүртэл хугацаанд үргэлжилсэн бөгөөд хотын туурийн зүүн урд хэсгийн гудамжны (зураг 1) бүтэц зохион байгуулалтыг тодруулах зорилготой ажилласан юм. Энэ хэсэгт 2007, 2008 онуудад гудамжны зүүн урд талд цувран орших барилгын тууриудаас сонгож Лос.6 талбайд (зураг 2) малтлага судалгааны ажлыг хийсэн билээ.

Дээрх Лос.6 талбай нь төв гудамжны урд талд байрлах ба барилгын суурыг малтах явцад халаалтын ханзны чулуу, барилгын суурь хэсгүүд илэрсэн бөгөөд ханзны өрлөг нь “L” хэлбэрийн гурван сувагтай байсан юм. Ханзыг хавтгай чулуугаар таглаж, шавраар завсар гаргалгүй чигжсэн байна. Ханзны нэг талын төгсгөл хэсэг нь зуухны амтай нийлсэн, зуухны амны голч 1 м, гүн 1 м хэмжээтэй. Харин зуухны амыг дотогш малтахад түлшний мод, аргал, модны нүүрс болон үнстэй холилдсон их хэмжээний хүнсний зүйлийн үлдэгдэл гарсан болно.

Тус барилгын араар баруунаас зүүн тийш сунаж тогтсон ил байгууламжгүй 20 м орчим өргөн хоосон зай байгааг Аураг ордны төв гудамжны хэсэг байж болох юм хэмээн үзэж туршилтын малтлага судалгааг эхлүүлсэн юм. Гудамжны зохион байгуулалтыг тодруулсанаар тус суурин газарт зам харилцаа магадгүй зам харилцаанаас үүссэн замын хонхор зэрэг ул мөрүүд илэрч тухайн үеийн тээврийн гол хэрэгсэл юу байсныг тодруулахад тулгуур болж болох юм. Малтлагын талбай нь хойд өргөргийн 47°05' 49",9 зүүн уртрагийн 109°09' 53.3" солбицолд буюу далайн түвшингээс дээш 1202 м өндөрт байна. Бид 2007 оны малтлагын талбайг хойш нь сунгаж 4 х 4 метр хэмжээтэй Н1, Н0, 99, 98 гэсэн 4 талбайг өргөргийн дагуу бүрэн огтлохоор сонгон малтлагыг хийлээ (зураг 5). Тус талбайг малтах явцад бидний гудамжны хэсэг хэмээн таамаглаж байсан үе давхаргаас 2007 онд илэрсэн халаалтын ханзтай барилгын ард талд нэмэлт зохион байгуулалт бүхий хоёр тасалгаатай үр тариа хадгалах агуулах (зураг 3), түүний хойд талаас төмөрлөгийн дархны холбоотой үйлдвэрийн жижиг зуух зэрэг зүйлс илэрсэн юм (зураг 4).


Төмрийн дарханы жижиг хэмжээний төмөрлөг дархлах буюу бэлэн төмрөөр бүтээгдэхүүн хийх үйлдвэрлэл явуулж байсныг нотлох баримт хэмээн үзэж болохоор байна. Мөн алт болон хүрлийн маш жижиг үлдэгдлүүд ваарны амсар болон ёроолд наалдаж үлдсэн хэсгүүд олдсон нь тэдгээрийг тусгай зориулалтын вааранд хийж хайлуулан цутгуурын хэвэнд цутгаж бүтээгдэхүүн хийж байсныг



нотлох чухал эх хэрэглэгдэхүүнийг олсон юм. Энэ жилийн малтлагын хугацаа бага байсан тул төв гудамж хэмээн бидний үзэж байгаа үе давхаргад арай хүрч амжилгүй судалгааг дуусгав.



Зураг 1. Аварын балгасны дэвсгэр зураг



Зураг 2. Лос 6 талбайн дэвсгэр зураг

Тус төмөрлөг хайлуулах бага оворын зуух нь Аураг ордны тууриас анх удаа харьцангуй бүтнээр илэрч буй дурсгал бөгөөд дарх хийхэд гардаг төмрийн зоргодос, төмөр хайлуулж байсан модны нүүрс, үнс, төмрийн шаартай барьцалдан үлдсэн зуухны ханын хэсэг, алт, хүрлийг хайлуулан цутгах ваар гэх мэт төмөрлөг боловсруулж байсныг нотлохуйц олон чухал олдворууд илэрснийг онцлууштай.

Мөн барилгын арын хоёр тасалгаатай байгууламж нь түүхий тоосгоор хийж дотор талыг нь шавраар өнгөлөн чийг, хорхой шавьж нэвтэрхээргүйгээр хийсэн үр тариа хадгалах байгууламж илэрсэн нь хотын туурийн бүтэц зохион байгуулалт, тухайн үеийн оршин суугчдын амьдрал ахуйг тодруулах нэгэн шинэ баримт болж

байна. Тус төслийн хүрээнд Хэрлэний хөдөө арлын археологийн дурсгалуудыг нарийвчлан бүртгэн баримтжуулж дэлхийн соёлын өв (ЮНЕСКО)-ийн урьдчилсан жагсаалтанд 2014 онд амжилттай бүртгүүлсэн бөгөөд цаашид “Хөдөө арал дахь Монголын эзэнт гүрний археологийн дурсгал, түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар” гэсэн номинацаар нэр дэвшүүлэх бэлтгэлийг хангахад чиглэсэн судалгааны ажил хийгдэж байна.



Зураг 3. Н1 талбай. нэмэлт зохион байгуулалт бүхий байгууламж



Зураг 3. Н1 талбай. Дарханы зуухны үлдэгдэл

“Таван хайлаастын ам”-ны монгол булшны малтлага судалгаа

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Хэрлэн Баян-улаан уул нь чулуун зэвсгийн үеэс аваад Монгол гүрний үе хүртэлх нүүдэлчдийн үе үеийн түүх соёлын дурсгалыг хадгалан ирсэн нутаг юм. Төслийн хүрээнд Хэрлэний хөдөө арлын нэг хэсэг болох Хэрлэн Баян-улаан уулын түүх, соёлын дурсгалыг бүртгэн, баримтжуулах, малтан судлах ажлыг хийж ирсэн бөгөөд 2012 оноос Их Хайлантын ам, Таван Хайлаастын ам орчмын монгол булшны малтлага судлагааг хийж эхлэсэн юм. 2015 оны хээрийн судалгааны ажил Хэрлэн Баян-улаан уулын Таван Хайлаастын аманд явагдсан ба өмнөх жилд малтлсан ТХ-5 дугаар бүлгийн үлдсэн 4 булшыг малтан шинжиллээ.

Таван Хайлаастын амны зүүн энгэрт үл ялиг дэвсэг дээр, хоорондоо 7 метр зайтай дөрөв дөрвөөр орших бүлэг оршуулгыг ТХ-5-р бүлэг хэмээн хайгуул судалгааны явцад тэмдэглэжээ. Өмнөх жил буюу 2014 оны малтлагаар энэхүү бүлэг оршуулгын 4-ийг (ТХ-5-1, 5, 7, 8-р булш) малтсан ба энэ жил үлдсэн ТХ-5-ын 2, 3, 4, 6-р булшинд малтлага явагдлаа.

Булшны байршил болон гадаад дотоод зохион байгуулалт: ТХ-5 бүлэг булш нь Таван хайлаастын амны зүүн энгэрийн дунд хэсэг болох жижиг дэвсэг дээр оршино. Малтан шинжлэсэн 4 булшны гадаад зохион байгуулалт буюу дараас нь ижил, газрын дээд хэсгийн дараас чулуу мэдэгдэхгүй, төв хэсэгтээ дараас чулуугүй, хөл талд нь бусдаас илт том нэг хавтгай, эсвэл хоёр том хэмжээтэй чулуу нийлүүлэн тавьж зууван хэлбэрт оруулан, булшны нүх, байгалийн хөрс 2-ын ирмэг дагуу өрөн, гадна талд нь жижиг чулуугаар хашин, баруун хойд, хойд, зүүн хойд зүгт хандуулан бүтээжээ. Булшны төвийн чулуугүй хэсэгт малтлага явагдсан ба 3 булшинд нимгэн хавтгай чулуугаар хашлага хийн тавьсан бол ТХ-5-ын 3-р булшинд хашлага чулуу болон авс илэрсэнгүй. Булшны гүн 150-297 см байгаа ба хамгийн гүн нь ТХ-5-ын 4-р булш 297 см гүнд хүрсэн. Өмнөх жилүүдэд малтсан (ТХ-4, ТХ-5 бүлэг) булшны зохион байгуулалттай харьцуулж харахад, газрын байршил, дараасны хэлбэр, булш хандсан зүг гэх мэт дээрхи дурсгалуудын хоорондын холбоо хамаарлыг харуулах ижил зүйлс хэд хэд байна. Жишээлбэл, - 2012-2015 онуудад малтсан дурсгалууд нь өндөр уулын дунд бие болон түүнээс



дээш оршиж байгаа; - Том чулуудыг зууван хэлбэрт оруулан булшны нүхний ирмэг дагуулан тавьж гадна талаар нь жижиг чулуугаар хашиж бүтээсэн; - Баруун хойд, хойд, зүүн хойд зүг хандсан; - Оршуулгын гүн гэх зэргийг дурдаж болно.



ТХ-5 2-р булш



ТХ-5 3-р булш



ТХ-5 4-р булш

Оршуулгын зан үйл: ТХ-5-ын 2-р булшинд хүнээ баруун хойд зүгт 3, 4-р булшинд үл ялиг баруун хойд зүг, 6-р булшинд чанх хойд зүгт хандуулан тавьжээ. Анатомын байрлалдаа үлдсэн (3,4-р булш) хүний яснаас харахад дээш харуулан тэнэгэр байрлалтай оршуулсан ба маш их тоногдож сүйдсэн учир эд өлгийн зүйлс анх хаана тавигдсан байсныг тогтоох боломжгүй болжээ. ТХ-5-ын 4-р булшнаас хадгалалт муу үйсэн ховдны хэсэг баруун хөлийн дунд чөмөг ясны харалдаа илэрсэн нь дотор талдаа төмөр зэвтэйгээ байна. Хөл болон толгой талд хөмөг илэрсэнгүй. ТХ-5-ын 2, 4, 6-р булшнаас бог малын шагай, шагайт

чөмөг яс илэрсэн. Нас барагчийн хөлийн яс анхны тавилтаараа байгаа бол их бие, гавал яс хөндөгдөж байрнаасаа зөөгджээ. Үүнээс харахад эрт үед эдгээр булш их хэмжээгээр тоногдож сүйдсэн нь илт байна. Бидний малтан шинжлэсэн 4 булшны 1 нь (ТХ-5 3-р булш) чулуун хашлага авсгүй, хүний ясны жижиг хэсгүүд булшны нүхний дунд болон хөл талаас илрэв. Дагалдуулсан эд өлгийн болон хойлгын зүйл илрээгүйг өмнө нь эвдэн сүйтгэж тоногдсонтой холбоотой гэж үзэх боломжтой байна. Учир нь 3-р булшны зүүн болон урд талын дараас чулуу хөндөгдөөгүй зууван хэлбэрээ хадгалан үлдсэн байхад баруун, хойд талын дараас чулуу байхгүй байгаа нь тонуулчид энэ талын дараас чулууг авч орон, хашлага болон хүний яс зэргийг хөнджээ. Харин ТХ-5-р бүлгийн 2, 4, 6-р булшны зууван хэлбэртэй дараасны зөвхөн толгой тал хөндөгдөж, 2, 6-р булшны хашлага бүтэн, 4-р булшны толгой болон хөл талын хашлага үлджээ.

Палеоантропологийн судалгаа: Малтлагаар илэрсэн хүний ясны хадгалалт маш муу үүний дээр ихэд тоногдсон тул хүний ясны олдворт ажиглалт болон краниологи остеологийн бүрэн гүйцэд судалгаа гаргах боломжгүй байна. ТХ-5-ын 2-р булшинд 13-15 орчим настай хүүхэд оршуулсан бол 3-р булшны хэрэглэгдэхүүнд нарийвчилсан тодорхойлолт гаргах боломжгүй ба ясны ерөнхий хөгжлөөр нас биед хүрсэн том хүн болох нь тогтоогдлоо.

4-р булшнаас илэрсэн хүний олдворыг 165 см дундаж өндөртэй 30-35 насны эрэгтэй хүн байна гэж тодорхойлсон бол 6-р булшны олдворт 160,9 см дундаж өндөр бүхий эрэгтэй хүн байна гэсэн палеоантропологийн урьдчилсан үр дүн гарсан.

Он цаг: Малтлага судалгааны үр дүнд илэрсэн хүний яснаас дээж авч Япон улсын Нийгата их сургуулийн лабораторид илгээн шинжилж үзэхэд

1. ТХ-5-ын 2-р булш НТ 1396-1442
2. ТХ-5-ын 3-р булш НТ 1397-1442
3. ТХ-5-ын 4-р булш НТ 1399-1445
4. ТХ-5-ын 6-р булш НТ 1292-1399 гэсэн он цагийг хамаарч байна.

Товч дүгнэлт: Хээрийн судалгааны үр дүнд ТХ-5 бэсрэг оршуулгын газарт малтлага судалгааг амжилттай хийж бүрэн дуусгалаа. Хэдийгээр түүхэн мэдээлэл өгөх эд өлгийн зүйлс хомс илэрсэн ч палеоантропологийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан лабораторийн нарийн он цаг тогтоож өмнөх ба дараа жилүүдийн олдвор хэрэглэгдэхүүний он цагтай харьцуулах, генетикийн судалгаа явуулах боломжтой болсон. Бидний малтан шинжлэсэн дээрх булшнууд нь Хөдөө арал орчим амьдарч байсан хүн амын ахуй амьдрал эдлэл хэрэглэл, ёс заншил зэрэг эдийн болон оюуны соёлыг нэхэн судлахад чухал эх хэрэглэгдэхүүн болох төдийгүй лабораторын нарийн шинжилгээ хийснээр булш хооронд уг удамын харилцаа холбоо бий эсэх, генийн сан бүрдүүлэх, он цагийн уялдаа холбоог харж болох боломжтой юм.

ХУБИЛАЙН ЦЭРГИЙН ХОТ “ХӨГШИН ТЭЭЛИЙН БАЛГАС”-ЫН МАЛТЛАГА СУДАЛГАА-2015

Л.Мөнхбаяр, Т.Хантөгс

Эртний энэхүү хотын туурь нь Хангайн нурууны баруун урд үзүүр Хан Хөгшин хэмээх уулын зүүн биед гурван тусдаа, шороо чулуу хольж барьсан хэрмүүдээс бүрдэнэ.

Хөгшин Тээлийн балгасны учир холбогдол, он цагийг тогтоох хамгийн найдвартай гэрч баримт нь анх тавьсан газартаа бүрэн бүтнээрээ хадгалагдан үлдэж манай үетэй золгосон хөшөөний бичээс билээ. Түүнчлэн эртний энэ балгас нь нутгийн ардын дунд “Хубилай цэцэн хааны хот” хэмээх нэрээр уламжилж ирсэн ба хөшөөний бичгийг тайлж уншсанаар он цагийн хамаарал нь нэгэнт тодорхой болжээ.

П.К.Козлов өөрийн нийтэлсэн орчуулгад үндэслэн уг хөшөөг Хубилай, Ариг бөх нар хаан ширээ булаалдан тэмцэлдсэний эцэст Хубилай ялж, 1275 онд ялалтаа тэмдэглэн босгосон гэж үзжээ. Түүнчлэн энэхүү орчуулгад умар зүг дайлаар гарсан зүүн гарын шадар цэргийг мянганы дарга Чан Вэнь толгойлон явж хөшөөг босгуулсан мэт өгүүлжээ.

Энэ балгасыг анх 1926 онд Оросын Газар Зүйн Нийгэмлэгээс П.К.Козловоор удирдуулан илгээсэн Монгол-Төвдийн шинжилгээний анги гүймэг шинжин тодорхойлж, тэнд байсан нангиад бичигт хөшөөний хуулбар үйлдэн гэрэл зураг татан авч уг бичээсийн орос орчуулгыг нийтэлжээ. Хубилай өмнөд Хятадыг дайлаар явуулсан цэргийн гол хүчийг татан авчирч, эсэргүүцэн боссон ноёдыг дарах арга хэмжээг яаралтай авсан...” тэр үе бололтой. Хан Хөгшин ууланд хот цайз байгуулж, хөшөө босгон үйл явдлаа алдаршуулж асан энэхүү их цэрэг нь уг бослого тэмцлийг даруулахаар Хубилай хаанаас томилон илгээсэн цэрэг болох нь судалгааны явцад тодорхой болсон байдаг.

Манай хүрээлэнгээс Дундад зууны судалгааны салбараас эрдэм шинжилгээний ажилтан Л.Мөнхбаяр, Т.Хантөгс нарын 10 хүний бүрэлдэхүүнтэй баг нэгдүгээр хэрмийн баруун урд өнцөгт орших “Дарь эхийн сүм” хэмээх нэгэн барилгын баруун урд хана дагуу, мөн баруун хойд догол хэсэгт 2015 оны 9 сарын 9-нөөс 19-н хүртэл археологийн малтлага судалгаагаа хийсэн билээ. Малтлагын үр дүнд дээрх байгууламжийг байгуулахдаа газрыг хөрсийг сайтар дагтаршуулан булангийн босоо боржин багана чулууг дээр нь барин түүнийг 2 талаар байгалийн хавтгай чулууг өнцөг нийлүүлэн тэгшитгэн барьсан нь тогтоогдсон юм. Түүний дээд хэсэгт суурийн боржин чулуу хөндлөн хашаалан тавьж тэгш тавцанг байгуулсан нь тодорхой болсон юм. Тус хэсгээс малтлагаар гарсан дээврийн ваарны хагархай 1050, тоосгоны хагархай 335 ширхэг бөгөөд нурангийн зузаан хэсэг 60 см орчим ихээхэн таруу байдалтай байлаа. Мөн энэхүү талбайгаас нурхай ихээр хуримтлагдсан үед ихээхэн хэмжээний үнс гарсан нь тус барилга шатах үед үүссэн байх магадтай хэмээн таамаглав.

Шинээр гарсан суурийн боржин хэсгийг оролцуулан хийсэн малтлагын “Б” талбайд хийсэн үр дүнгээс үзвэл, уг суурийн боржин хэсгийг дээд хэсэгт хэвээр буюу “in situ” 3 ширхэг хэвтээ тоосгон өрлөг мэдэгдсэн нь тус барилгын ханын жинхэнэ байдлыг тодруулан мэдэж болох хамгийн чухал баримт юм. Уг өрлөгөөс үзэхэд тус барилгыг суурийн боржингийн дээд хэсэгт тоосгон хана бүхий байгууламж байсан нь тодорхой болов. Мөн түүнчлэн тус хэсгийн малтлагаас ихээхэн хэмжээний бүтэн тоосго, барилгын материал тоосгоны хагархай 1396, бүтэн тоосго 7 ширхэг, дээврийн ваарны хагархай 426 ширхэг илэрлээ. Мөн тус

барилгын материал бүхий үеийн доод хэсэгт ихээхэн хэмжээний хайрган чулуу гарсан нь барилгыг барихдаа байгалийн хайрган үе хүргэн ухаж суурийн хэсгийг дагтаршуулан засаад тус байгууламжийг барьсан гэх дүгнэлтэд хүргэв. Олдворын тухайтад, тухайн хэсгийн малтлагын явцад цөөнгүй тооны барилгын дээврийн нүүр ваар, дусал ваар гарсан нь он цаг тогтоох чухал хэрэглэгдэхүүн болох бөгөөд нэгэн цаг үед хамаарах буюу Юань улсын дээд нийслэл Шанду (ӨМӨЗО-д буй) хотын малтлага судалгаагаар илэрсэн зүйлстэй ижилсэж байна.



Хөгшин тээлийн балгасын Дарь эхийн сүм.



Малтлагын "А" талбай



Малтлагын "Б" талбайгаас илэрсэн навчин хээтэй барилгын чимэглэл



Малтлагын "Б" талбай

Малтлагын явцад нутгийн иргэдийн зүгээс бидэнд уг барилгад хамааралтай байж болох боржин чулуу олзворлож байсан байх магадтай газрын тухайн дам мэдээлэл өгөв. Мэдээллийн дагуу очиж шалгаж үзэхэд Хөгшин тээлийн 1-р хэрмээс баруун тийш 4 км зайд Их модотын аманд "Сайн ноён ханы өвөлжөө" хэмээн товлож пайз босгосон хэсгээс дээш уулын энгэрт үнэхээр боржинг бэлтгэж байсан газрын үлдэцийг олж баримтжуулан авлаа. Уулын налуу энгэрт байх маш том байгалийн боржин хавтгай хаданд эрт үеийн цуулан авах технологийн дагуу дээр нь 11-15см урт, 5 см өргөн цүүцний оромнууд үлджээ. Ором хоорондын зай 7-11 см байна. Уг газар ихээхэн налуун бөгөөд цуулан авсан барилгын материал болсон боржин чулууг хажуугаар нь урсах Бага таргилын голыг хөлдөх үед хэрмүүдэд хүргэсэн болов уу гэх таамаглал дэвшүүллээ.

“XVII зууны Монголын хотууд” төсөл: САРЬДАГИЙН ХИЙДИЙН СУДАЛГАА-2015

С.Чулуун, Э.Уртнасан, Ч.Энхтуул

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн захирал С.Чулууны санаачлан хэрэгжүүлж буй “XVII зууны Монголын хотууд” төслийг Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьт 2013 оноос эхлэн малтлага судалгаа явуулж байна. 2015 оны судалгааг 6 дугаар сарын 21-ээс 9 дүгээр сарын 26 хүртэл хийсэн байна. Судалгааны ангийн бүрэлдэхүүнд төслийн ахлагч С.Чулуун, төслийн зохицуулагч Б.Цогтбаатар, Талбайн ахлагч Э.Уртнасан, Ч.Энхтуул, ЭША С.Далантай, Б.Дашдорж, Т.Хантөгс, Ц.Буянхишиг, С.Амарбаяр, Б.Батболд, М.Энхбаатар, Ч.Батдорж, Н.Гонгоржав, Л.Алтантуяа, Н.Нандинцэцэг, С.Өлзийсайхан, У.Пүрэвжав болон туслах ажилтнаар МУИС, МУБИС, Улаанбаатарын их сургуулийн мэргэжлийн ангийн оюутнууд оролцсон 35 хүний бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Сарьдагийн хийд Төв аймгийн Эрдэнэ сумын Чулуут багийн нутаг Хэнтий нурууны салбар уул болох Хийдийн сарьдагийн хайрханы өвөрт оршино. Хийд нь Туул голын эх орчим Хийдийн голын эхэнд Хийдийн сүмийн гол, Хийдийн голын бэлчирээс баруун хойд зүг 2 км орчим зайд Хийдийн сарьдаг хайрханы өвөрт хойд өргөрөгийн 48°27'43.56"N, зүүн уртрагийн 107°59'41.88"E хэмд ДТД 2062 м өндөрт байрлана (зураг 1). Тус хийдийн туурьт 2015 онд малтлага судалгаа явуулахаас гадна археологи, угсаатны зүйн авран хамгаалах салбарын ЭША Б.Батдалай хийдийн агаарын зураглал хийсэн болно. Мөн хийдийн орчоос болон малтлагаар илэрсэн модноос дээж авч ой судлалын тэнхимийн модны цагираг судлалын лабораторид судалгаа хийж байна. Мөн тус хүрээлэнгийн дундад зууны судалгааны салбарын ЭША А.Энхтөр Япон улсын Нара Их сургуулийн доктор Тэцүо Шожитой хамтран ажиллаж хийдийн цогчин дуганд PARO багжаар 3D зураглал хийсэн байна (зураг 3).


Тус онд хийдийн төвд байрлах гадуураа хэрэм хашаа бүхий цогчин дуганд малтлага судалгааг төвлөн хийсэн байна. Энэ удаагийн малтлагаар 2014 онд малтсан цогчин дуганы хоймрыг гүйцээж малтах, цогчин дуганы төв заал болон хэрмийн урд хаалга, хэрмэн дотор зарим газар сорьц малтлага хийхээс гадна хийдийн ойр орчмоор зарим зохион байгуулалт тодорхойгүй газар сорьц малтлага хийсэн болно.

2015 онд малтлага судалгаа явуулахад БСШУЯ-наас тусгай зөвшөөрөл авч, БОНХАЖЯ болон Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын захиргаатай гурвалсан гэрээ байгуулж БОНХАЖЯ-ны Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар малтлага судалгаа хийх зөвшөөрлийн дагуу судалгаа явуулсан болно.


Мөн хийдийн хамгаалалтын бүсийг тодорхойлох зорилгоор бүх барилгын туурийг хамруулан дөрвөн буланд нь цэг авлаа. Эдгээрийг дурдвал баруун хойд булан: 48°27'48.1 N, 107°59'33.7E, баруун урд булан: 48°27'32.9 N, 107°59'33.7 E, зүүн хойд булан: 48°27'48.1 N, 107°59'52.2 E, зүүн урд булан: 48°27'32.9 N, 107°59'52.3 E хэмд тус тус байрлана. Эдгээр цэгүүд нь өргөөш 380 м, уртааш 470 м хэмжээтэй 17.86 га талбай эзлэж байна.

Мөн 3 жилийн судалгааны явцад 5 барилгын туурийг шинээр илрүүлсэн юм. Тус 5 барилга нь хэрэм бүхий гол барилгаас урд зүгт 120 орчим метр зайд хоорондоо 20 орчим метр зайтай орших бөгөөд тэргээрийг №8, 9, 10, түүнээс урд зүг 100 гаруй метр зайд 2 барилга илэрүүлэн №11, 12 хэмээн дугаарлав (зураг 2).

Энэ онд Сарьдагийн хийдийн туурьт 659.5 м² талбайд малтлага хийж, 662 м³




Агаарын зураг



Цогчин дуганы анхны байдал



Хийдийн дэвсгэр зураг



Цогчин дуганы 3D зураг



Зураг 7.




Зураг 5.



чулуу, шороо гаргасан байна. Гаргасан чулууг хэрэм хашаан дотор кублэж тавьсан бол шороог хэрэм хашаанаас гарган асгасан бөгөөд малтлагын талбайгаас шороо асгах газар хүртэл 90 орчим метр зайтай байна.



Зураг 6.



Зураг 4.

2015 онд хийсэн малтлага судалгаараа цогчин дуганы хоймор хэсгийг бүрэн малтаж дуусгасан байна. Тус малтлагаар язгуурын таван бурхан бүтэн болон сэргээн засварлаж бүтэн болгосон 728 ширхэг байна. Эдгээр нь хагархай бурхантай нийлээд 1500 орчим болно. Мөн 2014-2015 оны малтлагаар дуганы хойморт, баруун зүүн тал тус бүрт асар том хэмжээний шавар бурхан байсан нь мэдэгдсэн байна (зураг 4.3). Харин хоймрын голд том хэмжээний бурхны үлдэгдэл болох шавраар хийсэн сэнтийний түшлэг, ялтсан хуягны хэлтэрхий, цагаан, хөх шаазангийн хагархай зэргээс өөр зүйл илрээгүй байна. Энэ нь хоймрын голд том хэмжээний шавар бурхан байсан гэдгийг илтгэх аж.

Дээрхи том хэмжээний шавар бурхадаас гадна баруун, зүүн хана дагуу 1 м голчтой, 20 см өндөр шавар бадны дээр босоо байдалтай байсан 3 м орчим өндөр шавар бурхан байсан нь мэдэгдэх бөгөөд зөвхөн тавхай нь үлдэж бусад хэсэг эвдэрч хэмхэрсэн байна (зураг 4.4). Гэвч тус бурхадын нүүрний зарим хэсэг болон хөл, гарын хэсэг үлдэж хоцорсон байна. Энэ онд том хэмжээний бурхан буюу бурхан №1-ийн доороос шүншиг илэрсэн бөгөөд хадгалалтийн хувьд маш муу байна (зураг 5.1,2). Шүншигэнд тулга, тогоо, шаазан цом, цул мөнгөн аяга, бурхан сийлсэн мөнгөн эдлэл, илд 2 ширхэг, жадны шилбэр, сумны зэв, цахиур гар буу, ялтсан болон хөө хуяг, дуулга, дөш, ясаар хийсэн нарны цаг зэргийг тусгай зан үйлийн дагуу эмх цэгцтэй тавьсан байна (зураг 6.4,5,7-10,13,16).

Мөн дуганы хойморт малтлага хийснээс гадна дуганы төв заалыг таллан баруун талыг бүрэн гаргалаа. Дуганы төв заал нь гол хэсэгтээ чулуун шалтай, бусад хэсгийг модоор хийсэн байжээ. Дугана нь хоорондоо 2.5-3 м зайтай 56 баганатай бөгөөд багана нь 40х40 см хэмжээтэй байна (зураг 4.1). Дуганы баруун, зүүн, урд талдаа хаалгатай. Урд хаалга 2.2 м өргөн бол, баруун, зүүн талын хаалга 1.5 м өргөн аж. Төв хаалганаас урагш 3.5 м зайд чулуун хана байх бөгөөд голд нь мөн 2.2 м өргөн хаалганы ором байна. Энэ хаалгаар дуганы урд байх саравч руу ордог аж. Харин дугана руу орохдоо тус саравчны хоёр талаар тойрч ордог байна.

Мөн дуганы дундуур урагш довжооны урд зах хүртэл нэвт гарсан ус зайлуулах шуудуутай бөгөөд шуудууг шалны доор хавтгай чулууг хавиргалан хоорондоо 15 см зайтай босгож, дээр нь нимгэн хавтгай чулуугаар таглан 5 см зузаан шавраар хучсан байна. Дуганы урд хаалганаас довжооны урд зах хүртэл 11 м зайтай бөгөөд энэ хооронд 30 см налуутай хийсэн байна.

Мөн энэ онд дуганд малтлага хийснээс гадна хэрмийн урд хаалганд малтлага хийсэн ба уг хаалга нь судлаачдын тогтоосноор дотогш нударга хэмээн нэрлэгддэг байна. Хаалганы гадна талд чулуун шат илэрсэн бөгөөд хоёр тал буюу баруун, зүүн талаасаа 15-16 гишгүүртэй байна (зураг 4.2). Энэ нь газрын түвшнээс дээш 3.5 м өндөр аж. Шатны хойд талд буюу хэрмийн хананд газрын түвшнээс дээш 2.2 м өндөрт хоорондоо 1.5 м зайтай ус зайлуулах хоолойн нүх байна.

Хэрмийн урд хана нь малтлага хийсэн талбайд мэдэгдэж байгаагаар тухай үеийн газрын түвшинээс дээш 2.2 м өндөр чулуун хана, түүний дээр шавраар дэлдэж хийсэн ханатай байна. Хэрмийн урт ханын өргөн нь 5 м бөгөөд дотор талд шавар хананд тулган 1 м өргөн чулуун хана хийсэн байна. Мөн хэрмийн урд хаалганы дотор талын хана болон буланд тулган хийсэн хэдэн баганы үлдэгдэл мэдэгдсэн бөгөөд цөөн тооны шатсан мод илэрсэн юм. Тус модны дээр хоорондоо бөөрөөрөө нийлсэн хоёр хэсэг овоорсон байдалтай шаварлаг хөрс илэрсэн байна. Бид үүнийг төсөөлөхдөө хаалганы дээр суварага юм уу, ямарч л байсан шавар дээвэртэй байсан хэмээн таамаглаж байна.

Мөн дуганы хоёр талаас хэрэм давуулан 3 м өргөн талбайд малтлага хийсэн юм. Үүний үр дүнд хэрмийн зүүн талын хананд тулган барьсан өрөөнд шавар сац хэдэн мянгаар тоологдох хэмжээгээр хийсэн байгаа нь энд хүн амьдардаг бус харин шашны ямар нэгэн зан үйл үйлддэг байжээ гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм. Мөн тус тасалгааны орчмоос ямар нэгэн дээврийн ваар гэхээр зүйл илрээгүй. Харин шаварлаг хайргатай хөрс илэрсэн нь суварга байсан байх гэсэн сэтгэгдэл төрж байна.

Мөн Соёлын өвийн төвд хийлгэсэн найрлага тогтоох шинжилгээгээр сарьдагийн хийдээс илэрсэн язгуурын таван бурхны нэгээс дээж авсан бөгөөд хийдийн баруун урд зүгт байх нэгэн жижиг нуураас авсан шаварны дээж хоёрын найрлаг адил байгаа нь дээрхи шавар бурхадыг хийдийн орчмоос авсан шавраар хийсэн гэдэг нь мэдэгдэж байна.

Бидний энэ оны малтлага судалгаа амжилттай дууссан бөгөөд цогчин дуганы анхны бүтэц зохион байгуулалтыг сэргээн харж болохуйц мэдээлэл цуглуулсан байна. Мөн бурхан шашны болон аж ахуйн, цэрэг дайны холбогдолтой, тухайн үеийн гадаад харилцааг ямар өргөн хүрээнд байсан талаар тодруулах бодит олдвор хэрэглэгдэхүүн илрүүлсэн юм.

Цогчин дуганы хэрэм нь 99х81 м хэмжээтэй, урд болон баруун зүүн тал тус бүрдээ хаалгатай аж. Дуганы төв заал нь нэлээд өндөр бөгөөд хоёр үе дээвэртэй, эхнийх нь улбар шар өнгөтэй бол түүний дээр жижиг хэмжээний алтан шаргал өнгөтэй аж. Эдгээр нь нийлээд 10 орчим метр өндөр байсан болов уу хэмээн таамаглаж байна. Барилгыг чулуугаар өрж гадуур нь цагаан шохойгоор өнгөлсөн байна (зураг 7). Дуганы төв заал нь баруун, зүүн урд буланд хоёр давхар руу гардаг шаттай аж. Шат нь хоорондоо 30 см зайтай гишгүүртэй бөгөөд 400 орчим налуу байна. Заалны дотор талын бусад зохион байгуулалт мэдэгдэхгүй байна.


МУИС-ИЙН АНТРОПОЛОГИ-АРХЕОЛОГИЙН ТЭНХИМЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

3.Батсайхан

Тус тэнхим 2015 онд Ховд аймгийн Дөргөн сумын нутаг дахь “Дун Гоулд” ХХК, “Ренова илч” ХХК-ын “Хар ус II”, Дорноговь аймгийн Замын Үүд боомтын Хар овоо орчимд орших “МЦЦТ” ХХК-ын ашиглалтын талбайд Монгол улсын Соёлын өвийг хамгаалах хуулийн холбогдох заалтын дагуу археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дун Гоулд ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбай

“Дун Гоулд” ХХК-ийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2015-оны 10-р сарын 1-ээс 10-ийг дуустал археологийн хайгуул судалгаа зохион явуулав. Тус компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайн ихэнх хэсэг нь Ховд аймгийн Дөргөн сумын нутагт багахан хэсэг нь Увс аймгийн Өлгий сумын нутагт байх ажээ. Талбай Дөргөн сумаас баруун хойш 20 гаруй км зайтай Их нууруудын хотгор дахь том уулсын нэг Шаргат уулыг эзлэн оршино. Талбайн урд зах Хар ус нуурын хойд эргээс 4 км зайтай. Талбай 1.2х24х4 км хэмжээтэй, уулархаг, хайгуул судалгаа хийх нөхцөл хүнд байв.



Талбайн газарзүйн онцлогийг харгалзан нарийвчилсан, энгийн болон хялбарчилсан аргаар хайгуул судалгаа хийхэд хайгуулын лицензтэй талбайн дотор эртний 27 булш бүртгэн солбицолыг тэмдэглэн зураг авч товч тодорхойлолт хийсэн. Эдгээр булшууд далайн түвшнээс дээш 1280-1820 м өндөрт байна. Талбайн урд зах Хар ус нуурын хурдастай залгаа орших бөгөөд нуураас хойш Шаргат уулын урд хормой хүртэл үргэлжилсэн олон тооны булштай 4 хэсэг талбай бий. Гэхдээ эдгээр булшууд талбайн гадна орших учир тус компаний үйл ажиллагаанд шууд нөлөөлөхгүй юм. Харин кэмп байгуулах болон аж ахуйн аливаа үйл ажиллагаа явуулахдаа анхаарал болгоомжтой байхыг сануулж байгаа хэрэг юм.

Түүнчлэн тусгай зөвшөөрөлтэй талбайн хойт хэсэгт цөөн өвөлжөө, бууц байна. Ардын зан үйл явуулдаг газар болон тахилга шүтлэгтэй уул овоо байхгүй бололтой.

Нутгийн хил заагийг тэмдэглэсэн бололтой хэд хэдэн жижиг овоо талбайн хойд захаар бий.

Хайгуул судалгааны явцад илэрсэн, талбай дээр тэмдэглэсэн бүх булшны дугаар, зураг, солбицол болон товч тодорхойлолтыг хийсэн юм. Бидний бүртгэн тэмдэглэсэн булшууд дугуй хүрээтэй болон хүрээгүй овгор дугуй гэх хоёр хэв шинжид хуваагдах бөгөөд МЭӨ XV-IX зууны үед холбогдох түүх, археологийн утга зохиолд “хиргисүүр” хэмээн нэрлэдэг оршуулгын байгууламжууд болно. Энэ төрлийн булшууд монголд хамгийн өргөн хүрээтэй тархсан байдаг ба хүрлийн хожуу үеийн Төв Азийн соёлын томоохон голомтыг төлөөлдөг дурсгал юм.

“МЦЦТ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбай

“МЦЦТ” ХХК-ийн хүсэлтийн дагуу “Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 17.10-р заалтыг үндэслэн тус компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааг 2015 оны 10-р сарын 25-29-ний хооронд зохион явуулав.

2014/003Х талбай нь Дорноговь аймгийн Замын-Үүд боомтоос хойш 4 км орчим зайтай Хар овоо хэмээх газарт хилийн бүсэд оршино. Талбай 2.7 км урт, 1.5 км өргөн бөгөөд ширгэж хатсан тойрмуудын дунд тэгш талд уул, толгод, ундны усны задгай эх үүсвэргүй газарт байх ажээ. Газарзүйн хувьд археологийн хайгуул судалгаа зохион явуулахад хүндэрэлгүй бартаа саадгүй газар болно.

Талбайд археологийн хайгуул судалгаа хийж үзэхэд одоогийн өнгөн хөрсөн дээрээс эртний хүний үйл ажиллагаатай холбоотой биет эд өлгийн зүйл болон



ямар нэг төрлийн археологийн дурсгал олдоогүй бөгөөд түүнчлэн, тухайн газар нутагтай холбоотой ямар нэг домог яриа байдаггүй юм байна. Үүнээс гадна уг талбай нь археологийн дурасгал орших болзолт газар биш бөгөөд зарим хэсэгт үндсэн чулуулаг хөрсөн ил гарсан харагдана Харин уг талбайгаас 1956 оноос эхлэн хүрмэн чулуун хурдасыг олзворлож байсан тод ул мөр үлдсэн байх ба сүүлийн үеийг хүртэл орон нутгийн иргэд авч ашиглаж байжээ. “МЦЦТ” ХХК нь дээрх хүрмэн чулууг авч бутлан боловсруулж барилгын зориулалтаар ашиглах бөгөөд олзворлолтын явцад нөлөөлөх археологийн дурсгал талбай болон түүний ойр орчимд байхгүй болохыг тогтоов.

**“Ренова илч” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбай**

“Ренова илч” ХХК-ийн “Хар ус II” нэртэй нефтьийн хайгуулын талбайд 2015 оны 10-р сарын 25-наас 11-р сарын 16-н хүртэл археологийн хайгуул судалгаа зохион явууллаа. Хайгуул судалгааг “Google earth”-ийн сансарын зураг дээр хийсэн ажиглалт дээр тулгуурлан төлөвлөсөн арга зүйд үндэслэн газар дээр туршин явуулсан нь үр дүнтэй ажил болов. Тухайлбал, дунд болон өндөр нягтралтай сансарын зураг дээр баруун монголын өндөр уулс, нам болон дундаж өндөртэй уулс, үлдэгдэл хадан уулс, гол, нуурын эрэг хөвөө, жижиг толгод, дов гүвээ гэх мэт олон хэв шинжийн тогтоцтой Их нууруудын хотгорт эртний булш болон хэрэм, бэхлэлт суурин зэрэг археологийн дурсгалууд ямар орчинд оршин байж болохыг урьдчилан төсөөлж, тэр төсөөллийн үндсэн дээр шинэ дурсгалт газрыг эрж хайх, илрүүлэн олох ажлыг ихээхэн хөнгөвчилсөн судалгаа болсон юм. Төлөвлөсөн маршрутын дагуу газар дээр хайгуул судалгаа зохион явуулж, өгөгдсөн солбицлыг шалган үзэхэд зөрөө гараагүй бөгөөд гагцхүү сансарын зураг дээр ажиглагдаагүй жижиг булшууд шинээр нэмэгдэж байлаа. Түүнчлэн, гол төлөв гол, нуурын ойр хадан гарц бүхий газраас зайдуу орших талбайд усанд мөлгөржсөн жижиг хайргаар байгуулсан хавтгайвтар багавтар булшууд тэр бүр сансарын зурагт харагддаггүй болохыг мэдэв. Үүнээс гадна хэд хэдэн талбайг шинээр илрүүлэн олж тэмдэглэсэн бөгөөд тэдгээр булшууд, дээр дурдсан газар зүйн орчны аль нэг хэв шинжид багтаж байгаа юм.

Хайгуул судалгааны ажлын өөр нэг чухал үр дүн бол урьд өмнө судлаж байгаагүй хэв шинжийн дурсгалыг баруун монголоос шинээр илрүүлэн олсонд оршино. Тухайлбал, Увс аймгийн Өлгий сумын нутаг Сондуулын гол, Хар нуурын зүүн өндөр эрэг дээр орших 5-10 м голчтой, гэрийн буйр мэт нэг дор бөөгнөрсөн дугуй байгууламжууд болно. Эдгээр дугуй байгууламжууд эртний тариалангийн ор мөр бүхий газруудад байгаа бөгөөд газар гэр буюу сууцны үлдэгдэл байж болох юм гэж таамаглаж байна. Үүнтэй ижил төстэй байгууламж болон эртний тариалангийн ор мөр Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт хэд хэдэн газарт бий боловч малтан судлаагүй тул эцсийн хариулт малталт судалгааны дараа гарах болно.

Увс нуурын сав газарт эртний газар ашиглалтын талаар Монгол, Тувагийн хамтарсан судалгааны материалаас үзэхэд Уйгур ялангуяа, Хятан улсын үед тус бүс нутагт багагүй хэмжээний газар боловсруулан тариалж байсныг тогтоосон бөгөөд эртний сууринд хийсэн малталтаас хятан бичээстэй модны хэсэг хүртэл олдсон тухай дурджээ.

Хар ус II талбайд бүртгэн судалсан булшийг дараах байдлаар хоёр бүлэг, хэд хэдэн дэд хэв шинж болгон ангилж болно.

- Дөрвөн хөшөөтэй дугуй хүрээтэй болон хөшөөгүй хүрээтэй булш
- Овгор дугуй булш
- Жижгэвтэр хавтгай дугуй булш
- Хашлагатай дугуй булш
- Дөрвөлжин хүрээтэй булш
- Дөрвөн буландаа хөшөөтэй дөрвөлжин булш
- Гонзгой дөрвөлжин булш


Эдгээр булшны ихэнх хэсэг нь нэг соёлын өөр өөр хэв шинжийн дурсгалууд бөгөөд ардын ярианд хиргисүүр хэмээн нэрлэхээс гадна түүх, археологийн шинжлэх ухаанд энэ нэрээр орсон байна. Хиргисүүр хэмээх нь нэгэн төрлийн оршуулгын байгууламж болно.

Хиргисүүр нь Тувагийн өмнөд хэсэг, Өвөр Байгалийн баруун хэсэг болон Монголын Сүхбаатар аймгийн баруун хойд тал хүртэлх өргөн уудам нутагт

тархжээ. Эдүгээ монголд 140 гаруй хиргисүүрийг малтан судлаад байгаа бөгөөд байгалийн шинжлэлийн аргаар тогтоосон он цагаас үзвэл МЭӨ XIV-IX зууны буюу хүрлийн хожуу үеийн дурсгал болно. Харин цөөн хэсэг жижиг хавтгай дугуй булшууд энеолитийн үеийн булшууд байж болох талтай.

Талбайд багавтар 5 хэрэм, 2 суурин байгаа бөгөөд Ховд голын адагт орших том хэрмийг Галдан бошигт байгуулсан гэж үздэг боловч малталт судалгаа хийгээгүй юм байна. 2 дахь хэрэмтэй суурин нь Бумбат хайрханы Хүрэн бэлчирийн зүүн урд орших бөгөөд он цаг тодорхойгүй. Хуучин хүрээ хийдийн туурь байж болох боловч одоогоор ямар нэг мэдээ олдоогүй байна. Шинээр илрүүлэн олсон 5 жижиг хэрмийн зарим нь эртний бунхант оршуулгатай хэмжээ болон хэлбэрийн хувьд төстэй байна.

“Ренова илч” ХХК-ийн Хар ус II талбайд зохион явуулсан археологийн хайгуул судалгааны явцад шинээр дараах дурсгалууд илрэв. Үүнд: 114-н талбайгаас булш 2024, суурин 2, хэрэм 5, гэрийн буйр мэт дугуй хонхор байгууламж 200 гаруй, эртний тариалангийн ор мөр 2 газарт, нийт 5 төрлийн 2230 гаруй археологийн



дурсгал бүртгэв. Үүнээс 53.1, 53.2, 73-р талбай бүтнээрээ, 72-р талбайн тал нь хайгуулын талбайн гадна 1-1.7 км зайд оршиж байгаа бөгөөд тэнд 300 орчим булш байгаа юм. Тухайлбал, тус компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайд 1700 орчим булш байна. Тайлангийн багатаамжаас шалтгаалан 100-гаас доош булштай талбайд орших булшны солбицолуудыг нэг бүрчлэн бичиж тэмдэглээд харин гол төлөв 100-аас дээш булштай газрын талбайг зурагт хүрээлэн тэмдэглэв.

Хээрийн хайгуул судалгаагаар илэрсэн эртний дурсгалууд газар зүйн дараах орчинд оршино. Үүнд:

- Өндөр уулсын дундуурх хавцлын эх
- Хуурай жалга, сайрын завсар хооронд
- Гол, нуурын эрэг дагуух хадан гарцтай бэсрэг уулс
- Үлдэгдэл хадан уулс

- Гол, нуурт ойр тэгш тал гэх мэт орчинд ихэвчлэн тохиолдох бөгөөд уснаас хол орших дундаж өндөртэй уулсаар ховор, харин уулсын гүнд булш огт тавигддаггүй байсан бололтой.

Үүнээс гадна Тээл, Завхан голын бэлчир, Хүнгий голын хойд эрэг, Бор Хярын элсний өмнө тал болон элсний хойно орших жижиг нуурын хавь орчим газар шинэ чулуун зэвсгийн буц суурин байж болох талтай бөгөөд элсний нүүдлээр нэг ил гарч, нэг далд орж байх тул суурин судалгааны явцад илрүүлэх боломжтой. Манхан сумын төв болон Хойт Цэнхэрийн голын эх өөд хуучин чулуун зэвсэг цөөнгүй олддог боловч дээрх сумтай залгаа талбайд энгийн аргаар хайгуул хийхэд чулуун зэвсэг олдсонгүй.

ШУТИС-ИЙН БУХС-ИЙН АРХЕОЛОГИ-ЭТНОГРАФИЙН СУДАЛГААНЫ БАГИЙН ЭГИЙН ГОЛЫН ХӨНДИЙД ХИЙСЭН 2015 ОНЫ АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ СУДАЛГАА

Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, С.Болормаа,
Ц.Бямба-Очир, Р.Төгссайхан, С.Бат-Эрдэнэ

Судалгааны түүх: Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг Эгийн гол дээр усан цахилгаан станц барих төслийн хүрээнд ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн салбарын хээрийн судалгааны анги 2015 оны 6 сарын 3-ноос 8 сарын 2-ныг хүртэлх нийт 60 хоногийн хугацаанд археологийн авран хамгаалах малтлага судалгааг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд Эгийн голын бэлчирт орших археологийн (EGAS) дурсгалыг малтан судлах ажлыг зохион байгуулав. Энэхүү хээрийн судалгааны ажил нь 2014 онд тус сургуулийн судлаачдын археологийн авран хамгаалах судалгааны ажлын үргэлжлэл байлаа¹.

Хийгдсэн ажил: 2015 оны хээрийн судалгааны ажлын гэрээнд заагдсан нийт 34 тооны түүх, археологийн дурсгалуудыг /өмнө нь малтсан дурсгалууд орсон болно/ малтан судалсанаас гадна бид Эмгэнт хошуунаас Холтост нуга хүртэл нарийвчилсан хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэнээр 4 тооны хиргисүүр, 2 тооны дөрвөлжин булш, 20 тооны он цаг тодорхойгүй дурсгал², 3 тооны Түвэд бичигтэй хөшөө чулуу³, 2 тооны хадны зураг⁴ олж илрүүлэн малтан судлав. Судалгааны үр дүнд нийт 53 дурсгалуудыг малтан судласан болно.

Хот суурингийн малтлага судалгаа

Холтостын хүрэмт⁵ N-490 28°34.4 E-1030 21°45.8 ДТД-931м

Энэхүү хэрэм нь үндсэн 2 хэрмээс бүрдэх бөгөөд бид эл хоёр хэрмийг Хүрэмт I, Хүрэмт II хэмээн дугаарлалаа. Хойт талын хэрэм нь тэгш дөрвөлжин хэлбэртэй 90х90 метр хэмжээтэй, урд талын залгаа хэрэм нь 70х122 метр хэмжээтэй ба газрын онцлогтой тааруулан урд хэрмийг дугуйруулан үйлдсэн байна. Хэрмийг үйлдэхдээ дотор талаар шуудуу ухаж, түүнийхээ шороог далан болгон овоолох зарчимаар үйлдсэн. Энэ 2 хэрэм хоорондоо шороон хэрмээр тусгаарлагдсан Хэрэм тус бүр зүүн тийш гадагшаа гарах хаалгатай байсны ул мөр болох сэтэрхийтэй агаад урд байрлах хэрэм нь хаалга болон хаалганаас гарсан зам нь газрын хэвийг даган хэрмын зүүн хойт зүг чиглэсэн байна.

Эл сууринд барилга байшин байсан гэх ямар нэг чулуу болон шороон овоолго


¹ Хээрийн судалгааны ангид төслийн удирдагч, ШУТИС-ын БУХС-ийн Хүмүүнлэгийн салбарын доктор, дэд профессор Ю.Болдбаатар, судалгааны хээрийн ангийн ахлагчаар доктор, дэд профессор Л.Эрдэнэболд, судлаачид С.Бат-Эрдэнэ, Ц.Бямба-Очир, С.Болормаа, Д.Хатанбаатар, Ч.Ванчигдаш, Г.Мөнх-Эрдэнэ туслах судлаачаар Р.Төгссайхан, Т.Мөргөнцэн, З.Одбаяр нар, түүнчлэн туслах ажилтнаар Г.Амарсайхан, Б.Болормаа, Г.Ариунзул, Э.Долгордулам, Д.Тогтохбаяр, Н.Дамбийням, Э.Эрдэнэ-Уул, Б.Энхтамир, М.Өлзий-Орших, С.Цогзолмаа, Т.Анхбаяр, С.Тамжид, Д.Баярнэмэх, Э.Бат-Эрдэнэ, М.Бямбадорж, С.Ганзориг, Ш.Чинтүшиг, Г.Түвшинбат, Б.Лхагвасүрэн, Б.Мөнхсарнай, Б.Халиун, Н.Ариунболор, С.Мөнххэрлэн, А.Хонгорзул, А.Ананд, Б.Туул нар ажиллав. Хээрийн судалгааны ангийн тогоочоор П.Сэржмаа, жолооч О.Зандраа, Г.Цэвмэд нар ажиллав.

² Шинээр илрүүлсэн булш дурсгалыг EGAS-A-1...гэх мэтээр тэмдэглэсэн болно.

³ Шинээр илрүүлсэн Хөшөө чулууг EGAS-B-1...гэх мэтээр тэмдэглэсэн болно.

⁴ Шинээр илрүүлсэн Хадны зургийг EGAS-C-1...гэх мэтээр тэмдэглэсэн болно.

⁵ Бид 2014 онд Эгийн голын сав дагуу археологийн малтлага судалгааны ажлын явцад нарийвчилсан хайгуул судалгаа хийсэн бөгөөд хайгуулын үр дүнд илэрсэн эл сууринг Холтостын хүрэмт хэмээн тэмдэглэсэн болно.



ул мөр мэдэгдээгүй тул хойд хэрэмд бид боломжит нөхцлөөр 5х5 м кв үүсгэн өргөргийн дагуу англи цагаан толгойн үсгээр буюу А-Р, уртрагийн дагуу тоогоор буюу 1-18 хүртэл А-Р, уртрагийн дагуу 1-18 гэж дугаарлаж, О-3,5,7,9,11,13,15 Р-2,4,6,8,10,12,14 С,Е,Г,І,К,М-9 D,Ғ,Н,Ј,І,Н-10 гэсэн өргүүдэд мөн Н-9,10 өргийг дайруулан уртрагийн дагуу 2м кв хэмжээтэйгээр малтлагыг явуулав. Урд хэрмийг бид 2м кв хэмжээтэй хойноос урагш уртрагийн дагуу N,1-N,60 хүртэл дугаарлаж, N-30 кв-аас өргөрөгийн дагуу E,1- E,30 гэж зүүн талын бэхлэлт хүртэл N-1 ээс E-30 хооронд А-1 ээс А-28 хүртэл дугаарлан 3х1м хэмжээтэй ташуу сорилын шуудуу татан дугаарлаж малтлагын ажлыг хийлээ. Ингэхдээ бидний малтлага судалгааны ажлын гол зорилго бол тус хотын туурийн бүтэц зохион байгуулалтыг голлон тодруулахыг зорьсон бөгөөд ямар нэгэн барилга байгууламжийн ул мөрийг олох, түүний соёлт давхаргыг тодруулахад гол ажлын зорилгоо чиглүүлэн ажиллалаа. /Хавсралт зураг-1/

Булш оршуулгын дурсгал

2015 оны Эгийн голын сав нутагт ажиллах археологийн судалгааны ажлын хүрээнд бид Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг, Эгийн голын хөндийн Холтост нуга, Эмгэнт хошуу, Баруун Бэлсэг, Хангинахын шугуй, Хужирт нуга гэсэн газруудад малтлага авран хамгаалах малтлага судалгааг хийж гүйцэтгэв. Эл судалгаагаар EGAS-2-031 өмнө малтсан, EGAS-2-032 өмнө малтсан, EGAS-2-034, EGAS-2-035, EGAS-2-055, EGAS-2-057, EGAS-2-095/3-026/ давхардаж дугаарласан, EGAS-3-024, EGAS-A-09, EGAS-A-10, EGAS-A-17 нийт 11 тооны хиргисүүр, EGAS-2-094/3-027/ давхардаж дугаарласан, EGAS-A-06, EGAS-A-07, EGAS-A-08, EGAS- A-26 нийт 5 тооны Дөрвөлжин булш, EGAS- A-03, EGAS- A-05, EGAS- A-15/ нийт 3-н тооны Монгол булш, /EGAS-A-01, EGAS- A-02, EGAS- A-04, EGAS- A-11, EGAS- A-12, EGAS- A-13, EGAS- A-14, EGAS- A-16, EGAS- A-18, EGAS- A-19, EGAS- A-20, EGAS- A-21, EGAS- A-22, EGAS- A-23, EGAS- A-24, EGAS- A-25, EGAS- A-27, EGAS- A-28, EGAS- A-29, EGAS- 3-016/ нийт 20-н тооны Тахилын байгууламж, EGAS-2-049, EGAS-2-050, EGAS-2-052, EGAS-2-084, EGAS-3-002, EGAS-3-005, EGAS-3-006, EGAS-3-007, EGAS-3-028, EGAS-B-1, EGAS-B-2, EGAS-B-3/ нийт 12 тооны Хөшөө чулуу, EGAS – C-1, EGAS – C-2 нийт 2 тооны хадны оршуулгыг авран хамгаалсан болно.

Товч үр дүн

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Холтостын хүрэм хэмээх газар



орших хотод хийсэн малтлага судалгаагаар ямар нэг соёлт давхрага байшин барилгын хана хэрэм, туурь зэрэг зүйлс илэрч олдоогүй боловч тус суурин нь өндөрлөг эрэгт оршиж байгаагийн хувьд цэрэг дайны зориулалттай түр суурин байсан байх талтай. Эл суурийнгаас малын яс, ваар савны хагархай, төмөр эдлэл зэрэг олдсон нь чухал хэрэглэгдэхүүн бөгөөд сурвалжийн мэдээ сэлт зэрэгтэй харьцуулан судлаж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах боломжийг бүрдүүлж өгч байна.

Бид Монголын эзэнт гүрний үед холбогдох булш 3-ыг малтан судалсны 3-лаа хүний оршуулгатай байв. Эдгээр 3 булшны нэг нь насанд хүрсэн хүний яс, дагалдах эд өлгийн зүйлийн хамт байсан ба EGAS-A-3 хэмээн дугаарласан болно. Харин нөгөө хоёр дурсгал болох EGAS-A-5, EGAS-A-15, хүүхдийн оршуулга байсан бөгөөд ялангуяа EGAS-A-5 нь 3-5 насны нялх хүүхдийн оршуулга байсан нь сонирхолтой юм. Хоёр дахь Монголын эзэнт гүрний үед холбогдох булш нь 6-8 орчим насны хүүхдийн оршуулга байсан бөгөөд үйсэн эдлэл, төмөр эдлэлийг дагуулан тавьсан нь сонирхол татаж байлаа. /Хавсралт зураг-2/

Хүрлийн үед холбогдох 20 тахилын байгууламж малтан судалсны цөөн хэдээс нь археологийн олдвор илэрч бөгөөд бусад нь хоосон байв. Дээрх үеийн чулуун байгууламжаас ямар нэгэн оршуулгын зан үйлийн ул мөр илрэхгүй байх нь түгээмэл байдаг. Энэ тухайн үеийн хүмүүсийн итгэл үнэмшилтэй холбоотой юм.

XVII-XX зуунд хамаарах шарын шашинд холбогдох Түвд, монгол бичээстэй 11 хөшөө чулууг малтан судлаж 3 хөшөө чулууг шинээр илрүүлэн судласан бөгөөд эдгээр нь XIX-XX зууны эхэн үе хамаарах боломжтой бөгөөд эргэл мөргөлчдийн сүсэг бишрэлийн улмаас болгож байсан шүтлэгийн орон бололтой. Эдгээр хөшөө чулууд нь түвэд болон монгол бичгээр бурханы шашны мөргөл залбиралын агуулгатай зүйлсийг байгалийн хад чулуун дээр зурж сийлэн үйлдсэн ажээ. Эдгээр хөшөө чулуудын босгосон газарт багахан хэмжээний сорилын малтлагуудыг явуулахад ямар нэгэн эд өлгийн зүйлс илэрсэнгүй. Дээрх хөшөө чулууд нь Монголын соёл, шашны түүхэнд багагүй ач холбогдолтой, цаашид нарийвчлан судлах ёстой дурсгалууд юм. Бидний судалгаа хийсэн Эгийн голын хойт эрэг орчимд XX зууны эхэн хүртэл шарын шашны томоохон төв байсныг Бэлсэгийн хийдийн туурь, түвд бичигтэй хөшөө чулууд илтгэж байна. /Хавсралт зураг-3/



2015 онд хийсэн авран хамгаалах хайгуул судалгаа. ШУТИС-ийн БуХС-ийн Археологи-Этнографийн судалгааны багийн хамт олон 2015 онд Улаанбаатар хотын хан-Уул дүүрэг, Налайх дүүрэг, Төв аймгийн Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан сум, Өмнөговь аймгийн Баян-Овоо сум, Булган аймгийн Дашинчилэн, Бүрэгхангай зэрэг сумдын нутагт 8 удаагийн хайгуул судалгаа хийж нийтдээ 45096,67 га тайлбайгаас хадны зураг - 58, хадны оршуулга - 5, хиргисүүр - 76, дөрвөлжин булш - 17, тахилын байгууламж - 32, хүннү булш - 314, түрэг булш - 1, монгол булш - 4, суварга - 2, чулуун шивээ - 1 зэргийг тус бүр шинээр илрүүлэн бүртгэжээ.



Хавсралт зураг 1. Холтостын хүрмийн агаарын зураг



Хавсралт зураг-3. Түвд бичигтэй хөшөө чулуу

ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2015 ОНД ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ ХАЙГУУЛ,МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Ч.Амартүвшин, Б.Батдалай, Д.Бөхчулуун

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Археологи, угсаатны авран хамгаалах салбараас 2015 онд нийт 55 хайгуул, малтлага судалгааны хээрийн шинжилгээний ажил зохион явуулсан байна.

Хайгуул судалгаа

2015 онд тус хүрээлэнгээс 9 аймгийн нутагт 25 компанийн 49 лиценз бүхий талбайд авран хамгаалах хайгуул судалгаа хийж үүний 22 талбайгаас чулуун зэвсгийн дурсгалт газар 7, хиргисүүр 35, дөрвөлжин булш 1, хадны зургийн дурсгалт газар 4, хүннү булш 19, хүннүгийн үеийн төмөр хайлуулах зуух 1, хотын турь 1, хүн чулуу 1, монгол булш 19, хадны оршуулга 1, булш 270, чулуун байгууламж 35, хийдийн турь 1 нийт 390 дурсгал илрүүлэн баримтжуулсан байна.

Мөн Төв аймгийн Борнуур сумын нутагт Аглаг бүтээлийн хийдийн чиглэлд шинээр тавигдаж буй авто замын шугамын дагуу 2 хиргисүүр илрүүлэн замын эхлэл хэсэгт буй 1 хиргисүүрийг авран хамгаалах шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна.

Малтлага судалгаа

Тус хүрээлэнгээс 2015 онд 2 аймгийн нутагт 3 удаагийн авран хамгаалах малтлага судалгааны ажил зохион явуулжээ. Үүнд: Төв аймгийн Заамар сумын нутаг “Мондулаан” ХХК-ийн ашиглалтын талбайд 1, Борнуур сумын нутагт Аглаг бүтээлийн хийдийн чиглэлд шинээр тавигдаж буй авто замын шугамд 1, усан цахилгаан станц барих талбайд 75, нийт 77 дурсгал хамрагджээ.

Төв аймгийн Заамар, Борнуур сумын нутагт 2 хиргисүүр малтаж адууны толгой, бод малын яс, ваарны хагархай илрүүлэн судалсан байна.

Өнгөрсөн онд хийгдсэн авран хамгаалах малтлага судалгааны хамгийн том төсөл нь 2014 оноос эхэлсэн “Эгийн голын түүх, археологийн дурсгалуудын авран хамгаалах судалгаа” төсөл билээ. Уг төслийн хүрээнд түүхийн олон үед хамаарах 75 дурсгалын авран хамгаалах малтлага судалгааг нийт 8 багт хуваагдан 60 хоногийн хугацаатай хийж гүйцэтгэсэн байна.

Чулуун зэвсгийн судалгааны баг Дөрөлж-3 суурингийн малтлага судалгааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ Баянголын дунд болон адаг орчмын 3-н газарт, Харуулын гозгор уулын баруун бэл Их Хөтөлд туршилтын малтлага, мөн Эгийн голын зүүн гар талаас цутгах жижиг голуудын сав дагуу, өндөр уулын бэл хэсгээр чулуун зэвсгийн хайгуул судалгааг хийв. Мөн Эг-Сэлэнгийн бэлчирийн зүүн өмнө талд Бухын голын зүүнтэй буй Бухын манхан (Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг) хэмээх дээд палеолитын үед холбогдох чулуун зэвсгийн суурингийн хамрах хүрээг тодорхойлох зэрэг ажлуудыг хийж хайгуул судалгаагаар Их хөтөл хэмээх газраас 122, Харуулын гозгороос 32, Дархан уулаас 3, Бөгсийн голоос 3 чулуун зэвсэн түүвэрлэжээ.

Дөрөлж-3 чулуун зэвсгийн суурингийн малтлагаас нийт 85 ширхэг чулуун зэвсэг илэрснээс 3-р давхаргаас 72 ш, 4-р давхаргаас 13 чулуун зэвсгийн олдвор илэрчээ.

Баянгол-2 чулуун зэвсгийн сууринд гүн жалга бүхий өндөр дэнжийн зүүн хажуугийн налуу хэсэгт дэнжийн хөрсний бүтцийг тодорхойлох, олдвор

хэрэглэгдэхүүн аль давхаргаас илэрч байгааг тодруулах зорилготой малтлага хийж 12 давхарга илэрсэн ба хөрс нь ихэд холилдсон, төв хэсэгтээ 3 м гаруй өндөр элсэрхэг хайрга чулуун давхарга илрэв. Элсэрхэг хайрган давхарга нь доод хэсэгтээ олон үелсэн байдалтай байна. Малтлагаар 11 давхаргаас нийт 259 ширхэг чулуун зэвсэг илрүүлжээ.

Мөн Баянгол-4, 4А, 4В, 4С, Баянгол-5, Их хөтөл, зэрэг газруудад бага хэмжээний сорилт малтлага хийж 300 орчим чулуун зэвсгийн дурсгал, 124 ширхэг ваарны хагархай илрүүлжээ.

Чулуун зэвсгийн дурсгал судлах баг Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ сумын Таримал багийн нутаг Нуурайн давааны ард Бухын манхан хэмээх газарт орших чулуун зэвсгийн дурсгалт газрыг шинээр илрүүлэн олж хамрах хүрээг 23 га хэмээн тогтоосон байна.

Эгийн голын хүрэл зэвсгийн үеийн судалгааны баг нь Өвөр Ханан, Нарст, Бөгсийн гол, Мухдагийн ам, Тэмээ уул, Асгат, Цацын гол, Бурхан уул, Элст хөтөл гэсэн нийт 9 газарт хиргисүүр 10, чулуун овоолгот булш 18, дөрвөлжин булш 3, тахилын байгууламж 3, чулуун байгууламж 15 нийт 54 дурсгалыг малтаж ваарны хагархай, бугын эвэр, хүрэл товруу болон хиргисүүрийн дагуул байгууламжаас адууны толгой болон малын шатсан ясны хэсгүүдийг илрүүлсэн байна.

Мөн 2014 онд эхлүүлсэн бууц суурингийн малтлага судалгааны ажлыг үргэлжлүүлэн судалсан бөгөөд уг сууцнаас илэрсэн үхрийн ясанд хийсэн С14 лабораторийн шинжилгээгээр хийсэн он цаг НТӨ 700-400 он хэмээн гарсан билээ.

Бууц суурингийн судалгааны баг Баянголоос гадна Холтост хүрэмийн хэрэмт дурсгалын зүүн урд талд Холтост нугын баруун талд хойд талаараа өндөр дэнжээр нөмөрлөгдсөн газарт сорилтын малтлага хийн ваарны хагархай, хүрэл хутганы хугархай зэрэг зүйлс илрүүлэн ваарны зуурмаг, шатаалт зэргээс үндэслэн хүннүгийн үед холбогдуулан авч үзжээ.

Уг төслийн хүрээнд хийгдсэн томоохон малтлагын нэг хүннүгийн жирийн иргэдийн булш бүхий Баруун Бэлсэгийн амны дурсгалт газар хийсэн малтлага судалгаа билээ. 2014 онд хүннү булшны судалгааны баг дурсгалт газрын зүүн урд хэсгийн 18 бүлэг булшыг малтан судалсан бол 2015 онд баруун хэсгийн үлдсэн 11 дурсгалыг малтаж нумын ясан наалт, шавар ваар, болор сувс, хүрэл хонх, ясан арал зэрэг сонирхолтой олдворууд илрүүлж олсноос ББ-23-р булшнаас илэрсэн ёроолдоо хятад ханз үсэгтэй төстэй дардас бүхий задгай амсартай ваар юм.

Хүний ясанд хийсэн судалгаагаар 7 эрэгтэй 2 эмэгтэй, 2 хүүхдийн яс болох нь тогтоогдсон ба булшинд дагалдуулан тавьсан мал, амьтны ясанд хийсэн судалгаагаар 2 хонь, 31 ямаа, 18 үхэр, 4 адуу, 4 нохойн яс байна.

Эгийн голын доод урсгал Баянголын зүүн талын нэгэн мөрөгцөгийн дээрх тэгш дэвсгэ дээр байрлах дөрвөн монгол булшийг малтан судаллаа. Эдгээрээс Баянголын 1, 4-р монгол булш насанд хүрсэн эмэгтэй хүний оршуулга байсан бол Баянголын 2, 3-р монгол булшинд хүүхдийн оршуулга байв. Талийгаачдыг нэг зүгт буюу бүгдийг нь зүүн хойш нь хандуулан оршуулсан байх бөгөөд гадаад болон дотоод зохион байгуулалтын хувьд тухайн үеийн оршуулгын зан үйлтэй ижилсэнэ.

Баянголын 1-р монгол булшнаас үйсэн эдлэл, хээтэй дугуй хүрэл эдлэл, хүрэл хонгио зэрэг зүйлс гарсан бол Баянголын 4-р монгол булшнаас богтаг малгайн үйсэн хатуулга, богтаг малгайн чимэглэл 2 ш, металл чимэглэл, хөөмөл метал чимэглэл, үйсэн чимэглэл, ээмэг, сувс, модон хатуулга, органик эдлэлийн хэсгүүд гарсан юм. Баянголын 4-р булшнаас гарсан богтаг малгайн чимэглэл нь гайхамшигтай чамин хийцтэй, урьд өмнө нь судалгаанд тааралдаж байгаагүй



шинэ эх хэрэглэгдэхүүн байлаа.

Хадны зургийн судалгааны баг тус бүс нутагт урьд өмнө нь илрэн бүртгэгдсэн Битүүгийн цагааны хадны сийлмэл зургийн дурсгалаас гадна Эмгэнт хошууны хадны сийлмэл болон зосон зураг, Дээд хийдийн агуй, Хөх хошууны зосон зургийг шинээр бүртгэн баримтжуулсан байна.

Эгийн голын хөндийд өргөн тархсан Төвөд бичээс бүхий хөшөөг нарийвчлан судалж Судалгааны явцад янз бүрийн хэмжээтэй 167 хөшөө чулууг бүртгэснээс төвөд бичигтэй хөшөө 41, ланз үсэгтэй хөшөө 2, төвөд болон ланз үсэгтэй хөшөө 3, төвөд, монгол бичигтэй хөшөө 2, бурханы дүр сийлсэн хөшөө 2-ыг баримтжуулан, бичээсийг сийрүүлсэн болно. Эдгээр хөшөөнүүдэд төвөд, ланз, монгол бичээс байхаас гадна хөшөөг нар, сар, суварга, лянхуа цэцэг, хас тамга зэргээр чимэглэдэг байжээ. Төвөд болон ланз үсэг бүхий хөшөөний дээд талд нар, сар эсвэл нар дүрсэлсэн байгаа нь монголчуудын ертөнцийг үзэх үзэл, төрт ёсны уламжлалын нилээд эртний уламжлал хадгалагдаж байгааг харуулна.

Тоногдож хөндөгдсөн дурсгал

Үүнээс гадна 2015 оны 4 дүгээр сард Дорноговь аймгийн Айраг сумын хэсгийн төлөөлөгч, дэд хурандаа Ж.Эрдэнэбилэг тус сумын нутагт хиргисүүр тоносон тухай мэдээллийг тус хүрээлэнд хүргүүлсний дагуу ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Археологийн төвийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Амгалантөгс очиж хэмжилт, тодорхойлолт хийн хиргисүүрээс гарсан хүрэл амгайг авч ирсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын төвд нутгийн иргэн Э.Дорждэрэм хашаандаа ногооны зоорь ухах явцад 3 м орчим гүнээс эртний хүний оршуулга илэрсэн тухай мэдээлсэн билээ. Уг мэдээллийн дагуу тус хүрээлэнгийн Археологи, угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ажилтан Б.Батдалай газар дээр нь очиж танилцан баримтжуулалт хийн хүний яс, болон 2 ширхэг шавар ваар, 3 ширхэг хүрэл хонхыг Улаанбаатар хотод авч ирчээ.

Товч дүгнэлт

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгээс Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хүрээнд нийт 8 аймгийн 20 сумын нутагт 52 удаагийн авран хамгаалах хээрийн шинжилгээний анги зохион явуулж 22 талбайгаас чулуун зэвсгийн дурсгалт газар 7, хиргисүүр 35, дөрвөлжин булш 1, хадны зургийн дурсгалт газар 4, хүннү булш 19, хүннүгийн үеийн төмөр хайлуулах зуух 1, хотын турь 1, хүн чулуу 1, монгол булш 19, хадны оршуулга 1, булш 265, чулуун байгууламж 35, хийдийн турь 1 нийт 390 дурсгал илрүүлэн баримтжуулсан байна.

Малтлага судалгаагаар нийт 77 дурсгал малтсанаас чулуун зэвсгийн суурин 3, хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр 15, дөрвөлжин булш 8, дугуй дараастай булш, тахилын байгууламж 19, хүннү булш 13, суурин 2, монгол булш 4 тус тус хамрагдаж 1000 гаруй олдвор хэрэглэгдэхүүн шинээр илрүүлэн цуглуулснаас Баруун Бэлсэгийн 23-р хүннү булшнаас гарсан ёроолдоо хятад ханз үсэгтэй төстэй дүрс бүхий дардастай шавар ваар, 24-р булшнаас гарсан ягаан өнгийн болор зүүлт, Баянголын 4-р монгол булшнаас гарсан богтаг малгай хүрэл чимэглэл нь маш уран хийцтэй, урьд өмнө нь судалгаанд тааралдаж байгаагүй шинэ эх хэрэглэгдэхүүн байлаа.

Үүнээс гадна тонуулчдын ухаж сүйтгэсэн мөр болон санамсаргүй хөндөгдсөн дурсгалын мөрөөр тус хүрээлэнгийн судалгааны баг газар дээр нь очиж тодорхойлолт, баримтжуулалт хийн олдсон олдворуудыг авсан байна.

Монгол улсын соёлын өвөө дээдлэн тонуулчдын мөрөөр явж илрүүлсэн

Дорноговь аймгийн Айраг сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч, дэд хурандаа Ж.Эрдэнэбилэг болон Төв аймгийн Жаргалант сумын иргэн Э.Дорждэрэм нарт гүн талархал илэрхийлье.




График-1. Авран хамгаалах хээрийн судалгааны тоон үзүүлэлт




График-2. 2015 онд хайгуул судалгаагаар илэрсэн дурсгалын тоон үзүүлэлт



Газрын зураг-1. Аваран хамгаалах хайгуул судалгаа хийсэн газрууд



Газрын зураг-2. Аваран хамгаалах малтлага судалгаа хийсэн газрууд



Газрын зураг-3. Хөндөгдсөн дурсгалын байршил

Илтгэлийн зохиогчдын танилцуулга*Монгол судлаачид*

Алдармөнх П.
Алтансүх Б.
Амарболд Э.
Амартүвшин Ч.
Амгалантөгс Ц.
Ангарагдөлгөөн Г.
Анхбаяр Б.

Анхсанаа Г.
Батбаяр Т.
Батболд Г.
Батболд Н.
Батдалай Б.
Батсайхан З.
Батсүрэн Б.
Батсүх Д.
Баттулга Ц.
Бат-Эрдэнэ С.
Баяндэлгэр Ч.
Баярбат Д.
Баярсайхан Ж.
Баярхүү Н.
Болорбат Ц.
Болормаа С.
Бөхчулуун Д.
Буянхишиг Ц.
Бүрэнтөгс Г.
Бямба-Очир Ц.
Ванчигдаш Ч.
Галбадрах Б.
Галдан Г.
Гантулга Ж.
Гүнчинсүрэн Б.
Далантай С.
Дэлгэрмаа Л.
Ерөөл-Эрдэнэ Ч.
Жаргалан Б.
Жаргалсайхан Б.

Идэрхангай Т.
Ишцэрэн Л.
Лхүндэв Г.
Мандах Д.
Мижиддорж Э.
Мөнхбаяр Л.
Мөнхтулга Р.

БНСУ-ын Сөүлийн Их сургууль
Соёлын өвийн төв
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Нүүдлийн соёл иргэншлийг судлах
олон улсын хүрээлэн
Соёлын өвийн төв
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Монгол улсын их сургууль
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Монгол улсын Их сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль
Монголын Үндэсний Музей
Эрүүгийн цагдаагийн газрын ЗБГХТХ
Монголын Үндэсний Музей
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Шинжлэх ухаан технологийн их сургууль
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Монголын Үндэсний Музей
Шинжлэх ухаан технологийн их сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль
Улаанбаатарын Их сургууль
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
АНУ-ын Ийелийн Их сургууль
Баян-Өлгий аймаг дахь ШУА-ийн
Философийн хүрээлэнгийн НЭЗБС
Улаанбаатарын Их сургууль
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
БНХАУ-ын Ухань Их сургууль
Улаанбаатарын Их сургууль
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн



Наранбаатар Б.	Эрүүгийн цагдаагийн газрын ЗБГХТХ
Нямхүү М.	ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн
Одбаатар Ц.	Монголын Үндэсний Музей
Одмагнай Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Одсүрэн Д.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Олзбаяр Г.	Монгол улсын их сургууль
Оргилбаяр С.	Улаанбаатарын Их сургууль
Очир А.	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
Очир Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Өлзийбаяр С.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Өмирбек Б.	Баян-Өлгий аймаг дахь ШУА-ийн Философийн хүрээлэнгийн НЭЗБС
Төгссайхан Р.	Монголын Цэргийн түүхийн музей
Төрбат Ц.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Төрбат Р.	Монгол улсын их сургууль
Түвшинжаргал Т.	Монголын Үндэсний Музей
Түмэн Д.	Монгол улсын их сургууль
Уртнасан Э.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Хантөгс Т.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Хатанбаатар Д.	Шинжлэх ухаан технологийн их сургууль
Цогтбаатар Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Цэвээндорж Д.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Цэрэнбямба Х.	Дүрслэх урлагийн музей
Цэрэндагва Я.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Чулуун С.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Энхбат Г.	Соёлын өвийн төв
Энхбаяр Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Энхбаяр О.	Эрүүгийн цагдаагийн газрын ЗБГХТХ
Энхболд С.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Энхтөр А.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Энхтуул Ч.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Эрдэнэ Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Эрдэнэ М.	Монгол улсын Их сургууль
Эрдэнэбаатар Д.	Улаанбаатарын Их сургууль
Эрдэнэбат Л.	БНСУ-ын Тежоны Их сургууль
Эрдэнэбат У.	Монгол улсын Их сургууль
Эрдэнэболд Л.	Шинжлэх ухаан технологийн их сургууль
Эрдэнэ-Очир Н.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Эрдэнэцогт Т.	Соёлын өвийн төв
Эрэгзэн Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн

Гадаад судлаачид

Ахметов М.	Казахстан улсын Дорно дахины судлалын хүрээлэн
Ашык А.	БНТУ-ын Эгүмэнэ Их сургууль
Базылхан Н.	Казахстан улсын Дорно дахины судлалын хүрээлэн
Бартон Л.	АНУ-ын Питсбургийн Их сургууль
Бён Ён Хуан	БНСУ-ын Соёлын Өвийн судалгааны Үндэсний хүрээлэн

Бернард В.	Францын Ренний Их сургууль
Брандштетер Л.	ХБНГУ-ын Киёлийн Их сургууль
Бросседер У.	ХБНГУ-ын Бонны Райны
	Фридрих-Вильхельм Их сургууль
Васютин С.А.	ОХУ-ын Кемеровийн Их сургууль
Врайт Ж.	ИБУИВУ-ын Абердины Их сургууль
Вүэ Мен Хуан	БНСУ-ын Соёлын Өвийн судалгааны
	Үндэсний хүрээлэн
Гарднер У.	АНУ-ын Ийелийн Их сургууль
Гиллиланд С.	АНУ-ын Калифорнийн Үндэсний парк
Гүнэр С.	БНТУ-ын Докуз Илулийн Их сургууль
Дюшен С.	Францын INRAP
Звинс Н.	АНУ-ын Калифорнийн Девисийн Их сургууль
Ивлиев А.Л.	ОХУ-ын Алс Дорнодын түүх, археологи,
	этнографийн хүрээлэн
Изүхо М.	Япон улсын Токио Метрополитан Их сургууль
Йылмаз А.	БНТУ-ын Едитепе Их сургууль
Миямото К.	Япон улсын Кюүшү Их сургууль
Крадин Н.Н.	ОХУ-ын Алс Дорнодын түүх, археологи,
	этнографийн хүрээлэн
Ким Сан-мин	БНСУ-ын Үндэсний Музей
Киясбек Г.	Казахстан улсын Дорно дахины судлалын хүрээлэн
Кларк Ж.	АНУ-ын Монгол судлалын төв
Ковычев Е.В.	ОХУ-ын Өвөр Байгалын Хүмүүнлэг-Боловсролын
	Их сургууль
Кортум Р.	АНУ-ын Еаст Тенниссийн Их сургууль
Лаури Б.	АНУ-ын Чикагогийн Их сургууль
Лепец С.	Францын Байгалийн түүхийн музей
Магай Ж.	Монакогийн Нэн эртнийн түүхийн музей
Миллер Б.	ХБНГУ-ын Боннын Их сургууль
Миякэ Т.	Япон улсын Шүкүтоку Их сургууль
Морган К.	АНУ-ын Невада Их сургууль
Николаева Д.	Францын Тулузын Их сургууль
Онгар А.	Казахстан улсын Дорно дахины судлалын хүрээлэн
Осава Т.	Япон улсын Осака Их сургууль
Розен А.	АНУ-ын Техасын Их сургууль
Рыбин Е.П.	ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын
	Археологи, угсаатан зүйн хүрээлэн
Сагава М.	Япон улсын Тоохоку Гакүин Их сургууль
Сайто Ш.	Япон улсын Осака Их сургууль
Салисис К.	Францын Альп, Газрын дундад тэнгисийн
	Эртний археологийн хүрээлэн
Самашев З.	Казахстан улсын Дорно дахины судлалын хүрээлэн
Сасада Т.	Япон улсын Эхимэ Их сургууль
Сон Ый-жон	БНСУ-ын Үндэсний Музей
Ташагыл А.	БНТУ-ын Эгүмэнэ Их сургууль
Тэйлор У.	АНУ-ын Нью Мексикийн Их сургууль
У Сэй-ён	БНСУ-ын Үндэсний Музей
Үсүки И.	Япон улсын Саппора Гакүин Их сургууль
Фаркухар Ж.	АНУ-ын Питсбургийн Их сургууль



Франкен К.	ХБНГУ-ын Археологийн хүрээлэн
Фурхолът М.	ХБНГУ-ын Киёлийн Их сургууль
Хадел П.	АНУ-ын Калифорнийн Сан-Францискогийн Их сургууль
Ханичёрч У.	АНУ-ын Ийелийн Их сургууль
Харинский А.В.	ОХУ-ын Эрхүүгийн техникийн их сургууль
Хаценович А.М.	ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, угсаатан зүйн хүрээлэн
Хуанбо Чансо	БНСУ-ын Үндэсний Музей
Хюл Ж-Л	АНУ-ын Баруун Кентаки Их сургууль
Ширайши Н.	Япон улсын Нийгата Их сургууль
Шнайдер Ж.	АНУ-ын Калифорнийн Үндэсний Парк
Яанз Л.	Канадын Терентийн Их сургууль